



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2026 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**НЭГДСЭН ХУРАЛДААН**



**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг**

|                                                                                                                                                                                                                                                                                      |                    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>                                                                                                                                                                                                                                               | 1-2                |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                                                                    | 3-35               |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                                                             | 36-186             |
| <hr/>                                                                                                                                                                                                                                                                                |                    |
| <b>1.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах</b>                                                                                                                                                                                                                                           | 39-45              |
| <b>2.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай асуудал /үргэлжлэл/</b>                                                                                                                                                                                                   | 45-46              |
| <b>3.Зарим Байнгын хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал</b>                                                                                                                                                                                                                | 461-51             |
| <b>4.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай</b>                                                                                                                                                                                                                             | 51-53              |
| <b>5.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</b> | 53-100<br>176      |
| <b>6.“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>                                                                                                                                                | 101-110<br>176     |
| <b>7.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>                                                                                            | 111-113            |
| <b>8.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/</b>                                                      | 114-123<br>177-178 |
| <b>9.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>                                | 123-133<br>178-180 |
| <b>10.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд</b>                                                                                                                        | 133-139<br>180-181 |

---

**хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

**11.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

139-144

181

**12.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

144-145

**13.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

145-146

**14.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

146-151

170-175

181-184

**15.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

151-170

184-186

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
07 дугаар сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.<sup>1</sup>

Томилолттой: Ж.Алдаржавхлан;

Чөлөөтэй: Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Х.Ганхуяг, Ц.Мөнхбат, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Р.Сэддорж;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баасанжаргал, Д.Батбаяр, Д.Батлут, Х.Баттулга, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, С.Лүндэг, З.Мэндсайхан, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Д.Амарбаясгалан;

Хоцорсон: Н.Алтанхуяг-06 минут, С.Амарсайхан-38 минут, Ч.Анар-01 минут, Т.Аубакир-03 минут, Ц.Баатархүү-02 минут, М.Бадамсүрэн-27 минут, П.Батчимэг-59 минут, Э.Батшугар-01 минут, Ж.Баярмаа-45 минут, Э.Болормаа-44 минут, Х.Булгантуяа-09 минут, Ш.Бямбасүрэн-01 минут, М.Ганхүлэг-04 минут, Ц.Даваасүрэн-54 минут, Б.Дэлгэрсайхан-03 минут, Б.Жавхлан-16 минут, Б.Жаргалан-12 минут, Д.Жаргалсайхан-32 минут, П.Мөнхтулга-2 цаг 09 минут, О.Номинчимэг-32 минут, Б.Пунсалмаа-41 минут, Д.Пүрэвдаваа-2 цаг 47 минут, О.Саранчулуун-09 минут, Ц.Туваан-18 минут, Г.Тэмүүлэн-14 минут, А.Ундраа-26 минут, Г.Уянгахишиг-01 минут, Б.Хэрлэн-1 цаг 58 минут, Д.Цогтбаатар-02 минут, Ж.Чинбүрэн-08 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хойшлуулсан тул, “Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хорооны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны явцад хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллаас тус тус хасагдсан тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 07 дугаар сарын 02-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Номтойбаяр, Л.Мөнхбаатар нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын дараалал өөрчлөх талаар

<sup>1</sup> Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 8 гишүүн ирцэд нэмэгдсэн.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан горимын саналыг танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэх асуудлын дарааллын арван дөрөвдүгээрт товлосон Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай, арван тавдугаарт товлосон Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлуудыг хоёрдугаар асуудлын дараа хэлэлцүүлэх Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61  
Татгалзсан: 20  
Бүгд: 81

75.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлуудыг хэлэлцэх асуудлын дарааллын гурав, дөрөвдүгээр асуудал болгон хэлэлцэхээр тогтов.

### ***Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

**С.Бямбацогт:** 1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 11  
Бүгд: 84

86.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

### ***Хамт өргөн мэдүүлсэн:***

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 11  
Бүгд: 84

86.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 11  
Бүгд: 84

86.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 14  
Бүгд: 84

83.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 13  
Бүгд: 84

84.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 13  
Бүгд: 84

84.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
Татгалзсан: 15  
Бүгд: 84

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 12  
Бүгд: 84

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 14  
Бүгд: 85

83.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 13

Бүгд: 85

84.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 14

Бүгд: 85

83.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 13

Бүгд: 85

84.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 15

Бүгд: 86

82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 17

Бүгд: 86

80.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 14

Бүгд: 86

83.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
Татгалзсан: 17  
Бүгд: 86

80.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 15  
Бүгд: 86

82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 15  
Бүгд: 86

82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 14  
Бүгд: 86

83.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 18  
Бүгд: 86

79.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 15  
Бүгд: 87

82.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

**Холбогдуулан боловсруулсан:**

22.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 16  
Бүгд: 87

81.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 14  
Бүгд: 87

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

24.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 15  
Бүгд: 87

82.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

25.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 14  
Бүгд: 87

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

26.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 17  
Бүгд: 88

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

27.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 17  
Бүгд: 88

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

28.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 18

Бүгд: 88

79.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

29.Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 15

Бүгд: 89

83.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

30.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 18

Бүгд: 89

79.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

31.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 16

Бүгд: 89

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

#### ***Холбогдуулан боловсруулсан:***

32.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 16

Бүгд: 89

82.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

33.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 13

Бүгд: 89

85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

#### ***Хамт өргөн мэдүүлсэн:***

34.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
Татгалзсан: 14  
Бүгд: 89

84.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

35.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 15  
Бүгд: 89

83.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

36.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 13  
Бүгд: 89

85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

37.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 17  
Бүгд: 89

80.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

38.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
Татгалзсан: 14  
Бүгд: 89

84.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

39.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 13  
Бүгд: 89

85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

40.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77

Татгалзсан: 12

Бүгд: 89

86.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

41.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77

Татгалзсан: 12

Бүгд: 89

86.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

42.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77

Татгалзсан: 12

Бүгд: 89

86.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

#### ***Хамт өргөн мэдүүлсэн:***

43.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 14

Бүгд: 89

84.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

#### ***Хоёр.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай асуудал /үргэлжлэл/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч Э.Анар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

*Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох саналаар нууц санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77  
Татгалзсан: 14  
Бүгд: 91  
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:30/

*Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Зарим Байнгын хорооны даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Б.Бейсен нар үг хэлэв.

**С.Бямбацогт:** 1.Байнгын хорооны саналаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Мэндбаярын Мандхайг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77  
Татгалзсан: 18

Бүгд: 95  
81.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 21  
Бүгд: 95  
77.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, Улсын Их Хурлын *тогтоолыг танилцуулав.*

*Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:45/*

*Уг асуудлыг 10 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Дөрөв.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны даргад нэр дэвшигч Н.Мягмар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт Б.Баясах нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 1 өдрийн завсарлага өгөв./10:52/

***Тав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын

Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл тайлангийн хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Мөнхсоёл, Д.Энхтүвшин, Л.Соронзонболд, Да.Цогтбаатар, Ө.Шижир, Ж.Батсуурь, Д.Ганбат, Г.Очирбат, М.Мандхай, Ж.Баярмаа, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 12 цаг 04 минутаас 14 цаг 49 минутад хуралдааныг удирдав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:28/

**Зургаа. “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл тайлангийн хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин танилцуулав.

Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Л.Соронзонболд, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Да.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:56/*

***Долоо.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран, мөн газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Г.Жавхлантөгс, С.Тэнгис, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн газрын зөвлөх Ж.Мягмарсүрэн, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга Б.Зандан нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:33/*

***Ес.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн Д.Долгорсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Эрдэнэбат, А.Ганбаатар, Ө.Шижир, О.Номинчимэг нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:09/*

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 49 минутаас 15 цаг 41 минутад хуралдааныг удирдав.

**Арав.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:25/*

**Арван нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Мөнхбаатар, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ч.Мөнх-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга

бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Э.Бямбажав, Цагдаагийн ерөнхий газрын Залилах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга Д.Сайнжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, Хяналт шалгалтын газрын зөвлөх Х.Хэрлэн нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн тавьсан асуултад Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 15 цаг 41 минутаас 17 цаг 44 минутад хуралдааныг удирдав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:42/*

***Арван хоёр.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцын бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Сүхбат, Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд, Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Б.Буяндэлгэр, Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул, мөн банкны Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ажлын 1 өдрийн завсарлага өгөв./15:46/

***Арван гурав.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Сүхбат, Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд, Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Б.Буяндэлгэр, Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул, мөн банкны Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ажлын 1 өдрийн завсарлага өгөв./15:49/

***Арван дөрөв.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв нар хариулж, тайлбар хийв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 1 цагийн завсарлага өгөв./16:03/

***Арван тав.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хэвлэлийн төлөөлөгч бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга Ц.Ганзориг, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Д.Гүн-Үйлс, Д.Мягмарсүрэн, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хэвлэлийн төлөөлөгч бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга Ц.Ганзориг, Монгол Улсын Засгийн газрын саналыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Монгол Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Нэр дэвшигч болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Энхтуяа, Ө.Шижир, О.Саранчулуун, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Д.Гүн-Үйлс, Д.Мягмарсүрэн, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт*

явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:09/

**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг асуулт, саналаар үргэлжлэв.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Л.Мөнхбаясгалан, Д.Үүрийнтуяа, Б.Уянга нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:27/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 17 цаг 34 минутаас хуралдааныг удирдав.

**Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хоёр дахь хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Монголбанкны дэд ерөнхийлөгч

Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл тайлангийн хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

**С.Бямбацогт:** Дэд хорооны саналаар “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 35

Бүгд: 104

66.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, С.Замира, Ж.Энхбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 104 гишүүнээс 73 гишүүн дэмжиж, 70.2 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

**“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл тайлангийн хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

**С.Бямбацогт:** Дэд хорооны саналаар “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 28

Бүгд: 104

73.1 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

**Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Г.Жавхлантөгс, С.Тэнгис, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн газрын зөвлөх Ж.Мягмарсүрэн, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга Б.Зандан нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх нар байлцав.

*Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт**

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 28  
Бүгд: 104  
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийн **“ХАРИУЦЛАГА”** гэснийг **“ГОМДОЛ ГАРГАХ,”** гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг 7 дугаар зүйлтэй нэгтгэн, 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“5 дугаар зүйл.Гомдол гаргах эрх**

5.1.Бизнес эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх, бизнес эрхлэгчид учирсан хохирлыг хуульд заасны дагуу нөхөн төлөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 26  
Бүгд: 104  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “үндэслэлгүй хяналт шалгалт хийх,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 26  
Бүгд: 104  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

***Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний***

**өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн Д.Долгорсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

*Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**С.Бямбацогт:** 1. Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах 85.43, 96.14 дүгээр зүйл, үндэсний код нэмсүгэй:

**1/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл:**

|    |       |            |                                                                                                    |    |
|----|-------|------------|----------------------------------------------------------------------------------------------------|----|
| 85 | 85.43 | 85.43      | Энэ бүлгийн бусад газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат.        | 5  |
|    |       | 8543.40.00 | Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн             | 20 |
|    |       | 8543.90.00 | Эд анги:<br>Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн | 20 |
|    |       |            | Бусад                                                                                              | 5  |

”

**2/96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл:**

“

|    |       |             |                                                                                             |    |
|----|-------|-------------|---------------------------------------------------------------------------------------------|----|
| 96 | 96.14 | 96.14.00.00 | Тамхины гаанс (гаансны толгой орно) болон сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн эд анги. | 20 |
|----|-------|-------------|---------------------------------------------------------------------------------------------|----|

”

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 26  
Бүгд: 104  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 31  
Бүгд: 104  
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.хамрын тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхинаас бусад тамхи, татах төхөөрөмж, түүний эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх; гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77  
Татгалзсан: 27  
Бүгд: 104  
74.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтаас доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэрийг хасах:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 28  
Бүгд: 104  
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

***Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

**С.Бямбацогт:** Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 39

Бүгд: 104

62.5 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, М.Мандхай, Г.Очирбат, Б.Хэрлэн, Да.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 104 гишүүнээс 70 гишүүн дэмжиж, 67.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

***“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Мөнхбаатар, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ч.Мөнх-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга

бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Э.Бямбажав, Цагдаагийн ерөнхий газрын Залилах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга Д.Сайнжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, Хяналт шалгалтын газрын зөвлөх Х.Хэрлэн нар байлцав.

**С.Бямбацогт:** Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 33

Бүгд: 104

68.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

***Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

*Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

***1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**С.Бямбацогт:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.38.“маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардлагатай хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэх Монгол Улсын иргэнд олгох эрхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
 Татгалзсан: 45  
 Бүгд: 104  
 56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29<sup>1</sup> дүгээр зүйл, 29<sup>2</sup> дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“29<sup>1</sup> дүгээр зүйл.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох**

29<sup>1</sup>.1.Ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн олборлож байгаа эсэхэд хяналт тавих, нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг тодорхойлох, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатны төлөвлөлтөд хяналт тавих, уурхайн хажуу болон хаягдал овоолгын чулуулгийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29<sup>1</sup>.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

**29<sup>2</sup> дугаар зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа**

29<sup>2</sup>.1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

29<sup>2</sup>.1.1.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолгын хэмжээ, уулын ажилд хамрагдсан талбай, ил болон далд уурхайн төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

29<sup>2</sup>.1.2.ашигт малтмалын ордын нөөцийг хэрхэн ашиглаж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргах;

29<sup>2</sup>.1.3.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно;

29<sup>2</sup>.1.4.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан хөндлөнгийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцах;

29<sup>2</sup>.1.5.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан үйл ажиллагааг хөндлөнгийн хараат бусаар хэрэгжүүлэх.

29<sup>2</sup>.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах заавар, шаардлагыг төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 39  
Бүгд: 104  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 39  
Бүгд: 104  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нартай зөвшилцсөнөөр хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 44  
Бүгд: 104  
57.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглоно” гэснийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох” гэж өөрчилж, 64<sup>1</sup> дүгээр зүйлийн 64<sup>1</sup>.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62  
Татгалзсан: 42  
Бүгд: 104  
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 38  
Бүгд: 104  
63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
 Татгалзсан: 39  
 Бүгд: 104  
 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
 Татгалзсан: 39  
 Бүгд: 104  
 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрээс “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
 Татгалзсан: 40  
 Бүгд: 104  
 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.*

***Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал санал хураалтаар үргэлжлэв.***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хэвлэлийн төлөөлөгч бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга Ц.Ганзориг, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Д.Гүн-Үйлс, Д.Мягмарсүрэн, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

*Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
 Татгалзсан: 38  
 Бүгд: 104  
 63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Чулуунбаатарын Батцэнгэлийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
 Татгалзсан: 92  
 Бүгд: 104  
 11.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Дашзэвгийн Мягмарсүрэнг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
 Татгалзсан: 29  
 Бүгд: 104  
 72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Сандагийн Эрдэнэ-Одыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
 Татгалзсан: 29  
 Бүгд: 104  
 72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Маналжавын Төрманлайг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
 Татгалзсан: 45  
 Бүгд: 104  
 56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** Сүхбаатарын Алтанцэцэг, Доржсүрэнгийн Батсүх, Ванжилын Бат-Эрдэнэ, Наваанпэрэнлэйн Жанцан, Дэмбэрэлийн Өлзийбаатар нарыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
 Татгалзсан: 38  
 Бүгд: 104  
 63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

“Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:06/

*Уг асуудлыг 18 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 13 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 8 цаг 06 минут үргэлжилж, 126 гишүүнээс 106 гишүүн хүрэлцэн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 06 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 00 минут*

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд ирцийг танилцуулъя. Ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн буюу 54 хувийн ирцтэй ирц бүрдсэн тул чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Долоо хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хэлэлцэх эсэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

“Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Эдийн засгийн байнгын хорооны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Анарын гаргасан горимын санал дэмжигдэж хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Энэ уг нь их чухал тогтоол байсан юм сан. Анар гишүүн яагаад ийм санал гаргасан юм бол? Өвөл Улаанбаатар хот хөлдөх юм бол тэгээд Анар гишүүн хариуцлага хүлээх нь байна шүү дээ.

Төрсөн өдөр нь тохиож буй Улсын Их Хурлын гишүүдийн тухай.

07 дугаар сарын 02-нд Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Нямтайширын Номтойбаяр, Лхагвын Мөнхбаатар нар төрсөн. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Нямтайширын Номтойбаяр, Лхагвын Мөнхбаатар нарт Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 15 асуудлыг хэлэлцэнэ.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 43 хуулийн төсөл байгаа. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Санал хураалтуудаар чуулган эхэлнэ.

2.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

3.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

4.“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

5.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

6.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

8.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүнийг түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

9.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

10.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

11.Орон сууцын санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ.

12.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

13.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн томилох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

14.Бусад асуудлын хүрээнд зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

15.Бусад асуудлын хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6.9-д нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгээс 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хэлэлцэх асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулах тухай асуудлаар 209 дугаартай албан бичиг ирүүлснээ уншиж танилцуулъя.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа санал хүргүүлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.12, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтуудыг үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх, мөн Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хууль эцэслэн батлах санал хураалтын дараа нэмэх горимын санал гаргасан тул шийдвэрлэж өгнө үү. Монголбанкны дэд ерөнхийлөгчийн дараа тийм үү? Бүлгийн дарга Батжаргал гэсэн бичиг иржээ. Бичгийг уншиж танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6.10-д хуралдаан даргалагч тухайн хуралдааныг нээж хэлэлцэх асуудалтай холбоотой нам, эвслийн бүлгээс ирүүлсэн горимын саналыг уншиж танилцуулан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Энэ талаар хэлэлцүүлэг явуулахгүй гэж заасан байгаа. Үүний дагуу санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя гишүүд анхааралтай байгаарай. Ирц бүртгэлийн санал хураалт. Гишүүд байр байрандаа суугаад суудлаа эзэлчихье. Ирц бүртгэлийн санал хураалт.

81 гишүүн ирцэд орсноос 69 гишүүн чуулгын танхимд хүрэлцэн ирсэн байна. Энэ “татгалзсан” гарч байгаа гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Санал хураалт явуулъя.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын чуулганы 07 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хэлэлцэх тов, дараалалд өөрчлөлт оруулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

81 гишүүнээс 61 гишүүн буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараалалд өөрчлөлт оруулах нь байна шүү дээ.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж, зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх, даргыг томилох тухай, Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлуудыг хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт, мөн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн дараа хураана. Хэлэлцэхээр шийдвэрлэлээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл эцэслэн батална.**

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хургалт бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Санал хураалт явуулъя.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

84 гишүүнээс 73 буюу 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 73 буюу 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 73 буюу 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 70 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 71 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 71 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 69 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

84-өөс 72 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 71 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 71 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 69 буюу 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 72 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 69 буюу 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 72 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 68 буюу 79 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

87-гоос 72 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Холбогдуулан боловсруулсан

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

87-гоос 71 буюу 81 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

87-гоос 73 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

87-гоос 72 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

87-гоос 73 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

88-аас 71 буюу 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

88-аас 71 буюу 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

88-аас 70 буюу 79 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 74 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 71 буюу 79 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 73 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Холбогдуулан боловсруулсан

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 73 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уур амьсгалын тухай хууль эцэслэн батлагдлаа.

Монгол улс бас энэ их чухал хууль баталж байгаа. COP17-гийн өмнө бас хийх ажилтай бас байгаль орчин, уур амьсгал, цөлжилттэй тэмцэхдээ бас маш чухал хуультай боллоо гэдгийг бас гишүүддээ онцолж хэлье. Баталсан гишүүддээ баярлалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 76 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 75 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 74 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 76 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 72 буюу 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

89-өөс 75 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 76 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 77 буюу 86 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 77 буюу 86 хувийн саналаар энэ хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар яаралтай горим горимоор өргөн мэдүүлсэн. Ариунзаяа нарын гишүүдээс санаачилсан. Түвшин нарын гишүүд санаачилсан. Нэгтгээд ингээд хэлэлцээд баталлаа. Нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэх, зардал нь үр ашигтай болох, нийгмийн даатгалын санг шимтгэл төлөгчдийн хөрөнгө бас зөв зохистой зарцуулагдах, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх ийм сайхан боломжийг бас бий болгож өгсөн хууль батлагдлаа. Тэгээд нийт гишүүдээ баярлалаа.

Дараагийнх Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг ахалсан Булгантуяа гишүүндээ баярлалаа бас орхичихсон байна шүү уучлаарай.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 77 буюу 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

89-өөс 75 буюу 84 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн тамхины импортын татварыг онцгой татвар болгох энэ хуулийн төсөл батлагдлаа. Хууль тогтоолын төслүүдийг баталлаа.

Түрүүн бас төрийн өмчит компанийн засаглал, бүтээмж, ил тод байдлыг сайжруулах, төрийн өмчит компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг баталсан. Энэ их олон жил яригдсан, олон Их Хурал, олон Засгийн газар дамжсан хуулийг бас баталсан Их Хурлын гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийг нь ахалж ажилласан манай Үүрийнтуяа гишүүн, Сайнзориг нарын гишүүддээ их баярлалаа. Номинчимэг гишүүний хууль арай яваагүй байгаа. Номинчимэг гишүүн бас онцгой татвараа нэмье гэж санаачилга гаргасан. Дараагийн асуудалдаа оръё.

10.26 цаг

**Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал Ардчилсан намын бүлэг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ажлын цаг дуустал завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үү? Жаргалан гишүүн, бүлгийн дэд дарга.

**Б.Жаргалан:** Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн томилгооны асуудал дээр өчигдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан боловч та бүхэн цөөхөн цагийн завсарлага өгсөн. Тэгээд энэ томилгоотой холбоотой бид нар бас бүлэг дээрээ нэр дэвшигчийг дуудаж уулзах гэх мэтчилэн асуудлууд байгаа.

Түүнээс гадна энэ завсарлага өгөх дээрээ тухайлах юм бол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс энэ нийслэлийн газар олголттой холбоотой Түр хянан шалгах хороо байгуулах асуудал дээр завсарлага өгч байгаа цаг хугацаа, тэгээд энэ цөөнхийн бүлэгтээ өгч байгаа цаг хугацаагаа ч гэсэндээ та бүхэн бодмоор байна. Тэгэхээр ийм ялгамжтай бас хандаж болохгүй. Бид нар чинь бас ийм үндэслэлтэй болоод завсарлага хүсэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ завсарлагыг бас сунгах хүсэлтэй байна.

**С.Бямбацогт:** Завсарлага өгөхдөө бүлгүүдийн дарга нар хоорондоо бас ярилцаад, ойлголцоод, мөн бас хууль санаачилсан гишүүд, оруулсан гишүүд маань ярилцаж ойлголцоод бас өгч байгаа шүү. Энд ямар нэгэн байдлаар тийм ялгамжтай өгч байгаа зүйл байхгүй.

Энэ завсарлага өгөх хугацааг сунгах боломжгүй байна. Олон хоног энэ нийтийн сонсгол хийсэн, томилгооны сонсгол хийсэн, хэлэлцүүлгүүд хийсэн, тэгээд хангалттай хийсэн. Тийм болохоор завсарлага сунгах, хугацаа сунгах боломжгүй. Санал хураалт явуулъя.

Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд нууц санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлтгэе.

Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилох саналыг дэмжье гэсэн саналаар, томьёоллоор нууц санал хураалт явуулъя.

Санал хураалтад оролцсон 91 гишүүнээс 77 буюу 84 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай, Төв банкны, Монголбанкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалдаа оръё.

10.31 цаг.

**Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**С.Одонтуяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга У.Отгонбаяр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг нэр дэвшүүлж хэлэлцүүлээ.

Мэндбаярын Мандхай нь 1981 онд төрсөн. Нөхөр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1998 онд Монгол Улсын Их сургуулийн дэргэдэх Хэл бичгийн гүнзгийрүүлсэн лицей бүрэн дунд сургууль, 1998-2002 онд Аялал жуулчлалын удирдлагын дээд сургуулийг Эко аялал жуулчлалын менежмент мэргэжлээр, 2003-2005 онд Их Британи Улсын Вэст Лондон коллежийг Аялал жуулчлалын удирдлага, 2007-2008 онд Их Британи дахь Америкийн Олон Улсын Их Сургуулийг тус тус төгссөн. Бизнесийн удирдлагын магистр. 2023 оноос Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн докторантаар суралцаж байна.

Мандхай нь 2006-2008 онд Англи Улсын “Office of Fair Trading” Засгийн газрын агентлагт Хэрэглэгчийн зөвшөөрөл комплайнс хариуцсан мэргэжилтэн, 2008-2009 онд Ази-Номхон далайн хөрөнгө оруулалтын партнерс компанийн Маркетинг ба төсөл хариуцсан менежер, 2009-2011 онд “Нортенсек” компанийн Бизнес хөгжил хариуцсан захирал, 11-ээс 15 онд “Оюу толгой” компанийн Нийгмийн төслүүд хариуцсан төслийн менежер, 15-аас 16 онд “Нүүдэлчин” групп компанийн Эрчимжсэн мал аж ахуйг нутагшуулах төсөл хариуцсан захирал, 16-аас 18 онд Монголжин Стратегийн зөвлөх компанийн зөвлөх, 16-аас 21 онд “Сүү” хувьцаат компанийн захирал, 21-ээс 23 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Бизнес ба Хүний эрх” төслийн Үндэсний зөвлөх, 2023-аас 24 онд Социал Демократ Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, 24 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 25 оноос Монгол Улсын Их Хурлын Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны даргаар ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандухайг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 76.2 хувиар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны дарга сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал дарга Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтад заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хуралд сонгогдсон, ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг нэр дэвшүүлж танилцуулсан бөгөөд Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарын нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Баярбаатар гишүүнд баярлалаа. Байнгын хороо хорооны даргад нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангаар тасаллаа. Мөнхбаясгалан гишүүний микрофон өгье.

**Л.Мөнхбаясгалан:** Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен бол 2 жилийн турш маш амжилттай ажилласан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний хуульд нэмэлт, өөрчлөлт, Хөдөө аж ахуйн тухай хуулийн анхдагч хуулийн төсөл, Хүнсний тухай хуулиуд гэх зэрэг маш том ач холбогдолтой хуулиуд бол эцэслэн батлагдаж байсан.

Одоо Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль мөн эцэслэн батлагдсан. Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Усны тухай хууль

гээд маш том хуулиуд яг бэлтгэл ажил Байнгын хороон дээр хангагдаад явж байгаа.

Утааны ерөнхий сонсгол, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн ерөнхий сонсго, Говийн усны тухай сонсголууд ингээд нийтдээ 6 удаагийн том сонсголуудыг хийж, тун амжилттай ажилласан.

Бейсен гишүүн бол маш эв нэгдлийг хичээж ажилласан. Байнгын хорооны бүх гишүүдэд ижил тэнцүү хандаж байсан. Ирцийг маш өндөр байлгасан. Мөн 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулагдах Нэгдсэн Үндэстний Байгууллагын талуудын конвенцын 17 дугаар бага хурлын бэлтгэл ажлыг бас их амжилттай хийж байгаа. Бейсен гишүүн бол хүний гавьяат эмч. Онгоцонд бие нь муудсан хүний амь насыг аварч, Монголын эмч нарын болон Монголын Улсын Их Хурлын гишүүдийн нэр хүндийг маш өндөрт хүргэж ингэж ажилласан гишүүн юм.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон даргаар 2 жил ажилласан эрхэм журмын нөхөр Буланы Бейсен танд амжилт хүсэж, цаашдынх нь ажил, хөдөлмөр, улс төрд нь бас амжилт хүсэн ерөөе.

Бейсен гишүүний халааг авч байгаа Мандхай гишүүн бол хөдөө аж ахуйн салбарт маш их үр бүтээлтэй ажиллаж байгаа ийм гишүүн байгаа. Бейсен гишүүн бол энэ Байнгын хорооны даргаар ажиллахдаа маш том ранк тогтоож өгсөн гэж боддог. Мандхай гишүүнийг бас энэ ранкийг цааш нь авч явж, гишүүдтэй ижил тэнцүү хандаж, том том асуудлууд дээр сонсгол хийх ажлын хэсгийг амжилттай зохион байгуулж ажиллана гэдэгт танд итгэж байна. Ингээд 2 гишүүндээ амжилт хүсье.

**С.Бямбацогт:** Буланы Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ өглөөний мэндийг хүргэе. Би Байнгын хорооны даргаар 2 жил ажиллалаа. 1 жил ажиллаад солигдох ёстой байсан тэгээд 2 жил ажиллуулсан бүх гишүүд, Байнгын хорооны гишүүддээ, ажлын албаныхандаа бас баярлалаа гэж хэлье.

Энэ 2 жилийн хугацаанд манайх олон хуулийн төслүүдийг хэлэлцээд баталлаа. Энд хамтран ажилласан Байнгын хорооны бүх гишүүддээ, Ариунжаргал тэргүүтэй манай ажлын албаныхандаа маш их баярлалаа гэж хэлье. Бас би хуулийн тэр тогтоол, мэддэг асуудлууд дээр манай Байнгын хорооны бүх гишүүд хамтран ажилласан. Нөгөө талаар өчигдрийн тэр Байнгын хорооны даргыг сонгох асуудал дээр Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн жендерийн асуудлыг бодож ингээд Мандхай гишүүнд зам тавьж, өгч нэрээ татсанд бас Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнд бас баярлалаа гэж хэлье.

Нөгөө талаар одоо тулгамдаж байгаа олон асуудлууд байж байгаа. Хөдөө аж ахуйн талын хуулиуд, байгаль орчны талын хуулиуд, урьд 8 сард болох СОР17-гийн хурал байгаа. Энэ ер Мандхай гишүүнд захих юм энэ Монгол Улсыг олон улсын түвшинд харуулах дэлхийн 190 гаруй орноос төлөөлөгчид ирэх юм. Энэ дээрээ сайн ажиллаарай. Байнгын хороо СОР Үндэсийн хорооны хурал болсон. Төлөвлөгөө нь гарчихсан байгаа. Нөгөө талаар энд том том төслүүдийг

хэрэгжүүлэх талын хэлэлцээ явагдах юм байна. Энэ дээр хамтарч ажиллаарай гэдгийг хэлье. Та бүгд баярлалаа.

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж суудалдаа суугаарай. Суудалдаа сууцгаая. Санал хураалт.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 77 гишүүн 81 хувийн саналаар Мандхай гишүүн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга боллоо. Баяр хүргэе.

Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

95 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 77 хувийн саналаар Мөнхбаатар гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга боллоо. Баяр хүргэе.

Байнгын хорооны даргаас сонгох саналыг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны дарга сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот. “Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар тус тус сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын, Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулгын саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулга сонссондоо тооцлоо. дараагийн асуудалдаа оръё.

10.45 цаг.

### **Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай саналыг та бүхэнд танилцуулъя. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт Хорооны дарга, Нарийн бичгийн даргыг хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно гэж заасныг үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Нэргүйн Мягмарыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилуулахаар санал болгож байна.

Нэргүй овогтой Мягмар нь 1976 онд Булган аймгийн Дашинчилэн суманд төрсөн. 1998 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг Эрх зүйч ба мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 1999 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг хууль зүйн магистр, 2005 онд Америкийн Их Сургуулийн Вашингтоны хуулийн коллежийг Хууль зүйн магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Тэрээр 1999-2006 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуульд багш, 2007-2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яаманд ахлах мэргэжилтэн, газрын дарга, 2009-010 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, 2010-2012 онд “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанид менежер, 2012-оос 14 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, 14-өөс 16 онд Америкийн Нэгдсэн Улсын Санфранциско хотод суугаа Ерөнхий консулын газарт Консул, 2017-2018 онд Азийн хөгжлийн банкны төслийн менежер, 2018-2023 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, 2023-аас 24 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга, 2024-өөс 26 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2026 оноос Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргаар ажиллаж байна.

Нэргүйн Мягмар нь төрийн албанд удирдах албан тушаал хашиж байсан, мэргэжлийн өндөр боловсрол, мэдлэг, мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлагатай зэргийг харгалзан түүнийг Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилуулах саналыг оруулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**С.Бямбацогт:** Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт Хорооны дарга, Нарийн бичгийн даргыг хорооны гишүүд дотроос Улсын Их

Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Нэргүйн Мягмарыг томилуулах саналыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурлын 01/8059 тоот албан бичгээр Улсын Их Хуралд ирүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг баримтлан 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Нэргүйн Мягмарыг Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлаар гаргасан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

**С.Бямбацогт:** Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Нэргүйн Мягмар хүрэлцэн ирсэн байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчийн асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Баярмаа гишүүнээр тасаллаа. Баярмаа гишүүнээр тасалсан байгаа. Бүлгийн дэд дарга Жаргалан. Микрофон өгье.

**Б.Жаргалан:** Монгол Улсын сонгуулийн төв байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо бол Монгол Улсад чөлөөт, шударгаар төрийн сонгууль зохион байгуулах ардчилсан тогтолцооны маш чухал бүрэлдэхүүн хэсэг болсон ийм байгууллага. Энэ жил Сонгуулийн ерөнхий хорооны 9 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан буюу дуусаж байгаа.

Тэгээд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ямар зарчмын байр суурьтай байсан бэ гэхлээр энэ Сонгуулийн ерөнхий хорооны 9 гишүүн бүтэн болж байж, бүрэлдэхүүн нь бүтнээрээ томилогдож байж энэ бүтцийн өөрчлөлтүүд хийх буюу орон тооны гишүүн болох Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Нарийн бичгийн дарга томилох нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаад байгаа.

Тэгэхээр одоогоор болохлоор Сонгуулийн ерөнхий хорооны 1 гишүүний хугацаа нь бол бүтэн дууссан байгаа. Дахиад 2 гишүүний хугацаа 08 сарын 28-нд дуусахаар байгаа. Тэгэхээр энэ бүтэц, зохион байгуулалтын асуудлаа энэ бүрэлдэхүүн нь бүтэн болсны ар дээр ер нь бол бас хийх нь зарчмын асуудал.

Яагаад вэ гэвэл энэ сонгуулийн байгууллагын эрх зүйн байдал бол Монголын ардчиллын бас маш том чухал зүйл гэдэг дээр бол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг бол хатуу байр суурьтай байгаад байгаа учраас энэ томилгоо дээр 3 хоногийн завсарлага хүсэж байна. Тэгээд өнөөдөр бол ээлжит бусаар Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг өглөө 9 цагт зарлаад одоо шууд чуулган руу оруулаад ирчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр манай бүлгээс бол 3 хоногийн завсарлага хүсье.

**С.Бямбацогт:** Жаргалан гишүүний хэлж байгаа бас Сонгуулийн ерөнхий хорооны 1 жил, 26-нд үндсэндээ 9 гишүүний бүрэн эрхийн хугацаа бүгд дуусаж байгаа. Хугацаа нь дуусчихсан 6 гишүүнийг бид нар сая ингээд томилоод 6 гишүүн нь ажилдаа орсон. 2 гишүүнийх нь хугацаа 8 сард дуусна. Ингээд үндсэндээ одоогоор бол бүрэн 9 гишүүнээс 8 гишүүнийх нь бүрэн эрхийн хугацаа нь ингээд бүрэн эрхийн хугацаандаа үүрэг гүйцэтгэх бололцоотой болсон.

Сонгуулийн ерөнхий хороо бид 27 оны сонгууль, 28 оны сонгууль гээд олон чухал сонгуулийг зохион байгуулна. Хурдан бүтэц бүрэлдэхүүнтэй болох асуудлаа Их Хурал энэ ямар ч байсан энэ хаврын чуулгандаа шийдлээ. Даргатай болох асуудлаа бас хурдан шийдэхгүй бол даргагүй үндсэндээ хагас жил гаруй явчихлаа шүү дээ даргагүй.

Тийм болохоор даргын асуудал хурдан шийдье гэж байгаа. Сонгуулийн ерөнхий хороо чинь даргатай болж байж бас нөгөө төсөв, ирэх оны төсөв, сонгууль зохион байгуулах, хар машины худалдан авалт гээд олон асуудлууд шийдэгдэнэ. Тийм болохоор та бүхэн маань бас зөв ойлгоорой. Тэгэхээр та бүхэн ярилцах шаардлагатай бол 1 өдрийн завсарлага өгье. Та бүхэн маргааш гэхэд асуудлаа бас ярилцаад ойлголцоод оруулаад ирээрэй гэж хүсье.

Ардчилсан намын бүлэгт 1 хоногийн завсарлага өглөө. Дараагийн асуудалдаа оръё.

10.52 цаг.

**Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Даваагийн Цогтбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Да.Цогтбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж хоёр дахь

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Улсын Их Хурлын байнгын хороодод шилжүүлсэн.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь заалтад заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Үндэсний аудитын газраас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтад заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж, Улсын Их Хуралд дүгнэлтээ хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 онд 33 их наяд 179.2 тэрбум төгрөг. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх орноос 2.1 хувиар өсөж, 30 их наяд 303.1 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2.4 хувиар өсөж, 31 их наяд 331 тэрбум төгрөг болж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, ДНБ/дотоодын нийт бүтээгдэхүүн/-ий 1.1 хувьтай тэнцэж байна гэж дүгнэжээ.

Түүнчлэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад заасны нэгдсэн төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг хангаагүй, жил бүр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байгаа нь төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдах эрсдэлтэйг анхаарах. Эдийн засгийн өсөлт саарч гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын үнэ буурсантай холбоотойгоор нэгдсэн төсвийн орлого тасарсан.

Мөн Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд бүрэн чиглээгүй, зарим хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжигдээгүй зардлыг дараа жилийн төсвөөс олгосон зэрэг төсөвт ачаалал үүсэх болон татварын системд бүртгэлтэй, олон жилийн насжилттай хуримтлагдсан өрийн дүн нэмэгдсэнээр татварыг шударга төлөх зарчим алдагдаж, улсын төсвийн орлого тасрах зэрэг эрсдэл нэмэгдсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төлөвлөлт дэх хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөх, хэрэгжилтдээ үнэн, зөв тайлагнах, үр дүнг оновчтой үнэлэх шаардлагатай. Мөн захиалагч байгууллагын хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэйг анхааруулсан зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 32, хязгаарлалттай 28 дүгнэлт өгсөн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгч, холбогдох байгууллагуудад зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтэд нэгдсэн төсвийн нийт зарлагыг нийгэм эдийн засгийн бодит үр дүнтэй холбон тооцож, үр дүнд чиглэсэн тооцоолол, тогтолцоонд шилжиж, хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын төсвийн хоорондын уялдаа сул, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг улсын хөгжлийн бодлогын хэрэгжилттэй уялдуулан дүгнэхгүй байгаа нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг нь үр дүнг тодорхойлоход хүндрэлтэй байгаа болон мөчлөг дагасан төсвийн бодлого нь төсвийн гүйцэтгэл дэх макро эдийн засгийн нөлөөллийг нэмэгдүүлж байгаа тул дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баримтлах, төсвийн тухай шаардлагыг мөрдөж ажиллах, орон нутгийн төсвийн нэгдсэн төсөвт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байгаад холбогдох байгууллагууд нь дүгнэлт хийх шаардлагатай зэрэг анхаарах асуудлууд байгааг онцолсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороод 2025 оны 06 дугаар сарын 23, 24, 26-ны өдрүүдэд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг ирүүлснийг танилцуулж байна.

1.Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаас Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх цаглаврыг өөрчлөх, хэлэлцүүлгийн хугацааг уртасгах, нээлттэй хэлэлцүүлэг болох, хяналт хариуцлагын тогтолцоог бий болгох.

2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаас сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэхдээ төсөвт өртгийг нэмэгдүүлж, зураг төсөв, гүйцэтгэлтэй холбоотой ноцтой зөрчлүүд гаргаж байгаад хариуцлага тооцох. Мөн Хүнсний хувьсгал, Цагаан алт болон Шинэ хоршоо хөтөлбөрүүдийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжих шалгуур үзүүлэлт тодорхойгүй зэргийг анхаарч, төсвийн хөрөнгө оруулалт, татаас болон хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг бодитой, ойлгомжтой болгох, хөтөлбөрүүдэд олгосон татаасыг хэрэгжилтийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шинээр ажлын байр нэмэгдүүлэх зэрэг бодит дүнтэй уялдуулан тайлагнадаг байх.

3.Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаас төрийн өмчит хуулийн этгээдүүдийн удирдлагын цалин хөлс, урамшууллыг ажлын бүтээмж, үр дүн зэрэгтэй уялдуулан тогтоох. Мөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах.

5.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаас гүйцэтгэсэн ажлын санхүүжилтээ авч чадахгүй байгаа төслүүд, мөн тендер зарлах хугацаа хоцорсонтой холбоотойгоор сургууль, цэцэрлэг барих төсөл хэрэгжихгүй байгааг анхаарах.

5.Төсвийн байнгын хорооны хуралдаанаас төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр илэрсэн зөрчил, дутагдлыг бууруулах, төсвийн хөрөнгө болон өр

төлбөрийн удирдлагыг сайжруулах, санхүүгийн бүртгэл, тайлагналын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн бүтцэд бодитой өөрчлөлт хийх шаардлагатай талаар.

6.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаас хүний эрүүл мэндийн байдал, үйл ажиллагааны чадавх, нийгмийн оролцоо болон орчны нөлөөллийг цогцоор нь үнэлдэг олон улсын аргачлалыг нэвтрүүлэх, боловсролын салбарын хүртээмжийг сайжруулах. Мөн төрийн худалдан авалт, тендер шалгаруулалт нь хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцсэн, ил тод, шударга, үр ашигтай явагдсан эсэхэд хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох.

7.Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаас төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, улсын хөгжлийн г жилийн төлөвлөгөө болон төсвийн уялдааг хангах, Засгийн газрын өрийн тогтвортой байдал болон гадаад валютын ханшийн эрсдэлийг бодитойгоор тооцоолох, мөн орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нь дараа жилд шилжүүлэн зарцуулах одоогийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай гэсэн саналуудыг гаргасан байна.

8.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц төсвийн зарлагын гүйцэтгэлийг, эсхүл хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн аль үзүүлэлтүүдийг нь ашиглаж төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг үнэлэн дүгнэх болон төсвийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн үр дүнгийн хоорондын уялдааг хангах, бодлого зохицуулалтын асуудлаар, мөн төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хөрөнгө оруулалтын зардлын нийгэм эдийн засагт үзүүлэх үр дүн, өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Түвшин төрийн өмчит хуулийн этгээдүүд болон төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан, улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гэж 3 ангилан Улсын Их Хурлаар хэлэлцэх боломжтой эсэх, Улсын Монгол Улсын нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангаагүй бол хариуцлагыг хэрхэн тооцох, 2025 онд төсөвт тодотгол хийгээгүй нөхцөлд тухайн оны нэгдсэн төсвийн нийт орлогын хэдэн хувийг урсгал зардалд зарцуулахаар тооцоолол гаргасныг тодруулж, цаашид төсвийн урсгал зардлыг бууруулахтай холбоотойгоор ямар бодлого хэрэгжүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар төрийн өмчит хуулийн этгээдүүдийн удирдлагуудын цалин, төлөөлөн удирдах зөвлөлийн томилолт нь компанийн үр ашигтай уялдаж байгаа эсэх, эрчим хүчний салбарын санхүүгийн зөрчлийн талаар, төрийн өмчийн хуулийн этгээдүүдийн орлого, зарлага, үр дүн, тэдгээрт олгосон татаас, авлага, өр зээлтэй холбоотой асуудлын талаар тодруулж, асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батжаргал улсын эдийн засаг, төсвийн үзүүлэлт тэлж байгаатай холбогдуулан нэгдсэн төсөв болон улс, орон нутгийн төсвийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай талаар дурдаад Төсвийн

тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагуудыг хангуулахын тулд орон нутгийн төсвийн зарим үзүүлэлтүүдэд хязгаарлалт тогтоох, Засгийн газрын тусгай сангуудын хяналтыг сайжруулах, мөн Засгийн газраас төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны бодлого, чиглэл, орлого, зарлага болон ашигт ажиллагааны түвшинтэй холбоотой асуудлуудыг жил бүр Улсын Их Хуралд тайлагнадаг байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин төсвийн орлогыг бодитойгоор төлөвлөх, төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн зөрүүг бууруулж, энэ зөрүүг тодорхой түвшнээс хэтэрсэн тохиолдолд хариуцлага тооцдог байх, нэгдсэн төсвийн суурь зарлагын тэнцлийг хангуулах, урсгал зардлын бүтцийг оновчлох төсөл, арга хэмжээний бэлтгэлийг хангасны дараагаар гадаад зээлийг авч, ашиглалтыг сайжруулахад анхаарах. Мөн урт хугацааны өгөгдөлд суурилсан нэгдсэн төсвийн урсгал зардалд иж бүрэн шинжилгээ хийх, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа Монгол Улсын нэгдсэн төсөвт 5-10 жилийн хугацаанд хэчнээн хэмжээний төсөв зарцуулсан, ямар үр дүн гарсан талаар хандлагыг нь тогтоож, дүгнэлт хийх, Улсын төсвийн төсөл хэлэлцэх дэгийн талаар Улсын.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Минут нэмж өгье. Индрийн микрофоны минут сунгая.

**Да.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн ирэх оны төсвийн төсөлд тусгах төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтээ тодорхойлоход анхаарах, цаашид төсвийн ерөнхийлөн захирагч бүр хэчнээн хэмжээний төсөв зарцуулсан байдлыг хөтөлбөрийн хүрсэн үр дүнтэй уялдуулан тайлагнадаг байх. Мөн төрийн өмчит хуулийн этгээдүүдийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг хөрөнгийн өгөөж, нийгэм, эдийн засгийн үр дүн болон өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдтэй уялдуулсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд нь үндэслэн тооцдог аргачлалд суурилсан үнэлэх, зарцуулалтыг нэвтрүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат Төрийн хэмнэлтийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлууд хасагдах асуудлууд байгаа тул хуулийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай. Төсвийн тайланг жилийн дараа бус явцын тайланг тухай бүр олон нийтэд нээлттэй тайлагнадаг байлгахад анхаарах нь зүйтэй талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Цогтбаатар даргад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд. Мэндсайхан сайд хаа байна? Энхбаяр сайд дуудаарай. Ажлаа хийх ёстой шүү. Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Даваажавын Гантуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч. Энхтайван хаа байна? Энхтайван дэд ерөнхийлөгчийг дууд. Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлтийн инновацын газрын дарга, Найдангийн Цэвэлмаа Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Ганболдын Нандинжаргал Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны Төрийн нарийн бичгийн дарга, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баттулгын Батбямба Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүрэнчулууны. Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ерэн-Өлзий Хаа байна? Дуудаарай. Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Огнонгийн Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Төмөрбаатарын Сумьяа Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. Сумьяа хаа байна? Дуудаарай. Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Вандангийн Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын удирдлага, төлөөллийн албаны дарга, Батдоржийн Цэрэндэлгэр “Эрдэнэс Монгол” компанийн Санхүү, нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл, тайлагналын хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч. Сангийн сайд, Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий ирсэн байна. Төмөрбаатарын Сумьяа Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга энэ албан тушаалтнуудыг ажлаа хий гэж дуудъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны болон холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцдог болохыг анхааруулж байна. Тийм болохоор ирээгүй гишүүдээ ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад бас сануулж байна. Сайд нар бас төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын тайлан хэлэлцэж байгаа учраас хуралдаандаа бас оролцоорой.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Асуулт, үг хамтдаа шүү.

Батсуурь гишүүнээр тасаллаа. Бөхчулууны айн? Сарнай гишүүн, Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Болсон одоо биш Мандхай гишүүн уучлаарай Мандхай гишүүн. Бөхчулууны. Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Ерөнхий сайд суудалдаа суухыг урья. Би танд зориулж үг хэлэх гэж байна. 2025 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор аудитын дүгнэлтийн үр дүнд өөрийнхөө дүгнэлтийг хэлье.

2025 оны аудитын тайлан бол Учрал сайд аа та сандалдаа сууна уу би танд, та энэ гүйцэтгэл. Дарга аа би энэ яг 3 минут 35 секундэд бэлтгэсэн үг байгаа. Та шинээр минут өгнө үү. Шинээр минут өгчих. Дарга аа шинээр минут өгчих. Дарга аа шинээр минут өгчих. Их Хурлын дарга аа шинээр минут өгчих л дөө. Би энэ чинь миний яг энэ 3 минут 35.

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хүндэтгэн үзэх шалтгаантай бичиг ирүүлсэн байна. Бичиг нь хаа байна Агар-Эрдэнэ даргаа? Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Монголбанкны дэд ерөнхийлөгч дуудаарай Энхтайван.

**Б.Пүрэвдорж:** 2025 оны төсвийн гүйцэтгэл хийсэн аудитын дүгнэлттэй холбоотойгоор Пүрэвдоржийн дүгнэлт. 2025 оны аудитын тайлан бол 1 жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан биш ээ. Энэ бол Монгол улсын төсвийн тогтолцоонд хуримтлагдсан бүтцийн эрсдэлийн оношилгоо юм. Өнгөц харахад 2025 оны төсөв 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан нь хамгийн том асуудал мэт боловч аудитын тайлангийн бүх тооцоог нэгтгэн уншихад огт өөр дүн, дүр зураг гарч ирж байна. Алдагдал өөрөө биш түүнийг буй болгож буй бүтэц өөрөө их аюултай байгааг анзаарч өнгөрөхгүй бол болохгүй.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 21 удаа өөрчлөгдөж, дунд хугацааны төсвийн хүрээнд 1 жилийн дотор 3 удаа шинэчлэгдсэн нь төсвийн дүрэм, улс төрийн мөчлөгийг дагаж өөрчлөгдөж эхэлснийг харуулж байна. Орлого тасарсан ч 1.2 их наяд төгрөгийн татварыг урьдчилан авч төсвөө нөхсөн нь ирээдүйн орлогоор өнөөдрийн асуудлыг шийдэх хандлага тогтсоныг илтгэж байна. Хөгжлийн төлөвлөгөөний 328 төслийн дийлэнх нь төсөвгүй үлдсэн нь хөгжлийн

бодлого төсвөөсөө салсныг нотолж байна. Засгийн газрын өр, ДНБ-ий 39.4 хувьтай байгаа нь тайван харагдавч өрийн 95.7 хувь нь гадаад валютаар байгаа нь төсвийг ханшийн савлагаанд шууд хамааралтайтай болгож байна. Дэлхийн улс орноос харахад Грек төсвийн алдагдлаас биш олон жил хуримтлагдсан төсвийн сахилгын доройтлоос, Аргентин татварын урьдчилгаагаар төсвөө сайхан харагдуулсаар байснаас, Шри-ланка үндэсний мөнгөн дэвсгэртийн сулралаас үүдэн дефолтод хүрсэн юм. Харин Швед төсвийн хатуу дүрэм, зарлагын дээд хязгаарыг хуульчилснаар, Эстони төсвийн сахилга, цахим засаглалаар халамж, татвар, төсвийн удирдлагын нэг мэдээллийн системд холбосноор, Чили улс уул уурхайн мөчлөгөөс төсвөө хамгаалж, “structural balance rule” хэрэгжүүлснээр улс орноо хөгжилд хүргэсэн юм.

Улсыг дампууруулдаг гол зүйл нь өндөр өр биш юм. Өрийн буруу бүтэц. Том алдагдал биш юм аа. Тогтмол давтагдах буруу. Төсөв мөнгөний хомсдол биш юм аа. Засаглалын доройтол юм гэдгийг өнгөрсөн 10 жилийн парламентад орж ирсэн аудитын дүгнэлтээс харж болно. Монгол Улсын 2025 оны аудитын тайланд ч яг ийм анхааруулгыг өгч байна. Өнөөдрийн төсөв уул уурхайн орлогоор тэлж, урсгал зардлаар тогтож, өрөөр санхүүжиж, ирээдүйн татвараар нөхөгдөж, хөгжлийн бодлогоосоо аажмаар тасарч байна. Ийм бүтэц богино хугацаанд ажиллаж болох ч урт хугацаанд тогтвортой өсөлтийг бий болгодоггүй.

Хэрэв энэ бүтцийг өөрчлөхгүй бол дараагийн жилүүдэд төсвийн алдагдал хэдэн их наяд төгрөг байх нь хоёрдогч асуудал болж хувирна. Учир нь асуудал алдагдалтай биш, алдагдлыг дахин дахин үйлдвэрлэдэг тогтолцоонд оршиж байгаа. Тиймээс Монгол Улсад өнөөдөр шаардлагатай байгаа шинэчлэл нь, ээлжит тодотгол, шинэ татвар, эсвэл дахин нэрийн өрийн санхүүжилт биш юм. Харин төсвийн философиог өөрчлөх институцийн шинэчлэл юм.

Төсөв уул уурхайн үнэ өсөхийг хүлээдэг биш эдийн засгийн мөчлөгийг тэсвэрлэдэг байх ёстой. Төсөв улс төрийн амлалтыг хэрэгжүүлдэг хэрэгсэл биш үндэсний хөгжлийн урт хугацааны гэрээ байх ёстой юм.

2025 оны аудитын тайлангийн хамгийн том сургамж нь 1 их наяд төгрөгийн алдагдал биш харин Монгол Улсын төсвийн бодлогоо өөрчлөх сүүлчийн боломжийн өмнө ирснийг сануулсан явдал юм. Алдагдлыг 1 жилд нөхөж болно. Харин буруу бүтцийг өөрчлөхгүй бол дараагийн 10 жилд дэлхийн дефолт болсон улсуудын гашуун түүх биднийг хүлээж байна. Анхаарч ажиллана уу.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд Учрал хариулъя.

**Н.Учрал:** Тийм Пүрэвдорж гишүүн их чухал асуудлыг хөндлөө. Төсвийн тусгай шаардлагуудаас яг 2025 оны байдлаар бол бид үнэндээ шаардлага буюу суурь тэнцэл 2 хувь ашигтай байх шаардлагыг хангаж чадаагүй. үндсэн шалтгаан нь бол таны ярьж байгаа асуудал яг мөн. Бид урьд оны үлдэгдлээс зардлаа санхүүжүүлж, ийм хариуцлагагүй явж ирсэн байна. Би бас дээр мэтгэлцээний үеэр хэлж байсан. Энэ манай өнөөдрийн энэ Төсвийн хууль, энэ Төсвийн тогтвортой байдлын хууль чинь хуучин стандартаар яваад байна. Бараг тэр олон улсад тэр 1989 оны тэр “government financial statistic” гэдэг стандартаар өнөөдөр тэр стандартыг мөрдөөд байна. Нэг ёсондоо манай төсөв чинь өөрөө орлого, зарлагын бүртгэл л болсон. Хэдий хэмжээний хөрөнгөтэй юм гэдгээ бүтэн үнэлж ч

чаддаггүй. Их Хурлын 126 гишүүн жилийн шинэ 1 их наядын хөрөнгө оруулалтыг Их Хурлын ажлын хэсэг дээр хуваарилаад сууж байхад төрийн өмчит зарим компанийн 9 ТУЗ-ийн гишүүнтэй компани 5, 6 их наядыг хуваарилаад сууж байдаг чинь болох юм уу гэдгийг бол ярих л болчихсон.

Тийм учраас бол бид нар төсвийн тогтвортой байдлын хуулиа эргэж харах ёстой. Алдагдал муу муухай гэдэг үгээ болих хэрэгтэй. Огт өр байхгүй, орлого, зарлага нь тэнцчихсэн ямар ч алдагдалгүй төсөв оруулж ир энэ тэр гэдэг ийм улс төрийн попролтууд бол өнөөдрийг хүргэсэн. Тэгээд яадаг байсан гэхээр ерөөсөө GDP-гээ худлаа нэмдэг. Орлогыг худлаа төлөвлөдөг. Тэгээд 33.5 их наядын орлоготой тэр хэмжээгээрээ зарна гэж хэлээд 24 онд нөгөө Засгийн газрын байр барья гээд явж байх үе чинь яг тэр байхгүй юу. Худлаа ингэж ярихаа болих хэрэгтэй.

Тийм учраас бид нар бол ирэх оны төсвийг төлөвлөхдөө сууриар нь өөрчлөх ёстой. Эхний алхмаа хийе. Гэхдээ энэ бол урт хугацаанд хэрэгжинэ. Тийм учраас багадаа 5, 6 жил шаардана. Тийм учраас намрын төсөв дээрээ бол алхмаа хийе гэж бодож байгаа. Ядаж хөрөнгөө бүтэн үнэлэхгүй юм гэхэд үнэлгээг эхлүүлэх хэрэгтэй байна. Тэгж байж энэ төсвөө төлөвлөхгүй бол явахгүй нь.

Дээрээс нь наад Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдал чинь ингээд тэр орон зайг бид нарт бий болгож өгөхгүй байгаа. Тэгээд өгөх хүмүүс өөрөө шимтгэл төлдөг Нийгмийн даатгалын сан төсвийн бүрэлдэхүүн хэсэг дотроо байдаг 1.6 их наяд жил болгон төсвөөс өгөөд байдаг. Шимтгэл төлсөн даатгуулагч нар нь болохоор бас 4.5, 6 их наядыг санд нь бүрдүүлээд байдаг нийлүүл.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд 1 минут сунгая.

**Н.Учрал:** Тэгээд нийлүүлээд энийг төсвийн бүрэлдэхүүн хэсэг гээд үзчихдэг. Тэгээд орон зай огт байхгүй. Тэгээд ийм байдалтай. Одоо яг үнэндээ төсвийн тодотгол хийхгүй бол зарлага чинь, урсгал зардал чинь бараг 90 хувьд хүрнэ шүү дээ. Бараг ийм байдал руу авааччихсан байхгүй юу энэ төсвийг.

Тийм учраас сая энэ та бүхний баталж өгсөн нийгмийн даатгалын багц хууль, энэ тэтгэврийн реформ бол өөрөө шууд тэтгэвэр нэмэхээс л болгоомжилж, тогтолцоог зөв болгож, тэтгэврийг нь нэмье л гэж оруулж ирсэн зарчим. Тэрнээс биш ингээд л нөгөө улс төржилт нь дийлдэхээ болингуут ингээд бүгдийнх нь цалинг тэдээр нэмлээ, тэтгэврийг тэдээр нэмлээ гээд тогтолцоо нь буруу юм дээр аваачиж нэмсээр байгаад энд хүрчихсэн. Тэгээд тогтолцоо хийе гэхээр ингээд явж өгдөггүй. Тэгээд л бие биеэ хуурсаар байгаад өнөөдрийг хүрчихсэн.

Тэгэхээр ер нь суурь асуудлуудыг бүхэлд нь шийднэ. Тэгээд намрын төсөв дээр бол эхний алхмаа хийнэ. Энэ 89 оны энэ Жи Эф Эс стандарт ядаж тэр 2014 он руу шилжих ёстой л гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулчихъя даа дахиад. Болчихсон уу? Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Мөнхсоёл:** Өглөөний мэнд хүргэе. Төсөв бол маш чухал асуудал гэдгийг зөвхөн иргэд гэлтгүй Улсын Их Хурлын гишүүд маань бас хариуцлагатай хандаж үзэж байгаа, энэ гүйцэтгэлийн тайланг дахин дахин хэлэлцэж байгаа нь маш чухал үйл явц. Тэгэхээр төсөв өөрөө бас татвар төлөгчдийн мөнгө өө. Эдийн засгийн эрх чөлөөг бий болгоё гээд Учрал сайд өөрөө санал гаргаад Ерөнхий сайд одоо энэ хууль батлагдах шатдаа явж байна. Тэгэхээр эдийн засгийн эрх чөлөөг олон улсын түвшинд хэмжихдээ нэг шалгуур үзүүлэлт нь ДНБ-д харьцуулсан төсвийн зарцуулалт байдаг. Ингээд төсөв чухал төсөв өөрөө бодлогын хэрэгсэл гээд сая Ерөнхий сайд маань бас өөрөө хэлчихлээ.

Тэгээд 06 сарын 19-нд анхны хэлэлцүүлэг болсон 2025 оны төсвийн гүйцэтгэлээр. Тэрэнд асуусан асуултын маань хариулт болгоод. Монгол Улсын Ерөнхий аудитор хариулт ирүүлсэнд талархаж байна. Тэгээд гол асуулт маань шинээр төлөвлөсөн үйл ажиллагааны 37.8 хувь нь хөгжлийн бодлоготой уялдаагүй байна, барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний 50 хувь нь зураг төсөвгүй байна. Эдийн засгийн үр ашгийн тооцооллыг 37 хувьд нь хийгээгүй байна гэсэн ийм асуудлууд байсан. Энэ тохиолдолд хариуцлагыг яаж тооцох вэ, хэрхэн энэ байдлыг бүгдээрээ жил болгон давтаж ярихгүйн тулд сайжруулах вэ гэж асуусан байсан. Тэгээд аудитораас ирүүлсэн маш чухал саналуудаас 2-ыг нь уншихъя гэж бодож байна.

Улсын Их Хурлын дарга Бямбацогт бас Улс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа энэ цаг үед бас чухал байх гээд зориуд уншаад өгчихье.

Нэгдүгээрт, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлах зөрчил давтагдан гарч байгаад анхаарал хандуулж, төсвийн төслийг хэлэлцэх, батлах явцад зарчмын зөрүүтэй санал гарч, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж тусгах, хэлэлцүүлэх тохиолдолд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хэн хэрхэн хянах талаарх зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах шаардлагатай байна гэж Монгол Улсын Ерөнхий аудитор санал ирүүлсэн байна.

Хоёр дахь санал. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хянах, ашиглалтад хүлээн авах, хөрөнгөд бүртгэх үе шат бүрд захиалагч, хяналт хэрэгжүүлэгч, хүлээн авах комисс зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна. Хэрэгжүүлэх дотоодын хяналт сул байгааг хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах ийм гурван санал ирсний 2-ыг хэлж өглөө.

Иргэд ч гэсэн бас давхар сонсоод, мэдээд, хянаад, ажиглаад, хараад хариуцлага нэхээд явахад хэрэгтэй учраас зориуд уншиж өгч байгаа юм. Дараа нь бас 06 сарын 19-нд ийн эхний хэлэлцүүлгээр хөндсөн асуултын хариултад Монгол Улсын Их Хурлын Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас дэлгэрэнгүй хариу ирүүлсэн байна. 2 хариултыг бас уншаад өгчихье.

Нэгдүгээрт нь хөгжлийн төлөвлөгөө ба төсвийг нэгдмэл байдлаар хэлэлцэх чухал байна. Өөрөөр хэлэх юм бол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй нь хамт хэлэлцэж,

төлөвлөгөөнд туссан боловч төсөвт ороогүй, эсвэл уялдаагүй төслүүдийн санхүүжилтийг дараа оны төсвийн хязгаараас хасах хүртэл зохицуулалтыг хийх хэрэгтэй.

Бас нэг дараагийн 3 саналынх нь 2 дахь нь Ки Пи Ай-ийг жинхэнэ утгаар нь бодит амьдралд хэрэгжүүлье. Мөнгө үрсэн байдлаар нь биш. Үр ашигтай зарцуулсан байдлаар нь дүгнэдэг болъё гээд. Маш чухал 3, 3-н саналыг энэ Үндэсний аудитын газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлснийг товчхон, дэлгэрэнгүй нарийн уншиж өглөө. Цаашид анхаарцгаах байх.

**С.Бямбацогт:** Санал хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Д.Энхтүвшин:** Бид нар намар улсын нэгдсэн төсөв хэлэлцэж баталдаг. Тэгээд энэ үед бол улсын төсөв тэгээд эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сан болон бусад үндэсний баялгийн сангуудын асуудлыг ярьдаг. Тэгэхээр Улсын Их Хурлаар энэ төсвийн гүйцэтгэлийг баталж байгаа нь бол энэ төсвийн хариуцлагын циклийг яг бүтэн болгож батлаад хэрэгжилт, гүйцэтгэлийг нь хянаад ингээд явж байгаа ийм цикл. Гэтэл энэ харилцааг өшөө сайжруулах хэрэгцээ хараад байна л даа. Өнөөдөр бид нар бол нэгдсэн төсвөөс зөвхөн улсын төсвийн л гүйцэтгэлийг нь баталж байна.

Өөрөөр хэлбэл, 30 гаран жишээлбэл юу тэнцвэржүүлсэн орлого 30 тэрбум гэж байхад 18 тэрбумтай, их наядтай холбоотой л асуудлыг нь хариуцлагдажуулах гэсэн иймэрхүү байдлаар оруулж ирж байна. Гүйцэтгэлийг нь баталж байна. Тэгээд намар бид нар батлахдаа бол төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр, хөтөлбөр, арга хэмжээ бүрээр нь ингэж задалж нарийвчилж гаргадаг. Одоо тэгэхэд 2-хон тоо оруулж ирж байна.

Тэгэхээр энэ нь өөрөө бид нарын энэ хүсээд байгаа яагаад энэ гүйцэтгэл баталж байгаа энэ өнөөдрийн арга хэмжээний гол зорилго буюу энэ хариуцлагыг, циклийг бүтэн болгож хамгийн төгсгөлийн хэсэг дээрээ бас бид нар бас энийг сайжруулахгүй бол энэ бол зүгээр ийм ёслолын төдий арга, бэлгэдлийн төдий ийм арга хэмжээ болчихоод байна. Тэгэхээр энийг дэлгэрүүлэх шаардлага байна гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангуудыг бас энэ гүйцэтгэлүүдийг нь баталдаг байхгүй бол энэ төсвийн биш шимтгэл юм чинь гэдэг байдлаар хандаж магадгүй. Тэгэхдээ энд орж ирж байгаа орлого төлж байгаа төлбөрүүдийн ихэнх нь төсөвтэй холбоотой байгаа юм.

Дээр нь Үндэсний зөвлөлүүд нь бол өөрсдөө баталж гүйцэтгэлийг нь хянадаг учраас энд бол бие даасан ийм шинж байхгүй. Тэгэхээр энийг бол Улсын Их Хурал дээр энэ гүйцэтгэлүүдийг хянадаг байвал яасан юм бэ гэсэн ийм санаа байгаад байгаа юм.

Дээр нь энэ төсөл, хөтөлбөр болон төслийн ерөнхийлөн захирагч тус бүрээр нь ингэж гаргаж, энэ нэгдсэн 2-хон тоо биш ингэж задалмаар байгаа юм. Тэгэхгүй бол аудит ингээд л жил болгон хязгаарлалттай ч юм уу, сөрөг дүгнэлтүүд гаргаад

авахад яг зөвлөмж өгөөд л өнгөрдөг. Тэгэхээр энд бол хариуцлагын асуудал яригдмаар байгаа юм.

Дээр нь энийг батлахгүй байх тохиолдол байвал яах юм гэдэг заалт бол хууль дээр ерөөсөө байхгүй. Гүйцэтгэл батлахгүй бол. Зарим улсуудад бол заавал баталдаг. Батлахгүй бол Засгийн газар нь бас буцаж аваад тодорхой залруулгууд хийж оруулж ирдэг. Хэрвээ энэ гүйцэтгэлээ батлахгүй бол төсвийн хэлэлцүүлэг, төсөв батлах ийм харилцаа руу ордоггүй. Тэгэхээр энэ хариуцлагын өөрөө том цикл байгаа учраас энэтэй холбоотой зохицуулалтыг нэмэх хэрэгтэй санагдаад байна.

Дээр нь энэ төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр нь энэ гүйцэтгэлийг баталбал энэ хариуцлагатай холбоотой Төсвийн тухай хуулийн далдугаар зүйлийг бас илүү хариуцлагыг нь тодорхой болгох ийм зайлшгүй шаардлагууд байгаад байгаа. Тэгээд энэ дээр Сангийн яамнаас ч юм уу, Сангийн сайд байхгүй болохоор хэнээс асуух вэ? Яг энэ чиглэлийн өөрчлөлтүүдийг бас хийх хүсэл зориг байна уу? Энэ талаар юу гэж бодож байгаа талаар асуулт асууя.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Сангийн Төрийн нарийн хариулчих уу? Манай Сангийн сайд хүндэтгэн үзэх шалтгаантай байгаа юм байна. Тэгэхээр бас Энхбаяр сайд хариулж болно. Энхбаяр сайд хариулчаач. Эдийн засаг, хөгжлийн сайд.

**Ж.Энхбаяр:** Энхтүвшин гишүүнтэй санал нэг байна. Энэ төсвийн циклийг бүтэн болгох үр дүн дээр нэлээн ажиллах хэрэгтэй. Орон нутгийн төсөв, төрийн өмчит компаниудын төсөв, ингээд сангууд үндсэндээ энэ хяналтын гадуур явагдаад байгаа. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал мөн их ач холбогдол өгч, энэ хяналт шалгалтын бүтэн болгох, үр дүнг тооцдог ажлыг хийх хэрэгтэй. Механизм хангалттай байгаа. Аудит гэж бүхэл бүтэн том систем ажиллаж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ажиллаж байна. Улсын Их Хурлын төсвийн хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хороо ажиллаж байна. Тэгэхээр юу нь дутуу байна вэ гэдэг дээрээ энэ би бол Засаг талаасаа илүү Их Хурал Их Хурал өөрөө улсын төсвийг баталдаг онцгой бүрэн эрхтэй. Үүний хариуцлагыг бас хүлээх учиртай.

Тэгэхээрээ Их Хурал өөрөө энэ циклийг бүтэн болгох асуудлаа санаачилгатай ажиллаад тэр хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлбэл Засгийн газрын хүрээнд. Засгийн газар чинь батлагдсан төсөв, батлагдсан хуулийн хүрээнд л ажиллаад байгаа шүү дээ. Энийгээ хиймээр байна.

Түрүүн Пүрэвдорж гишүүний хэлсэн үгэн дээр хэдэн байр суурь хэлэхгүй бол бас дутуу юм гараад ерөөсөө болдоггүй. Орлого маань тогтвортой биш байгаа. Түүхий эдийн үнийн өсөлт бууралтаа дагаж өсөж, бууж байгаа. Өнөөдрийн байдлаар 100 гаруй хуулиар тогтмол зардлыг хуульчлан баталсан байгаа. Тэгэхээрээ бид бас энэ төсвийн бодлого, хөгжлийн бодлого гээд бид нар чинь 26-аас 30 он хүртэл хэрэгжүүлэх үндсэн бодлогоо батлаад авсан. Тэр хүрээнд жил жилийн үндсэн чиглэлүүд орж ирнэ. Тэрийгээ дагасан төсвийн хүрээ орж байгаа.

Тэгэхээр энэ өнөөдрийн гүйцэтгэл дээр бас шүүмжтэй гараад байгаа маш олон асуудал хэлэлцүүлгийн явцад төсөв, төсөв төсвийн хүрээний батлах үед манай Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан дур зоргын асуудлууд маш хүчтэй

нөлөөлж байгаа шүү. Энийгээ бас хаа хаанаа анхаараад бүгдээрээ энэ хууль, эрх зүйн орчноо засаг талаасаа ч тэр, төсөв дээр санаачлаад ороод ирнэ. Их Хурал талаасаа ч тэр мэргэжлийн Төсвийн байнгын хороо, Төсвийн хяналтын дэд хороо бас ажлаа хийгээд чамбайруулаад ингээд төсвийн сахилга, төрийн хөгжлийн бодлого хоёроо ингээд уялдуулаад ингээд явбал болох боломж өндөр байгаа. Тэгээд жоохон бид нар ажиллах хэрэгтэй байна. Нэг үеэ бодвол бас юм бол улам л бас чамбайраад сайжраад л байгаа шүү дээ. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сангаас сая энэ нөгөө гүйцэтгэлийг Улсын Их Хурлаар батлах чиглэлээр энэ нөгөө Төсвийн тухай хуулийн 8.10, 9.1.3 дээр өөрчлөлт оруулбал Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийнхан юу гэж бодож байгаа тэр талаар хариулт өгөөч.

Дээр нь Сангийн яамнаас тэр төсвийн гүйцэтгэлийг батлахдаа төслийн ерөнхийлөн захирагч болон төсөл, хөтөлбөрүүд, арга хэмжээнүүдээр нь задлаад хавсралт байдлаар ч юм уу тэгээд аудитын дүгнэлттэй нь ингээд гаргавал Сангийн яам энэ тал дээр ямаршуу байр суурьтай юм? Ийм 3 байгууллагаас асуулт асууя.

**С.Бямбацогт:** Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон Сангийн яам. Дараад нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бэлдэж байгаарай.

**Б.Анар:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Анар. 2025 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр 25 оны 07 сарын 09-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр төсвийн тухай хуулийн 8.10.4 дээр Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах гэж орсон байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө хэрэгжих хугацаа нь 2027 оноос юм.

Тэгэхээр 26 оны гүйцэтгэлээс гэхээр ирэх жилийн, энэ жилийн явж байгаа гүйцэтгэл ирэх жил хэлэлцэгдэхдээ улсын төсвийг бол яг одоогийн хуулиар бол зөвхөн улсын төсвийн гүйцэтгэлийг батлаад, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгдсэн тайланг бол Улсын Их Хуралд хүргүүлж байгаа.

Ирэх жилийн төсвийн гүйцэтгэлээс эхлээд энэ нь бол яг нэгдсэн төсвөөрөө хэлэлцэгдээд явна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээрээ уул нь тайлан нь гараад ерөнхийлөн захирагч бүл болгоных нь аудит.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулчихъя Анар Сангийн яамны Төрийн нарийн.

**Б.Анар:** Аудит хийгдээд бол нэгдсэн тайлангийн бүрдэл хэсэг болоод явдаг. Энэ яг батлагдахдаа бол уул нь яг төсөв нь бол төсвийн ерөнхийлөн захирагч бүрээрээ тусдаа батлагдаж байгаа. Санхүүгийн тайлан ч гэсэн тусдаа хийгдэж байгаа. Тэгэхээр энийг бол тусад нь салгаад хийгээд явах бол бүрэн боломжтой байгаа.

Дээрээс нь нэмээд 26 оны, 26-аас 30 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл бол өнгөрсөн оны эцэст бол батлагдсан. Энэ хүрээндээ бол төсвийн ерөнхийлөн захирагчдын хүрэх үр дүн Ки Пи Ай-ыг бол ерөнхийлөн захирагч тус бүрээрээ салбар тус бүрээрээ баталчихсан байгаа.

Тэгэхээр 26 оны төсвийн гүйцэтгэл Их Хурал дээр орж ирэхдээ яг нэгдсэн төсвийн гүйцэтгэлээрээ, санхүүгийн нэгдсэн тайлангаараа, дээрээс нь нэмээд салбар болгоны төсвийн ерөнхийлөн захирагч болгоны гүйцэтгэл, түүний үр дүнгийн тайлангуудтайгаа ингээд цуг орж ирж батлагдахаар байгаа. Тэгэхээр дараа жилийн төсвийн гүйцэтгэлээс энэ нь илүү иж бүрэн болоод явна гэж ойлгож болно.

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Тийм ахиц дэвшлүүд гарч байгаа. Тэгээд миний зүгээр асуусан юу нь бол нэгдсэн төсвөө хэлэлцдэг болно ирэх жилээс. Миний асуусан асуулт нь болохоор нэгдсэн төсөв хэлэлцэхээс гадна нэгдсэн төсвийн бүрдэл, орон нутгийг бол бид нар орон нутаг нь баталж байгаа учраас тусдаа гүйцэтгэлийн батлахад бол орон нутаг гүйцэтгэлээ баталж таарах байх. Нэгдсэн төсөв хэлэлцэх үед Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын санг жишээлбэл төсвийг бол баталж байгаа учраас энэний гүйцэтгэлийг нь хэлэлцэхээс гадна улсын төсөв дээр нэмээд эрүүл мэнд, нийгмийн даатгал дээр үндэсний баялгийн сангуудын асуудлуудын гүйцэтгэлийг нь хэлэлцдэг байвал гэдэг ийм тодорхой асуулт л асуусан л даа. Тэгэхээр ерөнхийдөө бол боломжтой. Гэхдээ боломжтой гэдэг нь хуульд өөрчлөлт орж байж л өөрчилнө л дөө. Саяын тэр нөгөө 8.14-ийгөө тэр гүйцэтгэл нь зөвхөн улсын төсөв биш баталсан бусад тэр төсвүүдийг нь өөрчлөх. Тэгэхээр түрүүн Энхбаяр сайдын хэлснээр бол энийг гишүүд өргөн баривал гэсэн. Уул нь зүгээр Сангийн яам энийг өргөн бариад явбал илүү зөв юм болов уу гэж бодоод л асуугаад байгаа юм.

**С.Бямбацогт:** Энхбаяр сайд хариулъя. Жадамбын Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Энэ орон нутгийг ердөө орхиж болохгүй. Энэ улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын харилцаа улсын төсвийн алдагдлыг нэмэгдүүлж байгаа, төсвийн орон зайг хумьж байгаа гол хүчин зүйл болчихоод байгаа. Тэгэхээр энийг яаралтай залруулахгүй бол ердөө болохгүй байгаа юм. Манай энэ өмнөх парламент дээр энэ нийслэл болон орон нутгаас сонгогдсон гишүүд нэлээн яаж байгаад, лобби үүсгэж байгаад ингээд эрх зүйн ийм 2 салаа нөхцөл байдлыг үүсгэсэн. Энийг засахгүйгээр бас энэ төсвийн шаардлага хангах асуудал бас цаашид хангагдахгүй. 25 оны төсвийн шаардлага 4 тусгай шаардлагаас 1 шаардлага буюу суурь тэнцэл 2 хувийн ашигтай байх шаардлага хангаж чадаагүй. Үндсэн шалтгаан нь орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнээс нэмж баталж байгаа. Жилд дамжуулан төсөв санхүүжүүлж байгаа. Ингээд нөлөөлж байгаа зүйлүүд байгаа. Тэгээд энэ мэтчилний энэ төсвийн сахилга батыг сайжруулах ажлыг үнэхээр анхаарч хийхгүй бол бас хүндрэлүүд их болж байгаа.

**С.Бямбацогт:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

**Л.Соронзонболд:** Энэ 25 оны төсвийн гүйцэтгэл ялангуяа төсвийн гүйцэтгэл муу байгаа дээр, гүйцэтгэл муу гарч байгаа дээр нөгөө хариуцлага тооцох асуудал ер нь аягүй тодорхойгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чинь 26 оны 7 сар болчихоод байдаг. Тэгээд 25 оны төсвийн гүйцэтгэлээр төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрдээ ямар хэмжээний хариуцлага тооцсон юм, ямар ямар алдаа гаргасан дээр нь арга хэмжээ авсан байдаг талаар ийм тайлантай орж ирдэг бол зүгээр юм болов уу гэсэн ийм санал байгаад байгаа.

Дээрээс нь болохоор бол бас Улсын Их Хурал дээр ерөнхийдөө энэ төсвөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт дээр энэ тойргоос сонгогдсон ч бай гишүүд бол бас нэлээн их ач холбогдол өгч төсөвт бол тусгуулдаг. Гэтэл худалдан авалтын үйл ажиллагаа зохион байгуулалтаас хамаараад энэ төсвийн худалдан авалтын гүйцэтгэл муу гарч байгаа. Би зүгээр жишээ болгоод хэлэхэд бол энэ 25 оны төсвийн гүйцэтгэлтэй хамаагүй. Гэхдээ зүгээр сая ингээд 26 оны худалдан авалт дээр Дорнод аймгийн зүүн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн засварын тендер зарлагдсан байгаа 2 тэрбум төгрөг. Энд нэг компани орсон байна. Ялсан байна. Нөгөө компани нь очиж ажлаа үзэнгүүтээ өө энэ ашиггүй юм байна бид нар оролцохоо болилоо гээд. Ингээд 05 сарын 31 болоод нөгөө ажил хийгдэхээ больсон. Тэгэхээр ийм хариуцлагагүй байдал бол маш их байна. Ийм компанийг шалгаруулж байгаа энэ байдал бол үнэхээр хангалтгүй байна.

Тэгэхээр Худалдан авах ажиллагааны газраас асуух гээд байгаа юм. 2025 оны төлөвлөсөн төсвийн худалдан авалтын гүйцэтгэл хэдэн хувьтай гарсан бэ нэгдүгээрт?

Хоёрдугаарт шалгарчхаад ингээд ажлаа голоод больсон ийм худалдан авалтын төслүүд хэд байгаа юм гэдэг асуулт байна.

Мөн миний ойлгосноор бол энэ тендертэй холбоотой, худалдан авалттай холбоотой гомдлууд Сангийн яаман дээр очдог юм байна. Ингээд Сангийн яам бол гомдлыг нь шийдвэрлэдэг. Гомдлыг шийдвэрлэхдээ шалгарсан компанийг биш дараагийн компанийг нь шалгаруулдаг бас тохиолдлууд байдаг юм шиг байгаа юм. Тэгээд ийм тохиолдол хэд байдаг юм? Яагаад ийм шийдвэр гаргадаг юм, яагаад ялчихсан компанийг нь болиулдаг юм? Худалдан авах ажиллагааны газраас асуух гээд байгаа нь шалгарчихсан компани нь 05 сарын 31 болохоос долоо хоногийн өмнө шалгарчхаад байхад чинь бид нар танайхтай гэрээ хийж амжихгүй юм байна гээд шалгаруулахаа больчихож байгаа юм. Нөгөө гэрээгээ цуцаллаа гэж байх шиг байгаа юм гэх мэтчилний ийм юмнууд болдог юм байна. Энэ дээр хариу өгөөч гээд нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт энэ 25 оны төсвийн гүйцэтгэл дээр хийсэн аудитын тайлангийн 15 дугаар хуудсан дээр байна. Засгийн газрын цэвэр хөрөнгө гэдэг, өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын оролцоо 7.8 их наяд төгрөгөөр өссөн юм байна. Тэгэхээр энэ Засгийн газрын энэ цэвэр хөрөнгө 7.8 их наяд төгрөгөөр ямар эх сурвалжаас, ямар эх үүсвэрээс өсөв өө гэдэг дээр тайлбар өгөөч гэсэн ийм 2 асуулт.

**С.Бямбацогт:** Худалдан авах ажиллагааны талаар, тендертэй холбоотой асуулт Доржханд Шадар сайд худалдан авалт хариуцсан сайд.

**Т.Доржханд:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр 2025 оны худалдан авах ажиллагааны хувьд нийтдээ 2 их наяд 67.6 тэрбум төгрөгийн 90 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Тэгээд үүнээс бол түрүүн Худалдан авах ажиллагааны газраас нийт 1 их наяд 889.5 тэрбум төгрөгийн 87 төсөл, арга хэмжээ нийт 497 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс гүйцэтгэлийг нь асууж байна. Гүйцэтгэлийн хувьд бол гэрээ байгуулсан 74 төсөл, арга хэмжээ, багц 299 ажлыг бол зохион байгуулсан. Үр дүн бол 85.1 хувь гарсан байгаа.

2024 онд бол энэ үзүүлэлт бол 50 хувь байсан. Одоо энэ бол ингээд 85.1 хувьтай ингээд өсөөд явж байгаа. Өмнө нь бол 2 худалдан авалтын 1 нь хуулийн байгууллагаар шийдэгддэг байсан. Одоо энийг бол бид нар аль болох амжилттай зохион байгуулах, нээлттэй ил тод, тэгээд илүү цахимжсан хэлбэрээр зохион байгуулах байдлаар ажиллаж байгаа. Үүнд бол амжилтгүй болсон худалдан авах ажиллагаанууд бол байна.

Тухайлбал, 9 худалдан авах ажиллагаанууд зураг төсөл байхгүй. 3 нь болохлоор техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй гэсэн ийм шалтгаанаар худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.

Та түрүүн Хэмнэлтийн хуулийг бол ярьж байх шиг байна. 05 сарын 01-нээр хөрөнгө оруулалтын арга хэмжээ худалдан авалтын гэрээ хийгдээгүй тохиолдолд бол хэмнэлтэд тооцогддог. Энэ өөр хуулиар ингээд зохицуулагддаг. Тэгэхлээр үүнтэй холбоотойгоор бол тодорхой төслүүд бол хэрэгждэггүй нь бас бодит үнэн. Яагаад вэ гээд тэгэхлээр бодит байдал нь болохлоор төсөв батлагдаад тэгээд батлагдсан төсвийн хүрээнд бол худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг. Батлагдсаны дараа бол зураг төсөв ажлын даалгавар гэдэг зүйлийг бол манайхаас шаарддаг. Тэгээд энэ хугацааг бол 2-3 сар ер нь бол тухайн жилийн 3 сард гэхэд бол ажлын даалгаврууд, ТЭЗҮ юмнууд, зураг төслүүд бол ирдэг. Ингээд худалдан авах ажиллагаа бол зарлаад явдаг. Нээлттэй зарладаг.

30 хоног үнэлгээ. Ингээд 15 хоног 45 хоногийн дотор бол шахдаг. Амжилтгүй болсон тохиолдолд дахин зарладаг. Тэгэхлээр ер нь яг энэ 3 сараас аваад үзэх юм бол 5 сар хүртэл бол дахиад ийм 60 хоногийн хугацаанд бол энэ ажлыг бас хийх шаардлага бол үүсдэг. Тэгээд дөхөж ирээд маш олон гомдол гардаг. Үнэн. 10 худалдан авах ажиллагаанд оролцсон, 20 худалдан авах ажиллагаанд оролцсон тохиолдолд 1 нь шалгардаг, 9 нь гомддог, 19 нь гомддог. Тэгээд гомдсон аж ахуйн нэгжүүд Сангийн яам руу бол гомдлоо бол илэрхийлдэг. Тэгээд эндээс бол.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Манай төсвийн онцлог түүхий эдийн үнийн өсөлт, бууралтаас хамааралтай саваад байгаа юм. Жишээлбэл, 25-ны гүйцэтгэл гарахад нүүрс 24 оны жилийн эцсээс 40 хувийн уналт хийсэн. Энэ нь төсвийн орлогын гүйцэтгэлд бага гарахад нөлөөлсөн. Энэ нь өөрөө бусад төсвийн зардал дээр ачаалал үүсгэж байгаа. Бид төсвийн зардлуудаа хуульчлаад тогтмол зардлуудаа нэлээн хуульчилсан зардлууд баталсан тоо маань их байгаа. 100 гаруй хуулиар тогтмол зардлыг баталчихсан. Орлого маань бол зах зээлийн савлагаатай. Энэтэй холбоотойгоор энэ төсвийн гүйцэтгэл нэлээн дутуу гарч байгаа байдал. Нэг.

Хоёрдугаарт хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүд төсвийн эх үүсвэргүй, зураг төсөлгүй, техник эдийн үндэслэлгүй ийм дутуу боловсруулсан материал саналуудыг Их Хурал дээр олноор баталсан. Энэ нь өөрөө энэ худалдан авах ажиллагааг хүндрүүлсэн буюу хэрэгжихгүй байх ерөнхий төсвийн гүйцэт.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулчихъя. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Энэ Их Хурлын гишүүдийн оруулсан дутуу бүрдэл бүхий энэ саналууд өөрөө төрийн худалдан авах ажиллагааны шаардлага хангахгүйгээр буцах унах, маргаан үүсгэх гол шалтгаан болоод байгаа. Тэгэхээрээ хаа хаанаа бас асуудлууд анхаарах хэрэгтэй байна л гэдгийг хэлмээр байгаа юм.

Жишээл, нүүрс бол экспорт орлого 171 сая ам.доллараар дутсан. Алтны тооцоолол 250 сая доллараар дутсан. Энийг нь ийм мэтчилний нөгөө түүхий эдийн ханшны савлагаа өөрөө төсөвт нөлөөллүүд их өндөр байгаа нь төсвийн гүйцэтгэл дутуу гарсантай холбоотой гэж бас хэлэхийг хүсэж байгаа юм.

**С.Бямбацогт:** Сангийн яам. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

**Б.Анар:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Энэ санхүүгийн нэгдсэн байдлын тайлангаар, нэгтгэсэн тайлангаар 11.1 их наядаар яг ямар өөрчлөлтүүд оров гээд. Энийг ингээд дотор нь ангилаад үзэх юм бол 4 төрлийн ангилалд хувааж авч үзэж болохоор байгаад байгаа юм. Эхнийх нь бол мөнгөн хөрөнгө бол нийтдээ мөнгөн хөрөнгө талдаа бол 3.6 их наядаар, үндсэн хөрөнгө бол 6 их наяд 173.8 тэрбум төгрөгөөр, богино хугацаат хөрөнгө оруулалт 1 их наядаар, урьдчилгаа 290.4 тэрбум төгрөг ингээд нийт дүнгээрээ 11.1 их наядаар энэ 7 мянга гаруй төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн нэгдсэн тайлангийн өөрчлөлтөөр бүртгэгдсэн.

Энэ үндсэн хөрөнгө нэмэгдсэн хамгийн том дүнтэй үндсэн хөрөнгө бол энэ батлан хамгаалах салбарын тодорхой нөгөө Зэвсэгт хүчний Жанжин штаб дээр байсан тодорхой газруудыг бол нөгөө үндсэн хөрөнгөд бүртгэж авсантай холбоотой байна. Дээрээс нь.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулчихъя.

**Б.Анар:** 1 их наяд 1.3 их наяд нь энэ Ирээдүйн өв сангийн орлого төвлөрөлттэй холбоотой. Мөн 1 их наяд нь Нийгмийн даатгалын сангийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын мөнгөн хөрөнгө. Дээрээс нь ингээд төрийн өмчит компаниуд төсөвт байгууллагууд энэ мөнгөн хөрөнгө татсан, гадаад эх үүсвэрүүдээс мөнгөн хөрөнгө татсан хөрөнгө босгосон. Ингээд бүгдээрээ нийлээд 11.1 их наяд болж байгаа гэдгийг бас хэлье.

Худалдан авалттай холбоотой бас нэмэлт Сангийн яаман дээр энэ гомдол гардагтай холбоотой асуудлыг бас тайлбарлая. Өнгөрсөн оны ер нь бол энэ хэмнэлтийн асуудал бол 3 үндсэн гол шалтгаантай. Эхнийх нь түрүүн хэлсэн олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ. 2 дахь нь манай дотоодын импортын

хэмжээ 1.1 их наядаар тасарсан. Тэгэхээр импортын тасалдалтай холбоотойгоор импортын онцгой гааль, НӨАТ-тай бараануудын орлого бол тасарсан.

Дээрээс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр 535.9 тэрбум төгрөг бол хэмнэлтэд тооцогдсон. Тэгэхээр энэ дүнгүүд бас нөлөөлж байна. Дээрээс нь.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Даваагийн Цогтбаатар гишүүн. Соронзонболд гишүүн тодруулж асууя.

**Л.Соронзонболд:** Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайлан дээр бас энэ нэгдсэн төсвийн, зарлагын гүйцэтгэлд ялангуяа энэ орон нутгийн төсвийн асуудал их нөлөөлж байна. Нөлөөлөх хэмжээ нь маш их болчихлоо гэдэг ийм дүгнэлтийг бичсэн байсан.

Тэгэхээр ер нь бид нар болохоор бол энэ төсвийн гүйцэтгэл яриад байдаг. Тэгсэн мөртөө энэ төсвийн хүрээний мэдэгдлийнхээ гүйцэтгэлийг ерөөсөө ярихгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдлийн гүйцэтгэлийг ярьдаг болох, дээрээс нь бол энэ төсвийн зарлагын гүйцэтгэлд орон нутгийн энэ төсвийн гүйцэтгэл хэрхэн нөлөөлж байгаа талаар бас нэлээн тодорхой ярьдаг болохгүй бол болохгүй байна гэж үзэж байгаа.

Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуух гээд байгаа асуулт маань энэ төсвийн хүрээний мэдэгдлийн гүйцэтгэл гэж та нар ер нь гаргадаг юм уу? Тэгээд төсвийн тухайн жилийн төсвийн улсын төсвийн гүйцэтгэл гаргахад энэ талаарх мэдээллээ нэгтгэж өгдөг үү гэдэг ийм 2 асуулт байгаад байна.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийн дарга Дэлгэрсайхан. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

**Ж.Дэлгэрсайхан:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Энэ бол их төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаатай холбоотой их чухал асуудал хөндсөнд баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа энэ асуудал, нэгдсэн төсвийн гүйцэтгэл хэлэлцдэг болох талаар 27 оноос заалт хэрэгжинэ гэдгийг түрүүн Сангийн яам хэлсэн. Бид нар хэдийгээр энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцээд байгаа боловч нэгдсэн төсвийн 30 хэдэн их наядын гэсэн тоон дотроос бол цөөн хэсгийг нь хэлэлцэж байгаа. Түрүүн Энхтүвшин гишүүн бас хэлсэн Баялгийн сан болон бусад зүйлсийг бид хэлэлцэхгүй орхигдуулаад байна гэж.

Тэгэхээр энэ орон нутгийн төсөвтэй холбоотой бид төсвийн гүйцэтгэл дээр нэгдсэн төсвийн Улсын Их Хурлаас баталсан тоо буюу макро эдийн засгийн бодлого хэрхэн хэрэгжиж байгааг ярихгүй бол өнөөдөр Улсын Их Хурлаас тоо батлаад явуулдаг. Орон нутгийн бие даасан байдал гэдэг нэрийн доор орон нутаг төсвөө хэтрүүлснээр Улсын Их Хурал дээр батлагдсан тоо бол хэтрээд явж байгаа. Энэ нь бол улсын төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэлд бол сөргөөр нөлөөлөөд. Хөрөнгө оруулалтын төсөв нь өөрөө улсын төсвийн.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулчихъя 3 дугаар индэр.

**Ж.Дэлгэрсайхан:** Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалт нь төсвийн тусгай шаардлагыг биелүүлэх бупер механизм болоод төсвийн зардлыг, хөрөнгө оруулалтын зардлыг танах, хөрөнгө оруулалтын зардлыг царцаах байдлаар, мөн улсын төсвийн нийт зардалд улсын төсөв дээр хэрэгжиж байгаа зардалд бол орон нутгийн төсөв тодорхой хэмжээний шахалт үзүүлээд байгаа.

Тийм учраас орон нутгийн төсвийг хэлэлцэхгүй ч гэсэн нэгдсэн төсвийг хэлэлцэхдээ, төсвийн гүйцэтгэл хэлэлцэхдээ Төсвийн хүрээний мэдэгдлийн тэр макро эдийн засгийн тоонуудад улсын төсвийн гүйцэтгэл, орон нутгийн төсвийн гүйцэтгэл хэрхэн нөлөөлснийг бол бид зайлшгүй ярьж байхгүй бол цаашдаа улсын төсөв өөрөө шахагдах ийм үзэгдэлд орж болзошгүй байгаа гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууж, үг хэлнэ.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын дарга а таны индэр дээрээс хэлж байгаа үг болгон биелж байх ёстой. Одоо төсвийн гүйцэтгэл гээд бид нар 133 их наядын гүйцэтгэл ярьж байхад энэ танхимд танай намын Засгийн газрын байгуулсан сайд нараар хэд байна? Одоо би Зам, тээврийн яамтай холбоотой энэ мөн төсвөөс хамгийн ихийг нь үүрдэг Зам, тээврийн яамны сайдтай холбоотой, Төрийн нарийнтай нь холбоотой юм ярих гэхээр энэ дотор аль нь ч алга байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр орж ирчхээд уг нь хурал та удирдах болгондоо дэг хэлдэг. Үнэн, зөв хариулаарай. Мэдэж байгаа бол тодорхой хариулаарай. Хариуцлага алдаад байна. Одоо бид нар энэ хууль зүй талаасаа ямар хариуцлага тооцох ёстой юм бэ гээд Улсын Их Хурлын гишүүн асуухаар бичээд өгчихсөн байгаа тэндээсээ унших гэдэг хариулт өгч байна шүү дээ. Таны дэг сахиулаад байгаа чинь энэ мөн үү? Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ерөөсөө улс төржилт хийгээд Монгол Улс зайлуул даа зуны хэдхэн дулааны улиралд л замаа барина, замаа засна шүү дээ. Зам барих ёстой. Баянхонгор аймагт 2 зам барих ёстой. Очоод нээлтийг нь хийе гэхээр нээлтийг нь хийлгэхгүй. Одоо ингээд 6 сар дууссан. 7 сар гарч байна. Энэ хариуцлагыг нь би Ерөнхий сайдтай ярих уу, зам тээврийн сайдтай ярих уу? Төрийн нарийн бичгийн дарга нь дахиад энэ дотор байхгүй. Тэгээд энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дарга нарын цалингийн талаар ил гаргаж ярьсан. Аудитын дүгнэлт ч гарсан. Би нэг ч юмыг худлаа яриагүй. Санаанаасаа зохиож ярьсан юм надад нэг ч байхгүй.

20-65 сая төгрөгийн цалин авч байна гээд ил гаргаад ярьсан чинь сайд нь хурал дээр орж ирээд үгүй хөөрхий минь 25 сая л юм билээ. Авгай хүүхэд нь салах гээд хэцүү байна гэнэ. Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас гэж байгаа шүү дээ. Тэгээд төрийн өмчит компаниудыг удирдаж чадахгүй, авгай хүүхдийг зохицуулж чадахгүй юм бол энэ улс төр, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг удирдаж ер нь яах гээд байгаа юм? Бодитойгоор авчихсан дүн нь 778 сая төгрөг тэрийг нь дунджаар хуваахаар 65 сая төгрөг. Тэгээд энэ цалин болон бусад урамшуулал юу байдаг юм авч болдог бүх юмыг нь аваад л 65 саяыг авсан байна шүү дээ. Тэгээд эд нартаа хариуцлага тооцъё, яавал үр ашигтай байх юм гэдэг юмаа ярихгүй авгай хүүхэд нь ярьж орж ирээд байх юм. Зарчим хаана байгаа юм бэ? Бид нар улс эх орны асуудал ярьж байгаа юм уу? Тэр айлын авгай хүүхдийн

асуудлыг ярих гээд суугаад байгаа юм уу? Тэгээд энэ чинь бүр урдаас, Улсын Их Хурлын чинь урдаас мэдэгдэл гаргаж байна шүү дээ. 1 гишүүн ярьсны төлөө компаниуд нь бүгдээрээ ээлж дараал лаад л мэдэгдэл гаргаж байна. Манай захирал хөөрхий минь 65 саяас бага цалинтай. Уучлаарай ч биш залруулж яриарай ч билүү.

Тэгээд нөгөө захиалагчийн хяналт хийгээд байгаа гээд байгаа нөгөө Барилга, хөгжлийн төв чинь надаас долоо дор хүн тэр хэдэн тоосгыг өрсөн юм шиг байгаа юм. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ гээд Барилга, хөгжлийн төв мөнгөө авдаг. Одоо ёстой шуудайд хийсэн үхрийн эвэр шиг юм өрчхөөд наанаас нь төмрөөр хавтгайлаад төрийн удирдлагуудаа бүгдийг нь аваачиж байгаад нээлт хийчихсэн. Нөгөө байшин чинь түрүүчээсээ нурж байна буюу улсын төсөв чинь үр ашиггүй үрэгдэж байна гэдгийг хэлээд хэлээд байна.

Ер нь манай Дэлгэрсайхан сайд уг нь 24 оноос хойш хамгийн тогтворгүй засгийн газрууд солигдож байгаа 3 солигдсон. Хамгийн тогтвортой үлдсэн сайд нь. Тэгээд гараас нь юм гардаг юм байхгүй. Манай энэ тойрог руу явахад Элсэн тасархай наана цаана зам гэж там болчихсон. Дахиад Хөөврийн голоос цаашаа Шартын даваа руу ордог зам битүү осол болдог. Битүү там болчихсон. Дахиад Баянхонгороос Өвөрхангай орох зам дахиад там. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Зам, тээврийн сайд 2 энэ асуудлууд руугаа анхаарахгүй. Яах вэ сайд нь улс төр хийдэг юм байж. Ядахдаа Төрийн нарийн бичгийн дарга нь ажлаа хиймээр байна.

Тэгээд энэ аудитаас гаргачихсан дүгнэлт дээр байгаа 500 орчим тэрбум төгрөгийн өр, авлага дотроо замбараагүй явж байгаа. Тэгээд л Тавантолгой, Төмөр зам нь мөнгө зээлдэг. Өгдөг, авдаг, нөгөө өглөг авлагадаа бүртгэдэггүй, хянадаггүй, ямар ч засаг замбараа байхгүй 500 орчим тэрбум төгрөг. Ерөнхий сайд өөрөө сууж байна. Анхааралдаа авах байлгүй дээ. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь сайдынхаа мэдэлд байгаа компаниуд нь хоорондоо өглөг, авлага.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя. Гэхдээ уул нь бол Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж байгаа юм гишүүд. Яг энэ үүднээсээ Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Цогтбаатар дарга нөгөө санал, дүгнэлтээ танилцуулсан. Түүнээс л асууж, хариулах ёстой юм. Гэтэл Цогтбаатар дарга бид хоёр хоорондоо хоёулаа хууль зөрчөөд л явж байна, дэгээ зөрчөөд явж байна л даа. Өөрөө хариулах ёстой байтал өөрөө асуугаад л. Тийм болохоор гэхдээ. Харин тийм би бас дэг сахиулъя. Дэлгэрсайхан сайд бас ороод ирлээ. Тэр Монголбанкны дэд ерөнхийлөгч нь хаа байна дууд. Ирсэн үү? Ирчихсэн байна. Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Цогтбаатар гишүүнд баярлалаа. Төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байна. Тэгээд ер нь би түрүүн хэлсэн шүү дээ энэ 89 оны энэ стандартаар чинь өнөөдөр бид нар төсөв баталдаг, тэгээд гүйцэтгэлээ тавьдаг энэ байдлаа өөрчлөх хэрэгтэй гэж. Тэгэхээр намрын төсөв дээр бол нэг алхам хийе. Яг энэ Их Хурлын гишүүдийн тавиад байгаа зөв. Компани бол орлого, зарлагаасаа гадна манай компанид ямар хөрөнгө байгаа вэ гэдгээ үнэлж байж төсвөө баталдаг шүү дээ. Гэтэл улс болохоор зүгээр ийм орлого, зарлагын бүртгэлтэй ийм төсөв оруулаад ирдэг. Тэгээд улс нэг төсөвтэй төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс мөртөө

тэнд төрийн өмчит компаниуд дахиад ТУЗ-өөрөө дамжуулаад төсөв батлаад байхаар Их Хурлын гишүүд ингэж шүүмжлэхээс яах юм. Зөв шүү дээ. Би бол зөв гэж бодож байгаа.

Тийм учраас 24 онд тэр төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг тухайн үеийн Засгийн газар өргөн мэдүүлж байсан. Тэгээд өнөөдөр Их Хурлын гишүүд та бүхэн маань энэ төрийн өмчит компанийн хуулийг баталж өглөө. Тэгээд үүнд маш их баяртай байна. Энэ парламентын хаврын чуулганы хугацаанд бол бид нар олон жил хүлээгдсэн дуусдаггүй олон яриаг дуусгасны нэг бол төрийн өмчит компанийн хууль болж байна. Тэгээд намар бол Засгийн газраас төрийн өмчит компани дээр баримтлах үндсэн чиглэлийг оруулж ирнэ.

Гэхдээ энийг 3.6 сая хүнтэй улс, тэгээд 126 гишүүнтэй, парламенттай, 5 намтай тэгээд хүний өөрийгүй нийлж байгаад баахан хүн шахчихсан. Тэгээд төрийн өмчит компани дээр жоохон хөдөлгөөн хийхээр засгийг чинь огцруулна шүү гээд дарамтлаад байдаг зовлон ихтэй. Яг үнэндээ бол би бас зовлон ихтэй шүү дээ. Тэгэхээр одоо яах вэ гэхээр сая 12 компани дээр төрийн өмчит компаниуд дээр олон улсын санхүүгийн аудит оруулаад энэ төрийн өмчит компаниудыг хөрөнгө оруулалтын багц болгоод бирж дээр гаргая. Ингэж байж засаглал сайжрах юм байна гээд урилга явуулчихсан. Сая Блак Рок нөгөө Франклин Темплтон 2 манайтай хамтарч ажиллана гэдэг саналаа өгчхөж байгаа байхгүй юу. Наадмын өмнө бид нар санамж зураад ажлыг нь эхлүүлэх гэж байна.

Таны ярьж байгаа цалин дээр бол тэр гүйцэтгэх захирлууд бол мэдээж өөрөө цалингаа тогтоохгүй байгаа. ТУЗ тогтоож байгаа. Тэгэхээр шинэ хуулийн дагуу энэ ТУЗ-үүдийг хараат бус байдлыг нь сайжруулахгүйгээр эд нар ингэж тогтоож байгааг болиулах ёстой.

Хоёрт бол яг үндсэн цалин нь бол яг таны яриад байгаатай тоотой бол зөрж байгаа. Тэгэхдээ би тэр нөгөө хоол, унаа, элдэв бүүр баахан зардлыг тавиад байх шиг байна. Тэгэхдээ Засгийн газар дээр яг энэ төрийн өмчит компанийн хуулийн дагуу зорилго, үр дүнд суурилсан цалингийн шинэ шатлал руу төрийн өмчит компаниудыг явуулна. Зөвхөн Ки Пи Ай биш. Өү Кэй Ар гэж нэрлэдэг юм шүү дээ. Энэ бол өөр тогтолцоо. Зүгээр компанийн захирал өөрөө компаниа ашигтай ажиллуулаад Баялгийн санд орлого хуримтлуулаад, хуримтлалыг өсгөөд ажиллаж байвал цалингаас гадна үр дүнгийн урамшууллыг тооцно. Сайн ажиллаж байгаа компанийн захирал тэдэн төгрөг өгөхөд ч бэлэн байна. Иргэний хуримтлалд үнэхээр бодитой орлого хуримтлуулж байвал. Шинэ хуулийн дагуу ашиггүй ажилладаг төрийн өмчит компани гэж бол байхгүй болж байгаа шүү дээ. Зөвхөн нийтийн үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлнэ. Яг энэ хуулийнх нь дагуу явуулна. Ингээд Өү Ки Ар гэдэг энэ цалингийн шинэ шатлалыг ТУЗ-уудад Засгийн газраас үүрэг болгохоор бэлтгэж байна. Энэ бол одоогийн цалинг 53.1 хувиар бууруулна. Би бас хатуу хариуцлагатай хэлчихье. 53 хувиар бууруулна.

**С.Бямбацогт:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуух ёстой гишүүд. Үгүй бол нөгөө төсвийн гүйцэтгэлтэй холбоотой хэлж болно. Ажлын хэсгийн гишүүн бол Сангийн сайд хүндэтгэн үзэх шалтгаантай хэлсэн. Төрийн нарийн бичгийн дарга нь байна. Бусад холбогдох талын ажлын хэсгийн гишүүд сууж байгаа. Бусад Засгийн газрын гишүүд заавал бас байх ёстой

биш. Гэхдээ Дэлгэрсайхан сайд бас сая Цогтбаатар гишүүний гишүүнийхээ хувьд Зарлагын хяналтын дэд хорооныхоо даргын хувьд биш гишүүнийхээ хувьд асуусан асуултад хариулт өгчихье.

**Б.Дэлгэрсайхан:** Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Бид бол ер нь өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд ер нь нийтдээ 8400км хатуу хучилттай авто зам барьсан. Энэ хатуу хучилттай авто зам маань насжилт өндөр болсон түрүүчээсээ. Ер нь засвар хийж чадахгүй байсаар байгаад өнөөдрийг хүрсэн. Саяын таны хэлдэг Элсэн тасархай хавийн тэр зам бол ингээд Баянхонгорын чиглэлийн тэр замд их засвар гараад одоо ажиллаж байгаа. Бид тодорхой стратегийн ач холбогдолтой бүхий чиглэлийн энэ замууд дээр энэ жилдээ бол их засварыг хийж байгаа. Дээр нь бас мөн Лүнгийн замыг удахгүй ингээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлэхээр Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа хамтраад ажиллаж байгаа. Тэгээд ер нь бол цаашдаа бид бол ингээд.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Би одоо танд микрофон өгөхөөр чинь дэг зөрчих гээд байна шүү дээ. Харин Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74.5. Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Энэ Дэлгэрсайхан сайд аудитын дүгнэлттэй холбоотой, энэ Тавантолгой төмөр замтай холбоотой 262 тэрбум төгрөг, тэгээд өр, авлагаа хоорондоо шилжүүлж өгөлцөж авалцсан Монголын төмөр зам, дахиад л нөгөө Тавантолгой төмөр зам 66 тэрбум төгрөг, Монголын төмөр зам 78 тэрбум төгрөг гээд дандаа энэ зөрчил дутагдлууд танай яаман дээр 500 орчим тэрбум төгрөгийн асуудал байгаа байхгүй юу. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэхээрээ замбараагүй байна л гээд байгаа юм төсвийн ерөнхийлөн захирагч нар нь. Тэгээд энэ дээр анхаарч ажиллаарай гэж байгаа болохоос биш яах вэ таны тэр зам засна гэдэг чинь бол зөв.

Гэхдээ энэ маш удаж удаж байгаад хийгдэж байгаа. Танай Төрийн нарийн бичгийн дарга ажил хийхгүй улс төржөөд байгаа шүү гэдгийг би өмнө нь танд бодит байдлаар нь ч гэсэн хэлсэн шүү дээ. Тэгээд одоо болтол сайжирдаггүй. Нөгөө зам барих гээд байгаа цаг хугацаа чинь дууслаа шүү дээ. Баянхонгор аймаг 2 зам барих ёстой. Очоод ажлыг нь эхлүүлье гэхээр яам одоо болтол эхлүүлж өгдөггүй. Энэ нөхцөл байдлуудаа анхаараарай. Тэгээд нэмэлт цаг өгсөн даргад баярлалаа.

**С.Бямбацогт:** Талархал илэрхийлсэн Цогтбаатар гишүүндээ баярлалаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны. Энэ Баянхонгорын ах нар тэр Эрдэс Монголын захирал Даваадалай тэр Баянхонгорын Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Баярмагнай та нар нутгийн дүүгээ битгий шоовдорлоод бай л даа. Бас үгийг нь сонсоод бас асуудлыг нь шийдэж байгаарай.

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ө.Шижир:** Ер нь бол нөгөө аудитын дүгнэлтийн араас хариуцлага яригддаггүй гэдэг асуудал байгаад байгаа юм. Яг өнгөрсөн хугацаанд энэ олон хэдэн их наядын зөрчил дээр хэчнээн албан тушаал дээр хариуцлага тооцогдсон юм бэ гэдэг статистик одоо болтол байдаггүй. Засгийн газар нь хүртэл өөрөө хязгаарлалттай дүгнэлт авчхаад байдаг. Аудитын байгууллагууд нь энэ дээр бас

араас нь ингээд тодорхой хариуцлага тооцдог эрх мэдэлтэй байхгүй бол ингээд бид нар 10 хэдэн их наядын зөрчилтэй гарсан байна гээд яриад л өнгөрдөг, сонсоод л өнгөрдөг ийм юм болчихоод байна.

Ингээд аудитын дүгнэлтээс харахад нийслэлийн үнэт цаастай холбоотой Сэлбэ дэд бүтэц дээр гэхэд 33 сарын хугацаатай 500 сая доллар зээлээд зориулалтын дагуу ашиглаагүй арилжааны банканд ашигласан байна гээд ингээд дурдчихдаг. Ингээд дүгнэлт дээрээ байж байдаг. Зориулалтын дагуу ашигладаггүй. Үүнтэй холбоотой бас нийслэлээс Туулын хурдны зам дээр аудитын дүгнэлт хийсэн байдаг. Хамгийн анх төсөвт өртөг нь 594 тэрбум төгрөг байсан Туулын хурдны зам 2025 онд 1.9 их наяд болоод тэгээд 3-хан сарын дараа 2.4 их наяд болоод нэмэгдчихэж байгаа юм. Тэгээд үүн дээр хүртэл нийтдээ 4 дахин нэмэгдэж байгаа. Үүн дээр хүртэл ямар дүгнэлтүүд хийдэг юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Уг төслийнхөө хүрээнд нийтдээ 500 тэрбум төгрөг, 2025 онд 410, 2026 онд 99 гээд нийтдээ ингээд 500 тэрбум тараачихсан. Тэгээд аудитын дүгнэлт дээр нь юу гэж байна вэ гэхээр 500 тэрбум төгрөгийг олгохдоо ажил гүйцэтгэх төлөвлөгөө, тоо хэмжээ, ажлын хуваарь зэрэг баримт бичгийг үндэслээгүй олгочихсон гэж байгаа юм. Үндэслээгүй олгочихсон энэ дүгнэлт дээр нь ингээд биччихсэн байгаа юм. Туулын хурдны замыг хуульд нийцүүлэн байгуулаагүй гээд биччихсэн байгаа юм. Гэрээний нөхцөлийг хэлэлцэж тохирсон баримт бичиг байхгүй гэж байгаа юм. Уг төслийг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид бүрэн нийцүүлээгүй. ТЭЗҮ, зураг төсөл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагыг хангаагүй гээд. Тэгээд энэ улсад чинь ер нь эзэн гэж байна уу? Ямар ч ТЭЗҮ-гүй, ямар ч зураг төсөлгүй, төлөвлөгөөгүй, ажлын тоо баримтгүй, ажлын төлөвлөгөөгүй, хоорондоо нийлсэн бараа, бичиг баримтгүйгээр 500 тэрбум төгрөг зүгээр ингээд гарчихдаг юм уу? Энэ улс оронд чинь ер нь эзэн гэж байгаа юм уу? Ингээд харахаар ер нь энэ Улаанбаатар хот чинь энэ улиасныхаа улингараа шийдэж чадахгүй байж байж яаж энэ Улаанбаатар хотын түгжрэл, яаж энэ Улаанбаатар хотын энэ авто замын түгжрэл болон утааг шийдэх юм? Авсан зээлээ зориулалтын дагавар ашиглаагүй хадгалчихсан. Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй байхад нь гэрээ байгуулчихсан. ТУЗ, ТЭЗҮ-гүй байхад нь 500 тэрбум олгочихсон. Ингээд энэ аудитын дүгнэлтээс би хараад ярьж байгаа шүү. Энэ улсад чинь ер нь эзэн гэж байгаа юм уу? Ямар ч бичиг баримтгүй, ямар ч албан ёсны гэрээ, контрактгүй ингээд 500 тэрбум төгрөг зүгээр ингээд шилжүүлчихдэг юм уу? Тэгээд хамгийн өрөвдөлтэй нь аудитын дүгнэлт дээр тооцоо нийлье гэсэн чинь тухайн компани нь, төсөл хэрэгжүүлэгч компани нь нутаг руугаа явсан учраас тооцоо нийлэх бичиг баримт гаргуулж авч чадахгүй байна гээд ингээд өрөвдөлтэй юм бичээд суучхаж байгаа байхгүй юу. Тэгээд энийг ерөөсөө гайхаад байгаа юм.

Дараа нь энэ төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн объектыг хэрхэн түрээслэх тухай байна аа? Төр өөрөө өөрийн өмч хөрөнгөтэй мөртөө жилд 34 тэрбумаар оффис түрээслээд 14 тэрбумыг үйл ажиллагааны зардалд өгч байгаа юм. Ингээд нийтдээ 50 тэрбум төгрөг. Зөрөөд төр өөрөө өөрийнхөө хөрөнгийг түрээслэхдээ 11 тэрбум төгрөгөөр олж байгаа. Улаанбаатар хотын хотын төвд Засгийн газрын өмч буюу Засгийн газрын хөрөнгөд хотын төвд л байгаа. Дунджаар 50 мянгаар бусдад түрээсэлдэг бол өөрсдөө 171 мянган төгрөгөөр оффис түрээсэлдэг. 40 тэрбум төгрөгийн зөрүү үүсэж байгаа юм. Бид нар мөнгөтэйн зовлонг эдлээд байгаа биз. Мөнгөгүй улс ингэхгүй шүү дээ. Үндэсний аудитын

газар нь өөрөө байшин савандаа багтахгүй жилд 500 орчим сая төгрөгөөр бусдаас байр түрээсэлж байгаа юм.

Тэгэхээр Засгийн газраас хэзээ энэ асуудлыг нэг мөр шийдээд төр өөрийнхөө өмчийн хөрөнгөд өөрөө байрших юм бэ? Үгүй яагаад ингээд өөрийнхөө хөрөнгийг бусдад метр квадрат нь 50 мянгаар түрээслээд өөрсдөө яагаад метр квадратыг нь 171 мянгаар түрээслээд байгаа юм? Ийм бодлого ийм үйл ажиллагаа гэж байдаг юм уу? Энэ чинь компаниар бол хамгийн муу менежмент шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах бэ? Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм Шижир гишүүний бариад байгаа зарчим яг миний хийж байгаа ажлын зорилттой яг л нийцээд байдаг юм. Манай төрийн албан хаагч нар харж байна. Их Хурлын гишүүд ийм байгаа учраас л би та нарт энэ асуудлаа шийдье л гээд байгаа шүү дээ. Тэгээд энэ төрийн өмчит компанийн захирлууд бас харж байгаа. Их Хурлын гишүүд ийм шаардлага тавиад байгаа юм шүү. Тэгэхээр бүгдээрээ бол арга замаа олсон шүү дээ төрийн өмчит компанийн хууль гаргачихсан.

Тийм учраас тэр нөгөө 12 компани руу олон улсын тэр менежмент, санхүүгийн аудит оруулъя гээд урилга хүргэ гээд шийдвэр гаргаад байгаа чинь яг энэ Шижирийн яриад байгаа юм байхгүй юу. Тийм Шижир гишүүн ээ таны яг хүслийг биелүүлэх шийдэл бидэнд байна. Ингээд үе шаттай явуулж байна. Төрийн өмчит компанийн хууль баталчихлаа. Одоо намар оруулаад ирнэ. Тэгээд намайг худлаа ярьсан гээд та нар дээр шүүмжлээд байсан. Би ерөөсөө худлаа яриагүй. 260 орон тоог цомхотгочихсон. Тэгээд “Эрдэнэс Монгол” ч байхгүй болсон. Чингис хаан баялгийн сан болчихсон. Одоо цаашаа төрийн өмчит компани, ашиггүй ажиллаж байгаа төрийн өмчит компани гэж байхгүй. Төр ашиггүй ажиллаж байгаа тодорхой салбарт нийтийн үйлчилгээг иргэддээ хүргэх зорилгоор тодорхой орон нутгийн өмчит компани байгуулаад ажиллаж болно. Бусад тохиолдолд болохгүй ингээд шийдчихсэн. Би сая та бүхэнд хэллээ. Ки Пи Ай-ын үнэлгээг бол захиралтай, төлөөлөн удирдах зөвлөл гэрээ байгуулаад үр дүнгийн урамшуулал олгоно. Захирлын цалин хөлс урамшуулал бол үр дүнгийн тогтолцоо тэр Өү Ки Ар гэдэг зарчим дээр шилжинэ. Цалин 53.1 хувиар буурна. Ийм л шийдвэрийг ТУЗ рүү өгсөн. Энийгээ биелүүлнэ.

Дээрээс нь тэр наад тэр Эрдэнэс, Оюу толгой билүү тэр компани дээр оффис авчихсан энэ тэр асуудал үүсээд байна шүү дээ. Шударга үнэний дуу хоолой болчихсон зарим хүмүүс сүүлийн үед геел-дээд байгаа. Тэгээд тэр хүмүүс дээр би хариуцлага тооцно. Хариуцлага тооцно. Тэгээд л явуулна. Ер нь бол ингээд худлаа хэлэхгүй ажил ингээд шууд шууд явж байгаа.

Тийм учраас тэр оффис түрээсэлдэг байдал бол одоо байхгүй. Одоо тийм юм байхгүй. Тэгээд Их Хурлын гишүүдээсээ би хүсэж байгаа энэ ажлыг хийхэд надад тийм хугацаа бөгөөд тайван байх боломж өгөөч ээ. Тэгэхгүй бол тэгээд хүн яриад хэдүүлээ ингээд явбал явахгүй шүү. Агуулгаар нь зөв гэж бодсоноо харъя. Энэ шинэчлэлт, өөрчлөлт дотор та бүхний сонгуульд ажиллаж байсан менежер, туслахууд зөндөө өртөнө. Хүний, өөрийгүй энэ дээр тайван байлгаарай. Хуулиа

барья, зарчимтай байя. Тэгээд яг энэ таны хэлээд байгаа бүгдээрээ энэ асуудлаа авч гарахгүй бол бас арай хэтэрсэн. Би бас зөвшөөрч байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүнийг нэмж тодруулъя.

**Ө.Шижир:** Тэгээд хариуцлагын асуудалтай холбоотой асуултад хариулт авч чадсангүй. Энэ аудитын газрын гаргасан дүгнэлтүүд дээр хэчнээн хариуцлага тооцогдсон байдаг юм? Бид нар жил болгон л ийм 10 их наядын л зөрчил ярьдаг, жил болгон л хэдэн их наядын зөрчил ярьдаг. Тэгээд дээр нь нэмэх нь төрийн өмчит компаниудын дахиад л зөрчил яригддаг. Тэгээд үүн дээр ерөөсөө 1 ч хариуцлага тооцогдсон юм байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр үүн дээр би тодорхой бас хариулт авмаар байгаа юм.

Ер нь бол төр өөрөө өөрийнхөө хөрөнгийнхөө эзэн байж байж л бусдын өмнө өнгөтэй өөдтэй явна шүү дээ. Тэгэхгүй өөрт байгаа юмаа үрэн таран хийчхээд, өөрт байгаа хөрөнгөө үнэлж чадахгүй бусдад үнэгүй шахуу ашиглуулаад зөрж бусдаас түүнээсээ 4 дахин үнэтэй оффисын барилга, талбай түрээслээд байхаар чинь энэ улсад чинь энэ жилд хэмнэх 40 тэрбум төгрөг чинь хайран биш байдаггүй юм уу? Бид нар тийм мөнгөтэй болчихсон улс юм уу? Мөнгөгүйн зовлонгоо л гайхаад байдаг. Гүйцэтгэлийг нь харахаар мөнгөтэйн зовлонгоо л илээд байгаа хүмүүс байгаад байгаа байхгүй юу. Хамгийн гол нь төлөвлөлт нь буруу, төлөвлөгөө нь буруу, гүйцэтгэл нь буруу үр дүн нь тэгэхээр буруу л гарч таарна. Тэгээд энд 27 оноос хойш энийг шийдээч ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр хариуцлагатай холбоотой асуудлаар Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Энэ улсын төсөв одоогийн баримталж байгаа хуулиар Их Хуралд өргөн мэдүүлэхэд энэ чинь өөрөө компаниар бол зүгээр мөнгөн гүйлгээний тайлан байна шүү дээ. Орлого, зарлагын бүртгэл. Тэгээд нөгөө социализмын үед батлагдсан онолоор капитализмыг удирддаг. Тэгээд энэ дээр яг үнэнийг яриад урагшилчихъя гэхээр улс төр нь ингээд дийлдэхгүй ингээд байгаа байхгүй юу. Тийм учраас сууриар нь зөв болгохын тулд төсвийн реформыг намар эхлүүлнэ. Олон жил олон ч улс төрчид ярьсан юм билээ. Үүнийг хийхийн тулд төрийн өмчит компани ч бай төр ямар хэмжээний хөрөнгөтэй вэ гэдэг үнэлгээг явуулахын тулд энэ нийтийн өмчийн хуулийг баталж өгөх хэрэгтэй. Өмчийн эзэн хэн бэ гэдгээ тодорхойлж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгж байж энэ хөрөнгө мөнгө чинь тодорхой болж байж энэ өөрөө тэр 89 оны тэр Жи Эф Эс стандарт гэдэг юм 2014 он руу явна шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Аудит, Аудитын газрын дарга 3 номер.

**3.Цэдэнжав:** Шижир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Цэдэнжав. Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүнгээр 2024 онд төрийн аудитын байгууллагаас 251 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар 225 албан шаардлагыг хүргүүлсэн. 2025 онд бид 278 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар 252 албан шаардлагыг хүргүүлсэн байгаа. Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлтэй холбоотой асуудлаар бид хууль зөрчилтэй холбоотой хариуцлага тооцох арга хэмжээ авах ёсоор төсвийн ерөнхийлөн захирагчид бол албан бичиг хүргүүлээд ажиллаж байна. 25 оны

албан шаардлагын хэрэгжилт хугацаа бол болоогүй байгаа. 24 оны албан шаардлагын хэрэгжилт бол.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмж хариулъя.

**3.Цэдэнжав:** Албан шаардлагын хэрэгжилт бол 90 гаруй хувийн хэрэгжилттэй ажиллаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд хариулъя. Нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Шижир гишүүн ээ энэ оффистой холбоотой асуудал байгаа юм. Бид ийм зарчим бариад нэлээн явсан байхгүй юу бас улс төр эд нар энэ Их Хурал дээр асуудал үүсээд төр өмчтэй байна хувьчил гээд. Тэгээд шийдвэр гаргаад байшин барилгууд нь хувьчлаад бараг дууссан. Ингээд компаниуд бол оффисоо яах юм бэ гэхэд хувийн хэвшлээ дэмж, хувийн хэвшлээсээ түрээсэл. Дэлхийн нийтлэг жишиг бол оффис түрээсэлдэг. Төрийн өмчит компаниуд оффистой байх болохгүй гээд ингээд баахан оффис түрээсэлсэн. Одоо наад оффис түрээслэх яасан их мөнгөтэй юм, боль гэвэл буцаад өмчтэй болох асуудал руугаа очно.

Машины дугаарын асуудал байгаа юм. Дарга нар улаан номертой машинтай яваад байна больцгоо цагаан бол гээд ард түмэнтэйгээ адилхан бол гээд болгосон. Бас улс төр үүсээд энэ чинь хаана байгаа нь мэдэгдэхгүй байна, цэнхэр болго гэсэн. Одоо цэнхэр болгочихсон. Яамнууд машинтай байна болохгүй байна, нийлүүл гэсэн нийлүүлчихсэн. Такси.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр энэ мөн автомашины хэрэглээн дээр адилхан. Бааз байгуулсан бааз ашигтай ажиллах ёстой гэж шахсан. Тэгэнгүүт яамнууд ажиллахаа больсон. Таксигаар яв гэсэн. Урсгал зардал, томилолт нь дийлдэхээ больчихсон гэх мэтийн ингээд. Тэгэхээр энийгээ ярилцаад мөр тодорхой болгомоор байна. Яамдын унах машин тэд байна. Яамдын 1 албан хаагчид ноогдох оффисын хэмжээ тэд байна. Төрийн өмчит компаниуд оффистой байх юм уу, эсвэл түрээслэх юм уу бас энэ бодлогыг нь л гаргаад өгөхгүй бол ингээд тухай тухай улс нөгөө жилийнхээ Их Хурлаас шалтгаалаад 1 шийдвэр 2 тал руу туйлширч ээлжлээд гараад байгаа байдал байгаа байгаа байдал байгаа юм. Эдийн засаг чинь тэлж байна, салбарууд өргөжиж байна. Яах аргагүй энэ тэлж байгаа энэ оффис хэрэглээ шаардлагууд үүсээд байдаг. Тэгээд яаж шийдэх вэ гэдгээ бас шийдээд өгчихвөл бидэнд бас амар болно шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүн нэмж тодруулъя.

**Ө.Шижир:** Манай Энхбаяр сайд асуултаа буруу ойлгосон бололтой. Аудитор чинь ийм байгаа шүү дээ. Нийтдээ төр өөрөө өөрийн өмчийг 81 мянган м<sup>2</sup> талбайг бусдад түрээслээд дунджаар 50 мянгаар түрээсэлж байгаа байхгүй юу. Өөрийн өмчийнх нь талбайг. Зөрөөд 80 мянган м<sup>2</sup> талбайг үүнээсээ 3.5 дахин үнэтэй түрээслээд байна гэж байгаа юм. Дүндээ дүн байгаа биз дээ талбайн хэмжээ нь. Өөрийнхөө талбай дээр, өөрийнхөө талбай дээр өртгөөр нь байж болохгүй яагаад бусдаас 3.5 дахин илүү түрээслээд байгаа юм бэ гэж байгаа юм. Асуулт нь.

Тэрнээс төр нэмж оффис авах тухай яриагүй. Угаасаа өөрт чинь байгаад байна шүү дээ. Өөрт чинь байгаад байгаа юмаа ашиглахгүйгээр бусдаас 3.5 дахин үнэтэй түрээслээд байна гэсэн үг. Нэг.

Хоёрдугаарт цэнхэрт цэнхэр дугаартай холбоотой асуудал ярилаа. Яг үнэндээ бол эмнэлэг, цагдаа, онцгой байдал, хил хамгаалахын машинууд л цэнхэр дугаартай байгаа шүү дээ. Сайд нарын, Засгийн газрын харьяа яамны яамнуудын машин бүгд цагаан дугаартай байгаа шүү дээ. Тэмээнээс тэмдэгтэй эмнэлэг цагдаа, онцгой, тэмээнээс тэмдэгтэй, тусгай тэмдэгтэй машинууд л цэнхэр дугаартай байгаа шүү дээ. Одоо хэдүүлээ гараад харъя л даа цэнхэр дугаартай машин бараг байхгүй дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Шижир гишүүн их чухал асуудал хөндөж байгаа юм. Би сарын өмнө яг энэ гүйцэтгэл ярьж байхад хэлж байсан ирэх долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар яг таны саяын асууж байгаа төрийн өмчийн компаниудын түрээсийн байртай холбоотой ажлын хэсгийн хяналт шалгалтын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх гэж байгаа. Ер нь урьдчилсан байдлаар чуулган дээр хэлж байсан тооноос 2 дахин их түрээс төлдөг гэдэг ийм зүйл гарч ирсэн. Би энийг бас дутуу байна гэж үзсэн.

Тийм учраас өөрийнхөө тушаалаар энэ ажлын хэсгийг байгуулж, яг 45 хоног ажиллуулаад байгаа. Энийг дахиж үргэлжлүүлж ажиллуулах ёстой юм байна гэж үзсэн. Яагаад гэхээр бас дутуу байгаад байна. Энэ байдал дээр зүгээр хамгийн томыг нь хэлчихье би энэ Иргэний нисэхийн ерөнхий.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр 2025 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэнэ гэдэг бол 2024 оны баталсан төсөв буюу түүнээс өмнөх он жилүүдэд шилжиж ирсэн төсвийн гүйцэтгэлийг ярьж байгаа гэсэн үг. Тэгэхлээр мэдээд эндээс бол сургамж авна уу гэхээс л 2, 3 жил өнгөрчихсөн. Тэгээд минут цөөхөн байгаа учраас би энэ өнгөрснийг биш энэ гүйцэтгэлээс санаа авч, Ерөнхий сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Хэрэг эрхлэх газрын дарга нарт хэд хэдэн санаа хэлэх гэсэн юм. Сая Ерөнхий сайд төсвийг нэгдүгээрт тодотгоно гээд хэлчихлээ. Хоёрдугаарт 27, 28 онд том алхам хийнэ гээд хэлчихлээ.

Тэгэхлээр та 28 оны алхам чинь бол та үр дүнг нь үзэхгүй сонгууль болчихно. Тэгэхлээр та үнэхээр алхам хийх гэж байгаа бол таны үндсэн энэ улс төрд үлдээх тэр үнэт зүйл бол 27 оны төсвөөр л өнгө зүс нь илэрнэ. Мөн 26 оны тодотголоор гээд илрэх юм байгаа юм. Тэгэхлээр би энэ дээр юу хэлэх гэж байна вэ гэхлээр энэ 27 оны төсвийн тодотгол биш ээ, 26 оны төсвийн тодотгол, 27 оны төсөв 2 дээр 2, 3-н зүйлийг анхаараач гэж хэлэх гэж байгаа юм.

Нэгдүгээрт эрүүл мэнд, боловсролын энэ дутуу баригдсан барилгуудыг ерөөсөө дуусгая. 28 онд дуусгана гэвэл худлаа. Энэ 25 оны төсөв гүйцэтгэл ярина гэдэг чинь 3, 4 Засгийн газрын өмнөх ажлыг бид нар ярьж байгаа байхгүй юу. Харин ч тэрнийх энэнийх гэж хүн рүү хийхгүй байна л даа.

Тэгэхлээр юу хэлэх гээд байна вэ гэхлээр 26 оны төсвийг тодотгоход сая 25 оны гүйцэтгэлээ хийчихсэн бөгөөд жилийн эцэст гүйцэтгэлээ авч чадаагүй маш олон компаниуд байна. Замын, барилгын. Яг оны эцэс рүү гүйцэтгэл нь ирчихсэн тэгээд чөлөөт үлдэгдлийг нь татчихсан. Тийм учраас 25 онд ажлаа хийж дуусчхаад одоог хүртэл мөнгөө авч чадаагүй энэ хувийн хэвшлийгээ татан унагаж байгаа энэ асуудлаа дэмжиж, компаниудаа дэмжиж 26 оныхоо төсвийн тодотголд энэ гүйцэтгэлээ хийсэн компаниудын мөнгийг бүрэн тавьж нэг цэглэмээр байна. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал нь 27 оны төсөвт 24 оноос хойш 3, 4 тасалж орж ирсэн хөрөнгө оруулалт дуусав уу, болив уу, дуусав уу болив уу гээд олон жил болчихсон учраас хувийн хэвшлээ татан унагаад байгаа асуудлууд байж байгаа юм. Тийм учраас 27 оны төсөв бол ерөөсөө хагас дутуу байгаа, 50-аас дээш гүйцэтгэлтэй байгаа бүх объектуудыг дуусгамаар байна. Ерөөсөө л ингэж үлдэгдлээ цэвэрлэж авахгүй бол өө ерөнхийдөө нэг энэ жил төдийг тавья гээд л амсуулна гэж ярьдаг шүү дээ. Амсуулж тавьсаар байтал ерөөсөө бүтэн гүйцэд ч юм алга, дууссан ч юм алга. Тэгээд энэ урт хугацааных нь явцад нь нөгөө 24 оны, 25 оны тэр үнэтэй цэнтэй юм чинь 26, 27-нд ингээд хувийн хэвшлээ бүрэн дүүрэн татаж унагаад байна.

Дээр нь КОВИД-ын үед барилгын салбараа тэр тарифын асуудлыг нь шийдэхгүй байж байгаад татан унагачихсан бол одоо энэ замын салбарыг бүтэн татан унагах гээд байна. Яагаад вэ гэхлээр замын ажил хийж байгаа компаниудын бараг 70-аад хувь нь газар шорооны ажил байдаг. 70-аад хувийнх нь ихэнх нь түлш шатахуун буюу дизелийн түлшний асуудал байдаг. 92-ын асуудал байдаг.

Тэгэхлээр юу хэлэх гээд байна вэ гэхлээр энэ шатахууны болон бусад инфляцын асуудлуудыг нь хийж өгөхгүй бол Монголд чинь ер нь бүтэн нэртэй, бүлээн зүстэй чадавхтай хувийн хэвшлийн компани гэж байхгүй боллоо Ерөнхий сайд. Тийм учраас энэ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Батсуурь гишүүн бол маш зөв асуудлыг хөндлөө. Энэ амьдралын жаргал, зовлонг бас ойлгодог, аймаг, орон нутаг удирдаж байсан хүн бол бодитой бас шийдэл ярьдаг. Би Батсуурь гишүүнтэй бас нэг засагт хамтарч ажиллаж, бас асуудлыг авч гардаг ийм бас мэдлэг, ур чадварыг нь бас хүндэтгэж явдаг. Тэгээд манай энэ Ардчилсан намын бүлэгт бол ийм маш их асуудлыг ийм шинжлэх ухаанчаар үнэнийг ярьж асуудалд ханддаг гишүүд зөндөө бий. Тэгээд би сөрөг хүчнээ бол надтай ийм шийдэл яриасай гэж үргэлж хүсдэг. Тэгээд шийдэл ярихаар өөдөөс огцруулна та нарыг гээд ингээд байхаар нөгөө бид нарт ерөөсөө нөгөө яриа хэлцэл байхгүй.

Тийм учраас би саяхан энэ Нийгмийн даатгалын хууль дээр түвшин гишүүнтэй хүртэл бас энэ санхүүгийн захаа яаж дэмжих вэ энэ тэр гээд ярих ч бас сайхан уур амьсгалтай байсан. Би ер нь асуудал дээр дандаа ингээд шийдэл яриад явбал маш их баяртайгаар хүлээж авна. Тэгэхээр таны хэлж байгаа зөв өө. Би Сангийн сайдад, Эдийн засаг, хөгжлийн сайдад би бас тодорхой бас үүрэг өгье

өө. Энэ хөрөнгө оруулалтын ажлуудаа дуусга аа ирэх оны төсөв төлөвлөхдөө. Энэ бол үнэхээр төвөгтэй байгаа шүү.

Жишээ нь өнгөрсөн онд 700 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гаргаж чадаагүй юм байна лээ. Гаргаж чадаагүй. Үүнээс 270 тэрбум төгрөг нь гүйцэтгэлээ ирүүлсэн боломж мөнгө байхгүй гээд гаргаагүй. Тэгээд юмны үнэ жил ирэх тусам өсөөд байдаг ийм байдалтай. Тэгэхээр ирэх оны төсөв дээр саяын мөнгө төгрөгийг нь гаргаж чадаагүй тэр 270 тэрбум төгрөгийг тодотголоор шийдэх хэрэгтэй одоо Сангийн яамныхан. Тэр хувийн хэвшлийг ажил хийлгэсэн бол битгий ингээд хүндрүүлээд бай. Жил ирэх тусам наад мөнгө чинь өсөөд байна. Зардал нь улам өсөөд байна. Бараа, бүтээгдэхүүнийх нь үнэ нь өсөөд байна. Одоо тодотголоор шийдэхгүй бол ирэх жил улам л өснө. Яагаад хүнээр ажил хийлгэсэн бол мөнгө төгрөгийг нь өгдөггүй юм бэ? Тэгээд би ажил аваад гүйцэтгэлээр нь санхүүждэг энэ төсөв өөрөө. Тэгээд нөгөө гүйцэтгэл нь болоогүй бол өгөхгүй байна гээд байдаг цаг яваад байдаг бараа, бүтээгдэхүүний үнэ өсөөд байдаг биднээс шалтгаалахгүй өсөөд байдаг. Тэгэхээр энэ асуудлаа бид нар шийд гэдэг би үүргийг өгч байна. Ирэх оны төсвийн тодотгол дээр ингээд оруулж ир ээ. Тэгээд шийдье. Энэ нэгдүгээр асуудал.

Хоёрт бол Батсуурь гишүүнд би бас хандаж хэлэхэд би ерөөсөө сонгуульд зориулж ажиллахгүй байгаа шүү. Би тэр 27 оны, 28 оны сонгуульд зориулж ажиллахгүй байгаа. Би зөвхөн өнөөдөр байгаа үедээ түүх бүтээе л гэж ажиллаж байгаа. Тийм учраас асуудлыг сууриар нь харахын тулд Их Хурлаар хуулиа батлуулаад реформын шинжтэй зохицуулалтуудыг хийсэн. Манай Засгийн газар 86 хоногийн хугацаанд хийсэн ажил 100 хоногийн 100 чөлөөлөлтийг 07 сарын 07-нд танилцуулна. Үгүй эргээд бодоход бас их олон реформыг явуулсан байна. Тийм баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батсуурь гишүүн тодруулъя.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ үгүй сонгуульд зориулсан биш. 28 он бол сонгуультай жил учраас таны 28 оны төсвийн тэр алхам хийх шинэчлэл чинь бол үр дүн нь харагдахгүй шүү. Тийм учраас 26 оны тодотгол, 27 оны төсөв 2 дээр л тэр алхмуудыг хийж энэ саяын хэлдэг үр дүнтэй ажлыг хиймээр байна гэж.

Ер нь бол тэрийг дуусгахаас өөр арга байхгүй. Жишээлэх юм бол 100 жил болсон гэж баяраа хийгээд байгаа мөртөө гэр цэцэрлэгтэй сумд зөндөө байна. 3 ээлжийн сургуулиудыг энийг ерөөсөө дуусгах хэрэгтэй.

Дээр нь төсвийг 3 хувааж тавина гэсэн Их Хурлын тогтоол байна уу ямар юм байна вэ тэрийг хүчингүй болгох хэрэгтэй. Ерөөсөө маш богино хугацаанд олон юм биш жилд нь багтааж дуусгадаг л ийм хэлбэр рүү орох юм бол хувийн хэвшил чинь ч хөл сөхрөхгүй маш богино хугацаанд үр дүнгээ үздэг, хөрөнгө оруулалтын чанартай, ашигтай энэ зүйл нь бол маш тодорхой харагддаг болох юм гэсэн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Төсвөө бид нар төлөвлөхдөө бол нэгд шилжиж байгаа хөрөнгө оруулалтуудыг шийднэ. Нэгд. Тэгээд их засвар, арчлалт, эхлүүлчихсэн байгаа

ажил хөрөнгө оруулалтуудаа бүгдийг нь дуусгана. Тэрний дараа дараагийн эрэмбэ бол тэр шинээр ажлууд гэж бол ойлгох ёстой.

Ер нь энэ одоогийн энэ Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль жишээ нь ер нь тэгээд л өөрсдийгөө л хөгжлийг чөдөрлөчихсөн юм шүү дээ. Тэгээд 06 сарын 01-нд тендер зарлаж чадаж гэрээ байгуулагдаагүй бол ингээд бүх юм зогсдог энэ тэр чинь ер нь амьдрал дээр худлаа юм байна лээ шүү дээ. 06 сарын 01-нд ер нь хаа хаанаа амжихгүй байгаа шүү дээ. Тэгээд энд хэн хохирч байна? Одоо ингээд л баахан төсөв мөнгө хураагддаг. Бөөн юм болж төсөв батална. Төсөв мөнгө нь хураана. 06 сарын 01-нд тендер зарлаж чадаагүй, гэрээ байгуулж чадахгүй. Яг ид бүтээн байгуулалтын үеэ өөрсдөө чөдөрлөчихсөн. Тэгээд энэ хууль муулийг оролдъё гэхээр тэгээд оролдуулахгүй л байна л даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батсуурь гишүүн тодруулъя.

**Ж.Батсуурь:** Тэгэхлээр одоо 26 оны төсвийн тодотгол шууд ингээд яригдаад эхэлнэ. 26 оны та ярина ч гээд хэлчихлээ. Тийм учраас юу гэж вэ гэхлээр одоо энэ 26 онд явж байгаа хөрөнгө оруулалтууд бол 20, 21, 22, 23 оны магадлалтай. Тийм учраас энэ юун дээр Зам, тээврийн яамны шийдвэр нь гарчхаад Сангийн яам байна хориг тавиад байгаа гэсэн. Яагаад вэ гэхлээр тэр үед түлш 2000 байхад, 1800 байхад хийсэн төсвийг одоо явж байгаа ажил нь 3500, 3800, 4000 гарчхаад байна. Бодит нөхцөл бид нар ингээд асуудлыг шийдэж өгөөч гэнгүүт энэ магадлалыг маш богино хугацаанд бараг наадмын өмнө хийх та үүрэг даалгавар өгөөд энэ үр дүнгээр нь 26 оны төсвийн тодотгол суулгаж өгөх юм бол мөн хувийн хэвшлийг аврах боломж байна. Ингээд 27-ны төсөвт бүх хөрөнгө оруулалтуудаа дуусгаж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Энэ хөрөнгө оруулалтын ажлуудаа дуусгацгаая. Тодотгол дээрээ өргөн барья. Манай Эдийн засаг, хөгжлийн сайд байна. Сангийн сайд нарт би бас үүрэг өгч байна. Гишүүд ээ та нар маань бас нэг зүйлийг ойлгооч ээ. Төрийн хэмнэлтийн хууль гээд хууль байгаа сайн хууль мөн. Гэхдээ Төрийн хэмнэлтийн хуулиар тэр 06 сарын 01-нд гэрээ байгуулаагүй бол шууд хэмнэж байгаа шүү дээ. Тэр дотор тоног төхөөрөмж хүртэл давхиж байгаа байхгүй юу. Засвар үйлчилгээнүүд хүртэл яваад байгаа шүү дээ. Энэ чинь жилийн хугацаанд тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ явах байтал 06 сарын 01-нд ингээд хаачихдаг. Яг амьдрал дээр энэ чинь худлаа.

Тэгээд би Төрийн хэмнэлтийн хуулийг энэ заалтыг өөрчилье өө энэ худлаа байна гээд бариад ороод ирвэл ороод ирсний дараа Учрал хэмнэлтийн хуулиас буцлаа гээд геел-дээд эхэлнэ шүү дээ. Тэгээд ер нь амьдралаа, энэ улс орноо бодмоор байгаа юм. Тэрнээс хэн сайн геел-чингээ гээд бодвол ингэж явахгүй. Тэгэхээр Батсуурь гишүүний манлайл аа. Би дэмжье. Хэдүүлээ жоохон амьдралтай байя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Өдрийн мэнд ээ. Энэ бид нар 25 оныхоо гүйцэтгэлийг ярьж байх шиг байна. Тэгээд болж байгаа, бүтэж байгаа юм шиг ингээд үзээд хараад явахад

бол хэцүү л байна л даа. Энэ гадагшаа гаргаж байгаа түүхий эдийн энэ боломж бололцоо энэ үнэ ханшийн таатай нөхцөлд улсын төсвийг гүйцэтгэлээр нь ингээд харах юм бол, ард түмний амьдралтай зэрэгцүүлээд үзэх юм бол үнэхээр тэнгэр, газар шиг ялгаатай байна.

Өнөөдөр, саяхан элсэлтийн ерөнхий шалгалтаа өгч байгаа хүүхдүүдийг л хар. Тэр барьсан анги танхим, тэр авч байгаа цалинтай багш нараараа ингээд заалгаад энэ хүүхдүүд чинь өнөөдөр 3 хувь нь л тэнцэж байна шүү дээ. 60-аас дээш оноо авчихъя.

Өнөөдөр энэ эрчим хүчнийхээ салбарыг хар. Өнгөрсөн жилүүдэд ямар их хүнд нөхцөл байдалд өвөлжүүлэв. Цаашдаа ч тэгээд их аятайхан юм амлаж чадахгүй ингээд л сууж байна. Энэ мөнгө төгрөгөө хааш нь зарцуулаад юу хийгээд ийм болгочхоод байдаг юм бэ? Одоо гаднынхан тэгээд энэ хүмүүс ярьж байна шүү дээ. Үгүй ийм боломж бололцоотой энэ улс орныг яаж ингэж хөгжүүлэхгүй ядуу ингэж амьдруулж чадаад байна аа? Үнэхээр чадаад байх шиг байна л даа. Тэгээд Ардын намын 50 оныхон хулгай хийгээд л гараад явчихдаг. 60 оных нь хулгай хийгээд л гараад явчихдаг. 70 оных нь хулгай хийгээд л гараад явчихдаг. 80 оных нь хулгай хийгээд л гараад явчихдаг. Одоо манай Учрал сайд чинь 97 биш ээ 87 оных билүү? 90 оныхон гэж үзэж болох юм ингээд явчихна. Дараа нь 2000 оныхон бэлэн байх юм уу яах юм? 2010 оныхон чинь арай сургууль, цэцэрлэгтээ л явж байгаа байх л даа. Арай болоогүй байх. Тэгээд л дараагийнх нь ингээд манай үе сайхан болчихно л гээд байдаг. Иймэрхүү юмаар аргацаагаад.

Ингээд энэ төрийн мөнгийг татвар төлөгчдийн мөнгийг төсөвлөөд 30 хэдэн хувийг нь ДНБ-ийг улс дээрээ татаж ирээд төрийн өмчийн компаниуд дээрээ бас 30-аад хувийг татаж ирээд тэгээд цаана нь хэдэн уул уурхайн том компаниуд бүгдийг нь идэж уугаад ингээд энэ хувийн хэвшил чинь орон зай байна уу байхгүй юу?

Нөгөө мега төслүүд чинь юу болсон бэ? 24, 25 онд маш гоё мега төслүүд хэрэгжүүлнэ. Улс орон ингээд цэгцэрчихнэ, хөгжинө өө гэсэн тэр юу болсон бэ? Тухайн үед энэ чинь мега хулгай болно гээд би хэлж л байсан. Өнөөдөр би уучлалт гуйгаад сууж байх ёстой байхгүй юу. Одоо энийг ярьдаг хүн хэн ч байхгүй. энэ Өмнөд Солонгос яагаад хөгжөөд байгаа юм? Тэр Ерөнхийлөгчтэйгөө хариуцлага тооцож чадаж байна. Тэргүүн хатагтай нь 7 жилийн ял аваад л явж байна. Тэр цүнх авсны төлөө шүү дээ. Манайд яаж байна вэ? Нөгөө дуурайгаад байдаг Сингапурын Ли Куан Ю чинь улс орноо хөгжүүлээд өөрийнхөө тэр намынхаа нөхдүүдийг хуулийн хариуцлага тооцоод явуулчихсан байгаа. Тэгээд манайхан яадаг вэ гэхээр Ли Куан Ю тэр замыг сонгочихсон, нөгөө нэг зам нь бол авлига, хулгайтайгаа эвлэрээд явах байсан. Тэгээд ард түмнээ үгүйсгээд энэ замыг нь манайхан сонгоод яваад байх юм. Энийгээ яах юм? Ганц гялтайх юмнууд байна л даа. Тэр саяхан хийсэн Оюу толгой гээд л. Баахан уриа лоозон тавьдаг. Тэр чигээрээ үлддэг. Тэгээд энэ авлига, хулгай, гэмт хэрэгтэйгээ тэмцэхгүй нөхцөлд улсын төсөв ямар ч байгаа нэмэр байхгүй. Тэгээд энэ хуулийн дагуу амьдардаг, мөрөөрөө ажлаа хийж байгаа энэ хүмүүсийг шийтгэж байгаа байхгүй юу. Энэ авлига, хулгай, гэмт хэрэгтэйгээ тэмцэхгүй байгаагаар үгүйсгэж байгаа байхгүй юу. Хүмүүс чинь бас юмны наана цааныг ойлгодог болчихсон байна шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Би 2016 оноос Ганбат гишүүнтэй парламентад хамт сууж байна. Ганбат гишүүн бол 16 онд анх парламентад орж ирэхдээ л ийм 12, би бол тантай 16 оноос хойш. Тэгэхээр 16 онд анх би парламентад орж ирсэн үеэс л та ийм зарчим ярьдаг байсан. Улс төрд олон жил явахад бас Ганбат гишүүн шиг ингээд нэр цэвэр явна гэдэг хэцүү шүү нээрээ. Би бас энэ шинэ парламентын гишүүдэд хэлчихье. Улс төрд олон жил суугаад нэр цэвэр ингээд зарчим дээрээ үнэнч явах хэцүү шүү. Аль аль намд ийм зарчимтай гишүүд байгаа. Ганбат гишүүн шиг олон гишүүдтэй байсан бол бид бол хулгайд ялагдахгүй байх байсан гэж би боддог. Энэ бол бас үнэн чин сэтгэлийн үг. Тийм Ганбаа ах аа би тантай уулзахдаа бас хэлж байсан би унаад, босоод, бас уруудаж, өгсөж яваа хүн. Надад бол одоогийн улс төрчидтэй хэнтэй ч ямар нэгэн хамааралтай бизнес, элдэв бүлэглэлд нэгдсэн, элдэв тендерт оролцсон юм байхгүй учраас намайг шүүмжлэхээрээ сайндаа алиа бацаан л гэж байх шиг байна шүү дээ. Өөр сэдэв байхгүй байна шүү дээ. Би чинь атаман танихгүй. Энэ чин сэтгэлийн үг шүү дээ. 92 оныг та санаж байна уу? Би яаж санах юм бэ? Тэгэхдээ манай өнгөрсөн хугацааны бүх алдаа оноог засаж залруулсан суурь реформуудыг хийсэн дуусдаггүй яриаг дуусгасан Ерөнхий сайд байя л гэж би хичээж байгаа.

Тэгээд сонгуульд зориулсан элдэв үг, үйлдэл гаргадаг ийм биш. Энэ асуудлыг томоор нь харъя. Бидний бас энэ залуу үеийнхэн өөр болсон байна. Сая Оюу толгойн хэлэлцээр дээр ч харагдаж байна. Ийм ашиг сонирхолгүй, зарчимтай, тооцоо судалгаатай, асуудлыг сууриар нь хардаг дэлхийн хэлээр ширээний ард суугаад ярьдаг шинэ үеийн залуучууд энэ 17 жилийн хугацаанд төрж гарсан байна шүү дээ. Би тэдний дэмжлэгтэйгээр бид нар тэр Орано-тай ч гэрээ хийсэн. Сая Оюу толгойн хэлэлцээрт ч ялж байгаа байхгүй юу. Үгүй 17 жилийн өмнө тухайн үеийнхэн бол зүтгэсэн.

Гэхдээ энэ 17 жилийн хугацаанд тэр дэлхийн том компанитай бас нэг хэлээр ярьж мэдлүүлэхгүй байх энд ингээд сууж байгаа энэ олон төрийн албан хаагч нар бий болсон байна шүү дээ. Тэгээд энэ төрийн албан хаагч нараа бид нар хайрлаж, хамгаалж явж чадвал би бол хэнтэй ч хэлэлцээр хийж чадах юм байна гэдэг урам бас орчхоод байгаа шүү. Хулгайд ялагдахгүй юм байна гэдэг ийм урам олчхоод орчхоод байгаа. Бүүр чадалтай олон залуучуудыг би урьж оруулж, нам харгалзахгүйгээр зөв хүмүүсийг бүрдүүлж, би 28 онд бол би аягүй гэрэлтэй ирээдүйг хараад байгаа юм. Тийм учраас Ганбаа ах аа тэгээд тан шиг олон хүмүүс орж ирэх ёстой. Зарчимтай хэдүүлээ урагшлах ёстой. Ир.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** За яах вэ нөгөө яриад байсан мега төслүүдээс юу нь хэрэгжчихэв ээ? Оюу толгой гайгүй болчхож байх шиг байна. 14 мега төсөл гэл үү хэд ч гэлээ? Харин энэ Зам, тээврийн сайд чинь тэр боломжгүй гээд байсан тэр замыг холбочхов уу яачхав? Ямар ч байсан энэ Улаанбаатарын төв дээр, Улаанбаатарын дундуур шатах, дэлбэрэх юм явахааргүй л болгож байх шиг байна. Өөр юу байна аа? Хувийн хэвшлийг дэмжсэн ямар ажлуудыг хийчхэв ээ? Хувьчлал ер нь явагдав уу? Юу хувьчилчихсан юм? Өмнө нь хийсэн ажлууд хаана байна? Тэр банкныхаа хэдэн хувийг хувьчилна барина гээд байсан тэр явсан уу? Одоо энэ хувьцаа иргэд эзэмших ёстой. Тэр ногдол ашгаа тарааж байгаа компани

байна уу Говь энэ тэр гээд? Тэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга овоо юм ярих гээд л, хийх гээд л байхад тэрийг нь үгүйсгээд байх шиг байх юм. Та сая залуу.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм төрийн өмчит компаниуд дээр хамгийн зөв зарчим бол би сая Узбекистаны мөнгө босгосон зарчим гэж бодож байгаа. Яг хөрөнгө оруулалтын багц бий болгоод, ашигтай компаниудынхаа тодорхой хувиудыг нийлүүлээд портфоли болгож байгаад гаргачихсан. Тэгээд сая 12 компанид санал явуулсан. Үгүй ээ бод доо Блэк Рок, Франклин Темплтон хоёр Монголыг сонирхож байна шүү дээ. Би сая Тайланд форум дээр бас бас давгүй байлаа шүү дээ. Хүмүүс бас Монголыг бас эрүүлээр харж байна шүү дээ. Монголын шинэ Засгийн газарт итгэж байна шүү дээ. Тэгэхээр төрийн өмчит компанийн хөрөнгийг босгох чиглэлээр бол бид дэлхийн компанитай ажиллана. Тэгээд намар оруулж ирнэ. Тэгэхээр харин бас гадныхныг оруулаад ирлээ гээд геел-дээд эхлэх вий дээ тэр дээр нь Ганбаа ах аа сайн хэлэхгүй бол бас геел-чид их шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Ганбат гишүүн тодруулъя. Гүйцээж яриулах уу? Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

**Н.Учрал:** Тэгээд төрийн өмчит компаниуд дээр сая нөгөө Чингис хаан баялгийн сан болгосон. Сая ингээд Оюу толгойн хэлэлцээр дээр явж байна. Дээрээс нь таныг би 07 сарын 07-нд Засгийн газрын 100 хоног, 100 чөлөөлөлт дээр тайлангаа тавихад урьж байна. Тэр дээр бас дэлгэрэнгүй их сайхан ярья.

Эдийн засгийн эрх чөлөөний хууль 100 хуулийн реформ хийчихлээ. Одоо Засгийн газар наадмын дараа 5 жилийн тусгай зөвшөөрөл 10 болж байгаатай холбогдуулаад эрсдэлийн үнэлгээ сууриалаад шууд 5 жилийн тусгай зөвшөөрлийг 10 жилээр сунгаж өгнө өө. 41 тусгай зөвшөөрөл энгийн болж байгаа. Шууд хийнэ ээ. Хувийн хэвшлээ дэмждэг шинэ үеийн соёл тогтсон. Баялаг бүтээгч нараа дэмжинэ. Бодитоор 100 хоногийн чөлөөлөлтийг хийсэн. Хиймэл оюунаар тендер явуулна гээд хуульчилчихсан шүү дээ. Сая нөгөө 100 хууль дотор. Тэрийг явуулна. Ер нь хүний оролцоог багасгана. и-бизнес амилсан. Ингээд явж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбатын Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Сонсоод суугаад байсан чинь сүүлдээ чинь нэг нь намд орох, нэг нь намдаа авах ч гэх шиг юу ч яриад байгаа юм. Энэ чинь Зарлагын хяналтын дэд хорооны дүгнэлтийг хэлэлцэж байгаа биз дээ. Нөгөө тоглоом шоглоом болгоод л ингээд л байж байх юм. Тэгээд л юм хийхээр тануус геел хийж байна, эсэргүүцэж байна гээд л ярьдаг болчхож байна Учрал сайд. Тэгсний ачаар та өнөөдөр харин энэ намынхаа наад олигархуудынхаа эсрэг наад Ардчилсан намын хэдэн гишүүд чинь үнэхээр төвөгтэй байна, боорлоод байна аа, зөв чиглэл рүү явахгүй бол болохгүй байна, шударга ёсыг тогтоохгүй бол болохгүй байна гэдэг тэр үг хэлэх эрх чөлөөг чинь бид нар энд танд өгч байгаа шүү дээ Учрал сайд аа. Та хэлэлцэж байгаа асуудлаа ярихгүй төөрч яриад инээдэм шоглоом, тоглоом наадгай болгоод байх юм. Энэ чинь улсын ажил явж байна шүү дээ. Монголын ард түмэн харж байгаа шүү дээ. Энд 42 гишүүн сууж байгаа болохоор өнөөдөр та наанаа Ерөнхий сайд хийгээд намынхаа

олигархуудын эсрэг үг дуугарч чадаж байгаа эрхийг чинь Ардчилсан намын Их Хурлын гишүүн танд өгч байгаа шүү. Тэрийг аягүй сайн бодоорой та. Тэгээд таныг эсэргүүцээд үг хэлсэн хүмүүсийг юу яах гэж байгаа юм та? Одоо удахгүй яах юм коммунист намынхаа тогтолцоогоор шоронд аваачиж хийх үү? Эхнээсээ бид нар 2, 3 хүнээ хийлгэчихсэн байна. Авах гээд чадахгүй байна. Үгүй тэгээд энэ төсвийн гүйцэтгэл ярьж байхад чинь шал улс төрийн зорилготой сонин сонин юм яриад бараг намраас миний хийх ёстой бүх юмыг дэмжээрэй, битгий эсэргүүцээрэй гэх гээд байгаа юм уу яах гээд байгаа юм? Наадхаа тэр сар болгоныхоо мэтгэлцээн дээр асуулгынхаа цаг дээр л асуулцаагаад л ярилцъя л даа. Одоо энэ төсвийн гүйцэтгэл ярьж байна.

Аудитын дүгнэлттэй холбоотой хэдэн асуулт асуух гэсэн юм. Бүгд дээр нь аудитын дүгнэлт байгаа байх. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт гээд жагсаалтууд нь гараад ирчихсэн байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр 7.9 тэрбум төгрөг, Хүнс, хөдөө аж ахуйн сайд дээр 76 тэрбум төгрөг, Хууль зүйн яамны сайд дээр дүн алга. Сангийн сайд дээр 1 их наяд 200 тэрбум төгрөг, татвар төлөгч нарын татварыг түрүүлж авсан. Дараагийнх нь Сангийн сайд дээр 15 тэрбум төгрөг, Орхон аймгийн засаг дарга 9 тэрбум төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам дээр 927 сая төгрөг, Зам, тээврийн яаман дээр 267 сая төгрөг, Сангийн яаман дээр 3 тэрбум 900 гээд. Ингээд цаг бага байгаа болохоор товчилчихъё. Хот байгуулалт дээр 136 сая гээд явж байгаад энэ хүснэгтийн 19, 20 дээр байгаа. Боловсролын яам энэний өмнөх 18 дээр бол албан шаардлага хүргүүлсэн байгаа юм. 19 дээр Боловсролын яаман дээр 44.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоочихсон. Хууль зөрчсөн. Төсвийн тухай хуулийн 70.3.

20 Эрүүл мэндийн яамны сайд 116.1 сая төгрөгийн төсөв хэтрүүлээд зарцуулчихсан. Илүү олгосон гээд дүгнэлт гаргачихсан. Төсвийн тухай хуулийн 70.3 дээр төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилалд зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гэж байгаа юм. Тэгээд одоо чөлөөлье гэхээр 2 сайд нь байхгүй. Хариуцлага тооцох хүн байхгүй. Кабинетын зарчмаар явна гэвэл Ням-Осорын Учрал сайд 2025 онд Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан 24-өөс 25 онд. 25 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамны сайд байсан. Ингэхээр тантай хамаараад байгаа юм. Одоо яах вэ? Шударга ёсыг хэн сахиулах вэ? Хууль зүй яамны сайд энд сууж байна. Хууль зүй яамны сайд асан Энхбаяр сайд энд сууж байна. Хэн дээр хариуцлага тооцож энэ хуулийг хэн дээр хэрэгжүүлэх вэ? Ер нь цаашдаа яах вэ? Одоо ингээд сайд, дарга нар байж байгаад хууль зөрчиж баахан юм хийж байгаад сайдаасаа буугаад гишүүн болоод энд сууж байгаа гишүүдээ яах вэ бид нар?

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Энхбаяр сайд. Баттөмөрийн Энхбаяр.

**Б.Энхбаяр:** Төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор Үндэсний аудитын дүгнэлтэд үндэслэж холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох шинэ заалт орсон юм байна лээ. Хариуцлага тооцох гэдэг дотор бол тэр хуулийн заалт орохдоо нэг зүйлийг ялгаагүй зохицуулчихсан нь сонгогддог албан тушаал,

томилогддог албан тушаал. Бидний ярьдгаар бол төрийн жинхэнэ албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн улс төрийн албан тушаалтан гэсэн энэ нөгөө 3 албан тушаалын онцлог дээр сайн ялгалт, зохицуулалтыг нь бол хийгээгүй юм байна лээ. Энэ гүйцэтгэлийн дүгнэлтээс харахад бол сонгогддог албан тушаал буюу улс төрийн албан тушаалтныг ажлаас халах гэдэг ойлголт байдаг байхгүй юу. Улсын Их Хурлын гишүүнийг ажлаас халах гэж ойлголт байдаггүй. Эгүүлэн татах уу, огцруулах уу гэдэг хариуцлага байдаг. Төрийн жинхэнэ албан хаагч дээр юу байна вэ гэхээр ажлаас халах төрийн албанд эргэж оргож ирэхгүйгээр халах гэсэн ийм сахилгын арга хэмжээ байдаг.

Тийм учраас энийг нь ялгахгүйгээр хариуцлага тооцно гээд ийм ерөнхий заачихсан юм байна лээ. Энэ бол бид нар өнөөдөр 2025 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа. Энэ 25 оны талд нь бол Ардчилсан нам хамтарсан бас байгаа. Энэ 25 оны гүйцэтгэлээр үндсэндээ Оюун-Эрдэнийн Засгийн газар чинь 6 сард огцорсон байгаа. Тухайн тэр 6 жилийн хариуцлагатай намд бол Ардчилсан нам ял зэм бас юмаа үүрэх ёстой болно. Ингээд огцорчихсон байгаа юм. Тэр улс төрийн хариуцлага гэж яриад байна шүү дээ би нар. Засгийн газар нь бол хариуцлагаа үүрээд огцорчихсон байгаад байгаа юм. Төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой асуудлуудыг бол Үндэсний аудитын байгууллага, хууль хяналтын байгууллагад тэр зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтнуудыг нь бүгдийг нь бол шилжүүлсэн. Энэ шилжүүлсэн зөрчил, дутагдлуудын асуудлыг бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр тэр хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлуудын үр дүн, гүйцэтгэл юмнуудыг бол танилцаж, нэгтгэж байгаа асуудал бий.

Аудитын байгууллага бол шилжүүлэхдээ энэ нь бол юу гэдэг юм байна лээ шүү дээ албан шаардлага, акт ингээд энэ зөрчил зөрчлөөр нь бол ийм ялгамжтайгаар тэгээд яг энэ бол илүү гэмт хэргийн шинжтэй байна гэдэг үзсэн асуудлуудаа бол Үндэсний аудитын байгууллага бол шууд хууль хяналтын байгууллага руу ингэж шилжүүлж, хариуцлага тооцдог ийм асуудал, эрх зүйн орчин үйлчилж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Хэрэг эрхлэх газрын даргын үгийг бас аудитынхан, Төсвийн тогтвортой байдлынхан сонсож байгаа байх. Ер нь цаашдаа бид нар энэ аудитын дүгнэлт, зөвлөмжөө нэлээн чангаруулах ёстой. Гүйцэтгэх засаглалыг шахах ёстой. Та хэд бол Улсын Их Хурлын нүд, чих. Тэгээд түрүүн хэллээ шүү. Яг энэ шаардлагуудаа тухай тухай бүрд нь нэхээд болохгүй бол тэр хуулийн дагуу түрүүний үндэслэлүүдийг нь дурдаад явуулах ёстой.

Миний хэлсэн энэ асууж байгаа асуулт бол Төсвийн тухай хуулийн 70.3 Энхбаяр сайд аа төсвийн ерөнхийлөн захирагч гэж байгаа юм. Тэгээд төсвийн ерөнхийлөн захирагч гэж хэн бэ? Ерөнхий сайд, салбарын сайд нар. Тэгэхээр энийг би асуугаад байгаа байхгүй юу. Энэ дээр би асуултдаа гүйцээгээд хариулт авчихъя. Одоо яах вэ манай Ерөнхий сайд маань урьд нь ингээд бүх Засагт нь байсан байна. Одоо төсвийн ерөнхийлөн захирагч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Үгүй ээ харин хэлээд байна л даа. Төсвийн ерөнхийлөн захирагч гэдэг чинь Их Хурлын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүдийг хэлээд байгаа байхгүй юу. Одоо энэ Гантөмөр сайдаас эхлээд энэ Алтангэрэл хэн хэн, энэ чинь талд нь энэ хүмүүс чинь хариуцлага үйлдээд огцорчхоод байгаа байхгүй юу. Улс төрийн хариуцлагыг нь би яриад байна шүү дээ. Улс төрийн хариуцлагыг нь яриад байна. Улс төрийн албан тушаалтнууд нь хариуцлагаа үүрээд тэр Засгийн газар нь огцорчихсон. Бид нар тэр Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан сонсоод байгаа шүү дээ одоо. 2 Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан сонсоод байгаа байхгүй юу. Оюун-Эрдэнэ, Занданшатар гэсэн 2 Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан сонсоод байгаа шүү дээ одоо энэ.

Тэгээд энэ алдаа, дутагдлыг хамгийн гол нь дахиж гаргахгүй байх нь. Гантөмөр даргыг энд оруулж ирээд зодъё гээд байгаа юм уу, нийлж байгаад зодъё гээд байгаа юм уу ийм юм яриад байна шүү дээ та чинь.

**Ж.Бат-Эрдэнэ:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Хэнийг зодох нь энэ танхимд ярьдаг асуудал бас биш л дээ. Бид нар зарчим л ярьж байгаа. Хууль ярьж байгаа юм. Ардчилсан намын дарга байна уу, Ардын намын дарга байна уу хамаагүй. Ням-Осорын Учрал Ерөнхий сайдыг кабинетаа бүрдүүлж байхад нь л мордохын хазгай хийсэн шүү дээ. Олон залуучууд итгэж байсан. Илүү өөр томилолт байгаасай, өөр өнгө байгаасай, өөр үзэл санаа байгаасай, өөр энэ хуулийн шинэчлэлүүд реформуудыг хийчих хүмүүс оруулж ирээсэй гэсэн. Та юу гэлээ намаа бодож байна гэсэн шүү дээ. Энд бол Ардчилсан намынхан эрх ашгийн эрэмбээ улсаа боддог нэгд. Хоёрт намаа, бүлгийн эрх ашиг, гуравд хувь хүнээ бодож байгаа. Тэгэхээр та тийм шийдвэр гаргачихсан болохоор энэ залуу гишүүд чинь танд итгэл алдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ залруулахдаа ч гэсэн та энэ Ардчилсан намын үг хэлж байгаа гишүүдээ дэмжих хэрэгтэй. Тэгж байж та намынхаа олигархуудтай тэмцэнэ. Тэгж байж тэд нар чинь таны үгийг сонсоно шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм Очирбат гишүүн ээ би яг энэ олон жил яригдсан дуусдаггүй яриануудыг дуусгаж байгаа. Наад төрийн өмчийн компанийн хууль, энэ татварын реформ, тэтгэврийн реформ, бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө, хөрөнгө оруулалт, зөвшөөрөл, уур амьсгалын өөрчлөлт би ярьсан болгоноо дуусгасан 86 хоног дотор. Бүгд ярьснаас явуулаагүй. Энэ ажлыг хийж өгөхөд манай Их Хурлын гишүүд үнэхээр дэмжсэн. Аль аль намын энэ гишүүд дэмжсэн. Очирбат гишүүн бол бизнесийн салбарт олон жил ажилласан хүн. Ингээд сар сараар та надад баярлана. Одоо энэ хуулиуд хэрэгжээд манай энэ засгийн ажлууд явахаар. Хэдүүлээ ямар төрийн ажлыг насаараа хийх гэж байгаа биш. Энэ цаашаа өв болж үлдээсэй. Өр биш гэж л хүсэж байгаа юм. Тийм учраас ийм асуудал дээр нам байхгүй. Хамтран ажиллана.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мэндбаярын Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Эхний асуулт бол энэ Төрийн аудит, Нийслэлийн аудитын газраас асууя. Оны эцсийн аудитын шалгалтаар төрийн болон орон нутгийн өмчит, мөн нийслэлийн агентлагийн дарга нар өөртөө давуу байдал олгож, урамшуулал

авсан гомдол, мэдээллүүд гишүүдэд ирж байгаа. Энэ талаар шалгалтаар илэрсэн зөрчлүүд юу байна, авсан хариуцлага тооцсон ямар арга хэмжээнүүд авсан бэ гэдэг дээр бас хариулт өгөөдхөөрэй.

Хэрэв энэ асуудал дээр мэдээлэл хангалтгүй бол санхүүгийн зөрчилтэй дүгнэгдсэн удирдлагуудын жагсаалтыг албан бичгээр бас надад ирүүлнэ үү гэдгийг би бас эхлээд хэлчихье.

Хоёрдугаарт хөдөө аж ахуйтай холбоотой 25 оны батлагдсан төсөв 660 тэрбум төгрөг байсан. 70 хувийн гүйцэтгэлтэй 470 орчим тэрбум төгрөг зарцуулагдсан байгаа. Энэ өөрөө юу гэж хэлж байгаа вэ гэхлээр Монгол Улсын Засгийн газрын төлөвлөсөн бодлого 70 хувийн гүйцэтгэлтэй зорьсон ажлаа бол дутуу гүйцэтгэсэн байна гэсэн үг.

Гэтэл өнөөдөр хөдөө аж ахуйн энэ малчид, хоршоологчид, жижиг, дунд үйлдвэрлэлүүд улс орныхоо энэ хоол хүнсний хангамж, үйлдвэрлэлийг тасралтгүй явуулахын тулд бас их олон сорилтуудтай тулгарч байгаа. Уур амьсгалын өөрчлөлт энэ ган, зудын асуудлаас болоод энэ малгүй, ургацгүй үйлдвэрлэх бүтээгдэхүүн ч үгүй болж байгаа ийм ядууралд хүрч байгаа, энэ амьжиргаа буурч байгаа асуудал бол маш хүнд нөхцөлд байгаа. Ялангуяа орон нутагт бол маш хүнд нөхцөлд байгаа. Тэгээд энэ хөдөө аж ахуйн бодлогын гүйцэтгэл ер нь яагаад дутуу гарчхав аа? Яагаад энэ улс орны энэ хөдөөгийн асуудлуудыг шийдвэрлэхгүй байгаа юм бэ гэдэг асуултыг асууя.

Хоёрдугаарт Улсын Их Хурлын энэ төсөв баталж өгдөг энэ Засгийн газар нь төсвийг нь зарцуулаад үр дүнгээ тайлагнасан болоод ингээд өнгөрөөд байдаг. Жил болгон л ийм нөхцөл байдалтай. Тэгээд энэ тараасан материалаас харахад төсвийн зарцуулалт 50 хувьд ч хүрээгүй мөртөө гүйцэтгэл нь өөрөө зорилт, үр түвшиндээ хүрчихсэн, бүүр давуулан биелүүлчихсэн ийм үр дүн тайлагначихсан байгаа юм. Үгүй тэгээд хэрэв ингээд гүйцэтгэл нь 50 хувьтай ч хүрээгүй төсвөө зарцуулчихаад үр дүндээ хүрдэг юм бол бид нар тэгвэл энд ингэж төсөв батлаад ер нь сууж байх ямар хэрэг байгаа юм бэ? Одоо газар тариалангийн энэ хөгжүүлэхээр 102 тэрбум төгрөг баталсан байгаа. 55 тэрбум төгрөгийг зарцуулсан. Тэгээд хийсэн гол ажлаа тайлагнахдаа 10 банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгосон гээд биччихсэн байгаа даа. Тэгээд улаан буудай, төмс зорилтот түвшиндээ огт хүрээгүй байгаа. Яагаад вэ гэсэн хэрэглээ нь нэмэгдээд өвөлдөө бид нар чинь Хятадаас одоо хүртэл төмсөө авч байгаа юм. Улаан буудайгаа Оросоос одоо хүртэл импортолж байгаа юм.

Үгүй тэгсэн мөртөө ингээд гүйцэтгэлээ өөрөө хангалтгүй хийчихсэн. Тэгээд үр дүнгээ болохоороо бүтэн гүйцэтгэлтэй бүүр давуулан биелүүлчихсэн гээд оруулаад тавьчихсан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хамаарлыг бууруулах гэж энэ хөнгөлөлттэй зээл бид нар олгоод байдаг. Үр дүн байхгүй.

Мал аж ахуйг хөгжүүлэхээр 67 тэрбум төгрөг баталсан. 41 тэрбум төгрөгийг зарцуулсан байгаа. Энэ нь юу хэлж байна гэхээр төсвийнхөө бид нар гуравны нэгийг зарцуулаагүй байхад нөгөө зорилтот үр дүндээ хүрчихсэн гэсэн ийм тайлан тавьчихсан. Одоо гоц халдварт өвчний голомтыг 128-аас бууруулаад 100 хүрэхээр тооцсон юм байна. 34 хувийн гүйцэтгэлтэй. Халдварт өвчний голомтын тоог 184-өөс 148 буюу хүргэхээр байсан бол 430 хувийн гүйцэтгэлтэй. Тэгээд энэ өөрөө энэ

бодит үр дүндээ энэ хүнд одоо ингээд шүлхий гарчихсан, гоц халдварт өвчний асуудал маш даамжирчихсан ийм хүнд нөхцөл байдалтай байгаад байдаг. Гүйцэтгэл яагаад ингээд хангалтгүй яваад байгаа юм бэ? Хэрэв бид нар төлөвлөгөөгөө зөв төлөвлөөд явсан бол өнөөдөр үүсэж байгаа асуудал дээр бид нар даруй арга хэмжээ авч чадах байсан. Ийм асуудлыг даамжруулах шаардлага ер нь байхгүй байсан шүү дээ. Тэгэхээр ер нь бол.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Идэрбат гишүүн хариулах уу? Сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Энэ 2025 оны гүйцэтгэл сая таны тоон ярьж байгаа зүйлүүд энэ бодлогын гүйцэтгэлийн дүн биш л дээ. Энэ зээлээр олгосон зээлийн гүйцэтгэл байгаа юм. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбар дээр энэ “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” гээд энэ томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр ямар нэгэн байдлаар зээл олгохгүй. Арилжааны банкнуудаар дамжуулаад хөнгөлөлттэй зээлийг олгож байгаа.

Тэгэхээр энэ зээлийн зарцуулалт дээр, зориулалт дээр эд нар их зөв ойлголттой ярихгүй бол малчдаас Цагаан алтны зээл авсан уу гэж асуухаар малчин авахгүй шүү дээ тэр чинь. Үйлдвэрүүд аваад өнөөдөр ноосоор бүтээгдэхүүн хийгээд даавуу хийгээд ингээд явж байгаа. Зээлээр олгож байгаа энэ процессыг бүгдийг нь 100 хувь олго гэдэг тийм шаардлага бол байхгүй. Арилжааны банкнууд өөрсдийнхөө шаардлагыг хангаад хангасан аж ахуйн нэгжүүдэд нь өгч байгаа. Аж ахуйн нэгжүүд арилжааны банкны шаардлагыг хангахын тулд санхүүгийн сахилга бат, бизнес төлөвлөгөө, олон зүйлүүдээ гаргаад ингээд явж байгаа. Энэний тоон дүн байгаа.

Дараагийн асуудал мөн энэ хөдөө аж ахуйн салбар дээр, мал аж ахуйн салбар дээр мөн л энэ хөнгөлөлттэй зээлүүд олгогдоод явж байгаа юм. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбарын Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд, Хүнсний хувьсгалын хүрээнд энэ олгогдсон зээлүүд өнөөдөр үр дүнгээ өгөөд арьс ширний үйлдвэрүүд бүтээгдэхүүн авъя, бид технологийн хувьд бэлэн болчихлоо гэдэг гээд ингээд 5 аймгаас эхлүүлээд явж байгаа үүний үр дүн.

Өнөөдрийн ноолуурын ханш 200 мянга гарлаа гээд малчид нурууны тэнийж байгаа энэ үйл явц бол энэ олгогдсон зээлүүдийн үр дүнгээр энэ үйлдвэрүүд технологи, эргэлтийн хөрөнгө, бүх зүйлээ шийдээд явж байгаа. Үүний үр дүнг хөдөө аж ахуйд бас гарч байгаа. Тэгэхээр энэ улсын төсөв дээр ийм их мөнгө тавиад гүйцэтгэл нь огт зарцуулаагүй гараад байгаа юм бол биш ээ. Энэ зээлийн эх үүсвэрүүдийг суулгаж өгөөд шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд нь аваад ингээд явж байгаа дүн юм шүү гэдгийг бас би хэлэх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна.

Малын халдварт өвчинтэй холбоотой асуудал дээр тодорхой зорилт тавиад тэр голомтын тоог цөөрүүлэх, барих гээд энэ тавьсан зүйлүүд зарим зүйл дээр хэрэгжээгүй зүйлүүд бас байна. Үүнийг засахын тулд энэ мал эмнэлэг рүү, мал эмнэлгийн тогтолцоо руугаа яаж хамтарч ажиллах вэ гэдгээ энэ мал эмнэлгийн салбарын эрдэмтэдтэй болон Мал эмнэлгийн ерөнхий газрын энэ төрийн өмнө үүрэг хүлээгээд ажиллаж байгаа төрийн албан хаагчидтайгаа бид бас яг ямар арга замаар энийгээ биелүүлэх вэ гэдэг дээр бас ярилцаж байгаа зүйлүүд бол байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үндэсний аудитын газар.

**З.Цэнджав:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн нэгдсэн дүнгээр цалин, урамшуулалтай холбоотой, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 22.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс цалин, урамшуулалтай холбоотой 4.2 тэрбум төгрөгийн 374 зөрчил илрүүлж холбогдох дүгнэлтээ өгсөн байгаа.

Бид нийслэлтэй холбоотой, мөн нийслэлийн агентлагуудтай холбоотой асуудлаар ирсэн мэдээллийг гишүүнд албан бичгээр хариу өгье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Миний асуултыг бас яг сайн тодорхой ойлгож хариулсангүй гэж би бол хэлэх гээд байгаа юм. Хэрвээ бид нар ингээд бизнес төлөвлөөд бизнес эрхэлдэг байсан бол бизнесээ төлөвлөөд гүйцэтгэлээ бид нар яаж хянадаг билээ? Хэзээ ч ийм бодлого, энэ төсвөө бол хийхгүй байсан. Ер нь бол энэ хар аа нийт хөдөө аж ахуйн яг энэ төсвийн 70 хувь нь өөрөө татаас, урамшуулалд мөнгө явж байгаа. Бид нар малчинд олгоогүй шүү дээ гэж ярьчихаад гарсан үр дүн нь тодорхойгүй юман дээр ийм хариуцлагагүй хариулт хийж болохгүй.

Бид нар мөнгө зарцуулсан, зарцуулаагүй хамаагүй. Бид нар ер нь улсын төсөвт тусгагдаж байгаа энэ татаасны, урамшууллын энэ олгосон мөнгө болгон чинь өөрөө үр дүн үзүүлдэг байх ёсто. Энэ үр дүнгээ хэмждэг байх ёстой. Би энийг бол тасралтгүй ярьж явж байгаа. Үндсэндээ бол манайд үнэхээр ажлаа төлөвлөж чаддаггүй юм байна. Түүнийгээ хэрэгжүүлж чаддаггүй юм бай.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ж.Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Бага мөнгө зарцуулаад их үр дүнд хүрчихлээ гэж та хэллээ. Үнэхээр тэгсэн. Дандаа -20, 30 хувьтай байсан хөдөө аж ахуйн салбар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 60 хувийг хангадаг хэмжээнд очсон. 44800 шинэ ажлын байр бий болгосон. Экспорт, хөдөө аж ахуйн экспорт тэрбум доллар хүрсэн. Энийг үр дүн гэхгүй бол юу гэх юм.

Зөвхөн ноолуур гэхэд ноолуурын боловсруулсан экспорт 5 дахин өслөө шүү дээ. Жилдээ 300-аас доошгүй сая тонн мах гаргадаг болж байна шүү дээ. Өнөөдөр хөдөө малчид хамгийн аз жаргалтай, сэтгэл хангалуун хүн байна шүү дээ. Мал, мах нь үнэтэй, ноос, ноолуур нь үнэтэй. Хүнсний хөнгөн үйлдвэрүүд бүгд босчихлоо шүү дээ. Технологийн шинэчлэлээ хийчихлээ. Одоо Евроазийн зах зээлд экспортод гарна гээд бэлдэцгээж байна.

Газар тариалангийн тухай ярилаа. Улаан буудайн үйлдвэрлэл. Улсын Их Хурал 2 удаа хууль оролдож улаан буудайн тариалалтыг унагаасан шүү дээ. Юу болж байж бид нар буцааж босголоо.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Газар тариаланг 2 удаа Улсын Их Хурал хууль гаргаж унагаасан. Тэрийг залруулсан. Тэрний эффект нь хэдэн жилээр гараад арилахгүй явна шүү дээ. Энэ жил гайгүй. Ноднин уринш сайн хийсэн. Энэ жил ургацаа авах байх. Ингээд мах, гурил, төмс, хүнсний ногоо чинь инфляцын суурь байхгүй юу даа манай дотоодын инфляцад тооцдог. Энэ дотоодоосоо хангах ёстой юмаа бид нар шийдэхгүй бодлогын алдаан дээр энэ дээр, доороо эргэж буцсаар байтал ингээд үнийн өсөлтөөр хариу ирчхэж байгаа байхгүй юу. Ингээд инфляц нэмчихдэг. 1 хувийн инфляц нэмэгдэхэд тэтгэвэр дээр 30 тэрбум төгрөг төгрөг нэмж өгөх хэрэгтэй болдог. Хуульчилсан зардал. Нийт инфляцын чинь 11 хувийн чинь бараг 60, 70 хувь нь хүнсний барааны үнийн өсөлт гаргаад байна шүү дээ.

Тэгэхээр өнгөрсөн энэ 25 он бол хөдөө аж ахуйн хувьд бол гайхалтай жил байсан шүү. Атрын IV, Хүнсний хувьсгал, Цагаан алт хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн. Төрийн тэргүүний манлайлал маш өндөр байсан шүү. Тэгж.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Энхбаяр сайд та бид 2 ард түмний өмнө худлаа яриад яах вэ. Бид нар 13 сая малаа зуднаар алдсан. Хасахтай гарч байсан. Өнөөдөр тэрийгээ нөхөж байгаа учраас таны энэ яриад байгаа сайхан зүйлүүд чинь нэмэгдэж харагдаж байгаа байхгүй юу. Гэтэл та нэг юмыг ойлго. Өнөөдөр манай ядуурал 27 орны 1 хувь нь ядууралд өртчихсөн. Араас нь залгуулаад энэ ган, зудаас болоод, энэ шүлхийний өвчнөөс болоод малгүй болж байгаа орон нутгийн залуучууд иргэд өөрсдөө бараг 450 орчим мянга нь яг ядуурлын ирмэгт ороход унахад бэлэн байдалтай байгаа. Үгүй тэгж их хөдөө аж ахуйн салбар чинь босож ирсэн юм бол орон нутаг чинь хөгжил, цэцэглэл авчирсан чинь хаана байгаа юм? Орон нутгийн энэ залуучууд яагаад өргөөд өнөөдөр энэ гэр хороолол чинь дүүрээд байгаа юм? Энэ дээрээ хариулт өг л дөө. Үнэ чинь нэмэгдээд байгаа. Та инфляцаа буруу тайлбарлаад байна. Бид нар дотоодын үйлдвэрлэл нэмэгдээгүй байсан бол энэ үнэ чинь тогтворжчихдог юм байгаа биз дээ. Үргэлж дандаа ийм бэлдчихсэн ийм худал хариулт өгөхөө больж байгаа шүү дээ та нар.

**Ж.Бат-Эрдэнэ:** Статистикийн байгууллага. Үндэсний ерөнхий. Ажлын хэсэг хариулъя. Статистикийн газар байна уу? Статистик алга уу? Энэ ажлын хэсгээ бүрдүүлээрэй. Жудагийн Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Төсвийн гүйцэтгэл бол маш чухал ийм зөв л байгаа л даа. Бид нар энэ татвар төлөгчдөөс маш их хэмжээний татвар авчхаад тэгээд тэрийгээ хэрхэн, юунд зарцуулав гэдгийг л ярилцаж байна гэсэн үг. Анги хүртэл ингээд хүүхдүүдээс мөнгө татчихаад тэгээд тэрийгээ яг юунд зарцуулснаа маш хариуцлагатайгаар эргэж хэлдэг уг нь тийм үү. Яг энэ юу болоод яав аа гэдгийг чинь л бид нар ярьж байгаа маш ийм чухал цаг үе юм. Харамсалтай нь зарим сайд нар байхгүй байна. Сангийн сайдаас уг нь асуулт байна байгаа юм. Тэгээд нэг хүн нь л хариулах хэрэгтэй байх.

25 оны жишээг харахад худалдан авах ажиллагааны 71.1 хувь буюу 16.6 их наядын, мөн өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх тендерийн 77.9 хувь нь биелээгүй байна гэж. Бараг 80 хувь нь биелээгүй байна шүү дээ. 80 хувь нь. Тэгээд энэ чинь уг нь яг төсөв хэлэлцэх үеэр зүгээр бөөн юм болж байгаад тавиулдаг, төсөвтөө

тавиулдаг.Тэгээд энэ яг юундаа байдаг юм бол оо? Яагаад ингээд бүхэл бүтэн 80 хувь нь хэрэгжихгүй ингээд яваад байдаг юм бэ? Төлөвлөлт буруу байна уу, эсвэл юундаа байна вэ гэдэг ийм асуулт байна. Энэ дээр зориуд цохон тэмдэглэхэд төлөвлөлт бол нийслэл дээр бүүр байхгүй юм байна лээ шүү дээ. Төсөвтөө 4 удаа, 25 онд бүүр 5 удаа тодотгол хийсэн байгаа шүү дээ. 3 сард бараг 2 удаа хийсэн юм уу тээ гэдэг шиг. Энэ нийслэл гэлтгүй энэ Монгол Улс тэр чигтээ энэ төлөвлөлтдөө анхаарах ёстой юм биш үү. Яагаад гэвэл энэ төлөвлөлт, хэрэгжилт хоёрын чинь зөрүү асар их байгаад байна. Нэг.

Хоёрт уг нь Сангийн сайдаас асуух гэсэн юм. Бид нар 40 гаруй тэрбум долларын өртэй байна Монгол Улс. Тэгээд нөгөө хуулиараа өрийн хэмжээ ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй гээд. Тэгээд эндээ дулдуйдаад их баяртайгаар яваад байдаг л даа. Арга ч үгүй энэ чинь 39.4 хувь юм байна. Тэгэхээр бол яг хуульд заасан хэмжээндээ бол байгаад байна. Байгаад байна. Харамсалтай нь энэ 95.7 хувь нь гадаад валютаар байна. Гадаад валют доллароор.

Тэгээд зөвхөн энэ ханшийн өөрчлөлтөөс төгрөгийн ханш сулралтаас болж 1.7 их наядын алдагдал хүлээсэн юм байна. 1.7 их наяд. Гэтэл энэ чинь ямар нэгэн шинэ сургууль байгуулагдаагүй, шинэ эмнэлэг хийгдээгүй, баригдаагүй цэцэрлэг баригдаагүй ийм байж байж зөвхөн ханшийн сулралаас ийм их алдагдал хүлээнэ гэдэг бол маш ноцтой дүн юм байгаа юм. Тэгэхээр бид нар өрийн хэмжээ бол болж байна гэж баярлаад байх биш энэ өрийн бүтэцтэй санаа зовох ийм цаг ирчихжээ. Бүтэц ялангуяа энэ ханшаас болж байгаа. Тэгээд энийг уул нь Сангийн сайдаас асуух гэсэн юм л даа. Энэ өрийн бүтцээ өөрчлөх ямар нэгэн төлөвлөгөө байгаа юу? Гадаад өр биш, дотоодын зах зээлээсээ бонд босгох ч байдаг юм уу ийм дотоод эх үүсвэрээсээ хөрөнгө татах энэ тал дээр уг нь ямар бодолтой байгаа юм бол, ямар төлөвлөгөөтэй байгаа юм бол гэж асуух гэсэн юм.

Дээрээс нь бид нар нөгөө ашиглагдаагүй зээл маш их байгаад байгаа. Тэгээд сая дутуу, хагас янз бүрийн бас төслүүдээ хэрэгжүүлбэ гээд ингээд ороод явж байгаа. Одоо өшөө цаана нь зээлийн үлдэгдэл хэд байгаа юм бол оо? Үүний өр, өрийн хүү, хүү биш юм гэхэд ашиглаагүй зээлийн хураамж юм уу тэрэнд хэчнээн төгрөг төлдөг юм бол гэж асуумаар байгаа юм. Хэн нь хариулах юм байгаа юм?

Шилэн дансны хэрэгжилт. Энэ бол яг татвар төлөгчдийн мөнгийг юунд, яаж зарцуулж байгааг харуулах маш том ийм уг нь хууль байгаа юм. Харамсалтай нь энэ аудитын дүгнэлтэд юу гэж байна вэ гэвэл энэ төсвийн мөнгийг хэрхэн яаж зарцуулж байгаагаа тайлагнаж энэ шилэн дансанд байршуулах ёстой байгууллагуудын 55.1 хувь нь огт мэдээллээ байршуулдаггүй юм байна. Талаас илүү хувь нь. Тэгэхээр энэ дээр цаана нь юу явагдаж байгаагаа яагаад нуух ийм шалтгаан болж байгаа юм бэ? Энэ шилэн данс хөтлөлтийг хэрхэн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 13 цаг өнгөрсөн байна. Чуулганы хуралдааныг нэмж үргэлжлүүлбэ. Сунгаж хуралдъя. Доржханд сайд.

**Т.Доржханд:** Тэгэхлээр 2025 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт нийт 2 их наяд 67.6 тэрбум төгрөгийн 90 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 2025 оны 144 дүгээр Засгийн газрын тогтоолоор 1 их

наяд 889.5 тэрбум төгрөгийн 87 төсөл, арга хэмжээний 497 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Тэгэхлээр Баярмаа гишүүн маань энэ тоогоо бас сайн сонсоод аваарай. Тэгэхлээр энэ хугацаанд амжилттай болсон, гэрээ байгуулсан тоо болохлоор төсөл, арга хэмжээ 74, багц ажил 299, нийт төсөл, арга хэмжээний 85.1 хувь амжилттай болсон.

2024 оноос өмнө бол 50 хувь нь л амжилттай. 2 тендерийн, 2 худалдан авах ажиллагааны 1 нь амжилттай болдог байсан. Тэгэхлээр энэ үзүүлэлт бол 25 онд бол сайжирсан шүү. Бас бодитой мэдээлэл аваад явах нь зүйтэй байх. Амжилтгүй болсон 9 төсөл, арга хэмжээ, 187 багц ажил бол байна. Техникийн тодорхойлолт ирүүлээгүй 3. Ингээд үндсэндээ бол 85 хувьтай. Яг юунаас болоод энэ ажлууд ингээд хийгддэггүй юм бэ гэдэг талаар би бас тодорхой тоог бас танилцуулъя.

Тэгэхлээр техникийн тодорхойлолт ирүүлээгүй 21 багц арга хэмжээ, техникийн тодорхойлолт ирүүлсэн ч хугацаандаа ирүүлээгүй буюу 2025 оны 4 сараас хойш ирүүлсэн 84 арга хэмжээ. Тэгээд тендер шалгаруулалт явуулсан ч гэлээ гэсэн гомдол гарсан нээгээгүй 35 арга хэмжээ. Тендер зарласан ч 1 ч оролцож ирүүлээгүй буюу төсөвт өртөг нь бага гэсэн үг, ашиггүй байна гэсэн үг 31 гээд. Гомдол гарсан 26 гээд ингээд 197 багц ажил дээр бол ийм нөхцөл байдал үүссэн. Тэгээд маш энгийнээр хэлэхэд 90 хувь нь бол түрүүчийн яриад байгаа 14.9 нь амжилтгүй болсон байна шүү дээ. Түүний 90 хувь нь зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт нь бол ирээгүй л гэсэн үг. Тэгээд тийм болохлоор ийм үр дүн бол гарсан байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сангийн яамнаас. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Гадаад зээлтэй холбоотой асуултууд гарсан. Нийт Монгол Улс амлагдсан гэрээ, хэлэлцээр хийгдсэн 13.8 их наяд төгрөгийн ашиглагдаагүй зээл байж байна. Үүний 5.2 их наяд буюу 38 хувь нь газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэний усан цахилгаан станц. Энэ яагаад ийм өндөр гарсан гэвэл бид сая хаврын чуулганаар энийг төсвийн бүрэлдэхүүнээсээ гадна авч үзэхээр болсон. Энэнтэй холбоотойгоор энэ ашиглалт сайжирна. Бид зээлээ авчхаад байдаг, ашиглаж чаддаггүй, төсвийн хязгаар дээр орчхоод хязгаарлаад байсан. Энэ чөлөөлөгдсөн. Тэгэхээр нь ашиглалт сайжирна.

Дэд бүтцийн 78 төсөл явж байна. Үүн дээр 6 их наядын амлагаанууд хийгдсэн. Гэрээ, хэлэлцээрүүд янз янзын юмнууд нь ээлжлээд явж байна. Нийгмийн дэд бүтцийн 20 төсөл 2.4 их наяд байна. Ингээд 2 мега төсөл буюу энэ газрын тос боловсруулах Алтан ширээний төсөл Эрдэнэбүрэнг гаргаад ирэнгүүт бусад энэ эдийн зас.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Мега төслөө гаргаад ирэхээр энэ эдийн засгийн энэ дэд бүтцийн болон нийгмийн дэд бүтцийн энэ төслүүд нийт 98 төсөл орох орон зай үүсэж байна гэсэн үг. Тэгэхээрээ энэ 27 он бол нэлээн гадаад зээлийн ашиглалт нэлээн сайн явагдана. Өр хэр байна вэ гэж асуугаад байгаа юм. 2016 онд Засгийн газрын өр, нийт өрийн дээд босго бол 93 хувь байсан. ДНБ эзлэх Засгийн газрын

өр 93.1 хувь байсан бол одоо 29.4 хувь болж буурсан байгаа. Одоо бол тусгай шаардлага бол 60 хувиас хэтрэхгүй гэсэн ийм тусгай шаардлага тавьсан.

Ер нь өнгөрсөн хугацаанд Засгийн газар гадаад, дотоод өр, зээлээ цаг хугацаанд нь ямар нэгэн асуудалгүй төлж ирсэн. Ийм ч болохоор Монгол Улсын зээлжих зэрэглэл олон улсын санхүүгийн байгууллагуудаас өндөр үнэлгээ авч байгаа. Монгол Улсын гаргасан Засгийн газрын бонд бол маш амжилттай борлож зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярмаа гишүүн тодруулъя.

**Ж.Баярмаа:** Ашиглаагүй зээл ингээд байгаад байдаг. Энэ их урт хугацаанд авчихсан зээл юм байна лээ. Энийг тэгээд яамаар ч юм бэ дээ. Уг нь ингээд мега төслүүд хэрэгжүүлмээр байдаг. Харамсалтай нь мега хулгай болчихоод байдаг. Тэгээд ингээд хэрэгжүүлэх хэцүү, хэрэгжүүлэхгүй байх хэцүү, ашиглах хэцүү, ашиглахгүй байх хэцүү ийм л байдалтай байгаад байна.

Ингээд ийм гаднаас бид нар маш өндөр дүнтэй ингээд янз бүрийн шугамаар зээл аваад ханшийн хэлмэгдэлтэд ороод байдаг. Гэтэл авлага, авлагаа ер нь авч чадаж байна уу? Энэ дээр ингэж байна шүү дээ. Эдийн даатгалын сангийн, Нийгмийн даатгалын сангийн, Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк ХХК-д байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон Капитал банкны авах ёстой авлага 376 тэрбум байснаас 132 тэрбумыг нь л барагдуулсан. Цаана нь 244 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гэж байна шүү дээ. Энэ юу вэ? Энийг хэзээ яаж барагдуулах юм бэ? Нэг гараараа ингээд зээл аваад байдаг мөртөө нөгөө.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Та сая хэллээ 300-гаад тэрбум байсан. 100 гаруйг нь барагдуулсан. Энэ чинь ажил хийж байгаагийн л шинж шүү дээ. Ажил явагдаад байна. Олон жил болчихсон янз янзын хууль, эрх зүйн асуудал үүсээд ингээд хууль, цагдаа, шүүх хурал гээд зөндөө л юм болцгоочихсон. Тэгээд барагдуулж байна. Явуулж байна. Энэ дээр бид нар Засгийн газар тогтмол байнга ажиллаж байгаа. Та харж байгаа бол ерөнхий Засгийн газрын өр төлбөр тасралтгүй багасаж байгаа. Хөрөнгө бүртгэл сайжирч байгаа. Хөгжлийн бодлого чамбайрч байна. Бид Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуультай болчихлоо. Тэрийгээ дагаад таван жилийн төлөвлөгөө баталчихсан. Тэрнээсээ гажихгүйгээр төсвийн хүрээгээ хийдэг болж байна. Одоо төсвөө бид нар яг энэ хүрээнд барьж орж ирнэ. Төсөв улам чангаран чамбайрч байгаа. Хэрэгжилтийг шахах дээр манай Төсвийн хяналтын дэд хороо, ер нь улирал улирлаар нь гүйцэтгэлээ аваад шахаад ер нь бүгдээрээ яваад байвал ер нь хаа хаанаа л хэрэгтэй байна. Их Хурал талаасаа бас энэ гүйцэтгэлийг гаргахад бол нэлээн Төсвийн байнгын хороо, Төсвийн хяналтын дэд хороо 2 нэлээн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүн, сайд.

**Т.Доржханд:** Энэ гаднын эх үүсвэр ашиглах дээр бид нар ойлголтоо нэг болгомоор байгаа юм. Тэр нь юу байна гээд тэгэхлээр Монгол Улс бол өрийн удирдлагыг хамгийн сайн хийж байгаа 200 улсын эхний 3-д орж байгаа улс. Тэгээд

цэвэр дүнгээрээ болохлоор ДНБ-д орж байгаа, эзэлж байгаа өрийн үзүүлэлт бол 40 хувиас доошоо буучихсан юм шүү. Энэ нэг талаасаа ингээд сайн юм шиг боловч нөгөө талдаа бид нар бас нөгөө хөгжлийн санхүүжилтүүдээ хийж чадахгүй байгаа юм шүү.

Хөгжлийн санхүүжилтээ хийх гэхлээр төсөв дээр орон зай байхгүй. Төсвийн нөгөө гаднын зээлийн эх үүсвэрийг орлого, зарлага талд ингээд суулгадаг болсноос болоод хөгжиж байгаа энэ нөгөө дэд бүтцийнхээ төслүүдийг бид нар санхүүжүүлж чадахгүй байгаа нь бол энэ популизм. Тэгээд бид нар уг нь бол нөгөө олон улсын байгууллагуудаас хямдхан эх үүсвэрээ аваад, тэндээс экспертизээ аваад ардчилсан улс шүү дээ энэ чинь. Дэлхийн банк Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк энэ тэр оруулаад явах ёстой байтал энэ ажлууд нь хийгдэхээ болиод ирэхлээр экспертиз.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Доржханд сайд тодруулъя, гүйцээж хариулъя.

**Т.Доржханд:** Тэгэхээр сайн зүйлээ бид нар аягүй сайн ойлгож байх ёстой. Гэхдээ нөгөө талдаа бас бид нар ингээд дэд бүтцийн асар их ингээд санхүүжилтийн хэрэгцээтэй мөртөө хажуу талд ингээд хувийн 1 хүүтэй 30, 40 жилийн хугацаатай эх үүсвэр ингээд байгаад байхад тэрийгээ авч ашиглаж чадахгүй болчихоод байгаа юм. Тэрийг чинь дагаад нөгөө олон улсын сайн төсөл явуулдаг экспертизүүд багаараа ингэж ирж ажилладаг. Тэр нь нөгөө PAIP plan байхгүй болохоор ирж ашиглахаа больчихоод байгаа юм. Тэгээд олон улсын байгууллагууд маань Монголд ингээд хэтэрхий их ингээд юмаа хавчаад хаагаад байгаа бол бид нар үйл ажиллагаа явуулаад яах билээ дээ орон тоогоо хасаад эхэлж байгаа байхгүй юу. Ингээд ирэхлээр чинь энэ цөөхөн улстай 2 том гүрний дунд байдаг ардчилсан Монгол Улсын чинь эрх ашиг хаана байгаа билээ гээд.

Тийм болохлоор бид нар энэ дээр бол аль болох нөгөө нээлттэй хандаж, олон улстайгаа цуг ингэж явж байж санхүүжилтийг нь оруулж ирдэг байхгүй бол эндээ ингээд л төсөв яриад л, тэгээд л төсвийн алдагдлаа бага байх ёстой гээд л ингээд популизм руу ороод яваад байх юм бол илүү их боломжоо алдана шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Би 2, 3 асуудлуудыг бас хөндөж гаргаж ирж тавья гэж бодож байна. Бид нар төсвийн сахилга бат, хариуцлага гэдэг асуудлыг бас их сайтар хийх л ёстой болчихоод байдаг. 2023 оны төсвийн тухай хууль дээр Төсвийн байнгын хороонд бас би ажил хариуцаад байж байхдаа хэд хэдэн заалтуудыг оруулж ирж аудитын байгууллагыг илүү хариуцлагатай ажиллах, хариуцлага тооцох эрхийг нь бол зааж өгсөн. Одоо бол манай сайд нар бас анхаарах ёстой, төсвийн ерөнхийлөн захирагч нар анхаарах ёстой.

Төсвийн тухай хууль дээр бид нар Төсвийн тухай хуулийн 70.2 дээр, 70.4 дээр, 70.5 дээр хэрэв төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийнхөө хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилалд зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол ажил, албан тушаалаас нь чөлөөлөх зохицуулалтыг хийж өгсөн байгаад байгаа юм. Тэгэхээр аудит энийг илрүүлсэн бол Улсын Их Хурал хариуцлага тооцох, сайд нарыг ажил, албан тушаалтан чөлөөлөх, төсвийн

ерөнхийлөн захирагч нарыг бас сайд гэлтгүй бусад ер нь чөлөөлөх энэ эрх зүйг бол бий болгож өгсөн.

Бүр дээрээс нь нэмж өшөө бүр төлөвлөлт дээр ямар төсвийг боловсруулж батлуулахдаа үндэслэлгүй тоон мэдээнд тулгуурлан батлуулсан төсвийн гүйцэтгэлээр тогтоогдсон бол тухайн албан тушаалтныг ажил, албан тушаалтан чөлөөлөх үндэслэл болно гэж бас хийж өгсөн байгаад байгаа юм.

Дээрээс нь Төсвийн тухай хуулийн төлөвлөлттэй холбоотой, санал авахтай холбоотой эдгээр зохицуулалтуудыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол бас ажлаас нь хална гэсэн зохицуулалт хийж өгсөн. Энэ бол үндсэндээ би аудитын байгууллага бол эрх мэдэл бүрэн дүүрэн болсон. Та бүхэн аудит бол сайн ажиллаж, ард түмний өмнөөс нүд, чих болж байгаа энэ байгууллага хариуцлагатай ажиллах ёстой байгаад байгаа.

Гэтэл нэг талдаа өнөөдөр орж ирсэн дүгнэлт дээр бол ямар ч тийм хариуцлага тооцох, ямар нэг алдаа, зөрчил илрүүлээд тэр дээрээс нь ажил, албан тушаалаас нь чөлөөлөх гэдэг саналыг оруулж ирсэн зүйл нэг ч байхгүй байгаа. Ийм байдлаар бид нар цаашид төсвийн сахилга бат, хариуцлага гэдэг зүйлийг ярихад хүнд болчихлоо. Хүнд болчихлоо. Нэгдүгээрт. Тэгэхээр аудитын байгууллага яагаад энэ асуудал дээр ингэж хариуцлагагүй хандаад байна вэ? Би бүүр онцолж 2, 3 сарын өмнө та бүхнийг Байнгын хороон дээр орж ирэхэд хэлж байсан. Хариуцлагатай ажиллаарай. Би энэ хариуцлагыг нэхнэ шүү гэж хэлсэн.

Хоёрт бид нар ер нь төсвийн гүйцэтгэл хэлэлцэх дэгээ их өөрчлөх хэрэгтэй байна. Би Засгийн газарт санал тавьж байгаа. Одоо ингээд 06 сарын 17-нд өргөн баригдсан. Ингээд бид нарт хоёрхон долоо хоногийн дотор маргааш чуулган завсарлах гэж байхад ингээд хэлэлцүүлсэн болдог. Бид нар ч энийг үзэх, харах, танилцах, хяналт тавих эрх ерөөсөө юу ч байхгүй болчихоод байна шүү дээ. Бид нарын энэ мэдээлэлтэй танилцах эрхийг нь хүртэл хааж байна.

Тэгэхээр бол төсвийн гүйцэтгэл хэлэлцэх дэгийг нь бүгдээрээ өөрчилье өө. Би энийг Засгийн газар өөрсдөө өөрчлөлтийг хийгээд эхэлбэл сайн байна. Төсөв өргөн барихдаа энэ Төсвийн тухай хууль дээр гүйцэтгэлийг хэлэлцэх энэ дэгийг нь өөрчилж оруулж ирээч ээ гэдэг саналыг тавих гээд байгаа юм 9 сард. Тэгээд энэ бол нэг талдаа өөрөө Засгийн газарт бас хэрэгтэй.

Дараа дараагийн төсвийн төлөвлөлтүүдийг хийхэд илүү хариуцлагатай байдлаа дээшлүүлэхэд дотоод асуудлуудаа, алдаа, зөрчлүүдээ илж гаргаж ирж байхад эргээд бид нар хариуцлагатайгаар төсвөө хэлэлцдэг, ядаж нэг сар үздэг, бүүр болж өгвөл сонсгол хийдэг. Бүүр эсвэл юу гэдэг юм төсвийг хэлэлцэхийнх нь өмнө төлөвлөлтийг., дараа жилийн төсвийг хэлэлцэхийн өмнө өмнөх жилийнх нь төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж, сонсгол хийгээд ингээд ярьдаг, ил тод байдаг энэ зүйл нэгдүгээрт хэрэгтэй байна.

Хоёрт чуулганы төгсгөлд ингээд 10 хоногт багтаагаад л бараг 10, 20-н асуудлууд бөөнд нь ингээд л шахаж орж ирээд л үндсэндээ ингээд Улсын Их Хурлыг бараг Засгийн газрын хуулийн Тамгын газар шиг л ингэж ажиллуулах л ийм түвшинд аваачаад байна. Тэгэхээр энийг ер нь нэг талдаа би солиулах ёстой гэж

хараад байгаа. Засгийн газар энэ өөрчлөлтүүдийг хийвэл би сайн байна. Нэгд би тэр саналыг тавих гээд байгаа юм.

Хоёрт, Олон улсын валютын сангийн дүгнэлт гарлаа. Энэ бид нарын төсвийн сахилга бат чинь буруу байна, биш байна гэдгийг чинь зөвхөн бид нар ч хэлээд байгаа асуудлууд биш. Дотоодын экспертүүд ч хэлээд байгаа асуудлууд биш Олон улсын валютын сан манайд 2 долоо хоног ажиллаад 06 сарын 2-нд 6 сая дүгнэлтээ гаргачихсан байна. Энэ дүгнэлтийг та бүхэн үзэж, авч үзсэн үү? Энэ дээр дүгнэлт хийсэн үү? Эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байна. Төсвийн чинь нөхцөл байдлууд алдагдлууд нэмэгдэх нь, энэ 2026 он, 27 он чинь их хүнд байх юм шүү гэсэн дүгнэлтийг бичсэн байна. Энэ дээр ер нь ямар анализ хийж байна?

**Ж.Бат-Эрдэнэ:** Үндэсний аудитын газар хариулъя. Саяын Тэмүүлэн гишүүний асуусан асуулт. Хариуцлагатай холбоотой асуудал шүү.

**3.Цэдэнжав:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Цэдэнжав. Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд суусан хариуцлагатай холбоотой асуудлаар өмнө нь Тэмүүлэн гишүүн Байнгын хороон дээрээс бас тодорхой асуулт, чиглэл өгсөн. Үүний дагуу 2025 оны Засгийн газрын нэгдсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахад бас анхаарч ажилласан.

Ингээд бид Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.3, 70.4, 70.5-тай холбоотой асуудлаар бүх мэдээгээ бол ангилж авч үзсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт төсвийн ерөнхийлөн захирагч Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсүүлээд төсвийн ерөнхийлөн захирагчдад 53 ерөнхийлөн захирагчид бол албан шаардлага, албан бичгийг бол хүргүүлсэн.

Ингэхдээ бол Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.3, 70.4, 5-тай холбоотой асуудлаар ангилал бүрээр нь бол ялгаж хүргүүлээд ажиллаж байгаа. Ингээд мөн төрийн аудитын байгууллагаас энэ 27 оны төсвийг төсвийн төсөл хэлэлцэж эхлэхээс өмнө төсвийн ерөнхийлөн захирагч бүрээрээ энэ 70, Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийг зөрчсөнтэй холбоотой асуудлаар бол холбогдох уулзалтууд хийгээд Улсын Их Хурал Төсвийн байнгын хороонд бол бид нар мэдээллийг хүргүүлнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Энхбаяр сайд тодруулах уу? Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн 53 албан бичиг гэж байна шүү дээ. Энэ 53 албан бичгийн ардаас хэн хөөх ёстой вэ? Улсын Их Хурлын дэргэдэх Үндэсний аудитын газар гэдэг утгаараа Улсын Их Хурал хяналт тавих ёстой. Хоёрдугаарт хэрэв төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон бол энийг араас нь хэн нь Засгийн газар харах л ёстой л доо. Хуульд чинь юу гэж заадаг юм Үндэсний аудитын газрынхан? Зүгээр бичиг өгөөд хаячихдаг юм уу, яадаг юм? Дахиад тодруул даа.

**3.Цэдэнжав:** Бат-Эрдэнэ даргын асуултад хариулъя. Төрийн аудитын тухай хууль бол төрийн аудитын байгууллагаас өгсөн төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөө гаргаад 30 хоногийн дотор бол төрийн аудитын байгууллага буцааж мэдэгдэх ёстой. Ингээд бид нар энэ

хугацаандаа бол төсвийн ерөнхийлөн захирагч нартайгаа нэг бүрчлэн уулзаж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэрэв хэрэгжүүлээгүй бол яах ёстой вэ?

**З.Цэдэнжав:** Тодорхой төсвийн ерөнхийлөн захирагч түрүүн Энхбаяр сайд бас хэлж байсан энэ албан тушаалын төрлөөрөө тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийг томилох эрх бүхий албан тушаалтанд бол бид нар холбогдох хуулийн дагуу асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төрийн байгуулалтын байнгын хороон дээр байж байхдаа яг энэ асуудлыг ярьсан шүү дээ. Үндэсний аудитын газрынхантай. Та бүхний гаргасан бүх асуудал хэрэгждэг байх, хариуцлага тооцдог байх асуудал, бүх асуудлуудаа оруулж ирээд хэрвээ шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулъя гэсэн. Тэгээд тэр чигээрээ л чимээгүй боллоо. Тэмүүлэн гишүүн тодруулах уу, болсон уу?

Олон улсын валютын сантай холбоотой асуудал дээр хариулах хүн байна уу? Сангийн яамныхан.

**Б.Анар:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Олон улсын валютын сангийн артикль 4-ийн дагуу жил болгоны 6 сард бол ирээд Монгол Улсын төсөв, санхүүгийн удирдлагын талаар Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаар бол тайлан, дүгнэлтээ гаргадаг. Саяын энэ жилийн уулзалт бол сая энэ 6 дугаар сард Олон улсын валютын сангийн ажлын хэсэг бол ирээд ажиллаад явж байгаа.

Тухайн тайлангаар Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нөхцөл байдал нэгдсэн байдлаараа ямар байна, эрсдэл ямар байна, болзошгүй эрсдэлүүд юу байна вэ гэдгийг бол тодотгож тайлбарладаг. Энийг нь олон улсын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагууд бол мэдээллийн эх сурвалж байдлаар бол ашиглаад явдаг байгаа. Одоогийн авч байгаа мэдээллээр сүүлийн жилүүдэд авч байгаа бид нарын тайлангийн дүгнэлт бол moderate risk буюу эрсдэл бол дунд түвшинд байна гэсэн ийм үнэлгээг бол харьцангуй гайгүй эрсдэлтэй гэсэн .../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Б.Анар:** Дүгнэлтийг бол өгдөг. Тухайн өгч байгаа дүгнэлттэй холбоотойгоор, ирүүлж байгаа зөвлөмжүүдтэй холбоотойгоор бол Сангийн яамнаас, Төв банкнаас холбогдох арга хэмжээг аваад тэр авч байгаа арга хэмжээнийхээ талаар бас мэдээллүүдийг бол Олон улсын валютын сантай бол солилцоод ажиллаад явдаг байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Төсөв гэдэг бол үндсэндээ энэ өөрөө татвар төлөгчдийн л мөнгө байдаг. Энэ бол ард түмний болоод аж ахуйн нэгж, байгууллагуудын хөлс хүчээр бий болж байгаа. Тэгээд татвар төлөгчдийн мөнгийг бид нар үр ашиггүй зүйлд зарцуулах нь бол нэг талдаа ард түмнээ хуурч байгаагаас бол ялгаагүй асуудал.

Тэгэхээр бид нар энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой, төсвийн сахилга баттай холбоотой асуудлууд дээр хариуцлагатай хандах ёстой. Тэгэхээр би аудитын байгууллагын нэгдүгээрт хариуцлагатай ажил аа. Би Засгийн газарт ч гэсэн санал болгосон шиг саяын төсвийг гүйцэтгэлийг хэлэлцэх дэг өөрчлөх хуулийн саналыг ч гэсэн та бүхэн боловсруулах ёстой. Өөрсдийн чинь үйл ажиллагаанд бас хэрэгтэй.

Нөгөө талдаа төсвийн сахилга бат, хариуцлага гэдэг бол энэ өөрөө эдийн засгийн ч асуудал биш. Энэ бол нэг талдаа бас ёс зүйн асуудал байгаад байгаа. Тэгэхээр бид нар энэ дээр бол хатуу хандах ёстой. Хариуцлагаа ухамсарласан газарт л хөгжил ирдэг. Сахилга батгүй эрх чөлөө гэдэг бол өөрөө анархизм болдог. Тэгэхээр бид нар бол зайлшгүй энийг бол биелүүлэх ёстой.

Тэгэхээр аудитын байгууллага энэн дээр би хариуцлагатай ажиллаарай. Энэ дээр боловсруулж байгаа санал байна уу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээе, гүйцээж үгээ хэлье.

**Г.Тэмүүлэн:** Хоёрт, Олон улсын валютын сангийн дүгнэлтийг та бүхэн бас ингээд их дажгүй дүгнэлт ирчихсэн юм гэсэн байдлаар яриад байж болохгүй шүү. Энэ чинь бид нарын чинь болохгүй байгаа зүйлийг гадна талаас чинь харж дүгнээд та нар болохгүй байна шүү дээ, хүндэрлээ шүү дээ гээд хүн бид нарын өмнөөс санаа зовоод байна шүү дээ. Төсвийг чинь сахилга бат, хариуцлага чинь чухал болчихлоо шүү, хүндэрчихлээ шүү, критикал болчихлоо гэж асуудлыг ярьж байна.

Дээрээс нь юу гэдэг юм энэ дээрээ та бүхэн 2025 оны сүүлээр учирсан төсвийн чинь хүндрэл, төлбөрийг чинь тэнцлийн хүндрэлүүд эд нар чинь бас давхар хүндрээд байна. Сая ингээд юу гэдэг юм наад 2 мега төслөө төсвөөсөө гаргаад хаячхаж байгаа ч гэсэн буруу болчихлоо, энэ чинь бол сөргөөр нөлөөлөхөөр болчихлоо гэдэг асуудлыг ярьж байна.

Дээрээс нь эргээд та бүхэн энэ төсвийнхөө ил тод байдал, хариуцлагатай байдал, нэгдмэл байдлаа дээшлүүлэхгүй бол цаашдаа бид нар хэрхэхийг таашгүй болчихлоо гэдэг асуудлыг ярьж байгаа. Наад Монголбанк ч гэсэн бас дүгнэлт хийх асуудлыг гаргаж ир тавьсан байгаа. Бид нар энд бичсэнээр бол бүүр та нар 6 сарын байдлаар 7.4 тэрбум долларын нөөцтэй гэж ярьж байгаа боловч олон улсын стандарт.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Үндсэндээ бол хариулт хангалтгүй байлаа шүү гэдгийг бас сануулъя. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагт явуулъя. Дараагийн асуудалдаа оръё.

**“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

Төслийн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин танилцуулна. Түвшин гишүүнийг урьж байна.

**Б.Түвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7-гийн хэсгийг үндэслэн боловсруулсан “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2026 оны 06 сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланд дурдагдсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, нийтлэг болон давтан гарч байгаа алдаа, зөрчлийн бодит шалтгааныг судалж, тэдгээрийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахтай холбоотой болон хууль зүйн зохицуулалтын талаар санал боловсруулж танилцуулахыг Засгийн газарт даалгахаар тусгасан.

Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн олон жилийн насжилттай зээлийн хугацаа хэтэрсэн болон найдваргүй болон эрсдэлтэй зээлийн авлагын үлдэгдлийг тодорхойлох асуудлаар Төрийн аудитын байгууллага нь аудитын стандарт, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторт даалгасан.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төсөлд тусгагдсан Улсын Их Хурлаар зөвшөөрч шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд үндсэн үйл ажиллагаанаас бусад чиглэлээр зарлага гаргахыг хязгаарлаж байгаа нь бодит нөхцөлд нийцэхгүй байгааг анхаарах, төрийн өмчит компаниуд тодорхой асуудлын хүрээнд нийгмийн хариуцлага хүлээх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төрийн өмчийн хуулийн этгээдүүд ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг тул тухайн байгууллагууд арилжааны шинжтэй үйл ажиллагааг хориглох нь зүйтэй эсэх талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Дэд хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөрчлөгдөөгүй байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Соронзонболд гишүүнээр тасаллаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Төсвийн зарлагын дэд хороо бол бас онцгой давуу эрхтэй бас байгаа. Энэ ч бас аргагүй байх. Төсвийн зарлагыг цөөнхөөс даргыг нь томилоод Байнгын хороогоор хэлэлцүүлэхгүйгээр шууд Улсын Их Хуралд тогтоолын төслөө оруулж ирдэг бараг ганц дэд хороо байгаа. Тэгээд бусад тогтоолын төслүүд бол Байнгын хороогоор хэлэлцэгдэж орж ирдэг бол Төсвийн зарлагын дэд хороо бол шууд Улсын Их Хурлын чуулганд тогтоолын төслөө танилцуулдаг. Тэгээд энийг дэмжих, дэмжихгүй гэсэн асуудал гарч ирдэг.

Энэтэй холбогдуулж энэ тогтоолын төсөл дээр санал гаргаж болохгүй болохоор 2 асуулт байна. Энэ нэгдүгээрт нь энэ Монголбанкны 3.1 дээр нь Монголбанкны жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцдэг байх асуудлаар 27 оны төсвийн төсөл хэлэлцэх төсөлтэй хамт Улсын Их Хуралд энэ энэтэй холбогдсон хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар Улсын Их Хуралд оруулж ирэхийг Ерөнхий сайдад даалгаж байгаа юм.

Тэгэхээр ерөнхийдөө бол Монголбанкныг бол бие даасан байх ёстой. Засгийн газраас ч хараат бус байх ёстой. Засгийн газраас Монголбанканд чиглэл өгч болохгүй, нөлөөлж болохгүй, төсвийн шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлж болохгүй бие даасан байх ёстой гэсэн ийм заалтууд байгаа.

Нөгөө талаасаа бас Улсын Их Хурлыг бас мөнгөний бодлогод оролцож болохгүй гэсэн ийм Төв банкны тухай хууль дээр заалтууд байгаа. Тэгэхээр энэ заалттай холбоотой бусад улсууд бас яг энэ Монгол Төв банкныхаа энэ бие даасан байдлаа хадгалахын тулд энэ төсвийг нь хэлэлцдэг асуудал бага байлаа. Бид нар энэ Төв банкны тухай хуулийнхаа 30.3 дээр нь болохоор санхүүгийн тайлан болон аудитыг нь тэгээд дээр нь бас Улсын Их Хурлаас томилдог Хяналтын зөвлөлийнх нь энэ санал, зөвлөмжийг нь бас Улсын Их Хуралд танилцуулахаар иймэрхүү зохицуулалт байгаа. Тэгэхээр энэтэй холбогдуулаад Монголбанкнаас бас асууя. Энэ ийм зохицуулалт Монголбанкны төсвийг Улсын Их Хурал дээр ингэж хэлэлцэх ийм бололцоо, боломж байдаг юм уу? Энд Монголбанкны бие даасан, хараат бус байдалд нөлөөлөх үү? Энэ Засгийн газар болон Улсын Их Хуралтай харилцах харилцаануудыг нь тодорхой хуулиар хязгаарлачихсан зохицуулалт байгаа. Тэгээд энэтэй зөрчилдөх үү үгүй юү гэдэн нэг асуулт байна. Энийг Монголбанкнаас бас хариулж өгөөч.

Хоёрдугаар асуулт нь болохоор ер нь бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань бас яг энэ төсвийн сахилга батыг хангуулах маш чухал бүтэц байгаа юм. Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг гаргаж байгаа саналуудыг бол өнгөрсөн хугацаанд бол жишээлбэл энэ төсвийн тайлан дээр харахад бол яг л хэлчихсэн байгаад байгаа байхгүй юу орлогоо хэт өөдрөгөөр төсөөлсөн байна. Хөрөнгө оруулалтууд чинь гүйцэхгүй нь байна гэх мэтчилэнгээр гээд анхааруулж сануулаад байхад жишээлбэл ингээд Засгийн газар нь үйл ажиллагааны хөтөлбөртөө, энэ юун дээр ерөөсөө анхаараагүй ийм дүр зураг.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг дэмжих ёстой, хамтарч ажиллах ёстой бүтэц маань Төсвийн зарлагын дэд хороо юм шиг санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэнтэй холбоотой ямар нэгэн үг, үсэг байхгүй байгаад байна л даа. Тэгэхээр Төсвийн зарлагын дэд хорооны даргаас бас нэмэлтээр энэ Төсвийн тогтвор дотоод байдлын зөвлөлтэй хамтарч ажиллах энэ чиглэлээр дэд хорооны даргын хувьд юу гэж бодож байгаа талаар асуулт байна. Эхлээд Монголбанкнаас асуултдаа хариулт авчихъя. Тэгээд дараа нь Төсвийн зарлагын дэд хороо тэгээд асуулт нэмж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монголбанк 3 номер.

**Г.Энхтайван:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Төв банкны тухай хуулиар Төв банкны тухай хуулийн 30.4 дээр Улсын Их Хуралтай хэрхэн харилцах тухай зохицуулалтыг нарийн оруулж өгсөн байдаг. Энэ хүрээнд Төв банкны бодлого, үйл ажиллагаа, жилийн төсөв, түүний тайлан, гүйцэтгэлийг бол Төв банканд Улсын Их Хурлаас томилогдсон Хяналтын зөвлөл хэлэлцээд Хяналтын зөвлөл тайлангаа дүгнэлтээ Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлдэг. Тэр хүрээнд энэ жил 5 дугаар сард бол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо сонссон байгаа.

Төсвийг бол Улсын Их Хурлаас ингээд батлах юм бол энэ чинь яг юу болохыг бол би бол хэлж мэдэхгүй байна. Жишээлбэл төсөв батлаад 3, 4 дүгээр улиралд жишээлбэл төсөв дуусчихсан гээд аль нэгэн алтны компани ирээд алтаа тушаах гэсэн чинь мөнгө байхгүй болчихдог. Эсвэл доллар авах гэсэн чинь, доллар зарах гэсэн чинь мөнгө байхгүй байна гээд төсөв дуусчихсан гэдэг ийм асуудал руу л орох нь.

Дэлхий дээр парламентаараа төсвөө батлуулдаг Төв банк бол дэлхий дээр ерөөсөө байхгүй. 195 орны Төв банк бие дааж өөрөө төсвөө баталдаг тийм л зохицуулалттай байгаа. Олон улсын жишгээр энэ бол open market гэж нэрлэдэг. Хэрвээ энэ дээр ийм зохицуулалт гарах юм бол бид бүгдийн нэгдэн орсон Олон улсын валютын сангийн хэлэлцээр анх 91 онд нэгдэж орсон хэлэлцээр дээр яг энэ гэрээг бол олон улсын гэрээгээр бид бүхэн хүлээчихсэн байдаг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Даваагийн Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Монголбанкны бие даасан байдалд бол оролцъё гэж байгаа хэлбэр бол биш. Монголбанк өөрөө интервенц хийхэд ийм хэмжээний нөөц эх үүсвэр хэрэгтэй, алтны худалдан

авалтад зориулаад ийм эх үүсвэр хэрэгтэй гээд бүх үйл ажиллагаагаа хангалттай хэмжээнд төлөвлөөд ороод ирэхэд Улсын Их Хурал бол өөрсдөө батлаад явж байгаа юмыг Улсын Их Хурал заавал батлахгүй гэхгүй байх гэж харж байгаа юм.

Одоо байгаа нөхцөл байдал чинь яаж байгаа вэ гэхээр бид нар орон тоогоо багасга гэдэг Засгийн газарт хандсан нэг үг хэлэд энэ Улсын Их Хурал дээрээс шийдвэр гарахад тэр нь явсаар байгаад Монголбанкн дээр ч гэсэн очиж нөлөөлөөд байгаа юм. Тэгээд Монголбанкн дээр очиж нөлөөлөхөөрөө яадаг вэ гэхээр бас л баахан хүмүүс халдаг. Наранцогт дарга очингуутаа 15 тэрбумын ч билүү хэмнэлт гаргачихлаа гэж тайлбар өгөөд байгаа юм.

Тэнд бол яг үнэхээр инфляцтайгаа зөв ноцолдоод яг төгрөгийн ханш чангараад явж байгаа бол Монголбанкны төсвийг бид нар заавал танана, хасна.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Да.Цогтбаатар:** Танах, хасах зорилгоор энд бол орж ирээгүй. Төсвийг нь бид нар хангалттай баталж өгнө. Инфляцаа хангалттай нам доор барьж чаддаг бай, төгрөгийн ханш хангалттай хэмжээнд үнэ цэнтэй бай гэдэг энэ хяналтыг Монголбанкн дээр хэрэгжүүлэх л гэдэг агуулгаар нь орж ирж байгаа.

Тэгэхгүй энэ Эдийн засгийн байнгын хороон дээр орж ирэхээрээ үндсэн чиглэлээ батлуулах гэж байна гээд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг батлуулаад л ингэж ажиллалаа шүү гэж юм оруулж ирээд л ингээд л болчхоод байгаа юм. Энэ дээр илүү ажил хэрэгч байдлаар хандвал ийм зохицуулалт орж ирж болж байна л гэж байгаа юм. Жишээлэхэд, Монголбанкнд үнэхээр мэргэжлийн сайн боловсон хүчнийг аваад ажиллуулъя гэхэд дундаж цалингийн хэмжээг нь хүртэл Монголбанкн дээр аягүй бага болчихсон. Энийг ч гэсэн бид нар үнэхээр бодлогоор бодлогоор Монголбанкаа дэмжиж сайжруулж байж цаашаа явах ёстой л гэсэн ийм бодлого байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн талаарх асуултыг нэмээд хариулчих нь биз. Энэ тогтоолын төслийн энэ заалт болохоор яг л төсвийг Байнгын хороогоор хэлэлцэнэ л гэдэг чинь өөрөө төсвийг батлах агуулгатай, нөлөөлөх агуулгатай л ийм болчхоод байна л даа. Тэгэхээр энэ нь өөрөө нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэнтэй холбоотой хуулийн төслийг энэ төсвийн хамт оруулж ирнэ гэхээр хэлэлцэх дэг нь өөрөө өөр байгаа. Тэгэхээр Засгийн газарт ийм чиглэл өгөхөөр энэ нөгөө энэ чинь бол бас чухал институцүүдийн бие даасан байдалтай холбоотой асуудал учраас энэ нь өөрөө ингэж хэлэлцүүлэг нь бас олон нийтийн санаа бодлыг авч чадахгүй иймэрхүү байдалд орохоор харагдаад байна л даа. Тэгэхээр энэ заалтаас болоод жишээлбэл энэ тогтоолын төслийг дэмжих боломжгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр засах бололцоогүй. Уул нь бусад юмыг нь дэмжмээр байдаг. Тэгэхээр энэ дээр бас дэд хорооны дарга бас саналаа хэлээч. Түрүүчийн дутуу асуулт дээр бас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Даваагийн Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Өмнөх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй хамтарч ажиллах талаар бас асуугаад байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл зөвлөмж гаргаж Улсын Их Хуралд хүргүүлдэг. Аливаа төрлийн төсвийн тодотгол, төсөв батлах үеэр, төсвийн гүйцэтгэлийн үеэр ч гэсэн. Яг энэ дээр Энхтүвшин гишүүн өөрөө бас манлайлаад, санаачлаад төсөв дээрээ бид нар сахилга баттай байх ёстой, алдагдалгүй байх ёстой гээд явдаг.

Гэтэл яг бодит байдал дээрээ манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол жинхэнээсээ шүдгүй арслан. Бид нарт зөвлөмж, дүгнэлт өгөөд орхидог Улсын Их Хурал улс төрөө даахгүйгээр нөгөө зөвлөмжөө хэрэгжүүлж чадахгүй бид нарын, Олон улсын валютын сангийн өмнө хүлээчихсэн үүрэг нь хүртэл хамгийн сүүлийн жишээгээр бид нар нөгөө гадаадын зээл ашиглалтыг сайжруулах гэдэг хуулийг тусад нь гаргаж өгөөд бид нар төсвийн тухай хууль дээрээсээ дахиад л ингээд буруу жишиг рүүгээ яваад байгаа юм. Тэгээд энэ байдлуудыг нэмэгдүүлэхийн тулд тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн асуудлуудыг нааш нь оруулж ирсэн.

Монголбанктай холбоотой асуудлыг дэлгэрүүлээд дахиад ярих гэхээр энэ цаг дуусчихлаа. Цагаа дахиад өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Да.Цогтбаатар:** Яг ингэж хараандаа байлгаж төсвийг нь баталж өгөх гээд байгаа юм биш. Хууль зүйн яам жишээлэхэд Шүүхийн сахилгын хороо, хууль, шүүхийн байгууллага гээд 4, 5-н байгууллагын нөгөө оруулж ирсэн саналыг нь хасахгүйгээр тэр чигт нь өргөн бариад явчихдаг. Яг тэр жишгээрээ явах юм бол бид нар заавал Монголбанкийг та нар ийм төгрөгт багтааж цалингийн сангаа хийе гэдэг байдлаар харах гээгүй юм. Одоо бид нар инфляцаа энэ доор түвшинд удирдахын тулд бид нар ийм хэмжээний зардал гаргана, ийм хүн хүчээр ажиллана, 7, 800-н хүн тэнд ажилласан ч болно хамаагүй. Бид нар бүх зардал мөнгийг нь тавьж өгч байгаад яг чөлөөтэйгөөр нь ажиллуулахгүй бол өнгөрсөн хугацаанд зүгээр Засгийн газрын кассын нярав шиг л ажиллаж явж ирсэн.

Тэгээд энэнийх нь бодлогын алдаанаас нь болоод 7.8 их наяд, тэрбум долларын нөөцтэй байж байж эдийн засаг дахь мөнгөн урсгал хүртэл сайжирч чадахгүй энд 8 бодлогын хүү сайжирч чадахгүй сөрөг талууд маш их байгаа. Энийг бас уян хатан байдлаар хардаг болох үүднээс оруулж ирж байгаа гэдгийг бас зөвөөр ойлгоорой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Ер нь бол бид нарын өнөөдрийн бас олон зовлонгуудын нь бол яг энэ төгрөгийн тогтвортой байдал. Монголбанкны бие даасан байдал бол маш чухал асуудал байгаа юм. Гэхдээ энийг хуулиар бие даасан байдлыг нь хангах олон заалтууд томилгоо дээр нь ч гэсэн байдаг хэдий ч бас энийгээ хэрэгжүүлж чадахгүй. Тэгэхээр хууль дээр бол заалтууд бас хангалттай байгаад байна.

Тэгэхээр энэ нь өөрөө энийгээ хэрэгжүүлэх талаас нь илүү шахвал илүү үр дүнтэй юм уу? Харин энэ сая ийн орж ирж байгаа та тэгж шууд уншихгүй байгаа ч гэсэн зүгээр өөр талаас нь харвал төсвийг нь хэлэлцдэг болно гэдэг чинь л яг л бие даасан байдалд нь бас тодорхой хэмжээнд нөлөөлөх ийм эрх зүйн орчин нээж өгч байгаа болохоор энэ нь өөрөө түрүүчийн ярьдаг одоогийн бие даасан байдлыг нь хангах энэ заалтуудыг нь сайжруулах биш улам дордуулах иймэрхүү шинжтэй.

Дээр нь олон улсын нэгдсэн тэр бас гэрээ, конвенцуудад нь зөрчилдөхөөр бол энэ нь бас дахиад асуудал үүсэх учраас энэ өөрчлөлт оруулж болохгүй. Энэ тогтоолын төслийн гол нь санал оруулж болохгүй. Тэгэхээр дэмжих бололцоогүй л болох гээд байна л даа энэ заалтаас болоод.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Энэ Зарлагын хяналтын дэд хороо хуралдаж байхад бол Эрдэнэбат гишүүн ч гэсэн орж ирээд бас саналаа хэлээд тогтоолын төсөл дээр ийм саналтай байна гэдгээ санал хураалгаад явсан. Тэгээд манай гишүүдийн бас ажил нь бас давхацсан байх. Ер нь бол Энхтүвшин гишүүний хэлээд байгаа саналыг бол ойлгож байгаа.

Гэхдээ бид нар үнэхээр хараат бус байлгаж чадахгүй байгаа учраас энэ саналууд орж ирж байгаа гэдгийг бас та зөвөөр хараасай. Жишээлэхэд сая томилгооны асуудал яригдлаа ямар томилгоо явчлав гэдгийг нийгэм даяараа л харсан байх. Би нэмэлтээр хараат бус байж чадаж байна шүү дээ гэж хэлж чадахааргүй л томилгоо явчихлаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүний хэлээд байдаг ч бас жоохон ортой л байна л даа. Хараат бус байдлыг хангахад бас учир дутагдалтай байна л гэж. Дараагийнх нь Лхагвасүрэнгийн Соронзонболд.

**Л.Соронзонболд:** Төсвийн зарлагын дэд хорооноос боловсруулсан тогтоолын төсөлтэй танилцлаа. Хэд хэдэн бас сайн заалтууд бол орсон байна. Саяын Энхтүвшин гишүүний яриад байгаа асуудал энэ Засгийн газарт өгч байгаа үүрэг дээр Монголбанктай холбоотой асуудал орж ирж байгаа нь ер нь зүгээр логикийн хувьд, бүтцийн хувьд буруу юм шиг санагдаад байгаа байхгүй юу. Монголбанк чинь өөрөө Улсын Их Хурлын харьяа байгууллага. Гэтэл Монголбанкны жилийн төсөв болон төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцдэг байх асуудлаар Засгийн газар санал боловсруулах тухай оруулж ирж байгаа нь өөрөө ингээд буруу байна гэж харж байгаа юм. Тэгэхээр энийгээ зарлагын хяналтын дэд хороо засах боломж нь байгаа юм уу?

Ер нь бол Монголбанкны жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал дээр бол анхаарах асуудал юу вэ гэхээр Монголбанк бодлогоо бие дааж явуулах ёстой. Монголбанкны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа төсөв, хөрөнгө оруулалттай холбоотой асуудал дээр бол бас тодорхой Байнгын хороо хэлэлцдэг байх нь бол чухал гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр жишээлбэл өнөөдрийн Монголбанк маань бол зүгээр баланс дээр бол маш их үл хөдлөх хөрөнгө байгаа шүү дээ. Үл хөдлөх хөрөнгө. Тэр үл

хөдлөх хөрөнгөө түрээслээд байж байдаг. Тэгсэн мөртөө харьяа байгууллагууд нь бас өөр газар байр түрээслээд явж байдаг. Ийм байж болохгүй.

Тэгэхээр өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай байгаа хөрөнгийн асуудал, хөрөнгө оруулалтын асуудал, зардлын асуудлуудыг бол бас тодорхой хэмжээнд төсвийг нь хянаж шийдвэрлэдэггүй байх нь зөв. Харин бодлого дээр бол чөлөөтэй өөрсдийн бодлогын шийдвэрээ гаргахыг нь бол төсвөөр хязгаарлах шаардлагагүй гэж миний хувьд бол бодож байгаа.

Тийм учраас энэ дээр энэ 1 дүгээр асуудлын 3.Г бол уул нь шаардлагагүй юм шиг санагдаад байгаа юм. Яагаад гэвэл энэ чинь Засгийн газарт харьяалалгүй байгууллагын асуудлаар чиглэл өгөөд байгаа нь буруу байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр Төслийн зарлагын дэд хорооны дарга байр сууриа илэрхийлээч ээ гээд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Даваагийн Цогтбаатар гишүүн хариулъя.

**Да.Цогтбаатар:** Тийм Соронзонболд гишүүнтэй бас яг санал нэгдэж байгаа. Улсын Монголбанкны мөнгөний бодлого бол хараат бус бие даасан байдлаар явах ёстой. Тэгээд яг бид нар ингэж бодоод 2 шатлалт банкны тогтолцооноосоо эхлүүлсэн 92 оноосоо хойш өнөөдрийг болтол харахаар хангалттай хэмжээнд бие даасан байдлаар явсан эсэх нь эргэлзээтэй байдалд хүрсэн учраас энэ дээр ийм саналыг оруулж ирж байгаа. Таны хэлж байгаатай бас санал нийлж байгаа юм. Жишээлэхэд бусад хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө маш олонтой байж байж харьяа байгууллагууд нь ч гэсэндээ бусдаас үнэтэй үл хөдлөх түрээсэлж үйл ажиллагаагаа явуулдаг. Монголбанкны харьяанд байгаа үл хөдлөх хөрөнгийг бусдад бас хямдханаар түрээслүүлдэг гэдэг энэ асуудлууд байгаа.

Тийм учраас яг энэ тогтоолынхоо төсөл дээр холбогдох Байнгын хороо гэж байгаа юм. Тэрнээс заавал төсөв дээр ч юм уу, заавал Эдийн засаг дээр ч юм уу холбогдох хуулийн шаардлагатай асуудлууд байгаа бол Хууль зүйн байнгын хороотой хамтардаг юм уу, төсөв батлуулах шаардлагатай бол Төсвийн байнгын хороо юм уу, эсвэл яг хараат бус, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах бодлогын дэмжлэг хэрэгтэй бол Эдийн засгийн байнгын хороотойгоо хамтрах гээд.

Би бол Улсын Их Хурлыг учир зүггүй Засгийн газрын талд 100 хувь ажиллаад байна гэж бодохгүй. Харин ч эсрэгээрээ хараат бусаар ажиллах ёстой гэж бодож байгаа. Тийм ч учраас энэ Улсын Их Хурлаас томилогдсон манай аудит бол өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн 1 жилийн хугацаанд бол дан ялангуяа маш хараат бусаар ажиллаад дүгнэлтүүдээ маш зоригтойгоор танилцуулж байгаа. Энэ шигээ Монголбанкн дээр ч гэсэн мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулахын тулд Улсын Их Хуралтайгаа яаж хамтарч ажиллах юм тэр талаас нь хараасай л гэж бас хүсэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Соронзонболд гишүүн тодруулъя.

**Л.Соронзонболд:** Цогтбаатар даргаа гол асуугаад байгаа нь ингээд байгаа юм. Энэ Засгийн газарт ингээд даалгаад байна шүү дээ Монголбанкны асуудал. Энэ чинь харин зөв юм уу л гээд байхгүй юу. Яагаад гэхээр бид Монголбанк чинь өөрөө Улсын Их Хурлын харьяаны байгууллага байхгүй юу. Тэгэхээр Улсын Их

Хурал руугаа чиглэсэн байдлаар энийг өөрчилж болохгүй байгаа юм уу? Яагаад Засгийн газарт даалгавар өгөөд байгаа юм бэ л гэж асуугаад байхгүй юу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын харьяа байгууллага, дэргэдэх байгууллага бид нар магадгүй Байнгын хороондоо л өгөх ёстой байхгүй юу даа уг нь бол. Хариулах уу Цогтбаатар гишүүн?

**Да.Цогтбаатар:** Тийм нөгөө техникийн шинж чанартай бичвэрүүдийг жишээлэхэд энэ Улсын Их Хуралд нь, эсвэл Засгийн газарт нь гэдэг нөхцөл байдлыг уг нь бол нэлээн харсан юм. Тэгээд уг нь бол энэ Улсын Их Хурал дээрээ Засгийн газартаа чиглэл өгөх байдлаар найруулагдах байсан юм. Соронзонболд гишүүний яриад байгааг бол зарчмын хувьд дэмжиж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурал Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагадаа байгууллагынхаа асуудлаар Улсын Их Хурлаар тодорхой шийдвэр гаргах, шийдвэр гаргах юм чинь Улсын Их Хурлын дэргэд байгаа мэргэжлийн байгууллагууд буюу Байнгын хороодоос тодорхой дүгнэлтүүд бол гарч байх ёстой шүү дээ. Ганзorigийн Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой гарч байгаа тогтоолын төслийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Гэхдээ бид нар бас анхаарах ёстой зүйл байна. Уг нь хэрэгтэй хуулиуд их олон байгаад байдаг. Хэрэгжүүлдэггүй, хариуцлага тооцдоггүй, хариуцлагагүй байдал өөрөө бид бүгдийн хамгийн том асуудал болоод байна. Тэгэхээр би магадгүй энд заасан заалтууд хэрэгжинэ гэхэд бас итгэхгүй л байна. Нэг талдаа.

Тэгэхээр Засгийн газар бол энэ гүйцэтгэлийг нь заавал ч үгүй оруулж ирж танилцуулах ёстой. Энэ асуудлуудаар юу хийснээ бүрэн дүүрэн мэдээлэх зайлшгүй шаардлагатай. Энд би бас зарим давхацсан ч зохицуулалтууд бас байна гэж бол хараад байгаа. Би энд бүүр онцолж хэлье гээд байгаа.

Жишээ нь аудит бол би бас хариуцлагагүй ажиллаад байна. Засгийн газар ч гэсэн хариуцлага тооцохгүй байна гээд байгаагийн шалтгаан нь бид нар 23 онд энэ Төсвийн тухай хууль дээр бас ярьж байгаад Төсвийн тухай хуулийн 24.7 дээр яг иймэрхүү төсвийн болон төрийн орон нутгийн өмчид энэ компаниудаас ямар нэг санхүүжилт гаргахгүй дээр нь бүүр хориглож өгсөн юм. Бүүр нэр тухай зааж өгөөд аливаа тэмдэглэлт өдөр, өдөрлөг, ой баярт зориулж зарцуулахыг хориглоно. Хандив, тусламж, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдал нөхөх зэрэг дүрэмд заагдаагүй аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно гээд Төсвийн тухай хууль дээр, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.3 дээр, энэ хуулийн 5.5 дээр энэ хориглолтыг зөрчсөн этгээдийг ажил албан тушаалаас нь чөлөөлж учир учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ гээд энэ зохицуулалтууд хангалттай хийж өгсөн байгаад байгаа юм.

Гэтэл энэ заалтууд төсвийн хариуцлагатай холбоотой, сахилга баттай холбоотой энэ асуудлууд мянга энэ хуульд байгаад энийг хэрэгжүүлж байгаа, хариуцлага тооцож байгаа, аудит энийг авч ашиглаж байгаа зүйл байхгүй байгаад байна. Ийм назгай байгаад байвал бид нар цаашид ер нь хөгжил ярина гэхэд хүнд болчихлоо шүү.

Хариуцлага ярихгүйгээр бид нар цаашид энэ хөгжинө, барина, дэвжинэ гэж ярих бол үндсэндээ утгагүй асуудал. Тэгэхээр би хариуцлагатай хандаач ээ. Энэ хуулийг ч биелүүл. Ер нь дагаж гарч байгаа тогтоолуудыг ч та бүхэн бас хариуцлагатай хандаж, өөр өөрсдөдөө дүгнэлт хийж, өөрчлөлтийг уг нь Засгийн газар бас өөрсдөөсөө хийх хэрэгтэй байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ болохгүй, бүтэхгүй байгаа энэ зарчмын бус асуудлуудаа, дүрэм, журмуудаа бас өөрчлөх, засах, янзлах хэрэгтэй байна. Би дахиад л энэ Олон улсын валютын сангийн 06 сарын 26-нд гаргасан дүгнэлтээс би хэлэх гээд байгаа юм. Энэ юу хэлж байна вэ гэхээр нэгд Монголбанк ч гэсэн анхаарах асуудал энд байгаад байгаа юм. Та нар гадаад валютынхаа албан нөөцийг алдаагүй тооцож чадахгүй байна байна гэдэг асуудлыг ч хэлээд байгаа. 6 сард 7.4 тэрбум доллар гэж мэдээлсэн боловч манай Олон улсын валютын сангийн энэ нөөц тоо тооцдог энэ манай аргачлалаар бол энэ чинь хамаагүй доошоогоо байна гэдэг асуудлыг гаргаж ирж тавьж байгаа юм.

Одоо бид нар ингээд өөр өөрсдөдөө нийцүүлж аргачлал зохиодог, дүрэм, журам гаргадаг, бараг дэлхийд байхгүй дугуй зохиох гээд ингээд үзээд байдаг чинь болохгүй байна. Сангийн яам бас энэнтэйгээ бас анхаарах ёстой. Бид нар бодит дүнтэйгээ нүүр тулдаг байх ёстой. Үнэн өөрөө гашуун боловч угаасаа уг нь энэ улсад хэрэгтэй байгаад байгаа юм. Бид нар бодит дүн шинжилгээ хийгээд, алдаа дутагдлаа гаргаж ирээд залруулах хэрэгтэй байгаад байгаа юм. Сангийн яам чинь 2 жилийн өмнө тэр суурь зарлага, суурь тэнцэл гэдэг тийм стандарт бус дэлхийд байхгүй ийм ийм аргачлал гарч ирсэн. Одоо энэнээсээ болоод төсвийнхөө зарлагыг нэмэгдүүлчихсэн. Ингээд дураараа тэлчихсэн. Сая энд Олон улсын валютын сангийн дүгнэлт дээр бас хэлсэн байна. Та бүхэн дахиад ингээд төсвөөсөө 2 мега төслөө гаргаад тавьчихлаа. Одоо цаашид бол та бүхэн төсвийн дүрэм журам, стандарт гэж ярих ямар ч шаардлагагүй шахуу болчихлоо гэдэг асуудлыг чинь гаргаж ирж тавьж байгаа юм.

Ийм байдлаар та бүхэн бол төсвийн чинь ил тод байдал, төсвийн чинь хариуцлагатай байдал, төсвийн чинь менежмент бол хүндэрлээ шүү. Эдийн засаг чинь хүндэрч байна. Инфляц чинь өөрөө 11 хувь, 11.6 хувь болчихлоо. Сар сард 1 хувиар нэмэгдэж байна. Цаашид юу гэдэг юм төсвийнхөө зарлагыг танах, хариуцлагатай хандах, үр ашиггүй зүйлд зарцуулахгүй байх гэдэг асуудлуудыг гаргаж ирж тавьж байна шүү дээ.

Тэгэхээр бид нар ийм байдлаар назгай хандмааргүй байна. Алдаа, оноо, дутагдлуудаа гаргаж ирээд засаж, залруулаад явахгүй бол өнөөдөр үндсэндээ үнэнээс ингэж айгаад зугтаагаад байдаг. Ингээд дэлхийд байхгүй өөр аргачлалууд тоодог, хий хоосон худлаа тоо гаргаж ирдэг энэ нөхцөл байдлууд дээр бол бид нар зайлшгүй өөрчлөлт хийх шаардлагатай байна шүү. Энийг намар асууна шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүлэн гишүүн үг хэллээ. Үндэсний аудитын газрынхан маань хэн хэн байна, ямар хүмүүс байна? Та бүхэнд нэг үүрэг даалгавар өгье. Та бүхний гаргасан дүгнэлтийн дагуу Засгийн газар тодорхой ерөнхийлөн захирагч нарт өгсөн үүрэг даалгавар хэрвээ биелээгүй байгаа бол, Засгийн газар гүйцэтгэгдэхгүй байгаа бол буцаж Улсын Их Хуралд тайлагнадаг, Улсын Их Хурал энийг хэлэлцдэг үүрэг даалгаварт зохих Байнгын хороо болоод Улсын Их Хурлын

тогтоолоор үүрэг даалгавар өгөөд Засгийн газартай болоод тэр зохих хүмүүст нь хариуцлага тооцдог энэ дэг рүү оруулъя. Хуульдаа ийм зүйл санаачилж оруулъя.

Тэгэхгүй Засгийн газарт бид нар өнөөдрийг хүртэл даалгаад байгаа. Юу боллоо гэж Засгийн газар өөрөө өөрсдөө арга хэмжээ авсангүй, өөрсдийнхөө дотоод бүтцэд арга хэмжээ авсангүй гэж асуудал наашаа оруулж ирэх вэ дээ. Оруулж ирэхгүй биз дээ? Энийг хэн хийх вэ гэхээр Улсын Их Хурал л хийж таараа.

Тэгэхээр та бүхэн энэ намар гэхэд, ер нь бол энэ хуулийн төсөл буюу энэ хариуцлагын тогтолцоо юмнууд чинь болохгүй байгаа, гишүүдийн яриад байгаа дээр тодорхой дүгнэлт хийгээд, мэргэжлийн байгууллагын хувьд, Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагын хувьд Тамгын газрынхан анхаараарай намар гэхэд ийм тодорхой дүгнэлтүүдийг буцааж оруулж ирж танилцуул аа гэж ийм үүрэг даалгавар өгье.

Цогтбаатар гишүүн. Тэн дээр ч гэсэн бас дүгнэлт гарч болох юм байна шүү дээ.

**Да.Цогтбаатар:** Энэ Тэмүүлэн гишүүний яриад байгаатай бол бас маш сайн санал нийлж байгаа. Олон улсын энэ валютын сангаас бид нарыг төсвийг бид нар өөрөө дотроо хууль зохиогоод баталчихаар Олон улсын валютын тэрийг тийм эднийх төсвөө ингээд баталчихсан нь зөв гэж хүлээж авах юм шиг ойлгоод бид нар Төсвийнхөө хуульд дураараа гар хүрээд байгаа юм. Зарчим бол өөрчлөгдөхгүй. Олон улсад мөрдөгдөж байгаа зарчим.

Яг энэнтэй холбоотойгоор жишээлэхэд энэ холбогдох энэ хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, хариуцлагажуулах зорилгоор гээд энэ 2023 онд Занданшатар даргын үед энэ Засгийн газарт үүрэг нь өгөгдөж байсан тогтоол бас гарч байсан юм байна лээ. Тэгээд тухайн үед ажлыг нь бол бас л нөгөө хуульд Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн дарга өөрөө ажиллаж байсан. Төсвийн байнгын хороонд үүрэг нь өгөгдөж байсан. Зөвхөн аудитад биш.

Тэгэхээр өнөөдрийг болтол энэ нөгөө манай Бямбацогт дарга дэг сахиулна гээд байгаа энэ өмнө өгөгдөж байсан үүрэг даалгаврын биелэлтийг бас сайн харахгүй бол бид нар энэ өмнө нь үүрэг даалгавар өгөөд орхиод байдаг, гүйцэтгэл хяналтдаа бас эргээд хяналт тавьж чадахгүй байгаа гэдгийг бас анхаарах хэрэгтэй болсон байна лээ гэдгийг хэлэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтбаатар гишүүний, даргын ярьсан асуудлыг, саяын миний хэлсэнтэй холбогдуулаад ер нь санал боловсруулаад хэдүүлээ дахиж эргэж харах хэрэгтэй юм байна гэж.

Ингээд гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа. Хариулт авч дууслаа.

Одоо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагт явуулна. Дараагийнхаа асуудалд оръё.

13.56 цаг.

**Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Соронзонболд гишүүнийг индэрт урьж байна.

**Л.Соронзонболд:** Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчдийн газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн орлогын хэлтсийн

дарга, Шийрэмдамбын Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25-нд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, өгөх танилцуулга, Улсын Их Хуралд мэдээлэл өгөх худал мэдээлэл ирүүлэхийг хориглох гэх мэтчилэн тус тус заалтуудыг та бүхэнд сануулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Хэн байна?

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Маш их олон жилийн өмнө энэ “Соко интернэйшнл” гэж компанид энэ газрын тосны лицензээ олгосон. Тэгэхээр энэ газрын тосны яг энэ хэлэлцээр орж ирэхэд бол манай дээр үеийн гишүүд бас өөрсдийнхөө сонирхлыг оруулсан байдаг юм байна лээ. Тэгээд энэ хэлэлцээр дээр нь янз янзын заалт оруулж байгаад, шантайжилж байгаад жишээ нь өнгөрсөн 20 гаруй жилийн туршид нэгхэн компани энэ газрын тосны энэ үйл ажиллагаа явуулж байгаа газар дээр ажиллах хүчний бүх асуудлыг нь шийдвэрлэдэг давуу эрх авсан. Тэгээд тэндээсээ ингээд шантайж хийснийхээ хариуг ингээд аваад явсан ийм л муу түүхтэй ийм зүйл л дээ.

Тэртээ тэргүй одоо бид нар өөрсдөө энэ газрын тосоо олборлож чадахгүй тохиолдолд аль нэгэн улстай гэрээлж таарна. Тэгээд сүүлдээ “Соко интернэйшнл” нь арга бараад “Петрочайна Дачин Тамсаг” гэдэг компанид өгсөн. Тэгээд энэ “Петрочайна Дачин Тамсаг” гэдгийн Тамсаг дээр энэ Засгийн газраасаа эхсүүлээд л аймаг, сум, шат болгондоо ингэж өөр өөрийнхөө сонирхлыг оруулдаг. Тэгээд сая 500 мянган тонн нефть гаргадаг байж байгаад сүүлдээ бүүр 200 болсон гэсэн байх аа Энхбаяр сайд аа? 300 орчим мянган тонн л болсон.

Гэтэл бид нар энд Алтанширээ гэдэг газар дээрээ маш их өндөр үнэтэйгээр газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулж байдаг. Гэтэл цаанаас ирэх ёстой тэр шугам, хоолойгоо бүгдийг нь тавиад эхэлчихсэн. Эндээс нийлүүлэх ёстой тэр нефть бүтээгдэхүүн нь ийм бага түвшинд орох юм бол нөгөө бидний өндөр үнээр барьсан үйлдвэр маань, газрын тосны үйлдвэр маань үр ашиггүй явах, гаднаас хараат болох өөрөөр хэлбэл хойноос нефтээ авчирч байгаад энд боловсруулах ийм нөхцөл байдал руу ороод байгаа юм л даа.

Тэгэхээр энэ тээгийг арилгасан ийм төсөл орж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр бол мэдээж энэ Засгийн газар маш их идэвхтэй ажиллаж байна. Бид нар нэгэнт л “Соко интернэйшнл” компанид өгсөн тэр хэлэлцээрийнхээ тэр заалтыг өнөөдөр ч гэсэн хөрөнгө оруулагчид нь өөрчлөгдсөн тохиолдолд тэрийгээ биелүүлэх ёстой. Энэ дээрээ бас ингээд иргэний эр зориг гаргаад Засгийн газар

түүнчлэн ялангуяа Ж.Энхбаяр сайд энэ асуудлыг оруулж ирж байгаад би бас дэмжиж байгаа. Энэ бол зөв зүйл. Бид нар бол энэ нефтийн бүтээгдэхүүний тэр олборлолтыг нэмэгдвэл энэний дараагаар бол шууд нэмэгдэнэ. Энэ нэмэгдүүлсний үр дүнд бид нар дотооддоо шатахуунтай болох, аливаа нэгэн гаднын хараат бус байх энэ нөхцөл байдал маань илүү сайжирна гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ төслийг бид нар бүгдээрээ дэмжих ёстой л гэж ийм байр суурьтай байна. Тэгэхдээ бид нар бас шаардах ёстой юмаа шаардаад хариуцлагатай байх илүү энэ өөрчлөлтийг хийсний дараа олборлолтоо нэмэгдүүлэх, улсын төсөвт орох ёстой орлогоо нэмэгдүүлэх энэ ажлуудыг илүү сайн хийх ёстой.

Дээрээс нь дур дураараа дарамталдаг энэ бүх зүйлүүдийг бас хязгаарлах, шат шатандаа аймаг, сумдаа дарамталдаг, тэр хөрөнгө оруулагч нарыг бас хүнд нөхцөл байдалд оруулдаг ийм зүйлийг бас хязгаарлах ёстой шүү гэдгийг хэлье. Баярлалаа. Үг хэллээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Үнэхээр 1991 онд Газрын тосны тухай хуулиа Монгол Улс батлаад 35 жилийн өмнө шүү дээ. Ингээд 93, 95, 97 онуудад бүтээгдэхүүн хуваах гэрээ хийж хөрөнгө оруулалтыг урьсан. Нийт 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт орж газрын тосны эрэл хайгуул хийгдэж Монгол Улсын зүүн бүсэд Дорнод, Сүхбаатарын нутагт газрын тосны томоохон нөөц байгааг илрүүлж чадсан. Ингээд олборлолтод шилжсэн. Олборлолтын явцад хууль, эрх зүйн орчныг өөрчлөгдсөн. Ингээд маргаан үүссэн. Маргаантай холбоотой олборлолт буурсан, хөрөнгө оруулалт багассан.

Ингээд Монгол Улс газрын тосноос яг шатах, тослох материалаас ямар хамааралтай байгаа нь гадаад орчинд гарч байгаа энэ аюулгүй байдлын өөрчлөлтүүд их тодорхой болгож өгч байна. Иймд бид дотоодынхоо газрын тосны салбараа дэмжих ийм бодлогын хүрээнд энэ хууль, эрх зүйн орчныг өөрчлөлтийг оруулж ирлээ.

Бидний хөрш Казахстан улс мөн адилхан яг 1993 онд бүтээгдэхүүн авах гэрээ хийгээд гаднын хөрөнгө оруулалтыг үүрээд ажилласан. Одоо Казахстан улс гэхэд жилд 8 сая тонн газрын тос экспортолдог. Дотоод шатахуунаа өөрсдөө асуудлаа шийддэг түвшинд хүрчихсэн байгаа. Боловсруулалтын шинэ түвшинд хүрчихсэн гэсэн үг.

Тэгэхээр бид бас жоохон бодлогын алдаа, хугацаанд нэлээн хугацааны хувьд ч гэсэн нэлээн алд алдагдалд орчихлоо. Тэгээд энийгээ яаралтай засаж залруулах нь бол чухал байна. Дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батын Батбаатар гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт батлуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудалд орёе.

14.06 цаг.

**Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Мөнхсоёл таныг урьж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

**Б.Мөнхсоёл:** Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Жаргалан, Г.Очирбат нараас 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийн нэгтгэсэн төсөл буюу Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй 1 санал, 42 дугаар зүйлийн 42.2 2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх саналуудыг дэмжсэн болно.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган хууль зүйн техникийн засвар, өөрчлөлтийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөх өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Түрүүний Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Ерөнхий сайдын зөвлөх, Сүхээгийн Тэнгис Ерөнхий сайдын зөвлөх, Ганбаатарын Жавхлантөгс Шадар сайдын зөвлөх, Билэгтийн Зандан Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Жамбалдоржийн Мягмарсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх гэсэн ажлын хэсгийг танилцууллаа.

Ажлын хэсгийнхэн та бүхэнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа бол Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулахыг Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох хуульд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн алга байна. Ганбатын Хосбаяр гишүүн.

**Г.Хосбаяр:** Энэ хуулийн төсөл бол маш чухал ийм хуулийн төсөл. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуульд Монгол улсын иргэн бол шударгаар бизнес хийх, өмч хөрөнгөтэй болох ийм эрхтэй заалтууд байдаг. Ер нь бид нар сүүлийн үед бас гадаадын хөрөнгө оруулагч, эсвэл том хөрөнгө оруулалтыг л хамгаалах эдгээрийг бас дэмжих энэ талын л зохицуулалт, энэ талын л дэмжлэгүүдийг ярьж байгаа. Тэгэхээр ер нь энэ дотоодын бизнес эрхлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгчид энэ яг Монгол хүн бизнес эрхлэх, бизнесийн эрх чөлөөтэй байх энэ тал дээр ер нь урт хугацаандаа ямар бодлогын дэмжлэгүүдийг илүү их авч хэрэгжүүлэх ёстой гэсэн ийм судалга байна уу Эдийн засаг, хөгжлийн яаманд?

Жишээлбэл ингээд үл хөдлөхийн бизнес гэдэг бол урт хугацааны бизнес байдаг. Сүүлийн хэдэн жил Монголын монголчууд иргэн ч, тэр аж ахуйн нэгжүүд ч тэр маш их үл хөдлөхтэй болж байна. Орон сууцтай болж байна. Гэтэл энэ болгоноос бас ийм татвар авдаг, үл хөдлөх, тэр ба үл хөдлөхийг чинь барьж босгоход тэртээ тэргүй НӨАТ, ажиллах хүчин гээд бүх зардал, бүх татвараа төлчхөөд байхад дахиад тэр үл хөдлөх хөрөнгийг боссоных нь дараа үйл ажиллагаа явуулахад бас үл хөдлөхийн татвар энэ зүйлүүдийг аваад байгаа. Тийм учраас энэ дээр ер нь ямар байр суурьтай ажиллах вэ гээд.

Мөн энэ бизнесийн нэр хүнд гэж чухал асуудал байгаа. Өнөөдөр сошиал орчинд ч юм уу, ямар нэгэн байдлаар энэ жижиг, дунд бизнесийн нэр хүндийг бол маш их унагасан ийм үйлдлүүд хийдэг. Жишээлбэл, өө тэр хоолны газрын тийм үйлчилгээ тийм муу байна ч гэдэг юм уу. Тэр компани нийгмийн даатгалын өрөө төлөөгүй байна, татварын өртэй ч гэдэг юм уу, өө эднийх ийм муухай ч гэдэг юм уу. Тэгэхээр ер нь цаашдаа энэ бизнесийн нэр хүндийг хамгаалах тал дээр ер нь ямар бодлого бас барьж ажиллах вэ? Ийм зүйлүүдийг бас асууя.

Тэгээд өнөөдөр ер нь монголын бизнесийн орчинд бол бас нэлээн онцгойлон анхаарч авч үзэх асуудал бол энэ төгрөгийн ханшийн уналт л байна л даа. Өнөөдөр Монгол төгрөг 2014 онд одоогоос 12 жилийн өмнө 1 доллартой харьцах ханш 1750 төгрөг байсан бол өнөөдөр 3600 гараад явж байна. Тэгэхээр энэ маань нөгөө бизнесийн орлого, нөгөө бизнес хийгээд олж байгаа ашиг энэ юм маань энэ мөнгөний ханшийн зөрөөнд ингээд хэрчигдээд байхгүй болчихоод байна л даа. Тэгэхтэйгээ зэрэг зарим бизнесүүд бол ер нь бизнес хийж ингэж олон 10 жил зүтгэж байхын оронд бараг валют аваад хадгалчихвал бараг адилхан шахуу юм биш үү гэх юм хүртэл ярих тохиолдол гарч байна шүү дээ. Тэгэхээр энэ ханшийн эрсдэлийг бас ер нь яаж төгрөгийг тогтвортой байлгах, ханшийн эрсдэлээс хамгаалах энэ зүйлүүд дээр анхаарах вэ? Тэгэхээр энэ хууль бол маш чухал хууль. Тийм учраас энэ томоохон бодлогын түвшиндээ ийм асуудлууд дээр яаж анхаарч байгаа талаар бас сайд хэлээд өгвөл сайн байна.

Сөн энэ стандарт, техникийн зохицуулалтын эрх зүйн орчныг бас яаралтай боловсронгуй болгох шаардлага байгаа. Тэгэхгүй бол төр ингээд хувийн бизнес дээр очоод давхардсан олон стандарт, шаардлагуудыг тавиад байдаг. Тэдгээр нь зарим нь олон улсын стандарт шаардлагаас зөрсөн, эсвэл Монгол Улсын хууль, дүрэм журмаас давсан зүйлүүд хүртэл байдаг. Тэгэхээр энэ стандарт, техникийн зохицуулалтын эрх зүйн орчноо бас илүү тодорхой болгож өгөх ийм шаардлагууд байгаа гэж ингэж харж байна. Ингээд асуултдаа хариулт авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэргүүн Шадар сайд Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ хууль бол Монгол Улс энэ бизнесийн орчныг либералчлах хүрээнд их том алхаж байгаа. Өнгөрсөн 35 жилийнхээ хугацаагаа эргэн хараад дүгнэж байна. Ингээд бид зайлшгүй бизнесийн эрх чөлөөг хангах суурь зарчмыг тодорхойлж баталгаажуулах нь чухал байна гэж үзсэн. Энийгээ Бизнес эрх чөлөөний тухай хуулиар оруулж ирж байгаа. Энэ дотор бол төрөөс бизнесийн эрх чөлөөг хангах зарчим бол баталгаажиж бодлогын суурь болно. Хуулиар хориглосноос бусад бизнес үйл ажиллагаануудыг чөлөөтэй эрхлэх болно. Бизнесийн эрхлэгчдийг өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр салбараас нь зэрэг ялгаварлан гадуурхахгүй, шударга өрсөлдөөнийг дэмжих, ил тод байдлыг

хангах, ялангуяа төрийн бодлогыг тодорхой болгож байгаа. Эдийн засаг төрийн оролцоог эрс багасгаж, бизнес эрхлэлт бизнесийн орчин дахь дарамтыг бууруулна. Төрийн үйлчилгээ цахим, ил тод бизнес эрхлэгчдээс мэдээллийг 1 удаа аваад төр өөрт байгаа мэдээллийг шаардахгүйгээр бизнес эхлэх, хөгжүүлэх бололцоог нь дэмжинэ. Эрсдэлийн үнэлгээнд суурилсан давхардалгүй хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бодлогууд орж ирнэ.

Энэ Бизнесийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөрчлийн хууль, Зөвшөөрлийн хууль дагаж гарсны дараа Стандарт, техникийн зохицуулалт энэ Төр, олон нийтийн хяналтын 2 хууль дагаж орж ирж байгаа. Энэ бол амжсангүй. Намар хэлэлцэнэ. Ингээд манай Монгол Улсын бизнес орчныг цогц болж хувирна.

Төр бол бизнес эрхлэгчдэд хувийн хэвшлийг хийх бололцоотой салбарт өрсөлдөхгүй гэдгийг бол баталгаажуулж байгаа. Бизнес эрхлэгчдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг төрийн бүх хууль дээр баримтална гэж байгаа юм. Эрх зүйн орчинд дордуулахгүй гэж байгаа юм. Төрийн үйл ажиллагаанд хориглох асуудлыг шууд оруулж өгч байгаа. Бизнесийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж батлан гаргахыг Монгол Улс хориглож байна. Энэ бол маш том мессеж өгч байгаа. Өмч хөрөнгийг хууль бусаар хураан авах, дайчлахыг бүрэн хорьж байгаа. Бизнесийн нэр хүнд, өмчийн халдашгүй дархан байдал, тэр худал мэдээлэл гаргасан, түгээх асуудалтай холбоотой төр, төрөөс гардаг асуудлуудыг хатуу хориглож байгаа.

Төрөөс зүй бусаар бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх, оролцох, хуульд заагаагүй төрийн нэр барьсан хяналт шалгалтыг, дүрэм журам, акт гарган хэрэгжүүлэхийг бүрэн хориглож байгаа буюу бизнесийн эрх ашгийг хамгаална л гэсэн үг.

Энэ хүрээндээ дараагийн юу нь бол хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ёстой. Хөрөнгө оруулалтын орчин дээрээ бид иж бүрэн дүгнэлтүүд хийгдсэн. Бизнес эрх чөлөө, бизнесийн эрх чөлөөний индексээр жоохон сул байна. Энийгээ сайжруулж хөрөнгө оруулалт орчны таатай болох тэр хүрээнд бодлогын нэлээн том, ялангуяа хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж байгаа.

Хөрөнгийн зах зээлд шинэ хөрөнгө оруулалт татах таатай орчныг бүрдүүлж байгаа. Ялангуяа банкны салбарт.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ялангуяа хөрөнгийн зах зээл гадаадаас эх үүсвэр татаж, санхүүгийн салбарт нэлээн либералчлах ийм бодлого явуулж байна, гаргаж энэ хуулиар хуульчилж өгч байгаа. Ингээд зөвшөөрлийн энэ тогтворжуулах хугацаа сунгах, энэ гэрчилгээний шалгууруудыг хялбаршуулж, хугацааг нь эрс нэмэгдүүлж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалт дээр 40 гаруй хуулиар хязгаарлалт хийгдсэн байна. Салбаруудыг дийлэнх хэсгийг нь чөлөөлж өгч байгаа. Тэгээд энэ хөрөнгө оруулалтын баталгааг суурилж би дандаа олон улсын жишгийн дагуу ингэж боловсруулж оруулж ирж байгаа. Нийтдээ дагасан 20 гаруй хууль дээр энэ хөрөнгө оруулалтын орчин дээр өөрчлөлт гарна.

Дараа нь их том зүйл бол энэ зөвшөөрөл. Зөвшөөрөл гэж нэртэй маш олон хязгаарлалт, төрөөс эдийн засагт оролцох оролцоо байсныг нэлээн тодорхой болгож, хуульчилж, салбарын хуулиуд дээр зөвшөөрлүүдийг нь, тусгай зөвшөөрлүүдийг нь хуульчлан гаргаж өгч байгаа. Үүнээс цааш.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хосбаяр. Гүйцээж хариулъя Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Үүнээс цааш яамнууд өөрөө эрх зүйн акт гаргаж, зөвшөөрөл олгож, аливаа бизнес, үйл ажиллагаанд хязгаарлах ийм боломжгүй болж байгаа зөвхөн хуулиар. Салбарын хууль дээр зөвшөөрлүүдийг нь тодорхой болгож өгч байгаа. Хэрвээ зөвшөөрөл олгох бол Улсын Их Хурал дээр асуудал орно гэсэн үг. Үнэхээр энэ манай Пүрэвдорж даргын яриад байдаг 331 гэрээ, 264 бүртгэл, 232 дүгнэлт, 161 тодорхойлолт, 132 гэрчилгээ, 30 батламж, магадлан итгэмжлэл 30, лиценз 14, сертификат 9 гээд зөвшөөрөл гэж нэрлээгүй боловч бизнес үйл ажиллагаанд шаардагддаг төрийн байгууллагаас олгож байсан олон бичиг баримтуудыг тодорхой болгож, нэг мөр болгож цахим болгож байгаа.

Төгсгөлд нь хэлэхэд бол e-Business гээд шинэ платформ бий болсон. Энэ дээр бол бүх бизнесийн энэ зөвшөөрөл, бизнес эхлэх, үргэлжлүүлэх, хөгжүүлэх, хугацаа сунгах маш олон асуудлууд ил тод болсон. Энийг нийтээрээ идэвхтэй ашиглахыг хүсэж байна. Ингээд Монгол улсын бизнесийн орчинд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хосбаяр гишүүн тодруулъя.

**Г.Хосбаяр:** Эдийн засаг, хөгжлийн яамнаас бас асуухад энэ Эдийн засаг, хөгжлийн яамны гол ажил бол бас энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг өөрчилсөн. Энэ дээр амжилттай ажиллах байгаа. Тэгээд саяхан жишээлбэл Говь-Алтай аймагт 300мвт-ын цахилгаан станц хувийн хэвшил эхэлж байна лээ 2 их наядын өртөгтэй. Мөн саяхан бас Чойроос Замын-Үүд чиглэлийн технологийн зам бас хувийн хэвшил Хятадын хөрөнгө оруулалттай компани эхэлж байна. Тэгээд энэ болгон чинь бас энэ яг танай оруулж ирсэн 27 оны хөгжлийн төлөвлөгөө, энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн юман дээр харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэхээр ингээд хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийгээд ажил хийж байгааг бол би 2 гараа өргөөд дэмжиж байгаа хүн. Гэхдээ ер нь энэ улсын танай яамны нэгдсэн бодлогод чинь энэ 2 төсөл жишээлбэл байгаа юу? Энэ 2 төсөл хаагуур яваад ингээд хэрэгжээд эхэлчхэв? Энэ дээр бас энэ Доржханд сайд, мөн Энхбаяр сайд бас.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** 100 гаруй хуулиар бид нар хуульчлаад төсвийн зардлыг тогтоочихсон. Үндсэндээ төсөв маань урсгал зардал нь 2007 оноос бараг 90 хувь руу дөхөх байх. Тэгэхээр засгаас ямар бодлого оруулж ирсэн бэ гэвэл Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг өргөн барьж өөрчлөлт оруулсан. Энэ хуулийн хүрээнд бид эрчим хүч, дэд бүтэц болон бусад стратегийн гэж үзэх салбарууд дахь хөрөнгө оруулалтыг нээлттэй болгож, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар төр, хувийн түншлэлээр хэрэгжүүлэхийг бүрэн дэмжиж байгаа.

Нэгдүгээрт эрчим хүчний салбарыг бол бүрэн либералчлах ,хөрөнгө оруулалтыг татна.

Хоёрдугаарт дэд бүтцийн зам, боомтын холболтууд, стратегийн тээврийн гол гол чиглэлүүдийг бол энд хөрөнгө оруулалтыг урьж байгаа. Мөн бусад чиглэлийн бүтээн байгуулалтууд, зэс, ган, боловсруулах үйлдвэрийн салбаруудад бид нар төр хөрөнгө оруулалт хийхгүйгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төр бодлогын хувьд түншлэлийн хэмжээнд оролцох хэмжээнд энэ бодлогуудыг нэлээн урагшлуулна.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд сайд нэмж хариулъя.

**Т.Доржханд:** Түрүүн Хосбаяр гишүүн маш чухал асуулт асуусан. Тэр нөгөө ханш байхгүй юу. Ер нь явж явж эдийн засгийн аливаа асуудал бол ханш дээрээ л тогтдог, нөөц дээрээ тогтдог . Бизнес явлаа гэхэд нөөц. Тэгээд эдийн засаг уналаа гэхэд нөөц л байдаг, ханш л байдаг араас нь. Тийм болохлоор яг энийг яаж шийдэх гээд байгаа юм бэ гэдэг асуудал нь маш чухал. Тэгэхлээр нөөцийг үүсгэдэг 3 л зүйл байгаа.

Нэгдүгээрт нь болохлоор экспортоо өсгөнө, валют оруулж ирнэ.

Хоёрдугаарт нь гаднын хөрөнгө оруулалтыг татна, валют оруулж ирнэ.

Гуравдугаарт нь бол гаднаас эх үүсвэр татна, зээлнэ гэсэн үг. Бонд энэ тэр.

Тэгэхлээр энэ чиглэл дээр бол яг манай гадаадын хөрөнгө оруулалтын хууль дээр татварын болоод тэгээд дэмжсэн зохицуулалтууд бол маш их орж ирж байгаа гэдгийг хэлчихмээр байна цаг бага байгаа болохлоор.

Хоёрдугаарт түрүүний бас асууж байгаа энэ нөгөө хувь компаниуд түүгээрээ эрчим хүч өөрсдөө хэрэглээд тэгээд түүнийгээ өөрсдөө худалдаж авна гэвэл энийг тархмал эх үүсвэр гээд байгаа юм. Энэ дээр.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Т.Доржханд:** Тийм. Тэгэхээр одоо ингээд бид нар уламжлалт сэтгэхүйгээсээ жаахан салах хэрэгтэй. Төр ингээд эрчим хүчийг өөрсдөө үйлдвэрлэдэг, өөрсдөө зардаг, үнийг нь барьдаг, тэгээд хяналтаа тогтоодог гэж. Одоо төр бол зөвхөн дамжуулах үндсэн бүтэц дээрээ бол хяналтаа тавина. Үйлдвэрлэх асуудлыг бол 100 хувь хувийн секторт өгч байгаа юм. Хувийн секторт өгсөн тохиолдолд 2 зүйл байгаа. Нэг нь болохлоор таны үйлдвэрлэсэн цахилгааныг төр худалдаж авна гээд. Тэр нь Пи Пи Эй гээд байгаа. Энэ механизмаар бол сая ингээд нээлттэй маш анх удаагаа сайн ийм ил тод ямар нэгэн тийм ашиг сонирхол байхгүйгээр auction зарлагдаад хэвлэгдэнэ шүү дээ.

Нөгөөдөх нь болохлоороо төр ерөөсөө оролцохгүй. Та ямар хэмжээний эх үүсвэр, эрчим хүч хэрэгтэй байгаа түүнийгээ та тэгвэл түүгээрээ эрчим хүчний компаниас юм уу, эсвэл өөрсдөө нар, салхи, батарей хураагуураа үйлдвэрлээд тэгээд түүгээрээ л тэрийгээ хангана. гэж. Энэ бол ингээд тархмал эх үүсвэр буюу төр оролцохгүй хувийн сектор өөрсдийн хоорондох ийм зах зээл.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хосбаяр гишүүн тодруулъя.

**Г.Хосбаяр:** Тийм. Доржханд сайд ойлгож байгаа. Мэдээж би хэллээ шүү дээ хувийн хэвшил ингээд зам барих цахилгаан станц барихыг бол ингээд 2 гараа өргөөд дэмжиж байна. Энэ 2 төсөл дээр хоёулан дээр нь Засгийн газар, төсвөөс мөнгө гарахгүй юм байна лээ. Гэхдээ ингээд хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийж байгаа нь гээд ингээд хөгжлийн төлөвлөгөөнд тусгадаггүй ингээд дур дураараа юм эхлээд байж болдог юм уу? Тэр Говь-Алтайн 300мвт-ын чинь станц чинь маш том эх үүсвэр бий болж байгаа. Энэ чинь тэр хөгжлийн төлөвлөгөө дээр байхгүй байгаа үг үсгээрээ. Мөн Чойроос Замын-Үүд чиглэлийн зам чинь бас байхгүй байгаа. Мэдээж тэгэхээр энэ болгоныгоо тэр хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаад яг бас хувийн хэвшилтэйгээ уялдаж ийм юм юм хийх юм гээд ингээд явж болдоггүй юм уу? Нэг өглөө л нэг мэдээгээр л гэнэт ийм юм хийж байгаа гээд гараад ирэх юм. Мэдээж энэ баруун бүсэд хэрэгтэй станцыг ойлгож байна. Технологийн зам, даацын замыг ойлгож байна. Тэгэхдээ төлөвлөгөөнд ордоггүй юм уу л гэж асуугаад байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүн, Доржханд сайд хариулъя.

**Т.Доржханд:** Тэгэхлээр Монгол Улс ингээд төлөвлөлтөө хийхдээ төрийн санхүүжилтээр алийг нь хийх юм, төсвөөр алийг нь хийх юм, гаднын эх үүсвэрээр алийг нь хийх юм, төр, хувийн хэвшил хамтарч ямар төслүүдийг хийх юм бэ гэдэг энийгээ ингээд базаад тэгээд ингээд таван жилийн үндсэн чиглэл болгоод ингээд явдаг. Тэгэхлээр энэ дээр бол ингээд төлөвлөлтүүд ордог.

Үүний хажуугаар тухайлбал та ингээд төсөөл дөө гэртээ нарны панел авчихъя, өөрийнхөө цахилгааныг өрхийнхөө түвшинд хийчихье аль эсвэл компанийнхаа түвшинд хийчихье, уурхай байлаа гэхэд 100 байна уу, 200, 300мвт-ын хэрэглээ бол өөрийнхөө түвшинд хийчихье гээд явж байгаа хувийн секторын тэрийг бол бид нар төлөвлөлтдөө бол ингээд тусгаад явж бүрэн боломжтой.

Гэхдээ тэрийгээ ингээд манай төлөвлөлтөд байхгүй шүү, тийм болохлоор та нар энэ үйл ажиллагаа явуулахгүй шүү гэж хориглох зүйлийг бол бид нар бол оруулж өгөхгүй гэж байгаа. Тэгээд эрчим хүчний салбар бол нөгөө чөлөөт өрсөлдөөнийхөө салбар руу орох ёстой. Орохын тулд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Батбаатар гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн алга байна. Цэндийн Баатар гишүүн алга байна, Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үгээ хэлье.

**О.Номинчимэг:** Хаврын чуулган хаахад 2-хон өдрийн хугацаа байна. Өнөөдөр, маргааш хийгээд энэ 2026 оны 07 сард энэ Улсын Их Хурал үйл ажиллагаа хийгээд тал, мандатынхаа тал хугацаанд ингээд ажилласан гэдэг үр дүнтэй гарах гэж байна. Сүүлийн үед бол энэ нэн яаралтайгаар олон хууль 5 сарын сүүлээс болон 6 сарын эхэнд орж ирээд парламентаар хэлэлцүүлэгдэж байна нэн яаралтай горимоор. Тэгээд энэний нэг бол энэ хууль байгаа. Энэ хуулийг дагаад 100 гаруй хууль орж ирсэн байгаа. Энэний өмнө бид нарын бас хэлэлцсэн Нийгмийн даатгалын тухай хууль ч гэсэн дагаад олон хууль орж ирсэн. Зөндөө алдаа мадагтай зүйл болж байна.

Жишээ нь Нийгмийн даатгалын тухай хууль дагаж орж ирсэн шүүгчдийн тэтгэвэрт гарах насны асуудал дээр хайнга хандсанаас болж, өөрсдөөс нь санал аваагүйгээс болж бас Засгийн газар энийгээ татаж байх шиг байна. Та энэ Эдийн засгийн эрх чөлөө, Бизнесийн эрх чөлөөний хуультай холбоотой ч гэсэн олон дагасан хуулиудаас бас ийм зүйл ажиглагдаж байна. Холбогдох байгууллагуудаас нь санал авалгүй яаралтай горимоор гээд өөрсдөө бичээд ороод, тэр нь алдаа мадагтай байгаад эхнээсээ ийм асуудлууд гарч байна.

Тэгээд бид нар хууль тогтоогч нар. Хууль тогтоогч нар энэ улсын бодлогыг гаргахдаа хариуцлагатай байх ёстой, үр дагавар нь яаж гарахыг нь маш сайн харах ёстой. Энэ дэг зарчим сүүлийн үед ер нь мөрдөгдөхгүй байна. Мөрдөгдсөн ч тэр нь дабл стандарттай байна гэж харж байгаа юм. Тэгээд энийг Улсын Их Хурал цаашид ч гэсэн бид нар төрийн бодлого гаргах гэж байгаа бол ийм дабл стандарт байхгүй хаа хаанаа нухацтай байдаг энэ асуудалд анхаарах ёстой гэж харж байгаа юм.

Тэгээд энэ ажлын хэсгийн ахлагчаар ажилласан Энхтүвшин гишүүнээс асууя. Тэгээд Энхтүвшин гишүүн бол өмнө нь орж ирсэн энэ зөвшөөрөлтэй холбоотой хуулиуд дээр бас нэлээн сайн ажиллачихсан. Энэ асуудал нь бол нэлээн цэгцэрчихсэн гэж би ойлгож байгаа. Зүгээр Зөвшөөрлийн хууль дагаж орж ирээгүй олон хуулиуд энэ хуультай дагаж орж ирсэн. Тэр дагаж орж ирсэн хуулиудаас ямар ямар хуулийн асуудлууд нь асуудалтай байгаад ер нь татагдаж эсвэл буцаагдаж байгаа вэ, ямар учир шалтгаан байна гэж та бас ажлын хэсгийн ахлагчийн хувьд дүгнэж байгаа вэ гэдэг асуулт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулъя Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Энэ хууль хэлэлцэх эсэхээ яаралтай шийдсэн болохоос асуудал нь бол эртний хууль л даа. 25 оны жилийн эцсээс боловсрогдоод өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын орчны судалгаанууд хийгдээд, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв байгуулж, бүх салбараар нь, орноор нь уулзаж гомдлуудыг нь хүлээн аваад бүх төрийн бус байгууллага, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарч ажиллацгаагаад, Их Хуралд 1 удаа өргөн барьж буцаагаад улмаар Ардчилсан нам бас хууль санаачлаад, ингээд хамтраад, Их Хуралд ажлын хэсэг гаргаад, нийцүүлэлт хийгээд ер нь нэлээн ус, тос нь нэлээн ялгарчихсан нэлээн шигшигдсэн хууль. Тэгэхээр Номинчимэг гишүүн яг ямар хууль дээр ийм алдаа гарсан гэж та үзэж байна тэрийгээ тодорхой хэлнэ үү?

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг. Энхтүвшин гишүүн хариулъя, тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Энэ хуулийн төслүүд дээр бол ялангуяа энэ олон хуулийн дагасан төслүүдийн ихэнх нь бол Зөвшөөрлийн хууль болон Зөвшөөрлийн хуультай нийцүүлж өөрчилсөн ийм хуулиуд байгаа. Тэгэхээр энэ хуулиудыг намрын чуулганаас завсарласны дараа ажлын хэсэг нэлээн идэвхтэй ажилласан. Ажлын хэсгийн гишүүд болон Улсын Их Хурлын Тамгын газраас бас референтүүд, манай Баярмаа, Отгоо гээд хүмүүс нэлээн идэвхтэй ажилласан. Тэгэхээр зөвшөөрөлтэй холбоотой хуулиуд дээр өөрчлөлтүүдийг оруулсан байгаа. Тэгээд энэ хуулиуд маань засвар хийсэн өөрчлөлтүүд нь засгийн газраа өргөж орсон учраас харьцангуй хялбар болсон.

Тэр олон өөрчлөлтүүд нь болохоор хуулийн нэр томьёо, Эдийн засаг, Бизнесийн эрх чөлөөний тухай хууль гэдэг нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бүх хуулиуд нь хүчин төгөлдөр болох заалтууд нь ингэж өөрчлөгдсөн байгаа. Шинээр нэмж яаралтай горимоор өргөсөн хуулиуд дотроос Арбитрын тухай хуулийг буцаасан байгаа. Энэ нь болохоор яг үзэл баримтлал нь бас яг оролцогч талууддаа бас энэ хуулийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Тэгээд хэд хэдэн хуулийн төслүүдийг бол бас буцаасан байгаа. Өөрөөр хэлбэл 8 үзэмжийн шинжтэй зохицуулахад бас энэ хэрэглэгч зөвшөөрөл авдаг ч юм уу, яг энэ бизнесийн харилцаанд орчхоод этгээдүүдийн эрх ашгууд нь хөндөгдөж болзошгүй ийм зүйл, заалтуудыг буцаасан байгаа. Тухайлбал, Засгийн газар буцааж татсан хуулиуд дотор Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог 4 зөвшөөрөлтэй холбоотой харилцаа холбоо, радио давтамж, шуудан гэх мэтчилнээр өргөн нэвтрүүлэгтэй холбоотой энэ зөвшөөрөлтэй хуулиудыг холбогдсон зүйл, заалтуудыг нь буцаасан байгаа.

Мөн шүүх шинжилгээтэй холбоотой бас энэ хуулийн зүйл, заалтууд нь энэ хуулийн үзэл баримтлалтай бас нийцэхгүй байгаа учраас эдгээр хуулиудыг буцааж, хууль санаачлагчид нь буцаасан байгаа. Тэгээд хуулийн төслүүд дээр бол ажлын хэсэг бол бас заримдаа бараг өглөөний 7 цаг хүртэл сууж ажилласан байгаа. Тэгэхээр тал талдаа ажлын хэсэг болоод яг энэ Тамгын газрынхан бол яг бас алдаа мадаг гаргахгүйн тулд их хичээж ажилласан байгаа бас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Тэгээд энэ нэн яаралтай хэлэлцүүлж байгаа хууль ер нь бол нэн яаралтайгаар Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд холбоотой хуулийг л бид нар нэн яаралтайгаар хэлэлцэх ийм дэгтэй. Энгийн хэлэлцэж байгаа хуулиуд дээр бол энэ эцсийн хэлэлцүүлэг хийгээд эцэслэн батлах хүртэл заавал ажлын 5 хоног байна гээд тайлбарлаад байгаа юм. Тэгээд тэр нь ямар учир шалтгаантай юм гэхээр тэр бүх оролцогч талуудад мэдээлэл өгөх, танилцах боломжийг нь хангана гээд.

Яах вэ тэгээд миний санаачлаад хийж байгаа Тамхины хууль дээр бол бүтэн 10 сар, 11 сар хэлэлцүүлэг хийгээд бүх талууд нь бол танилцаж байгаа юм. Заавал дахиад 5 өдөр байх уу үгүй юү мэдэхгүй. Тэгтэл энэ нэн яаралтайгаар хэлэлцэж байгаа энэ хуулиуд бол тийм боломжийг бол тэр харилцагч stakeholder-ууд буюу тэд нарт бол өгөхгүй байна. Ажлын хэсэг, Тамгын газар дээр бол ажлын хэсэг үнэхээр нухацтай энэ өдөр, шөнөгүй ажиллаж байж л энэ алдаа, дутагдлуудыг гарж, шийдэл гарахаас сэргийлж байгаа. Тэгэхээр цаашид бид нар хууль хэлэлцэх энэ дэг дээр ч гэсэн иймэрхүү нөх нөхцөл байдлуудыг маш сайн анхаарч бас өөрчлөлт хийхгүй бол их сонин л байдалтай байна даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтыг 17 цагаас явуулна. Дараагийнхаа асуудалд орёе.

13.33 цаг.

**Тамхины тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Чинбүрэн гишүүнийг урьж байна.

**Ж.Чинбүрэн:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 71 гишүүн 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан импортын барааны гаалийн татвартай холбоотойгоор Гадаад харилцаанаас ажлын хэсэгт хүргүүлсэн албан бичигт гаалийн татварын 30 хувь болгон нэмэгдүүлэх нь Дэлхийн худалдааны байгууллагад бүртгүүлсэн тарифын дээд амлалтыг зөрчих эрсдэлтэй гэж дурдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэж, уг эрсдэлийг хэрхэн арилгахаар төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара хуулийн төслийг 2026 оны хаврын ээлжит чуулганд багтаан батлах шаардлага үндэслэлийн талаар, хуулийн төсөлд тамхины амт, үнэрийг хориглож байгаагаас болж хууль бус зах зээл үүсэх эрсдэлтэйгээс гадна, цаашид хүүхэд хэрэглэхгүй гэсэн баталгаа, бодит судалгаа хангалтгүй, мөн хяналтын тогтолцоог хэрхэн зохицуулж байгаа талаар тамхины бүтээгдэхүүнээс улсын төсөвт жил бүр их хэмжээний татварын орлого төвлөрдөг тул тамхины хэрэглээ буурснаар татварын орлого буурах эрсдэлийг хэрхэн тооцсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтыг хэрэгжилт нь далд худалдааг нэмэгдүүлэх эрсдэлтэй байх тул уг заалтын хэрэгжилтийг судалж, шаардлагатай тохиолдолд хүчингүй болох боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт

явуулсан бөгөөд Засгийн газраас яаралтай хэлэлцүүлгээр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хууль болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй нийцүүлэн гүйцээн боловсруулсныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу дахин санал хураалгах шаардлагатай 2 санал гаргасан бөгөөд үүнд хамрын тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхинаас бусад бүх төрлийн тамхины бүтээгдэхүүнд амт, үнэр оруулахыг хориглох тухай, мөн 2010 оны 01 дүгээр сарын 01-ээс хойш төрсөн иргэд тамхи, никотин агуулсан бүтээгдэхүүн худалдаалж нийлүүлэхийг бүрэн хориглох тухай зохицуулалтыг төслөөс хасах санал хураалт явуулсныг мөн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Цэцэгсайхан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Жаргалсайханы Төрболд Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Далхсүрэнгийн Долгорсүрэн Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн, Бямбаагийн Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч, Эрдэнийн Чойжилсүрэн Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч. Хадбаатарын Майцэцэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн

бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнсний худалдаа хөгжлийн тусгай зохицуулалтын асуудал хариуцсан шинжээч, Дагвадоржийн Ганзориг Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэнд, инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн Анагаахын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан шинжээч, Сүхбаатарын Болормаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24, 21.25, 21.31-д заасан нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцон холбогдох албан тушаалд үнэн зөв, бүрэн гүйцэт хариулт мэдээллийг өгнө.

Хэрэв худал мэдээлэл, үнэн бус мэдээлэл өгсөн бол Төрийн албаны тухай хуулийн холбогдох бусад заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ гэснийг та бүхэнд хуулийн заалтыг танилцуулъя.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би энэ хуулийг анх хэлэлцэх эсэхийг нь яригдаж байх үед би асуулт асуусан юм. Тэгээд асуулт асуучаад дараа нь үг хэлэх ёстой байсан. Тэгээд тэр хоорондоо би энэ яг ажлын хэсэг дээр байгаа гаалийн бүсгүйчүүдийн өмнө байсан тэр зажилдаг тамхи, vare энэ тэрийг би харж байгаад тэр зажилдгийг нь аваад тэгээд нэг зажилчаад үгээ хэлэх гэсэн чинь үг хэлж болдоггүй, бүүр толгой эргээд, дотор муухайраад. Тэгээд энэ чинь юу юм бэ энэ чинь айхтар ийм юмыг ингээд яагаад ингээд хэрэглүүлээд явж байдаг юм, яагаад импортлуулж байдаг юм гээд. Тэгээд тэрнээс хойш ингээд харж байхад бол энэ хуулийг эсэргүүцсэн хүмүүс гарч ирээд байна л даа. Тэгээд тэр чинь тамхи биш юм уу? Vare чинь тамхи биш юм уу? Тэр юу байдаг юм асаадаг юм би бол тамхи татдаггүй болох дээр мэдэхгүй байна л даа. Тэр янз янзын ийм халаадаг тэр юм чинь тамхи биш юм байна л даа одоо энэ эсэргүүцээд байгаа хүмүүсийнхээр бол. Тэгээд тэрийг нь яагаад ингээд тамхи татдаггүй хүмүүс огт татдаггүй юм, яагаад тамхичид нь тэрийгээ татаад байдаг юм? Тэр чинь тамхи л юм байгаа биз дээ? Тэгээд энийг эсэргүүцээд байгаа хүмүүс дээр би гайхаад байгаа юм.

Энэ Номинчимэг нарын гишүүд бол мэдээж энэ зохицуулалтгүй зүйлийг зохицуулъя гээд оруулаад ирж байгаа. Тэгээд энэ дээр эсэргүүцэж байгаа бол энэ дахиад тэр гишүүд өөрсдөө хууль өргөн бариад энэ асуудлуудыг дахин нарийвчлан зохион байгуулах бүрэн эрх нь бүгдээрээ байж байгаа шүү дээ. Хуулиа өргөн барь л даа. Тэгээд энэ асуудлаа цэгцлээд мэдээж заримыг нь зохицуулаагүй байна, заримыг нь шийдээгүй байна гээд бүгдийг нь яс шийднэ гэж нэг энэ хууль хууль өргөн барьснаар, өөрчлөлт өргөн барьснаар шийдэх боломжгүй шүү дээ. Тийм учраас энэ гишүүд өөрсдөө өргөн бариад тэр асуудлаа болохгүй байгаа зүйлийг нь дахиад засаад явах боломжтой.

Тэгээд ийм аюултай, хортой юмнуудыг тэгээд л залуучууд, хүүхдүүд хэрэглээд яваад байдаг. Энэ бид нар ирээдүйгээ энэ хүүхдүүдээ хамгаалахгүй юм

уу? Тэгээд ингээд бахь байдгаараа байгаад байх юм уу? Тийм учраас энэ хуулийг ямар ч байсан дэмжээд тэр хортой бүтээгдэхүүнийг хүний юу гэсэн үг юм бэ энэ чинь тэр чинь тамхи татаж байхад чинь тэр хоргүй гэж, хор нь багатай, тийм учраас татваргүй байна гэж ямар эрүүл ухаантай хүн нь эсэргүүцдэг вэ? Ийм байж болохгүй. Мэдээж зохицуулаагүй зөндөө олон зүйлүүд бий.

Жишээ нь, Эрдэнэчимэг нарын гишүүд энэ олон нийтийн газар тамхи татахгүй байх хуулийн төслийг өргөн барьсан. Маш сайн хууль болсон. Энд тэнд баар, ресторанд орох дээр зүгээр хамаг хувцас бүгдээрээ л тамхины утаа болоод л гэр орон тэр эхнэр, хүүхэд тэрийг л угааж цэвэрлэдэг ийм л байдаг байсан шүү дээ. Бүгдээрээ хорддог. Энийг цэгцэлсэн. Тэгэхдээ тэн дотор юу байдаг юм 500 метрт, сургуулиас 500 метрт зарна гэсэн энэ зохицуулалт орсон. Тэр нь бол тухайн үедээ зөв байсан.

Гэтэл өнөөдөр сум дээр яаж байна яг тэр дэлгүүр ингээд газраа авчихсан тамхиа зарж байсан. Гэтэл төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэг барьдаг. Тэр нь яг дэлгүүрийнхээ хажууд баригдчихдаг нөгөө хүн тэгээд яах юм 500 метр нөгөө дэлгүүрээ холдуулж барих юм уу? Ийм ийм асуудлууд байгаа. Тэгэхээр ер нь зарим нэгэн гишүүд бол яг энэ 500 метрийн асуудлаар хууль өргөн бариад ингээд явж байгаа. Яг энэнтэй адилхан энэ тамхин дээр тэр цахилгаан гэж яригдаад байгаа тэр цахилгаан тамхин дээр, зажилдаг тамхин дээр тэр асуудлууд байгаа бол тэр Их Хурлын гишүүд өөрсдөө хуулиа өргөн бариад энийгээ шийдвэрлээд засаад явах бүрэн боломж нь байгаа шүү дээ. Тэрийг нь тухайн үедээ бол яг энэ нь үнэхээр зөв байсан байна, энэ нь буруу юм байна гэдгийг нь тухайн үеийн санал хураалтаар шийдээд явна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд алга байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Энэ хуулийг тойроод нийгмийн хэлэлцүүлэг Улсын Их Хурал дээр гишүүд нь хоорондоо толхилцох элдэв юм болж байна. Үгүй тэгээд нэг зүйлийг би гайхаад байна. Одоо ингээд үр хүүхдүүдээ тамхинаас хамгаалъя гэж ингэж хууль баталж болохоо больчихсон юм уу? Яахлаараа энэ хууль санаачлагч Номинчимэг гишүүн рүү дагалдаад зөндөө олон гишүүд байгаа шүү дээ. Ямар их мөнгөтэй, ямар их зохион байгуулалттай яасан их дайрцгаадаг юм? Сүүлдээ бүүр хар аа мэдэгдэл гаргачихсан. Энэ Жэй Ти Ай Казакстан компанийн захирал Алексей Сергеевич гэж нөхөр, тэр Ки Ти Жи Корпорэйшн Ким Юн Хон энэ тэр гээд бүүр улайм цайм гарын үсэг зураад Монгол Улсын Ерөнхийлөгч өө Монгол Улсын Их Хурлын дарга аа, тамхины зах зээлийг хууль бус наймаанд бүү алдаарай. Үгүй. даварч байгаа юм биш үү. Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага Улсын Их Хурал өөрсдөө оногдсон эрхийнхээ хүрээнд хойч үеэ тамхинаас хамгаалъя, тамхинаас авдаг татвараа нэмэгдүүлье, тамхидалтыг багасгая, жил болгон уушгины хорт хавдраар үхдэг энэ олон 100 үхлийг багасгая гээд ингээд л хууль санаачлаад хэлэлцээд явахаар анхаарлын тэмдэг тавьж байгаад гадаадынхан гарын үсгээ зураад Ерөнхийлөгч, Их Хурал руу нь ингэж бичиг өгдөг энэ дэндэж байгаа юм биш үү. Би бол энэ зохих байгууллагууд нь харж байгаа байх гэж бодож байна. Энэ дагаж байгаа Монголын энэ тамхины худалдаа үйлдвэрлэгч компаниуд ч гэсэн бизнес хийж болно. Энэ эрх зүйн орчинд нийцүүлээд ажилла л даа. Хууль тогтоомжийг дагаж мөрдөөд тэр татвар хураамжаа төлөөд яв л даа. Сэтгэл чинь өвддөггүй юм уу? Энэ тамхинд орж байгаа залуучууд, угж шиг хөхөөд явж байгаа

хүүхдүүд эд нарыг хараад сэтгэл санаа чинь өвддөггүй юм уу? Уушгины хавдраар жил бүр ингэж нас барж байгаа хүмүүсийг хараад санаа чинь зовдоггүй юм уу? Хэрэглээг нь устгах алга болгох тухай хэн ч яриагүй. Монгол төр учраас зохицуулалттай болъёоо, зохицуулалтаа сайжруулъя, авах ёстой татвараа авъя, энийгээ зохих юмандаа зарцуулъя гээд ингээд л хууль санаачлаад явж байгаа шүү дээ.

Тэгэнгүүт ингээд л хоёр тал болоод л нэг тал нь ийм утаат тамхийг дэмжлээ барилаа, нөгөө тал нь электрон тамхийг дэмжлээ барилаа гэж байснаа яг шаардлага болоод гараад ирсэн чинь бүгдээрээ гарын үсэг зураад үг дуу нэгтээ мэт гараад ирж байгаа байхгүй байхгүй. Ямар их мөнгөтэй, ямар их Пи Ар-тай юм бэ? Үгүй энийгээ зөв юманд зарцуул л даа. Энэ Номинчимэг гээд хүн рүү дайраад яах юм, тэгээд энэ санаачилсан хүмүүс рүү дайраад яах юм тэгж хэлмээр байна энд даварчихсан нөхдүүдэд.

Харин би энэ ажлын хэсгийн ахлагч болон Номинчимэг гишүүдээс яг адилхан 1 асуултыг асуух гэсэн юм. Одоо ингээд бид нар эцсийн хэлэлцүүлгийг хийж байна. Энэ чуулганы хугацаанд батлах талаар энэ Улсын Их Хурлын Тамгын газар ямар байр суурьтай, Улсын Их Хурлын дарга маань ямар байр суурьтай байгаа юм бол оо? Одоо ингээд хойшлохын тоолонгоор гүтгэлэг, дайралт, элдэв нөлөөлөл Улсын Их Хурлын гишүүд болон бусад газруудад нөлөөлөх нөлөөлөл энэ бол гарах байх л даа. Бид бол нэг зүйлийг хэлэхэд энэ хэрвээ энэ удаагийн чуулганаар амжихгүй бол энэ хууль дээр ямар байдлаар эргэлзэлгүй, хойч ирээдүйнхээ өмнө худалдагдалгүй энэ хуулийг бол бид нар батлаад явах ёстой шүү. Энийг бол харин Улсын Их Хурлын гишүүддээ хэлчихье. Тэгээд 2 гишүүнээс асуултдаа хариулт авъя.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Алтангэрэл гишүүнд хариулъя. Тэгэхлээр мэдээж тамхи бол сонголт мэт харагдаж байгаа боловч энэ бол үр дагавар нь зөвхөн татсан хүндээ хортой биш гэр бүл, үр хүүхэд, нийгэмд өөрөө ямар их хор нөлөөтэй. Дээрээс нь энэ бол та бүхэн хэлж байна олон өвчний шалтгаан болж байгаа. Энэ талаар бид зөндөө олон ярьсан учраас энийг давтаж яриад яах вэ.

Гол нь Монгол хүний, Монгол хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал учраас бид энэ хуулийг хурдан батлах нь өөрөө их чухал байна. Хяналтад ороогүй байгаа зүйлүүдийг хянадаг бол хуультай болох нь чухал. Тийм учраас мэдээж энэ хууль бол бүгдийг зохицуулж чадахгүй ч гэсэн түрүүн Пүрэвдорж дарга бас хэллээ ямар ч байсан гэсэн үр хүүхдүүдээс өсвөр үеийнхнээ бид энэ амт, үнэрт хууртагдаж энэ тамхийг татуулдаг байх, никотины хамааралтай болох асуудлаасаа бол сэргийлж чадах нь чухал байгаа. Түрүүн хэллээ л дээ түрүүн тэр бохь зажлаад дотор нь толгой эргээд, ам, хэл бадайрсан гэж байна. Энэ никотины хэмжээ хэтэрсний шинж. Ерөөсөө эмч хүний хувьд хэлэхэд бол. Никотины хэмжээ хэтрэхэд ерөөсөө хүнд илэрдэг шинж тэмдэг бол ерөөсөө л дотор муухай оргино, бөөлжис хөрнө, тэгээд л зүрхний цохилт түргэснэ гэх мэтчилэн.

Хуулийг бол миний бие ажлын хэсгийг 05 сарын 08-наас ахалж эхлээд бид чадлаараа л ямар ч байсан бүх л хурлуудыг алгасахгүй, долоо хоног алгасахгүй л энэ хаврын чуулгандаа батлахаар зорьж ажиллалаа. Ингээд эцсийн

хэлэлцүүлгийг ямар ч байсан өнөөдөр хийх ийм боломж гарсанд бас их бахархалтай, баяртай байгаа. Зүгээр батлагдчих хэмжээнд бол одоогоор бол боломжгүй байна гэдгийг бол нэлээд олон удаа бас хэлсэн. Эцсийн хууль баталсан эцсийн алхыг зохих нь хууль зөрчөөд байна гэдэг ийм зүйлийг хэлсэн.

Яах вэ тэгэхдээ бид бас том юманд баярлах хэрэгтэй. Юу гэхлээр бид энэ экспорт, импорт, саяхан онцгой албан татварын асуудлыг ярьж чадлаа шүү дээ. Ингээд онцгой албан татварыг баталснаараа бид 7 сарын 22-ноос хэрэгжих утаат тамхи, ялангуяа утаат тамхинд болон халаадаг тамхи дээр татваргүй болох байсан энэ нөхцөл байдлаас Улсын Их Хурлын гишүүд мөн гаргаж өгч чадсан явдал бол бас их чухал алхам болж байгаа.

Бид нарын одоо энд оруулж байгаа төсөл бол 27 оны 01 сарын 01-нээс хэрэгжих учраас намар батлаад бид цааш нь хэрэгжүүлээд явах энэ боломжууд бас байгаа. Тийм учраас бас бүх зүйлийг алдчихлаа гэж битгий бодоорой. Харин бид бас нэлээн тийм чамбай ажиллахыг зорилоо. Алдаагүй байхыг хүслээ.

Дээрээс нь бас хамгийн гол бол энэ хуулийн гол үзэл санаа бол өсвөр үеийнхнээ никотинд хамааралтай болохоос сэргийлсэн үнэр, амтыг хорьсон явдал бол энэ хуулийн, ялангуяа хууль санаачлагчийн гол үзэл санааг агуулж чадсанаараа бол их чухал байна гэж харж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг хариулъя.

**О.Номинчимэг:** Энэ намар, хаврын чуулган бүрийн эхэнд энэ хэвлэлийн бага хурал хийгээд энэ Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлах ёстой гэж шаардаж ирсэн. Гэвч ер нь энэ хуулийг өргөн барьснаас хойш маш олон төрлийн гацаа, саад бол учирсан. Тэгээд энэ хаврын чуулганы хугацаанд бол энэ ажлын хэсгийн ахлагчийг нь шинэчлэн батлах, томилох гэж бас нэлээн хугацаа алдсан. Тэгээд хэлэлцэх асуудлын дараалалд орсон боловч бас янз бүрийн нөхцөл байдлаас үүдээд хойшилсон нөхцөл байдал үүссэн. Тэгээд одоо болохоор 2 дахь өдрийн би чуулган дээр Улсын Их Хурлын даргаас болон Улсын Их Хурлын Тамгын газраас яг энэ асуудлыг асуусан. Тэгээд хэлэлцүүлэг хооронд хуулиар тогтоосон заавал 5 хоногийн хугацаа байх ёстой хаврын чуулган маргааш буюу 07 сарын 03-нд хаагдаж байгаа учраас боломжгүй гэдэг ийм хариултыг өгөөд намрын чуулганаар эцэслэн батлах санал хураалтыг нь явуулна гэсэн байр суурь илэрхийлсэн байгаа. Гэхдээ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Гүйцээж хариулъя.

**О.Номинчимэг:** Энэ асуудал дээр би заавал албан бичгээр бас албан ёсны, хариулт бичигтэй сачигтай, гарын үсэгтэй, дараа нь баримт болох юм гаргаж өгөөч гээд бас бичгээр хандчихсан байгаа. Ер нь парламент хийе гэсэн хуулиа ямар ч байсан хэлэлцээд баталж чаддаг. Харин Монгол хүний эрүүл саруул, урт удаан амьдрах, үр хүүхдүүдийнхээ ирээдүйн төлөө боловсруулсан энэ хуульд тийм хувь заяа, төөрөг оноосонгүй. Маш харамсалтай. Гэлээ гээд бид ухрахгүй өнөөдөр эцсийн хэлэлцүүлгээ хийнэ. Эцсийн хэлэлцүүлгийнхээ саналын зарчмын саналуудаа хураана. Тэгээд энэ ажил бол намрын чуулган руу хойшилж байна.

Харамсалтай боловч бид энэнийхээ араас ухарч болохгүй. Цаашаа үргэлжлүүлээд явна гэдэг ийм байр суурьтай байна.

**Б.Пүрэвдорж:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэбат:** Хууль санаачлагчдын бас нэг болж дэмжиж оролцсон. Тэгэхээр энэ Тамхины хууль нэлээн бас би бол арай ч үгүй болов уу гэж бодож байсан бас айхтар лоббитой юм байдаг юм байна. Үндсэндээ манай энэ хууль санаачлагч голлож ажиллаж байгаа. Номинчимэг гишүүн эд нар руу их л зохион байгуулалттай дайрч байгаа харагдах юм. Тэгэхээр Монгол Улс хавдраар дэлхийд нэлээн дээгүүрт ордог. Үүнд нөлөөлөгч хамгийн гол суурь бол энэ тамхины асуудал. Бид нар бүхэл бүтэн өөрсдийнхөө төсөөлшгүй нэгэн үеийг тамхинд бүгдээрээ орох энэ суурийг нь дэвсэж өгөх энэ асуудлыг бол сүүлийн хэдэн жил анзааргагүй ингээд явуулчихсан. Үйлдвэрлэдэг улс нь өөртөө хориглочихсон байж байхад бид нар хүүхдүүдийн уушгийг, хүүхдүүдийн эрүүл мэндийг, дараалаад өнөөдөр усан тамхи татаж байгаа, варе гэдэг тамхийг татаж байгаа, зарим нь аяга хоолноос хүртэл хямдхандуу ийм байгаа нь эхний ээлжид дасгах, донтуулах, дараагийн ээлжид тэр хатуу тамхи руугаа орох ийм юмыг нь бол тавьж өгч байгаа асуудал байгаа. Эцэг эхчүүд ч гэсэн мэдэхгүй байгаа юм байна лээ. Сая би хөдөө хөдөө сумдаар энэ тэр явлаа багш нар бол илүү сайн мэдэж байна. Энэ бол ер нь бол хязгаарлахгүй бол тун аюултай байдалд хүрчихсэн. Бид нарын үеийнхэн бол тамхи татдаг хүмүүс бол тийм ч бас өндөр байгаагүй. Одоо бол энэ хүүхдүүд дараагийн ээлжид тэр тамхиныхаа асуудлыг улам хатууруулаад л дээшээ явна. Янжуур, варе гээд 2 хуваагдаж байсан сүүлтэй нийлээд ингээд энийг санаачилж, зүтгүүлж Монгол хүүхдүүдийн эрүүл мэндийн төлөө, ирээдүй хойч үеийнхээ төлөө ажиллаж байгаа энэ гишүүд рүү янз янзаар л дайрч үзэж байгаа юм байна лээ.

Тийм учраас энэ бизнес хийж болно. Энэ тамхины, хүүхдийн хойч ирээдүй, эрүүл мэндэд өшөө илүү зардал гарна энэний цаана. Тийм учраас энэ тамхины хуулийг уул нь энэ хаврын чуулганаараа би баталчих болов уу, арай ч бас яах вэ зарим нэгэн заалт юман дээрээ ярьж байгаад болчих болов уу гэж бас нэлээн сунжирсаар байгаад ингээд сүүлдээ бүр улс төр болгоод ингээд явж байгаа.

Тийм учраас энэ архи, тамхи, энэ мөрийтэй тоглоом, энэ авлигал гээд энэ 4 дээр Монгол Улс ер нь бол манай хойч, дунд, залуу үе бол ер нь хамгийн эрсдэлтэй байгаа. Тийм учраас энэ хуулийг бол элдэв янзын лобби хийхгүйгээр ингээд батлаад явах нь чухал байна гэдэг зүйлийг бол би бол онцолж хэлмээр байна.

Энэ ажлын хэсгийг ахалж байгаа Чинбүрэн гишүүн ч гэсэн өөрөө хавдрын эмч мэдэж байгаа. Энэ хавдрын суурь шалтгаан сахар гээд л энэ өвчний суурь шалтгаан, бусад төрлийн бүх өвчний суурь шалтгаан ийм зүйл байгаад байдаг. Үйлдвэрлэсэн улсууд нь, анх нэвтрүүлж байсан улсууд нь хориглочихсон гэдэг чинь маш том аюулын дохио байхгүй ер нь бол. Тэгэхдээ бид нар шууд хүчээр хорино гэхээсээ илүүтэйгээр эдийн засгийнх нь аргаар болон зохион байгуулалтынх нь хувьд нь хориглоё гэдэг л ийм зүйл. Энэ бол ирээдүйдээ оруулж байгаа уул нь том хөрөнгө оруулалт.

Тийм учраас энэ хуулийг баталж чадаагүйд бол харамсаж байна. Тэгэхээр энэ хуулийг бол заавал батлах ёстой. Энэ бол магадгүй өнөөдөр энэ 126

парламенттай гишүүдээс хамгийн чухал ирээдүйдээ хийсэн хуулийн нэг болно гэдэгт бол би огтхон ч эргэлзэхгүй байгаа.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Үг хэллээ. Одоо Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууна.

**А.Ганбаатар:** Тамхины хяналтын хууль бол залуучуудын эрүүл мэндэд хор хөнөөлтэй байна гээд эхнээсээ ярьсан. Тэгээд л энэ заал дотор байгаа гишүүд бүгдээрээ л дэмжиж байгаа шүү дээ. Зарим энэ хуурай хууль болчих вий гэж бодож, сэргийлж олон талаас нь харж үзсэн гишүүдийгээ бас буруугаар тайлбарлах, буруугаар гүтгэх ийм явдлууд гараад байна л даа. Энд улс төржсөн юм ерөөсөө байхгүй шүү дээ. Анхны төслүүд орж ирсэн. Тэр нь ажлын хэсэг болон Байнгын хороо, Их Хурлын чуулган дээр байр сууриа илэрхийлээд тэр нь албан бичгээр зарчмын зөрүүтэй саналуудаар ингээд л засагдаад л явж байгаа шүү дээ. Одоо бол бас дүр төрхөө харьцангуй олсон ийм хуулийн төсөл болж байна.

Гэхдээ хамгийн сүүлд ажлын хэсэг дээр гарсан санал, хамгийн сүүлд Байнгын хороон дээр гарсан санал бол тамхины хор хөнөөлийг сурталчлах, хүүхдүүдэд хортой гэж том том нэр барьж явахдаа нөгөө далд эдийн засаг, далд бизнесийг нь сэргээчих ийм эрсдэлтэй ийм саналууд бас гараад байгаа байхгүй юу.

Дээр нь энэ хуулийг шийдэхдээ бүрэн бүтэн харсан уу, судалгаа юмнуудаа бүрэн аваад хэлэлцэх энэ хуулийн төсөлд оруулах зарим нэг асуудлууд үлдчихсэн байгаа байхгүй юу. Яах вэ энэ нь тэгээд нэмэлт, өөрчлөлттэй дараа нь нэмээд явах байлгүй. Хамгийн сүүлд Байнгын хороон дээр манай Мөнхсайхан сайдын гаргасан санал бол хүний эрх зөрчиж байгаа юм. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийг бол шууд зөрчиж байгаа. Иргэнээ нас хүйс, өөрөөр хэлбэл 18 нас хүрсэн иргэн өөрийнхөө сонголтыг хийх эрхийг нь хаасан ийм заалт орж ирээд байгаа. Нэг бол Байнгын хороо дэмжээгүй гуравны хоёроороо унасан. Тэгэхээр өнөөдөр санал хураахдаа энийгээ бас бодоорой. Нэг зүйлийг хийхдээ хуурай хууль болгоод амьдралд огт хэрэгжихгүй ийм хууль болгоод, дээр нь хавсаргаад хүүхдийн нэр бариад гэдэг юм уу, эрүүл мэндийн асуудлыг урдаа хэт дөвийлгөөд цаанаа энэ ардчилсан нийгэмд амьдарч байгаа Үндсэн хуулиа зөрчсөн ийм юмнууд хийж болохгүй. Дэлхий даяар гарч байгаа хөдөлгөөнүүдийг бол мэдэж байна, ойлгож байна, дэмжиж байна.

Гэхдээ энэ чинь Монгол Улсынхаа Үндсэн хуулийг зөрчсөн ийм шийдвэрүүд гаргаж болохгүй байхгүй юу. Үүнийг гишүүд бас анхаараарай гэж хэлье. Одоо тэгээд ямар ч хууль гаргасан бие биеийгээ өөрсдийнх нь үзэл бодлоо илэрхийлсэн байдаг юм уу, байр сууриа илэрхийлсэн байдлаар нь ялгавартай хандаж, сошиал медиад хаяж өгч ингээд нэр төрийг нь гутаалгах ажлуудаа үүнээс цааш зогсоох хэрэгтэй.

Тухайлбал, амьдралд хэрэгжихгүй байгаа судалгаагаар хараад ирчихсэн байхад үүнийг хуулийн төслөөс нь авч хаяхдаа хэрэгжүүлж байгаа гэдгийг бол хэлж байгаа. Дээр нь энэ чинь ерөөсөө Тамхины хяналтын хууль байхгүй юу. Гэтэл хяналт 21 наснаас доош гэдэг юм уу, 18 наснаас доош энэ хүүхдүүд Ай Ди-г нь шалгаад зарахгүй байх байдал нь чухал байтал хүрээ хязгаараар тогтоогоод амьдралд хэрэгжихгүй ийм байдлаар цаашаа яваад байгаа шүү дээ. Яах вэ энийг

бол цаашдаа нэмэлт, өөрчлөлтүүд нь хийгээд явах байх. Энэ хууль батлагдаад явахад бол нүх гарна. Асуудал бол үүснэ. Тэгээд л амьдрал баян учраас харъя. Амьдрал дээр бол энэ засагдаад явна гэж найдаж байна. Анхнаасаа энэ хуулийн төслийг бол дэмжсэн гэдгээ бол хэлж байгаа. Гэхдээ засах юмнууд байсан гэдгийг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. Өчигдөр Улсын Их Хурлын дарга өөрийн сошиал хаяг дээрээ батлагдсан хууль хэрэгжих замдаа замхардаг гэж бичсэн байна лээ. Хууль цаасан дээр биш амьдрал дээр хэрэгждэг байх ёстой гэж бас бичсэн байна лээ. Энэ 100 хувь үнэн. Яагаад энийг хэлээд байна вэ гэхээр яг өнөөдрийн байдлаар хууль батлагдах явцдаа өлгийн дөө өтөлж байна. Анх өргөн барьснаас хойш 1 жил л 6 сарын хугацаанд ажлын хэсэг нь ч хуралддаггүй, Байнгын хороод нь ч хуралддаггүй, хэлэлцэх асуудал ч ордоггүй ингэж явсаар байгаад өнөөдөр эцсийн хэлэлцүүлгийг хийж чадахгүй намрын чуулган руу шидэгдэж байх шиг байна. Ахиад 2 сар энэ хуулийн лобби явна гэсэн үг. Ахиад 2 сарын хугацаанд намрын чуулган эхлэх энэ хуулийг унагаах төлөө, буцаах төлөө лобби явна гэсэн үг. Өнгөрсөн хугацаанд би хэлсэн 2 талд хуваагдчихаад бие биеийнхээ эсрэг харлуулаад, дунд нь Номинчимэг гишүүнийг харлуулаад байж байхдаа бүгд бие биеийнх нь эрх ашиг хөндөгдөж байсан. Одоо бүгдийнх нь нэлээн хөндөгдчихсөн байхгүй юу. Тийм болохоор өмнөх лобби чинь бүр хүчтэй явна. 09 сарын 15 хүртэл намрын чуулган гэхэд л энэ лобби улам хүчтэй явна.

Сүүлийн хэдэн хоногийн хугацаанд тамхи импортлогч компанийн захирлууд, түүний төлөөллийн хүмүүс, зарим Улсын Их Хурлын гишүүд ордон дотор тамхины лобби хийгээд явсан нь үнэн шүү дээ. Бид нар ийм юмнуудаасаа хэзээ татгалзах юм? Монголын парламент тамхичдын халаасны мөнгө нь багтаагүй шүү. Тамхи импортолдог компаниудын халаас нь Монголын парламент өнөөдөр арай ч багтах дээрээ тулаагүй шүү. Энэ улс чинь туурга тусгаар улс. Ард түмэнтэй, түүний төлөөллийн байгууллагатай арай бас ингэж энэ Монгол Улсыг парламентыг доромжилж болохгүй. Нэг Солонгос, нэг Орос гарын үсэг зурчхаад Монгол Улсын Ерөнхийлөгчид ханддаг ийм даварчихсан үйлдэл гэж ер нь юу байдаг юм. Хэрвээ наад хуулийг чинь батлах юм бол Үндсэн хуулийн цэцэд өгнө шүү гээд даналзаад байж байдаг гэж ер нь юу байдаг юм? Хэрвээ энэ хууль батлагдах юм бол хууль бус тамхины худалдаа нэмэгдэнэ гэнэ. Монгол улс чинь хилтэй, гаальтай, цагдаатай, тагнуултай.

Хоёрдугаарт тамхи чинь овор хэмжээтэй. Овор хэмжээтэй учраас хилээр улаан цагаан хайрцгаасаа гүйгээд яваад байж чадахгүй. Хэнийг доромжлоод байгаа юм? Нэг хэдхэн төгрөгтөө Монголын парламентыг худалдаад авчихна гэж бодоод байгаа юм уу? Би энийг бүүр хандаж хэлье. Хүүхэд, залуучуудыг ядаж 1 цагийн өмнө ч гэсэн хорт зуршлаас хол байлгая гэхээр хойш нь шидээд байгаа нь ямар учиртай юм? Хэдэн парламент дамжих гэсэн юм? Хэдэн намрын чуулган дамжих гэсэн юм? Хэдэн хаврын чуулган бай дамжих гэсэн юм өргөн барьснаас хойш? Одоо сүүлдээ бараг тамхи хоргүй шүү дээ гэдэг юм явж байна шүү дээ. Тамхи татах нь эрүүл мэндэд сайн гэнэ үү бараг тийм юм руу орж байна шүү дээ. Хэвлэл мэдээллийн байгууллагын мэдэгдэл гаргаад л Ерөнхийлөгч өө та болохгүй бол хориг тавиарай гэж ч байх шиг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт

халдаг бас хэн бэ тэд нар? Жилд 4000 орчим иргэн тамхинаас үүсэлтэй өвчлөөд нас бараад байна гэж байна. Бурхны оронд одоод байна гэж байна. Тэгээд явж л байг гээд байгаа юм уу? Энэ тоог нэм гээд байгаа юм уу яаа гээд байгаа юм бэ? Бид нар Залуучуудын хөгжлийн хууль гээд баталсан юм байна лээ. Залуучууд, хөгжлийн хуулийг баталснаас хойш өнгөрсөн хугацаанд би 8 тэрбум төгрөг үрсэн байгаа шүү дээ энэ хуулийн хүрээнд.

Гэтэл эсрэгээрээ залуучуудын хөгжлийг жинхэнээр нь дэмжье, залуучуудын хор зуршлаас хол байлгая хүүхэд залуучууд ирээдүйг хамгаалъя. Хортой учраас тамхинаас нь татвар авъя гэхээр татвар нэмж болохгүй шүү дээ гэдэг чинь ямар учиртай юм? Татвар нэмж болохгүй ээ, татвар нэмж яах гээд байгаа юм гэдэг чинь ямар учиртай юм? Арай ч бас ингэж доромжилж болохгүй шүү Монголын парламентыг тамхичдын хэдэн төгрөгт, тэдний халаасанд арай ч багтаж байгаагүй шүү.

**Б.Пүрэвдорж:** Хууль санаачлагч Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

**О.Номинчимэг:** Өнөөдөр бид 3 парламентын босгыг давж чадалгүй маш их эрх ашиг мөнгөний нөлөөнд удаа дараа сөхөж ирсэн Тамхины хяналтын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийж байна. Тэгээд энэ хууль энэ хаврын чуулганаар эцэслэн батлагдах санал хураалт явж чадахгүй нөхцөл байдалд хүрсэн байна. Маш харамсалтай.

Гэсэн ч энэ асуудлыг эцсийн хэлэлцүүлэгт хүргэж ирсэн ажлын хэсгийнхэн маань, Хүний хөгжлийн байнгын хорооны нийт гишүүд, чуулганд суугаад санал хураалтдаа оролцсон нийт гишүүддээ Монгол хүн, Монгол хүүхдүүдийнхээ нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье. Энэ хүрэх зам мэдээж дардан байгаагүй. 70 гаруй гишүүн 10 сарын өмнө хамтран өргөн барьсан хууль хурдан урагшлах учиртай мэт санагдавч тийм байсангүй. Бодит байдал дээр олон даваа саадыг бол тууллаа. Энэ хуулийг батлуулахгүй байх буцаахын төлөө ажилласан зарим гишүүдэд ч гэсэн мөн талархал илэрхийлье гэж бодож байна. Та бүхэн парламентад хуулийг ийм өрсөлдөөнтэй, ийм идэвхтэй хэлэлцэж болдог юм байна гэдгийг харуулсан ийм тод жишиг тогтоолоо гэж бодож байна.

Харин тамхины компаниудын санал болгож ирсэн зүйл, заалт, цэг, таслалгүй, тооцоолол нь 1 мөнгөний, бутархай мөнгөний ч зөрүүгүйгээр оруулж ирсэн нь баримттайгаа үйлдэж, улс төрийн замналын тань нэг хэсэг хар толбо болон үлдэнэ. Үүндээ өөрсдөө дүгнэлт хийх биз. Иргэд ч гэсэн өнөөдөр биш юм аа гэхэд хойч үед энэ дээр дүгнэлт хийнэ.

Тамхины бизнес эрхлэгчид бол тэдний эрх ашгийг хамгаалдаг хүмүүс намайг энэ хуулийг батлуулахын төлөө чичиж байна гэж олонтоо шүүмжилсэн. Тийм ээ би чичирсэн. Нэг ангид сурч байгаа 10 хүүхдийн 8 нь уушгины амьсгалын замын өвчтэй бас болчхоод байхад би чичрэхгүй гээд яах юм бэ. Утаатай, утаагүй бүтээгдэхүүн гэж ялгалгүй олон төрлийн хортой бодис, химийн бодис ийм нэгдлүүдээр хүүхдүүдийнхээ ирээдүйг хордуулж байхад дуугай сууж чадахгүй шүү дээ. Жил бүр 1 сумын хүн амтай тэмцэх Монгол хүнээ бид янжуур тамхинаас үүдэлтэйгээр алдаж байна. Ийм байхад чимээгүй өнгөрч болох юм уу? Өсвөр насныхан учир шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа, амьсгалын замын

өвчлөлөөр өвдөөд байхад чичрэхгүй байхын аргагүй биз дээ. Захын хүнсний дэлгүүрээс талх, чихэр худалдаж авдаг жаахан гараараа электрон тамхи худалдаад аваад явж байгаа 10 настай хүүхдүүдийг хараад нүдээ аньж чадсангүй. Тийм ээ би чичирсэн. Гэхдээ би ганцаараа биш ээ, эмч багш нар, аав, ээжүүд, хүүхдүүдийнхээ ирээдүйд санаа зовсон олон мянган иргэд энэ хуулийг батлуулахын төлөө дуу хоолойгоо нэгтгэсэн та бүхэндээ бас чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Улсын Их Хурал, парламент хийе баталъя гэсэн хуулиа яаж хийж баталж чаддагийг энэ сүүлийн үеийн өдрүүд бас харуулж байгаа. Түрүүн хэлсэн Монгол хүний төлөө эрүүл саруул, урт удаан амьдруулдаг, амьдруулахын төлөө, үр хүүхдийнхээ ирээдүйн төлөө боловсруулж оруулж ирсэн энэ хуульд бол ийм хувь заяа өнөөдөр тохиосонгүй. Маш харамсалтай байна.

Эцэст нь бүтэн жил гаруй хугацаанд намайг нэг бол янжуурын лоббичин, нэг бол vare-ны лоббичин, эсвэл бүр гаднын болон дотнын янз бүрийн байгууллагын захиалгаар ажиллаж энэ хуулийг боловсруулсан гэж гүтгэн харлуулсан тамхины бизнес эрхлэгчид болон тэдний эрх ашгийг төлөө ажилласан хүмүүст би хандаж нэг үг хэлье. Тамхи импортлогчдын гүтгэлэг, дайралт, харлуулалт намайг ухраагаагүй.

Харин ч энэ хуулийг батлуулах шаардлага ямар өндөр болохыг улам бүүр ойлгуулж, итгэлийг минь улам бататгасан. Тиймээс ч гэсэн та бүхэнд баярлалаа. Намрын чуулганаар энэ хуулийг батлуулахын төлөө шантралгүй бас ажиллах болно гэдгээ хэлье.

**Б.Пүрэвдорж:** Номинчимэг гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг, зарчмын зөрүүтэй санал хураалтыг үдээс, 17 цагаас явуулна. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалдаа оръё.

15.09 цаг.

**Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Юуны өмнө энэ Малчны тухай хууль танилцуулга хийх хооронд үг хэлье. Малчны тухай хууль бол 2024 оны 5 сард, сүүлээр батлагдсан. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтээр манай ялангуяа Бат-Эрдэнэ гишүүн болон Тэмүүлэн гишүүн нар маш их хариуцлагатай байж энэ нь хэрэгжилтийг хангах талаар олон жил бас зүтгэсэн. Үүнийхээ үр дүнд энэ сонсголыг хийсэн гэдгийг хэлье. Тэгээд Бат-Эрдэнэ гишүүнд бас талархал илэрхийлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүд орон нутагт ажиллах үеэр Малчны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар малчид, иргэдээс санал гарч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, О.Алтангэрэл, О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганбаатар, Д.Ганбат, М.Ганхүлэг, Б.Заяабал, Л.С.Лүндэг, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Р.Эрдэнэбүрэн нарын 21 гишүүнээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалтыг үндэслэн Малчны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Ерөнхий сонсгол зохион байгуулах хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын даргад 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр гаргасан болно.

Мөн Байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 6 дугаар тогтоолоор уг сонсголын бэлтгэлийг хангах зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн миний бие, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Г.Тэмүүлэн нар ажилласан.

Ерөнхий сонсгол зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдвээр ерөнхий сонсголын зарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т сонсгол явуулах сэдэв, огноо, оролцогч ажилчдыг бүртгэх зарыг Улсын Их Хурал албан ёсны цахим хуудаст байршуулна гэж заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр [parliament.mn](http://parliament.mn) цахим хуудаст байрлуулсан болно.

Оролцогчдыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 221.11-д заасны дагуу 14 хоногоос доошгүй хугацаанд бүртгэнэ гэж заасны дагуу 06 дугаар сарын 18-ны өдрийн 17 цагт бүртгэж дуусгасан.

Ерөнхий сонсголын талаар, ерөнхий сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2026 оны 06 дугаар сарын 23-наас 24-ний өдрүүдэд Төрийн ордон “Их Чингис хаан” танхимд нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, Монголын Үндэсний радио, телевиз, Малчин телевиз болон Улсын Их Хурлын цахим сувгаар дамжуулан олон нийтэд хүргэсэн болно.

Хоёр дахь өдрийн сонсгол Улсын Их Хурлын гишүүнээс гадна төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл шууд дамжуулах телевиз, Дорноговь сум, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Увс, Завхан, Дундговь зэрэг аймгуудаас давхардсан тоогоор 90 орчим малчин бол оролцсон.

Хоёр өдрийн ерөнхий сонсголын үр дүнгээс үзэхэд Малчны тухай хуулийн хэрэгжилт эхэлсэн хугацаандаа тодорхой ахиц гарсан хэдий ч хуулиар Засгийн газар болон холбогдох байгууллагад хүлээлгэсэн зарим үүргийн хэрэгжилт хангалтгүй, салбар хоорондын уялдаа сул, зарим журам, аргачлал батлагдаагүй, санхүүжилт болон хэрэгжилтийн зохион байгуулалт жигд бус байгаа нь өнөөдрийн үүссэн хүндрэл, нөхцөл байдлыг арилгах нөхцөл байдал нь дахин давтагдаж болзошгүй эрсдэлтэй байгааг бол тодорхойлж харагдсан.

Тайлангаас үзэхэд хоёр өдрийн сонсголын мэдээлэл, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төрийн байгууллага, албан тушаалтны тайлбар, танилцуулга, иргэний санал, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултад үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Малчны тухай хууль батлагдсанаас хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд заасан зарим чухал хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, журам батлагдаагүй, салбар дундын ажлын уялдаа холболт хангалтгүй, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих тогтолцоо сул байгаа нь харагдаж байна.

Малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залгамж халааг бүртгэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалт бол бодит үр дүнд хүрээгүй. Ялангуяа малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1 удаа нөхөн төлүүлэх зохицуулалт, малчны хөгжлийг дэмжих зарим арга хэмжээнүүд нь бүрэн хэрэгжээгүй байна.

Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үнэлэмж, малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Малчид хамгийн найдвартай зээлдэгч хэдий ч өндөр хүүтэй зээл авч байгаа нь хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт, ипотека, даатгалын тогтолцооны хүртээмж сул байгааг харуулж байна.

Малчдын тухай хуульд зөвхөн нэг салбарын бус Монгол Улсын эдийн засгийн үндэс, хүнсний аюулгүй байдал, хүнсний үндэсний уламжлал, мал аж ахуйн хөдөөгийн нөхцөлийн суурь асуудлыг зохицуулсан ач холбогдолтой хууль болохыг бол харагдсан.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих сэдэвт ерөнхий сонсголын тайлан, дүгнэлтийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Ерөнхий сонсголын тайлан, санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 120 дугаар зүйлийн 120.5-д заасны дагуу сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр хэлэлцэж, Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Ерөнхий сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газар 2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдөр, түүнчлэн тайлангийн санал, дүгнэлтийг хэлэлцэхэд Байнгын хорооны хүрээнд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.6 дахь хэсэг, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх нь Улсын Их Хурлын гишүүдээс хэлэлцэх үед санал гараагүй болно. Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайлан болон “Засгийн газраас чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Малчдын тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий сонсголын тайланг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн шийдвэрийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Л.Мөнхбаясгалан:** 2024 онд батлагдсан Малчны тухай хуулийн 50 гаруй хувь нь биелэгдээгүй ийм харамсалтай дүн мэдээ тодорхой болсон. Малчны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр 2 өдрийн хяналтын ерөнхий сонсгол хийсэн. Малчид ирсэн. Бүх талаас бид нар байр сууриа гаргаж ярилцсан. Хууль яагаад хэрэгжихгүй байгааг Улсын Их Хурлын гишүүдээс маш асууж малчид ч гэсэн ярьсан. Сайдууд, Засгийн газраас бол их оролцоо муутай байсан. Монгол төрийн хууль төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал баталсан бол тэр хууль заавал хэрэгждэг байх ёстой. Хууль баталсны дараа Засгийн газрын зарим нэг гишүүдээс энэ чинь ч болохгүй, тэр чинь ч бол болохгүй гэсэн ийм шалтаг, шалтгаан сонсмооргүй байгаа юм. Цагаан дээр хараар гарсан төрийн хууль заавал биелэгдэх ёстой.

Дээрээс нь Монгол Улсын дангааршил, Монгол Улсын өв соёл Монгол Улсыг авч явж байгаа малчдынхаа тухай ганц хуулийг хэрэгжүүлж чадахгүй, парламент хэрэгжүүлж чадахгүй ийм Монгол Улсын Засгийн газар байх ёсгүй гэж бодож байна. Өдөр болгон малчдаас санал, гомдол ирдэг.

Жишээ нь, уул уурхайн лиценз өвөлжөө, хаваржааных нь газартай давхацсан гээд хөөгддөг. Зарим нөхөн олговрыг нь өгдөггүй. Малаа ундаалах усгүй болсон, хүн нь усгүй болсон, нутаг орноосоо дайжиж байгаа, залуу малчид байхгүй маш олон асуудлыг ярьдаг. Тэгэхээр энэ бүх малчдад тулгарч байгаа асуудал бол энэ Малчны тухай хуулиар хэрэгжих ёстой юм. Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр Монгол Улсын дангааршил, Монгол Улсын өв соёл, Монгол Улсын тусгаар тогтнолыг нуруун дээрээ авч явж байгаа малчин ард түмнийхээ эрх ашгийг хамгаалсан энэ хуулийг бид заавал хэрэгжүүлэх ёстой.

Тийм учраас энэ тогтоолын төслийг Улсын Их Хурлын эрхэм гишүүд баталж, Засгийн газарт бид нар чиг үүрэг өгөөд харин энийгээ чуулган болгон дээр холбогдох Байнгын хороонд тайлагнаад явах ёстой. Тийм учраас энэ тогтоолын төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Одоо Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлаас анх удаагаа хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор сонсголыг бол зохион байгуулж байна. Тэгэхээр энэ үндсэндээ Улсын Их Хурал бид нар хууль батлахаас гадна баталсан хуулиа хэрэгжүүлдэг байх, хэрэгжилтийг бас шахаж шаарддаг байхад бас ийм дэвшил авчирсан ийм хяналтын сонсгол бол боллоо. Анх удаагаа бид нар бол хууль дээр хяналтын сонсгол хийж байгаа бас онцлог болж байна.

Ингээд энэ сонсгол 2 өдөр боллоо. Ингээд малчдын маань төлөөллүүд ирж оролцлоо. Салбар яамнууд ирж хийсэн ажлынхаа тайлан, танилцуулга, мэдээллүүдийг бас тавилаа. Ингээд түрүүн бас хэлсэн Мөнхбаясгалан гишүүний хэлснээр үндсэндээ энэ хуулийн хэрэгжилт 40-өөс 50-хан хувьтай, мал аж ахуйн салбар дээр бид нар онцгой анхаарахгүй бол үндсэндээ нөхцөл байдал бас их өөрөө сайнгүй байгаа. Монгол улсын гол тулгуур салбар бид бүхний бас юу гэдэг юм энэ хүнсний аюулгүй байдалтай хамааралтай, эдийн засгийн аюулгүй байдалтай хамааралтай гол чухал салбарын асуудал. Тэгээд энэ салбар дээр үндсэндээ бид нар анхаарахгүй бол цаашид энэ хөдөө орон нутагт энэ мал маллаж байгаа, мал дагаж байгаа малчин өрхийн маань тоо бол бас жилээс жилд буурч байна.

Дээрээс нь залуу үеийн оролцоо болоод залгамж халаа сул, хүн ам зүйн бодлого, хүйсийн харьцаа өөрөө алдагдчихсан. Нийгмийн баталгаа болоод эдийн засгийн баталгаа нь бас тогтворгүй гэдэг юм уу, эргээд энэ ч салбарт энэ бодлогын уялдаа, холбоог хангах гол зохицуулалт болсон энэ хууль маань бол үндсэндээ тал еэвэнгийн үлгэр шиг тал дутуу хэрэгжилттэй байна. Үндсэндээ энэ хууль дагаж гарах ёстой байсан хууль, журмууд маань 11 журмаас Засгийн газар батлах ёстой байсан, аймаг орон нутаг 3 журам гарах ёстой байсан эдгээр журмуудын бол тал нь бол хэрэгжиж батлагдсан. Тал нь бол хэрэгжээгүй. Тэгэхээр энэ үндсэндээ энэ хууль дээрээс бид нар хэрэгжүүлээгүй байгаа энэ журмуудыг

шуурхай батлагдаагүй байгаа, Засгийн газраас авч хэрэгжүүлээгүй байгаа хойшлуулсан дүрэм журам, аргачлал төлөвлөгөөг бол шуурхай хуульд нийцүүлж, баталж мөрдүүлэх энэ үүрэг даалгаврыг хугацаатай үүрэг даалгаврыг бол Засгийн газарт ингээд өгч байгаа.

Цаашдаа яг энэнтэй холбоотой саяын тэр нийгмийн баталгаа болон энэ ипотекийн зээл, мөн энэ малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ч гэдэг юм уу бүх энэ хууль дээр хэрэгжээгүй байсан асуудлуудыг бол ингээд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болгоод ингээд хийж байгаа. Энийг бид бүхэн бас энэ намар төсөв өргөн баригдахад энэ тогтоолын хэрэгжилтийг бас шалгах болно.

Цаашид ер нь тогтмол ер нь бид нар Монгол Улс энэ хууль дээр хэрэгжилтийг нь шахаж шаардаж ажиллахгүй бол Малчны тухай хууль бол хуулийг хэрэгжүүлдэггүй хариуцлагагүй төрийн нэг л жишээ болж гарч ирж байгаа. Өнөөдөр Монгол Улсад 937 хууль байна. Эдгээр хуулиас магадгүй Засгийн газар өөрийн үзэмжээр хэрэгжүүлдэг, хэрэгжүүлдэггүй, журмыг нь гаргадаггүй, эсвэл хойшлуулдаг ийм асуудлууд байна.

Тэгээд хариуцлагагүй төрийн нэг л жишээ гэж бол би бас хэлэх байна. Тэгэхээр үндсэндээ хариуцлага бид нар байхгүй бол цаашдаа хөгжлийг бол ярих боломж бололцоо байхгүй. Тэгэхээр бид нар асуудлыг тойрч ярих биш үндсээр нь бол шийдэх, энэ хуулийг хэрэгжүүлэх энэ сонсголыг бол бас ингээд хийлээ.

Цаашид бид нар бусад энэ ард түмний эрх ашиг хөндөгдсөн, олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн олон олон хуулиуд дээр бол сонсголыг хийж ингэж хэрэгжилтийг бол Засгийн газраас шахаж шаардаж ажиллах болно гэдэг бол бас эцэст нь.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хуулийг, сунгах тухай хуулийг Ганзоригийн Тэмүүлэн гишүүн 2020 онд өргөн бариад, би бас нэг хууль өргөн бариад бид хоёрын хуулийг хамтатгаж хэлэлцээд үүний үр дүнд 2021-2022 оны хооронд энэ хууль хэрэгжсэн. Нийтдээ 20 гаруй малчин энэ хуульд хамрагдаж, нийгмийн даатгалын шимтгэлээ төлж, нөхөн төлж тэтгэврээ авах боломж бүрдүүлсэн юм.

Тэгээд энд 20 гаруй мянган малчдаас 4000 орчим нь жишээ нь Ховд аймгаас хамрагдсан байгаа. Энэ нь хуулиа яаж тайлбарлаж олон түмэнд, малчдад тайлбарласны үр дүн гэж харж байгаа. Тэгэхээр энд бол Тэмүүлэн гишүүний манлайллыг бас хэлэх нь зүйтэй.

Дээрээс нь дахиад 2024 он онд энэ Малчны тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх энэ асуудлыг оруулсан. Тэгээд бас энэ малчдынхаа өмнөөс Тэмүүлэн гишүүнд бас энэ болон Бат-Эрдэнэ гишүүнд энэ хуулийг өргөн барьсанд талархаж байгаа.

Гол нь янз янзын Малчны тухай хуулиар бусад асуудлыг зохицуулсан ч гэсэн хамгийн их малчдын хүлээсэн зүйл бол нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх асуудал байгаа. Харамсалтай нь Засгийн газар энэ дээр хангалттай

ажил төрлөө явуулаагүй өнөөдрийг хүртэл энэ хуулийн хэрэгжилтийг малчид гишүүдээс шахаж шаардаж байгаа. Энэ дээрээ санаачилгатай ажиллаж байгаа Тэмүүлэн гишүүнд бас талархлаа илэрхийлье.

Байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг 17 цагаас явуулна. Дараагийн асуудалдаа оръё.

15.25 цаг.

**“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Пунсалмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгасан орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар сонсох арга хэмжээний хүрээнд Өргөдлийн байнгын хороо 2026 оны 03 сарын 17-ны өдрийн хуралдаанаар орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийг сонссон.

Өргөдлийн байнгын хороо 2026 оны 05 сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгасан орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн орон сууц захиалж хохирсон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хууль тогтоомжийн биелэлтийг шалган судалж, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 02 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ж.Золжаргал, Лувсанжамц, Ц.Мөнхтуяа, Б.Пунсалмаа, М.Сарнай нар ажилласан болно.

Ажлын хэсэг орон сууц захиалгын улмаас хохирсон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Улсын ерөнхий прокурорын газар, ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас шаардлагатай тайлбар, мэдээллийг авч, барилгын төслийн хэрэгжилтийн явцтай газар дээр нь танилцаж ажилласан талаарх мэдээлэл, судалгаатай танилцан, өргөдөл гаргагч иргэд болон төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй нийт 4 удаагийн уулзалт зохион байгуулсан болно.

Иргэдийн өргөдөл, гомдолд орон сууцтай төслүүдийн хэрэгжилтийн байдлыг судлан үзэхэд барилгын ажил удааширсан, бүрэн зогссон, үл хөдлөх хөрөнгийг давхардуулан захиалсан, хууль тогтоомжид нийцээгүй санхүүжилтийн хэлбэрээр хөрөнгө татсан, барилгын зөвшөөрөл болон бусад шаардлагатай эрх зүйн нөхцөл бүрэн хангагдаагүй байхад иргэдээс урьдчилсан төлбөр, хөрөнгө төвлөрүүлж, түүнийгээ зориулалтын дагуу ашиглаагүй, төсөл хэрэгжих боломжгүй болсон зэрэг зөрчил түгээмэл байлаа.

Мөн иргэдэд орон сууц захиалах гэрээний дагуу төлбөрөө бүрэн буюу их хэмжээгээр төлсөн, эсвэл дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд газар, үл хөдлөх хөрөнгөө чөлөөлсөн хэдий ч гэрээнд заасан хугацаанд орон сууцаа хүлээн авч чадаагүй, олон жилээр хүлээлгэгдэх нөхцөл байдал үүсээд байна.

Ажлын хэсгээс орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой харилцаанд өсөж байгаа зөрчил маргаан нь иргэдийн өмчлөх хөрөнгийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хөндсөн төдийгүй барилгын салбарын тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын орчин, төрд итгэх олон нийтэд итгэл сөргөөр нөлөөлж байгаад хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, төслийн санхүүжилтэд тавих хяналтыг сайжруулах, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, баталгааг бэхжүүлэх, салбарын ил тод байдал хамтын хариуцлагын тогтолцоо боловсронгуй болгох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулагдлаа.

Өргөдлийн байнгын хороо 2026 оны 07 сарын 01-ний өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дугаар заалт, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 11 дүгээр хэсэгт тус тус үндэслэн боловсруулсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Уг асуудлыг зөвхөн иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын гэрээний маргаан гэж үзэх боломжгүй бөгөөд төрийн байгуулалтын үйл ажиллагаатай шийдвэртэй холбоотой хүчин зүйлс болох барилгын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженерийн дэд бүтэц болон төрөөс олгодог зөвшөөрөлтэй холбоотой хүндрэлээс асуудлыг төрийн байгууллагын оролцоо, хариуцлагын хүрээнд үнэлж, шаардлагатай саналыг хэлж, төртэй холбоотой хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг тогтоолын төсөлд тусгах талаар хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа тогтоолын төсөл батлагдсаны дараа барилгын шугам сүлжээ, техникийн нөхцөл, инженерийн дэд бүтцийн хүндрэлээс шалтгаалан хэрэгжилт удааширсан, зогсонги байдалд орсон орон сууцын төслүүдийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 2027 оны улсын төсөвт шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг тусгах боломжийн талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 76.9 хувь нь дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Орон сууц захиалах, худалдан авах асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, уг асуудалд үүсэж байгаа зөрчил, маргааныг шийдвэрлэх, хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Пунсалмаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Батсүхийн Найрамдал Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Балжиннямын Мөнхбат Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Гүрцэдэнгийн Мөнхбаатар Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга, Даш-Янпилын Алтанзул Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга, Чилхаажавын Мөнх-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий прокурорын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Эрдэнэцогтын Бямбажав Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Дашцэрэнгийн Сайнжаргал Цагдаагийн ерөнхий газрын Залилах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга.

Ажлын хэсгийнхэн Их Хурлын гишүүдийн асуусан асуулт болон мэдээлэлд үнэн дүүрэн хариуцлагатай мэдээлэл өгөх ёстой. Худал мэдээлэл өгвөл Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Бейсен гишүүнээр тасаллаа. Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

**Б.Бейсен:** Энэ бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ шинээр орон сууцад орж байгаа айл өрхийг тухайн компанийнх нь урьдчилаад мөнгийг нь авчихдаг дараа нь зэвтэй усалдаг, хүлээлгэж өгөхгүй, хаалга нь эвдэрхий, ус алддаг, халаалт жигдэрдэггүй асуудал байгаа. Энийг ямар байгууллага шалгадаг юм нэгдүгээрт?

Хоёрдугаарт, одоо хөнгөлөлттэй зээлээр түрээсийн байр өгөх гэж байгаа Улаанбаатар хотын хэмжээнд. Тэгэхээр чинь энэ 20 хувийг нь засаг төлөөд цаана нь 250 мянгаар түрээслээд суудаг, 200 мянга нь тэр зээлдээ төлдөг, 50 мянга нь шимтгэлд нь явдаг гэсэн энэ үнэн үү? Ямар журмаар шалгаруулаад оруулах гэж байгаа, хүүхдийн тоогоор ч гэж ярьж байна. Энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Индэрийн 4 дүгээр микрофон асуултад хариулъя. Ямар албан тушаалд? Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэг хариулна.

**О.Номинчимэг:** Бейсен гишүүний асуултад хариулъя. Манай энэ ажлын хэсэг маш их олон 600 гаруй иргэдийн өргөдөл дээр үндэслэн Өргөдлийн байнгын хороо энэ асуудалд анхаараад ер нь орон сууц захиалгаас хохироод байгаа асуу

юундаа байна гэдгийг нэлээн удаан хугацаанд бас судалж, дүн шинжилгээ хийж, олон талын уулзалтуудыг хийсэн байгаа. Тэгээд үнэхээр одоогийн хууль, эрх зүйн орчин маань ямар нэгэн хяналт байхгүй, энэ иргэдээс орон сууц захиалахад ер нь бол хов хоосон газар зүгээр цаас үзүүлж байгаа захиалга мөнгийг нь авчхаж байна 100 хувь. Иргэд маань тэрэнд итгээд өгчхөж байна. Яагаад гэвэл мэдээллийн ил тод байдал муу байна.

Хоёрдугаарт өгч байгаа мөнгө төгрөг нь яг үнэхээр тэр орон сууцдаа орж байна уу үгүй юу гэдэг дээр хөндлөнгийн хяналт ерөөсөө байхгүй байна. Тэгээд гэрээ хийдэг. Нэг нь бол том барилгын компаниуд нэг нь бол зүгээр иргэн байдаг. Тэгээд энэ гэрээгээрээ гэрээгээрээ гээд гэрээгээ сүүлдээ өөрчилдөг, юу гэдэг юм хүлээхгүй бол энэ гэрээг чинь цуцална шүү гээд ингээд олон асуудал болдог юм байна. Тэгэхээр энэ олон жил яригдаж байгаа асуудал. Өргөдлийн байнгын хороо бол яг иргэдийнхээ энэ бодит асуудал дээр бол бид шийдэл гаргах ёстой гээд ажиллаж байгаа. Тэгээд үнэхээр одоогийн байгаа энэ нөхцөл байдал бол энэ барилгын салбарын, энэ залилангийн, инфляцын, бүх төрлийн эрсдэлүүдийг ерөөсөө иргэдэд үүрүүлээд байна. Энэ эрсдэлийг хэмжээд аль нэгэн талд нь эрсдэлийг контролдох боломжтой нөхдүүдэд хуваарилж өгөх асуудал байхгүйгээс болоод иргэд тэр чигээрээ бүх асуудал дээр хохирч байна. Дахин төлөвлөлтийн асуудал гэхихсэн яг ийм байна.

Тэгэхээр манайх бүхэлдээ ер нь хууль, эрх зүйн орчны хувьд ялангуяа энэ Барилгын тухай хууль Засгийн газраас өргөн мэдүүлэх гэж байгаа энэ хууль дээрээ яг иргэдийн эрх ашгийг хамгаалсан энэ асуудлуудыг заавал тусгаж өгөх ёстой байгаа юм. Тэрийг бол бид энэ тогтоолоороо бас үүрэг чиглэл өгч байна. Хууль тогтоомжийн нөхцөлийг бас сайжруулах тал дээр давхардуулан зарахгүй, залилан маягаар ийм явах, 2, 3-н хүнд зэрэг зарах асуудал ч гэсэн маш их байна. Тэгээд үүнийг бас шийдэх шийдлүүд юу байж болох вэ гэдэг дээр хууль санаачлагчаар гишүүд маань бас хууль санаачилж оруулж ирсэн байгаа.

Үүнээс гадна бас энэ мэдээллийн ил тод байдал бол маш чухал байна. Ер нь энэ барилга захиалга өгөх гээд байгаа компани маань санхүүгийн чадавхтай юм уу, урьд нь ямар барилгын төсөл хийж байсан юм, зөвшөөрлөө авсан юм уу, газраа авсан юм уу энэ мэдээлэл юу ч байхгүйгээс болоод Солонгост ажиллаж байгаа хүн энд ажиллаж байгаад сайхан байртай болоод очъё доо, хөдөө орон нутагт хүүхдүүд маань тэнд сурах гээд очиж байгаа юм чинь сайхан байртай больё доо гээд итгэж бараг сошиалаар хараад мэдээллийг нь хараад л захиалга өгч байгаа асуудал байна. Тэгэхээр энэ байдлыг бид хууль, эрх зүйн орчноороо цаашид сайжруулах ёстой.

Дээр нь нэмээд хохирчихсон байгаа иргэдийн асуудал юу байна. гэдгийг бид бас дүн шинжилгээ хийсэн. Ерөнхийдөө 3 бүлэгт бид нар харж үзэж байгаа. Эхний асуудал нь бол ерөөсөө төрийн байгууллагын үүрэг, цаг хугацаандаа биелэхгүй байгаагаас үүдээд удааширсан, түүнээсээ болоод санхүүгийн хүндрэлд орсон гэдэг ийм асуудлууд байна. Дахин төлөвлөлтийн асуудлууд дээр төр хийх ёстой дэд бүтцийн асуудлууд, зөвшөөрлийн асуудлууд хоорондоо уялдаа холбоо муутайгаас болоод ингээд удсан асуудлууд байна. Үүнийг бас шийдье гээд Засгийн газарт бас чиглэл өгч байна.

Хоёрдугаарт санхүүгийн чадавхгүй болсон байна. КОВИД-ын үеэр бас зарим барилгын компаниуд санхүүгийн өөрийнхөө удирдлагыг муу хийснээс, эрсдэлээ буруу хуваарилснаас болоод нөгөө иргэдээс авсан мөнгөө барилгадаа хийгээгүй, барилга нь баригдаагүй ингээд царцчихсан хөрөнгүүд байна. Энэ асуудлыг ер нь бол бас энэ царцсан хөрөнгүүдийг эргэлтэд хуулийн дагуу оруулах ёстой. Тэгж байж иргэд маань 10 жилийн өмнө өгч байсан 30 сая төгрөгөө бид нар авна гэхээсээ илүү байрандаа л ормоор байна гэдэг энэ өргөдөл шаардлагыг тавьж байгаа.

Гурав дахь асуудал бол ерөөсөө л энэ иргэдийн орон сууцтай болох мөрөөдөл дээр тоглосон залилангийн анхнаасаа залилья, гэмт хэргийн шинж чанартай ийм бас асуудлууд байна. Энэ дээр цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд бол идэвхтэй ажиллаж, үр дүнг гаргая гэсэн ийм тогтоолын төслийг Засгийн газарт үүрэгт өгөөд энэнийхээ хэрэгжилтийг хангахын төлөө бас Өргөдлийн байнгын хороо ажиллахаар тогтоолын төсөл оруулж байгаа гэдгийг хэлмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бейсен гишүүд тодруулъя.

**Б.Бейсен:** Энэ Эко констракшны барьсан River Castle гээд байгаа. Одоо иргэн, оршин суугчдаас хүсэлт ирж байгаа. Зэвтэй ус гардаг. Гадна талд нь зогсоол байхгүй. Гараашны хаалга нь одоо хүртэл эвдэрхий гээд тэрийгээ хүлээлгэж өгөх гээд яг ингээд яарч байгаа улсууд байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт шавааралдсан баахан орон сууц барьдаг, сургууль, цэцэрлэгийн төлөвлөлт хийдэггүй. Энэтэй холбоотой хотын түгжрэл үүсэж байгаа хүүхдээ сургуульд оруулах гээд энэ талаар Барилга, хот байгуулалтын яам энэ хот төлөвлөлтөө анхаардаггүй юм уу энэ талаар тодорхой хариу өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**Б.Найрамдал:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Найрамдал. Хотхон хороололд 10 мянган айлаас дээш айл өрхтэй хотхон хороололд сургууль, цэцэрлэг заавал байх хуулийн тогтоол 2025 онд батлагдаад явсан. Үүнтэй холбоотойгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 оны 02 сарын 08-ны өдөр гарсан албан даалгаврыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн байгаа.

Өнөөдөр Барилгын тухай хуулиар хотхон, хорооллын төлөвлөлттэй холбоотойгоор барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийг бол аймаг, нийслэлийн Засаг дарга нар өнөөдөр олгож байгаа. Архитектур төлөвлөлтийн даалгавар. Эскиз зураг болон барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөлттэй холбоотой, барилгын үйл ажиллагааны зөвшөөрлүүдийг бол бүгдэд нь олгож байгаа. Энэ хотхон хорооллын сургууль, цэцэрлэгтэй холбоотойгоор 2026 онд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас нийслэлийн хэмжээнд болон аймаг орнуудыг

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин тодруулъя Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Сая нөгөө Эко констракшны барьсан River Castle тэр охин компани барьсан байна даа. Том захирал нь Нямдаваа мэдэхгүй байгаа байх. Одоо гараашны хаалга нь орохдоо л эвдрэхээ байсан. Одоо ингээд ... орохоор тэр чигээрээ хаяад явах гэж байна. Засаагүй л байгаа. Ус нь зэвтэй гарч байгаа асуудал байгаа. Энэ дээр тэр хүлээж авахдаа компаниуд, байр хүлээж авах компанийнхан тэгээд яагаад дутагдалтай юм хүлээж авсан бол? Энэ талаар шалгалт хийх боломж байна уу нь?

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулъя 4 номерын микрофон.

**Б.Найрамдал:** Энэ дээр Бейсен гишүүний асуултад хариулъя. Яг нийслэл дээр 2024 онд анх байгуулагдсан зэвтэй устай холбоотой ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Мөн энэ зэвтэй устай холбоотойгоор бас Байнгын хороон дээр ажлын хэсгийн хурал дээр өмнөх долоо хоногт хариулсан. Энэ ажлын хэсэг бол яг өнөөдөр Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудын хүрээнд ажлын хэсэг байгуулагдаад ингээд явсан байгаа. Энийг нийслэлээс илүү тодорхой тайлбарлах байх. Барилга байгууламжийн ашиглалтад хүлээж авах үйл ажиллагаа нь бас нийслэл дээр явагдсан байж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нийслэлээс нэмж хариулъя.

**Б.Мөнхбат:** Нийслэлийн Засаг даргын орлогч Мөнхбат. Гишүүний асуултад хариулъя. Саяын гишүүний хэлээд байгаа хотхонтой холбоотой асуудал дээр хяналт шалгалт явуулъя. Мэдээж улсын комисс ажиллаад тухайн барилга байшинг хүлээгээд авчихсан ашиглалтад авсан байгаа. Энэ хүрээнд бас гүйцэтгэсэн үйл ажиллагаануудын саяын хэлсэн зэвтэй устай холбоотой асуудал, гарааштай холбоотой асуудал дээр ажлын хэсэг томилж, ойрын хугацаанд шалгалт явуулаад алдаа, дутагдал залруулахын төлөө ажиллая. Эргээд гишүүнд хариу өгье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дараагийн асуудалдаа орёё.

15.42 цаг.

**Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр ажлын 3 өдрийн завсарлага авсан. Завсарлага авсан хугацаа дууссан байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Жаргалан үг авч байна.

**Б.Жаргалан:** Энэ удаагийн Улсын Их Хурлын хаврын чуулганаар Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль өнөөдөр эцэслэн батлагдах хэлэлцүүлэг нь явж байна. Мөн Төрийн өмчит компанийн засаглалын тухай хуулийг эцэслэн батлах хэлэлцүүлэг бас өнөөдөр явлаа. Энэ утгаараа бол энэ удаагийн парламент төрийн өмчит

компанийн талаар баримтлах бодлогоо тодорхойлж, улмаар эдийн засаг дахь төрийн оролцооны хүрээ хязгаарыг бас тодорхойлж байгаа ийм түүхэн хаврын чуулган болж байгаа.

Гэтэл энэ цаг хугацаанд Засгийн газраас нөгөө талаараа Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон Орон сууцын санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байгаа. Эдгээр энэ 2 хуулийн төслүүд болохлоор саяын миний дурдсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон Төрийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэх тал дээр бас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн хувьд ч тэр, ер нь энэ парламентын түвшинд ч тэр Эдийн засгийн байнгын хороон дээр ч тэр цаашид дахин нийцлийг бол бас тодруулах, илүү ойлголцох, илүү зөвшилцөх шаардлагатай гэж үзээд энэ 2 хуулийн төсөл дээр авсан завсарлагын хугацааг дахиад 3 хоногоор сунгаж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 хоногийн хугацаанд 26 оны 06 сарын 25-ны өдөр 3 хоногоор завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа дууссан. Дахин 3 хоногоор завсарлага хүсэж байна.

Та бүхэн маань бас энэ асуудлаа дор дороо яриад бүлгийнхээ хурлаар хуралдаад бас шийдчихмээр байгаа юм Жаргалан гишүүн ээ. 1 хоногоор маргаашийн 07 сарын 03-ны өглөө өдрийн 10 цаг хүртэл завсарлага өглөө. Дараагийн асуудалдаа оръё.

15.46 цаг.

**Орон санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлыг хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр ажлын 3 өдрөөр завсарлага авсан. Завсарлагын хугацаа өнөөдөр дуусаж байна. Ингээд завсарлагын хугацаа дууссан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна уу? Завсарлах хугацаа дууссан. Ажлын хэсгийн нэрсийг ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болдбаатарын Буяндэлгэр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх, Оюуны Одбаяр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцын бодлого зохицуулалтын газрын дарга, Бямбабаатарын Сүхбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга, Дамдинсүрэнгийн Батзориг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын Барилгын материалын хэлтсийн дарга, Шаравын Бат-

Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Базарсадын Мөнхзул Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал, Өлзийбатын Мөнх-Ундарга Монголбанкны Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал. Үгүй шүү дээ эхнийх шүү дээ. Эхний асуудал байхгүй юу. Энэ дээр аваагүй шүү дээ. Урьд нь хоёулан дээр нь өгсөн тийм үү? Одоо тэгвэл дахиад саналаа хэлчих. Ардчилсан намын бүлгийн дэд дарга Жаргалан.

**Б.Жаргалан:** Энэ Орон сууцын санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хууль мөн энэ Орон сууцын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай бас яг нэг агуулгаар орж ирж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр бас мөн адил завсарлага хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэлэлцэж байгаа асуудлаар завсарлага хүсэж байна. 26 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн өглөөний 10 цаг хүртэл завсарлага өглөө. Дараагийн асуудалдаа орёё.

15.49 цаг.

**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Соронзонболд танилцуулна. Соронзонболд гишүүнийг индэрт урьж байна.

**Л.Соронзонболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2006 оны 06 дугаар сарын 25, 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хэрэгжих хугацааг хойшлуулах саналын шалтгаан, нөхцөлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа тус хуулийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өсөн нэмэгдэх хувь, хэмжээний хэрэгжих хугацааг хойшлуулах асуудалд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны байр суурь, Засгийн газраас Оюу толгой төслийн хүрээнд хийсэн хэлэлцээртэй холбоотойгоор “Онтрэ” компанийн талаар ямар амлалт, үүрэг хүлээсэн эсэх, Улсын Их Хурлын

гишүүн Очирбат Засгийн газрын шийдвэрийн улмаас хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор хохирсон аж ахуйн нэгжүүдийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтаас их хэмжээний орлого төвлөрүүлж байгаа атлаа хайгуулын ажлыг өөрөө санхүүжүүлэн зохион байгуулах боломж чадавхгүй байгаа шалтгаан, мөн Монгол улсад хайгуулын ажил гүйцэтгэх чадвартай хэдэн компани байгаа, дэлхийн зах зээлд зэсийн үнэ өндөр түвшинд хүрч, цаашид эрэлт өсөх төлөвтэй байгаа энэ үед өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өөрчлөх шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр талаарх Засгийн газрын байр суурь, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилт “Оюу толгой” компанийн хувь нийлүүлэгчдийн зээлийн үлдэгдэл, Засгийн газрын хэлэлцээрийн хүрээнд хувь нийлүүлэгчдийн гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээнд ямар өөрчлөлт оруулах, хуримтлагдсан зээлийн хүүг хэрхэн шийдвэрлэгдэхээр тохиролцсон, эдгээр өөрчлөлтүүд хэрэгжиж эхлэх хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалтын хэрэгжих хугацааг хойшлуулах болон болсон үндэслэл шаардлага, Ашигт малтмалын тухай хуульд орж буй нэмэлт өөрчлөлтүүд ямар давуу тал үр өгөөжийг бий болгох талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй 8 санал, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн 1 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Үүнд:

Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгож, сунгах зохицуулалт.

Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолт, хөрс хуулалт, хүдрийн олборлолт, овоолго, уурхайн төлөвлөлт, ашигт малтмалын нөөцийн ашиглалтын байдалд хөндлөнгийн, хараат бус дүгнэлт гаргах эрх үүрэг болон үйл ажиллагааны зардлыг төсөл хэрэгжүүлэгч гэрээний үндсэн дээр хариуцах бөгөөд хөндлөнгийн дүгнэлтийн үнэн зөв, хараат бус ажиллагаанд мөрдөх заавар, шаардлагыг нарийвчлан зохицуулах агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналууд болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим зүйл Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн, бусад хуулийн төсөлд давхацсан зөрчлийг арилгах саналуудыг бэлтгэсэн болно.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд тусган хууль зүйн техникийн засвар өөрчлөлтийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Пүрэвжавын Буянбаатар Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмал газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга, Мөнхсайханы Энхтулга Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга.

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтанд үнэн зөв, гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуулгад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулахыг хориглоно.

21.31.Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд нь хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн хуулийн заалтыг танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Энэ хуулийн төслийг тойроод Онтрэ-тай холбоотой асуудал яригдаад байгаа юм. Тэгээд сая Засгийн газар бас Рио Тинто Оюу толгойтой хэлцэл хийгээд тодорхой үр дүнд хүрсэн талаар мэдэгдсэн. Тэгээд тэрний дараа “Онтрэ” компанийн хувьцаа бас огцом өссөн. Яг тэр хэлэлцээр хийсэн өдөр. Тэгэхээр нөгөө талаас бас Рио Тинто-гийн өгсөн мэдэгдэлд Онтрэ-тай холбоотой бас тодорхой хэмжээний хэлцлүүдийн талаар ярьсан байсан. Тэр мэдэгдэл дээрээ заасан байсан. Тэгэхээр яг энэ дээр тодорхой бас яг Улсын Их Хурлын чуулган дээр энэ саяын болсон хэлэлцээр дээр энэ Онтрэ-тай холбоотой асуудал яригдсан юм уу үгүй юү, амласан амлалт, буулт хийсэн ийм зүйл асуудал байгаа юм уу гэдгийг нэгдүгээрт яг ийм яг тодорхой хэлчихмээр байна. Тэгэхгүй бол энийг тойрсон маргаанууд бас явагдаад байна. Гишүүдийн хувьд ч гэсэн.

Дээр нь ер нь цаашид энэ Онтрэ-тай холбоотой асуудлыг яаж явах талаар мэдээж нарийн юу байгаа байх. Ер нь бол энэ талаар бас юу Уул уурхайн яам ч юм уу энэ талаар тодорхой мэдээлэл өгчхөөч. Ер нь бол эргэлзээ бол яг Онтрэг тойрсон л асуудал байгаад байна. Энэ талаар мэдээлэл өгөөч.

Хоёрдугаарт би өмнө бас чуулган дээр асуусан Зөвшөөрлийн тухай хуульд баяжуулах үйлдвэртэй холбоотой зөвшөөрөл, маркшейдертай холбоотой зөвшөөрлийг хэлэлцүүлэг хийх ёстой. Олон нийтийн хэлэлцүүлэг хийж байж зөвшөөрлийн зөвлөлөөс зөвшөөрөл олгосон байх ёстой. Тэгээд зөвшөөрлийн зөвлөлийн өгсөн он, сар, өдрийг хэлсэн, хэлэлцүүлэг хийсэн гээд бас халти сүүлд нэмэлт мэдээ, тайлбар өгөхдөө дурдсан байгаа. Энэ талаарх мэдээллийг бичгээр яг хэдний өдөр ямар хэлэлцүүлэг хийсэн талаарх мэдээллийг өгөөч гэдэг ийм хүсэлт байна бичгээр.

Яагаад энийг бас асуугаад байна гэхээр баяжуулах үйлдвэрийнхэн, үйлдвэрлэгч нар болон маркшейдертай холбоотой энэ оролцогч талууд энэ зөвшөөрлийн яг энэ холбогдсон хэлэлцээр, хэлцэл явагдаагүй юм шиг энэ талаар бас дутуу ойлголттой байж магадгүй гээд энэ талаар ийм бас хүсэлтүүд тавигдаад байгаа учраас энийг зөв ойлголт өгөх үүднээс тэр мэдээллийг нь бичгээр өгөөч гэсэн ийм хүсэлт байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгээс хариулъя. Сайд хариулах уу? Дамдинням сайд.

**Г.Дамдинням:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. “Оюу толгой” компанитай олон асуудлаар Монгол Улсын Засгийн газар маргаантай, хэлцэлтэй байгаа. Энэний 2 асуудлыг үндсэндээ өнгөрсөн хаврын чуулганы, энэ хаврын чуулганы хугацаанд хийж дуусгалаа.

Нэгдүгээрт бол менежментийн төлбөрийг 2 дахин буулгах хэлцэлд хүрч чадлаа. Ингэснээр бол 2.2 тэрбум долларын зардлыг бууруулж, Монголын талын өгөөжийг 1.5 тэрбумаар нэмэгдүүлж чадсан. Өчигдөрхөн, уржигдархан зарласан мэдээлэл бол зээлийн хүүг бууруулсан ийм үр дүн гаргасан байгаа. Зээлийн хүүг бууруулснаар бид нар 6.2 тэрбум долларын зардлыг хэмнэж, үндсэндээ ингээд 30 орчим их наяд төгрөгийн гарах байсан зардлыг бууруулж, Монголын талын өгөөжийг нэмэгдүүлж чадсан ийм л ажлыг хийсэн. Мөн бас ногдол ашиг энэ жилдээ багтааж олгоно гэдэг ийм шийдэлд хүрсэн.

Онтрэ-тай холбоотой Монгол Улсын Засгийн газар ямар ч амлалт аваагүй, ямар ч амлалт аваагүй. Онтрэ-гийн Жавхлант, Шивээ толгой гэдэг 2 төсөлтэй лицензтэй талбайд хэлэлцээ хийж үзнэ. Ингээд Монгол Улсын үндсэн хуулийн 6.2-т суурь хэрэгжихээр буюу нийт өгөөжийн 50-аас, 51-ээс дээш хувь нь Монголын талд ирэх ийм хэлэлцээ хийж чадвал бид Улсын Их Хуралд нээлттэйгээр танилцуулна. Хэрхэхийг Улсын Их Хурал бүрэн шийднэ.

Тэгэхээр энд бол хаасан, нээсэн, нуусан, тохиролцсон юм юу ч байхгүй ээ. Энийг бол бас хариуцлагатайгаар мэдэгдье. Ямарваа төслийг эхлүүлэхийн тулд эхлээд заавал хэлэлцээд төсөл, хөтөлбөрийг нь харах ёстой байдаг. Тэгээд саналыг нь сонсож болно. Ийм л юм байгаа. Өөр юм байхгүй.

Зөвшөөрлийн холбоотой асуудал дээр бол бид Улсын Их Хурлын хуулийг өргөн барихад Улсын Их Хуралд бол бас хувь юу өгдөг бүрдэл хангаж өгдөг. Бүрдэл нь бол хангасан. Тэр мэдээллийг манай Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв өгнө өө. Ажлын хэсэг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг хариулъя.

**Б.Дашпүрэв:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 26, 11 дүгээр сар 17-ны өдрийн хуралдаануудаар бид бүхэн дүгнэлтээ гаргуулж авсан. Нийтдээ 2023 оны 03 сарын 01-нээс 12 сар хүртэл нийтдээ 16 удаагийн хэлэлцүүлэг хийж давхардсан тоогоор 1400 санал нэгтгэсэн байгаа. Мөн Маркшейдерийн холбоо дэмжиж Улсын Их Хуралд саналаа ирүүлсэн байгаа. Дэлгэрэнгүй хурлын протокол болон ТОВЬЁГ бэлдсэн байгаа. Танд бичгээр хүргүүлье. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас асар өндөр хамааралтай. Тэр тусмаа экспортын орлого 93 хувь нь энэ салбараас уул уурхай ашигт малтмалын салбараас асар өндөр хамааралтай байдаг. Ийм мөн энэ бүгдийг ингээд харахад уул уурхай, ашигт малтмалын салбар, энэ салбарын харилцааг зохицуулж байгаа энэ хууль гэдэг бол өөрөө асар чухал ач холбогдолтой. Энэ хуулийн хэлэлцүүлэг ингээд явагдаж байна. Явагдаж байгаа үед бас олон талын анзаарах ёстой байр суурь, мэдээллүүд, анхаарах ёстой мэдээллүүд гарч байна. Энэ салбарт ажиллаж байгаа, ажиллаж байсан Засгийн газрын бас хариуцлагатай алба хашиж байсан хүмүүс яг одоо энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад бас янз бүрийн байр суурь, мэдээллүүд өгч байна. Бас иргэний холбоод, мэргэжлийн байгууллагуудаас бас саналууд ирж байна. Оюу толгойтой холбоотой гэрээ, хэлэлцээр хийгдэж байгаа энэ үед Оюу толгойн төслийн үргэлжлэл болсон тэр “Онтрэ” компанийн лицензтэй холбоотой бас янз бүрийн мэдээллүүд гарч байна.

Тэгэхээр энэ хуулийн асуудлыг нэлээн бас нягталж ингэж яаран сандран биш нягталж ярилцах ёстой гэж Ардчилсан намын бүлгээс үзэж байна. Магадгүй Оюу толгой дээр тодорхой хэмжээний гэрээний хөнгөлөлт, зээлийн хүүгийн хөнгөлөлт, менежментийн төлбөрийн хөнгөлөлт гэдэг хөнгөлөлт гарч байгаагаасаа хэд дахин илүү цаана нь АМНАТ-ын хөнгөлөлт, олон зүйл энэний цаана яригдаж байгаа юм биш биз дээ гэдэг эргэлзээ, тээнэгэлзлийг бас хийж болохоор ийм нөхцөл байдал байна. Ийм учраас Ардчилсан намын бүлгээс энэ Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлгээс 3 хоногийн завсарлага хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүн ээ энэ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлэг дээр үндсэндээ бол өөрчлөлт бол гарах ямар ч бололцоо байхгүй шүү дээ. Хууль бол хэлэлцдэгээрээ хэлэлцэгдээд эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцээд явчихна. Одоо бол ямар нэгэн горимын санал, ямар нэгэн саналууд оролцох, ажлын хэсэг ажиллах боломж бололцоо бол өнгөрчихсөн шүү дээ.

Тэгэхдээ яах вэ та бүхэн маань бас эргээд ярилцчих тэгээд цагийн завсарлага өгье дөө.

Наадах чинь одоо эцсийн хэлэлцүүлэг шүү дээ. Тийм байх аа эцсийн хэлэлцүүлэг. Эцсийн хэлэлцүүлэг чинь хуультай холбоотой, хэлэлцүүлэгтэй холбоотой асуудал байгаа бол эцсийн хэлэлцүүлэг дахиж ямар нэгэн өөрчлөлт гарах бололцоо байхгүй шүү дээ. Тийм.

16.03 цаг.

**Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал байна.**

Дараагийн асуудал Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлогын зөвлөх Төмөртоогоогийн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин таныг индэрт урьж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга Цэдэн-Ишийн Ганзориг танилцуулна. Цэдэн-Ишийн Ганзоригийг индэрт урьж байна. Ганзориг.

**Ц.Ганзориг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.1-д заасны дагуу Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшүүлснийг та бүхэнд танилцуулж байна.

Дугарсүрэнгийн Гүн-Үйлс 1965 онд Улаанбаатар хотод төрсөн. 61 настай. Нийслэлийн 52 дугаар дунд сургуульд суралцан төгсөөд 1983-1984 онд Орос хэлний багшийн дээд сургууль, 1984-1989 онд хуучнаараа Зөвлөлт Холбоот Улсын Казаны Их Сургуульд суралцаж Орос хэл, утга зохиолын багш мэргэжил эзэмшсэн байна.

Гүн-Үйлс нь 1989-1992 онд Монголын радиод утга зохиолын нэвтрүүлгийн редактор, сэтгүүлч, сурвалжлагч, 1997-2000 онд Монгол Экспресс Титэм сонины эрхлэгч, 2003 оноос Монголын утга зохиол судлалын төвийн захирал, 2012 оноос “Төрт ёс, хаадын сан” хэмээх нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Их түүх, их хаадын сэдэв агуулгаар дагнан ажилласан 29 жилийн туршлагатай ийм хүн. Гүн-Үйлс 1991 оноос хойш уран зохиол, түүх судлал, Монгол хаадын судалгаа, нүүдэлчин соёлын чиглэлээр олон арван бүтээл туурвихын зэрэгцээ дэлхийн сонгодог зохиолч, найрагчид, гэгээнтэн, соён гэгээрүүлэгчдийн бүтээлүүдийг Монгол хэлнээ орчуулах, Монголын их хаадын намтар түүхийг судлах, ард түмнээ соён гэгээрүүлэх үйлсэд хүчин зүтгэж, 100 гаруй бүтээл туурвисан байна.

Иймд Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг Монголын олон нийтийн радио, телевизийн Үндэсний хорооны гишүүнээр томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээс хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн хэн бэ? Монгол Улсын Засгийн газрын саналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр таныг индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж Улсын Их Хурлын 2019 оны 30 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдсон Наваанпэрэнлэйн Жанцангийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон байна.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.5-д заасныг үндэслэн Үндэсний зөвлөлийн 1 гишүүний сул орон тоонд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг 2026 оны 04 дүгээр сарын 16-наас 23-ны өдрүүдэд нээлттэй зарласан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 244 дүгээр тушаалаар байгуулагдсан нэр дэвшигчийг сонгох ажлын хэсгээс Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас санал болгосон Чулуунбаатар овогтой Батцэнгэлийг сонгон шалгаргасан байна.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 сарын 29-ний өдрийн 16 дугаар хуралдаанаар Чулуунбаатар овогтой Батцэнгэлийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхийг хэлэлцэн дэмжсэн.

Батцэнгэл нь 1976 онд Улаанбаатар хотод төрсөн. 1997 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийг сэтгүүлч, 2016 онд Их засаг олон улсын их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Сэтгүүл зүйн магистр зэрэгтэй.

1997-2008 онд Монголын үндэсний телевизийн “Үдшийн хэмнэл” студийн редактор ерөнхий, редактор, захирал, ерөнхий продюсер, 2008-2012 онд Монголын үндэсний олон нийтийн телевизийн Программын хэлтсийн дарга 2012-оос 14 онд Үндэсний олон нийтийн радио, телевизийн дэд захирал, 2014-2016 онд “Монголын үнэн” сонины орлогч эрхлэгч, 2016-2018 онд “Монголын мэдээ” агентлагийн захирал, 2018-2021 онд Монголын үндэсний олон нийтийн телевизийн ийн захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай. 2025 оноос “Ди Би Эм лизинг” ХХК-ийн Захиргаа, үйл ажиллагаа хариуцсан нэгжийн захирлын албан тушаалыг хашиж байна.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.7-д заасны дагуу Засгийн газраас Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд Батцэнгэлийг нэр дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Хэрлэн гишүүн танилцуулна. Хэрлэн гишүүнийг урьж байна.

**Б.Хэрлэн:** Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас Сандагийн Од-Эрдэнэ, Дашзэвгийн Мягмарсүрэн, Маналжавын Төрманлай нарыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэрийг нь дэвшүүлж байна.

1.Нэр дэвшигч Дашзэвгэ овогтой Мягмарсүрэн 1980 онд Увс аймгийн Цагаанхайрхан сумд төрсөн 46 настай. 1998 онд Ховд аймгийн 1 дүгээр 10 жилийн дунд сургууль, 2002 онд Монгол Улсын Их Сургуулийг улс төр судлаач мэргэжлээр тус тус суралцаж төгссөн. 2006 онд Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын магистрын зэрэг хамгаалсан. Мөн 2014 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуульд улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Тэрээр 2002-2003 онд Улс төрийн боловсролын академийн Ховд дахь салбарт багш, эрдэм шинжилгээний ажилтан, сургагч багш, 2003-2005 онд Ховд их сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, 2006-2016 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Нийгмийн технологийн сургуулийн багш, 2016-2021 онд Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтын захирал, 2021-2022 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал, 2022-2025 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хүний нөөцийн албаны дарга, 2025 оноос Шинжлэх ухааны технологийн их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн профессороор одоог хүртэл ажиллаж байна.

2.Нэр дэвшигч Сандаг овогтой Од-Эрдэнэ нь 1966 онд Улаанбаатар хотод төрсөн. 60 настай. 1984 онд Улаанбаатар хотын 6 дугаар бүрэн дунд сургууль, 1988 онд Улсын Багшийн Дээд Сургуулийг физик, математикийн багш, 2001 онд Монгол Улсын Их Сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2003 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежерээр тус тус төгссөн.

Тэрээр 1988-1993 онд Соёлын төв өргөөнд дууны техникч, 1996-2012 онд “Тотал мюзик” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, 2014-2016 онд Дундговь аймгийн Засаг дарга, 2016-2025 онд Монголын уламжлалт харваачдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, 2020-2024 онд Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар тус тус ажилласан.

3.Нэр дэвшигч Маналжав овогтой Төрманлайн 1980 онд Улаанбаатар хотод төрсөн. 40 настай. 2006 онд Соёл, урлагийн их сургуулийн Радио, телевизийн дээд сургуулийг Радио, телевизийн сэтгүүлч, зураглаач мэргэжлээр төгссөн. 2016 онд Соёл, урлагийн их сургуульд Монголын телевизийн олон ангит киноны хөгжлийн асуудал сэдвээр Урлагийн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2004-2006 онд “Херо” энтертайнмент студид зураглаач, 2006-2016 онд Монголын олон нийтийн радио, телевизийн зураглаачдын албанд зураглаач, 2012-2014 онд “Монголын Алт” компанид хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, 2015-2016 онд “Шинэ дэлхий” телевизэд Зураглаачийн албаны дарга, 2016-2017 онд “Бест” студид продюсер, найруулагч, 2017-2022 онд “Эн Би Жи Кинг Монголиа” Программын албаны дарга, 2022-2026 онд “Малчин удмын хийморь” хязгаарлагдмал хариуцлагатай компанид продюсороор тус тус ажиллаж байна.

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дэд дарга, гишүүд ээ,

Эдгээр нэр дэвшигчдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэрлэн гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчдийн талаарх гаргасан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар гишүүн танилцуулна. Зулпхар гишүүнийг индэрт урьж байна

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэгт заасны дагуу олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн Сүхбаатарын Алтанцэцэг, Ванжилын Бат-Эрдэнэ, Доржсүрэнгийн Батсүх нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалт зарлаж, зарыг Улсын Их Хурлын цахим хуудсанд болон бусад олон нийтийн цахим хуудсаар нийцсэний дагуу 19 төрийн бус байгууллагаас нэр дэвшигчийн материал ирүүлсэн.

Байнгын хороо нэр дэвшигчийн ирүүлсэн хүсэлт, материалыг хүлээн авч, хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтлах зорилгоор Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас холбогдох лавлагаа, мэдээллийг авсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн бус байгууллагын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатараар ахлуулан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, А.Ганбаатар, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан шаардлага. Тухайлбал, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл

мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг Улсын Их Хурлаас нэр дэвшүүлэх тухай зохицуулалт, холбогдох шаардлагыг үндэслэн нэр дэвшигчдийн ирүүлсэн материал шаардлага хангаж байгаа эсэхийг хянан үзэж сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

Сонгон шалгалтын дүнд 19 нэр дэвшигчээс дээрх шаардлагыг хангасан 9 нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгох эрхийг хангах үүднээс Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал болгож, нэр дэвшигчдийн сонсголд оролцуулахаар ирүүлсэн. Үүнээс нэр дэвшигч Эрдэнэбилэгийн Адьяасүрэн өөрийн хүсэлтээр нэрээ татсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатарын Батцэнгэл, Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Жанчивдоржийн Билэгсайхан, Дашзэвгийн Мягмарсүрэн, Дагвадоржийн Наранцэцэг, Сандагийн Од-Эрдэнэ, Маналжавын Төрманлай, Гүнчин-Ишийн Энхбаяр, Лунаагийн Энхжин, Батболдын Энэрэлт нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нартаа хийсэн нэр дэвшигчийн сонсгол Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх, уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг, нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд, эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага, менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно гэж, 21.7 дахь хэсэгт төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж, 21.8 дахь хэсэгт нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж, Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчдээ хийх, нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай тогтоолыг баталж, нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахаар товлон сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сархдын Зулпхарыг томилсон.

Нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахаар товлосон боловч Байнгын хорооны хуралдааны ирц бүрдээгүйн улмаас хойшилсон тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар дахин товлж, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг хэвээр томилсон.

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Баярмаа, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Ц.Даваасүрэн С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Б.Найдалаа Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Ундрал, Н.Учрал, Б.Хэрлэн, Ө.Шижир, Б.Энхбаяр, Д.Энхтуяа нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана.

Тайлан, сонсголын дүнг үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана гэж заасны дагуу 2026 оны 06 сарын 30-ны өдөр сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргасныг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр нэр дэвшигчдээс Монголын үндэсний радио, телевизийг улс төрийн аливаа нөлөө, Засгийн газрын сурталчилгаанаас ангид, жинхэнэ хараат бус олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага болгохын тулд Үндэсний зөвлөлийн гишүүний хувьд ямар бодлого, бодит арга хэмжээ хэрэгжүүлэх талаар, томилсон байгууллага улс төрийн нөлөөллөөс ангид ажиллаж, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэрхэн баталгаажуулах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг 69.2 хувиар, Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Дашзэвгийн Мягмарсүрэнг 65.4 хувиар, Сандагийн Од-Эрдэнийг 73.1 хувиар, Маналжавын Төрманлайг 53.8 хувийн саналаар дэмжиж, Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатарын Батцэнгэлийг 34.4 хувиар дэмжээгүй болно.

Нэр дэвшигчдийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж буй тул Дэмбэрэлийн Өлзийбаатар, Сүхбаатарын Алтанцэцэг, Ванжилын Бат-Эрдэнэ, Доржсүрэнгийн Батсүх, Наваанпэрэнлэйн

Жанцан нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зулпхар гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Чулуунбаатарын Батцэнгэл байхгүй юм уу? Дашзэвгийн Мягмарсүрэн, Сандагийн Од-Эрдэнэ, Маналжавын Төрманлай нар хүрэлцэн ирсэн байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр түүнчлэн нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Энэ гишүүд маань олон нийтийг төлөөлөх ёстой. Гол тавигдаж тавигддаг шаардлага бол улс төрийн болон түрүүн хэлсэн бас дурдагдаж байсан Засгийн газраас хараад бас байх гээд. Өнгөрсөн хугацаанд бол бас яг энэ байдал хангагдаж чадахгүй жишээнүүд олон байж байсан. Засгийн газрын шинжтэй сонгуулийн үеэр бүх телевизийн сувгуудыг жишээлбэл бас яг энэ чиглэлээр ашигладаг ийм тохиолдлууд гарч байсан. Тэгэхээр энэ 2 удаа өмнө 6 жил бас дээр сонгогдоод дахиад сонгогдох гэж байгаа 2 хүн байна л даа. Гүн-Үйлс, Мягмарсүрэн 2.

Тэгэхээр ер нь өнгөрсөн хугацаанд жишээлбэл энэ чиглэлийн улс төрийн нам болон Засгийн газраас хараат бус, олон нийтийг төлөөлөх чиг үүргээ энэ зөвлөлд хэрхэн гүйцэтгэсэн гэж бодож байгаа талаар энэ 2 нэр дэвшигчээс асууя.

Хоёрдугаарт нь болохоор Батцэнгэл нэр дэвшигчийг Байнгын хороо дэмжээгүй байгаа. Тэгэхээр Байнгын хороо дэмжээгүй нэр дэвшигчийг 34.4 хувь гэдэг бас нэлээн бага дүн байгаа. Улсын Их Хурлаар хэлэлцэж дэмжих нь хэр зохистой юм бэ? Энэ талаар Байнгын хорооноос өөр хэн хэлэх ёстой. Батцэнгэл өөрөө нэр дэвшигч маань ч өөрөө ирээгүй юм шиг байна тээ. Тэгэхээр энэ талаар бас хэрвээ боломжтой бол Байнгын хороо дээрээс бас хариулж өгөөч.

Дээр нь Од-Эрдэнэ нэр дэвшигч энэ үндэсний өв, соёл контент экспортыг онцолсон байсан. Тэгэхээр энэ дээр энэ чиглэлээрээ бас ер нь бол сүүлийн жилүүдэд бас энэ гаднын соёлын нөлөөнүүд бас нэлээн их болж байгаа. Тэгээд Монголын үндэсний телевизийн контентын бодлого ч гэсэн бас ер нь ингээд харахаар яг энэ Монголтой холбоотой энэ чиглэлийн агуулгуудыг өшөө сайжруулах хэрэгцээ шаардлагууд байгаа. Энэ дээр Од-Эрдэнэ болон нэр

дэвшигч болон Гүн-Үйлс нараас бас энэ чиглэлээр ер нь цаашаа яаж ажиллах ёстой гэж бодож байгаа талаар нь асууя.

Дээр нь нэр дэвшигчдээс энэ зөвхөн Үндэсний телевиз гээд явахаас гадна энэ платформ маань дижитал их болоод байгаа. Тэгэхээр нэр дэвшигчдээс энэ залуучууд энэ өөр screen, телевиз үзэхээ болиод дижитал суваг руу их явж байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр ямаршуу бодлого энэ Үндэсний телевиз энэ олон нийтийн төлөөлөх энэ тал руугаа яаж энэ бодлогыг шилжүүлэх нь зөв гэж бодож байгаа талаар нэр дэвшигчдээс бас санаа, бодлыг нь сонсьё. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эхлээд нэр дэвшигчид хариулъя. Дараа нь Зулпхар гишүүн хариулъя. Нэр зааж асуусан байх аа. Гүн-Үйлс, Мягмарсүрэн, Од-Эрдэнэ. 4 номерын индэр.

**Д.Гүн-Үйлс:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Би их түүх, их хаадын сэдэв, агуулгаар дагнан ажилласан 30 шахам жилийн туршлагатай энэ “Төрт ёс, хаадын сан” гэж байгууллагыг сүүлийн 16, 7-н жил удирдаж байгаа хүн байгаа юм. Тэгэхээр яг миний өдөр тутам хийдэг ажил, судалдаг судалгаа бол яг энэ Энхтүвшин гишүүний асууж байгаа асуулттай бол шууд холбогдож байна гэж би ойлгож байна.

Тэгэхээр юуны өмнө манай Үндэсний олон нийтийн радио, телевиз бол бас олон сувагтай. Түүний дотор бол бас гадаад суваг байдаг. Юуны өмнө Монголын тухай үнэнийг, Монголын тухай түүхэн зөв, зүйтэй тэр дүгнэлтийг дэлхий бол Монголоос сонсох ёстой гэж би боддог. Түүнээс Монголын түүхийг бол ямар нэгэн гаднын шинжээчид, гаднын бас тийм туйлширсан үзэлтнүүд энийг тэгж ярьж, өөр өөрийнхөөрөө ярьж, тайлбарлаж, дэлхийд түгээх нь ихэссэн энэ үед бид энэний эсрэг бол бас баримттайгаар, их эв дүйтэйгээр энэ бүхнээ сурталчилж, таниулах нь зөв гэж би боддог юм.

Мэдээж хэрэг бидэнд бол түүхийн агуулга бол их байгаа. Гагцхүү хэлбэр дээрээ бол бид анхаарах ёстой. Мөн гишүүний хэлж байгаа тэр сүүлийн үед залуучууд телевиз үзэх нь багассан гэдэгтэй бол санаа нийлнэ. Энэ бол зөвхөн Монголд төдийгүй дэлхий нийтэд тулгамдаж байгаа ийм асуудал л даа. Залуучууд бол ер нь телевиз үзэхээс илүү утсаа л шагайгаад сууж байдаг болсон.

Тэгэхээр миний бодол бол мэдээж телевизийн контентыг сайн хийхийн сацуу тэр сайн хийсэн тэр бүтээлийнхээ зөвхөн тэр торгон агшныг жинхэнэ цөм болсон хэсгийг сонирхолтой хэлбэрээр бэлдэж, яг тэр залуучуудын сууж байгаа талбар руу нь бид өөрсдөө явж очих нь бас зөв юм болов уу гэж бодож байгаа. Тэгэхдээ энэ бол маш тийм товч бөгөөд залуучуудын сонирхол татах хэлбэрээр ингэж хийх нь зөв юм гэж би үздэг юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мягмарсүрэн, дараа нь Од-Эрдэнэ.

**Д.Мягмарсүрэн:** Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Дашзэвгийн Мягмарсүрэн байна. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Бас цаг үе болсон маш хэрэгцээтэй асуулт байна гэж ойлгож байна. Би улс төр судлаач мэргэжилтэй. Ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хувьд ялангуяа Монголын олон нийтийн радио, телевизийн хувьд тэр улс төрийн тэнцвэртэй байдлыг хангах нь

өөрөө маш чухал асуудал. Энэ мэдээллийн тэнцвэрт байдлыг ялангуяа улс төрийн тал дээр аль нэг тал руугаа хэлбийдэг талаар бас судалгааны дүнгүүд харж байсан. Тэгэхээр бас судалгааны дүнгүүд худлаа хэлдэггүй байх. Энэ тал дээр бас мэргэжлийн үүднээс олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд бас тодорхой хяналт тавьж ажиллана гэж бодож байна.

Хоёрдугаарт нь орчин үеийн залуучууд ер нь бол бүх насныхан өөрөө уламжлалт мэдээллийн хэрэгслээс нэлээн татгалзаад эхэлчихлээ. Ялангуяа сошиал медиа бол маш чухал үүрэгтэй болчихсон. Энэ маань өөрөө бас зарим сөрөг талуудыг бий болгож эхэллээ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Д.Мягмарсүрэн:** Тэгэхээр Монголын үндэсний радио, телевизийн хувьд энэ дижитал болон цахим агуулга контентын хувьд бас шинэлэг хэлбэрүүдийг өөртөө шингээх энэ боломжууд дээр бас анхаарч ажиллана. Би өөрөө “Монголын гээгдсэн түүх” подкастын хөтлөгч хийдэг. Тэгээд тэрхүү туршлагаа бас энэхүү Олон нийтийн үндэсний телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийхээ хувьд бас туршлага, мэдлэгээр дайчлан ажиллана. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Од-Эрдэнэ.

**С.Од-Эрдэнэ:** Сандагийн Од-Эрдэнэ байна. Ингээд энд байгаа эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Олон нийтийн радио, телевиз гэдэг бол Монгол Улсыг бас гадаад улсуудад, дэлхийд сурталчлах гол платформ гол цэг гэж бол ойлгодог. Тэгэхлээр Монгол улс бол юуны түрүүнд өөрсдийн үндэсний өв соёлоороо бас ялгарч, орчин үед энэ энэ залуучуудын ялангуяа хойч үеийн маань авч үлдэх гол юм бол энэ үндэсний соёл, спорт, бүх энэ уламжлалыг бол хойч үедээ үлдээх энэ контентуудыг бэлдэх нь бол чухал байгаа. Тийм учраас үндэснийхээ соёлоор бид бүхэн бас онцгойрч ингэж бол ялгарах үүргийг биелүүлэх нь манай бас олон нийтийн радио, телевизийн гол үүрэг гэж ойлгодог.

Миний бие хөдөө орон нутагт Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга хийж байсны хувьд бол.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**С.Од-Эрдэнэ:** Орон нутагт байгаа маш олон авьяастан, өв уламжлалууд байдаг. Энийг бид бүхэн бас ил гаргаж олон нийтдээ сурталчлах8 гадаад улсад бас Монгол улсыг сурталчлах нэгэн өвөрмөц хэв маяг болгох нь зүйтэй. Үүний тулд бас олон нийтийн радио, телевизийн бас нөөц бололцоо асар их санагддаг. Тэнд байгаа маш олон студи, өрөөнүүдийг бид бүхэн энэ хувийн хэвшлийн залуучууд, хиймэл оюун ухаантай холбох энэ үндэсний соёл, өв уламжлалаар дагнаж үйл ажиллагаа явуулж байгаа студиудийг олон нийтийн телевизэд байрлуулах, тоног төхөөрөмжөөр хангах энэ ажлуудыг зохион байгуулснаар бас манай энэ өнөөдрийн контентуудын чанар сайжрах, энэ уран бүтээлчдийн бас чадавх сайжрах байх аа гэдэг дээр онцгойлж ажиллана гэж бас бодож байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгээд баахан хувийн компаниудыг аваачаад тийш нь ажиллуулах гээд байгаа ... арай өөр өнцгөөс яриад байна шүү. Дараагийнх нь.

**М.Төрманлай:** Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэнд хүргэе. Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз нь өөрийн гэсэн онцлогтой олон нийтэд үйлчилдэг байгууллага. Тэгээд ер нь энэ төлөвлөгөөний хувьд ярихад хүүхдийн хүмүүжил, боловсролд чиглэсэн нэвтрүүлгийн төрөл, цагийг нэмэгдүүлэх, үндэсний өв соёлыг, хойч үедээ өвлүүлэн үлдээх, цуврал баримтат, уран сайхны нэвтрүүлэг хөтөлбөрт тусгуулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, амьдрах ухаан сургасан нэвтрүүлгийг хөтөлбөрт бас оруулахыг ажиллах болно.

Мөн энэ үндэсний олон нийтийн телевиз нь өөрийн гэсэн ийм алтан сан хөмрөгтэй байдаг. Энийг бас өв соёлоо тээх, үлдээх үүднээс энэ сошиал, цахим орчинд энийг үе шаттайгаар тавина гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зулпхар гишүүн. Нэр дэвшигч нар болчихсон бил үү? Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сонсгол зохион байгуулагдаад сонсголын би дүгнэлтийг Байнгын хороонд танилцуулсан Төрийн байгуулалтын. Төрийн байгуулалтын байнгын хорооноос, Засгийн газраас санал оруулж ирсэн нэр дэвшигч Чулуунбаатарын Батцэнгэлийг Байнгын хорооны жишээ нь гишүүдийн 34.4 хувь дэмжээгүй ийм дүн гарсан.

Хяналт шалгалтын тухай хуулийн 111.2-т нэгдсэн хуралдаанд эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батлагдсанд тооцно гээд ийм журамтай юм байна. Тэгээд энэ журмын дагуу Байнгын хороо бол жишээ нь Чулуунбаатарын Батцэнгэл нэр дэвшигчийн энэ санал хураалгахаар нэрсийг нь оруулж ирсэн байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулъя. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Тэгэхээр Батцэнгэл нэр дэвшигч дээр санал хураалт явагдана гэсэн үг үү? Өөрөө ирээгүй байна. Тэгээд санал хураалт явагдах уу? Эсвэл дэмжигдээгүй учраас санал хураалт явагдахгүй юу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Зулпхар гишүүн. Яг ямар санал оруулж ирж байгаа юм?

**С.Зулпхар:** Одоо хуульд заасны дагуу Улсын Их Хуралд ажлаас шууд тайлагнан хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалыг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журмын дагуу бол энд бол санал хураалт явагдаж таарахаар байна. Санал хураалт явагдана.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржзовдын Энхтуяа гишүүн.

**Д.Энхтуяа:** Би энэ байгууллагатай ер нь бага наснаасаа эхэлж холбогдсон. Залуудаа ажиллаж байсан бас энэ байгууллагын удирдлагаар бас олон жил ажиллаж байсан учраас үе үеийн Үндэсний зөвлөлийн гишүүдэд бол хүндэтгэлтэй

ханддаг. Томилогдоод ирдэг. Ер нь бол 2005 онд энэ анх Олон нийтийн радио, телевизийн хууль батлагдсанаас батлагдсаны дараа томилогдсон Үндэсний зөвлөл бол хамгийн чанартай, тухайн үед яг хууль дээр байгаа улс төрөөс хараат бус энэ байгууллагыг яг тэр хуульд зааснаар нь чиглүүлж явах ийм анхны удирдах зөвлөл, Үндэсний зөвлөл бол байгуулагдаж байсан юм.

Тэгээд намайг энэ Үндэсний олон нийтийн радио, телевизийн удирдлагаар ажиллаж байхад ерөнхийдөө улс төрийн маш их том томилгоонууд орж ирдэг. Одоо ч гэсэн бид нар бие биеэсээ нуугаад яах вэ ерөнхийдөө бас бие биеийгээ хуурсан ийм үйл ажиллагаа явагдаад л өөд өөдөөсөө худлаа яриад л ингээд сууж байна. Тийм учраас надад бол яг нэр дэвшээд ороод ирсэн энэ хүмүүс дээр тэр нь ийм энэ нь ийм гэх тийм зүйл алга.

Тэгээд яах вэ саяын энэ нэр дэвшигчдийн асуултад хариулж байгааг ингээд харахад бол та бүхэн яг энэ 2005 онд батлагдсан Үндэсний олон нийтийн радио, телевизийн хуулиа сайн уншсан юм уу? Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн бол тухайн байгууллагын дотоод үйл хэрэгт, үйл ажиллагаанд оролцдоггүй. Уран бүтээлийн ямар нэгэн хандлагаар тэнд нөлөөлөх боломжгүй. Энэ байгууллагыг хууль, эрх зүйн хувьд яаж паблик болгох вэ, хууль дээр нь ямар өөрчлөлт оруулах вэ, санхүү мөнгийг нь яаж төвлөрүүлэх вэ гэдэг дээр л та бүхэн төсвийг нь баталж өгдөг ийм л статустай ийм удирдах үндэсний зөвлөл байдаг юм аа.

Гэтэл та бүхэн өөрсдийнхөө яг мэргэжлээрээ тийм уран бүтээл хийнэ тэгнэ ингэнэ гээд. Яг тэр уран бүтээлийг паблик хэлбэрээр нь тэнд байгаа 600 намайг ажиллаж байхад 600 ажилтантай байсан. Бүүр намайг залуудаа ажиллаж байхад 1500 ажилтан, уран бүтээлчдээс энэ хүмүүс чинь мэргэжлийн хүмүүс бүгдийг нь хийгээд явчихдаг юм. Та нартай та наргүй тэр бүх паблик өв уламжлал юу байдаг юм хүүхдийн нэвтрүүлэг, байгаль, экологи гээд бүгдийг нь хийгээд явах ийм чадамжтай ийм хамт олон байгаа. Тийм хамт олон та бүхнийг хүлээж авна. Харин та бүхэн тэнд очиж улс төрийн нөлөөллийг хийхгүйгээр тэр хүмүүсийг яг л өөрийнх нь тэр чадвараар нь тэр байгууллагыг хуулийн хүрээнд нь үйл ажиллагаа явуулахад нь л дэмжлэг үзүүлэх ёстой байхгүй юу даа.

Гэтэл та бүхэн тийм ч уран бүтээл хийнэ. Би тэгнэ ингэнэ гээд өөрийнхөө үзэмжээр ингээд тайлбарлаад байгаа чинь буруу байна шүү. Тийм учраас надаа бол миний л асуулт байна. Гүн үйлс хуульч бас хуулиа уншсан байх гэж найдаж байна. Энэ хуульд 2005 онд батлагдсанаас хойш энэ хуульд бол өөрчлөлт оруулаагүй. Энэ телевиз бол яг улс төрийн нөлөөллөөс паблик телевиз бас болж чадаагүй байгаа. Тэгэхээр энэ хуульд өөрчлөлт оруулах уу, ер нь та энийг судалж үзэв үү, хуулийг нь уншив уу? Өнөөдрийн нөхцөл байдал ямар байна вэ? Ийм л асуулт асууя. Тэгээд орж ирээгүй хүмүүс

**Ж.Бат-Эрдэнэ:** Бүгдээс нь асууж байна уу? Энхтуяа гишүүний бас хэлдэг санааг бол би бас түрүүн хэлээд байгаа шүү дээ. Хандлага чинь арай ондоо юм уу гэж ажиглагдаад байна шүү гэж. Бүгдээрээ хариулъя саяын Энхтуяа гишүүний асуусан асуултад.

**Д.Гүн-Үйлс:** Энхтуяа гишүүнд баярлалаа. Хууль уншсан. Уншилгүй яах вэ тийм бүгдийг нь нэг бүрчлэн уншсан, танилцсан. Ер нь бол санал нэг байна.

Мэдээж хэрэг Үндэсний зөвлөлийн гишүүн бол яг энэ байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог менежер маягийн үүрэг гүйцэтгэх ёсгүй. Энэ бол зөвхөн бодлого тодорхойлох, төсөв мөнгөн дээр бас анхаарах, батлах ийм үйл ажиллагаа явуулдаг.

Мэдээж хэрэг жишээлбэл, телевизийн гүйцэтгэх удирдлага болон уран бүтээлчдийн дунд, сэтгүүлчдийн дунд ямар нэгэн үл ойлголцол, зөрчил гарлаа гэхэд тэрийг шууд зохицуулах нь бол үндэсний зөвлөлийн үүрэг биш. Харин тэр зөрчил, үл ойлголцол гараад байгаа суурь шалтгааныг хэрхэн байхгүй болгох вэ гэдэг дээр бол гүйцэтгэх удирдлагад бас бодлогын дэмжлэг үзүүлж, зөвлөх тийм боломжтой байгууллага гэж би харж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Д.Мягмарсүрэн:** Мягмарсүрэн байна. Санал нэг байна. Үнэхээр хуулийг бас боломжоороо судалсан. Батлагдаад 21 жил болж байна. Энэ хугацаанд өөрчлөлт ороогүй. Дэлхий дахинд 150 орон олон нийтийн радио, телевизтэй юм байна. Үүнээс 110 орон өөрийн гэсэн олон нийтийн радио, телевизийн хуультай тэгээд тэрний нэг маань бас Монгол улс. 20 гаруй жил өөрчлөгдөөгүй энэ хуульд бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг цаг үеийн хэрэгцээ шаардлагууд бол үүссэн. Тэгж байж энэ бас олон нийтийн радио, телевиз бас нэлээн чөлөөтэй амьсгалах боломжуудыг нээж өгөх тийм цаг үе ирсэн, ирсэн тул тулгарчихсан байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээрээ бас Үндэсний зөвлөлийн гишүүн бас яг хууль дээр. нийтдээ 10 эрх, үүрэгтэй юм байна лээ. Тэгээд тэр үүргийнхээ хүрээнд ажиллана. Мэдээж бас боломжийн хэрвээ болом боломж байгаа бол тэрхүү хуульд өөрчлөлт оруулах тодорхой саналуудыг бас боломжоороо гаргана. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.

**С.Од-Эрдэнэ:** Олон нийтийн радио, телевизийн тухай хууль бол бүх үйл ажиллагаа бол бас хараат бус байх ёстой. Гагцхүү бас олон нийтэд үйлчлэх энэ зарчим, хуулийн зарчмын дагуу бас Энхтуяа гишүүний гаргаж байгаа бас түрүүний саналтай бол санал нэг байгаагаа хэлье. Түрүүний бас уран бүтээлийн талаар, өв уламжлалын талаар гаргаж байгаа санал маань бол нөгөө Энхтүвшин гишүүний бас асуултад бодлогын хувьд хандаж байгаа хандлагаа бол бас илэрхийлсэн болно. Ингээд хуулийн дагуу ажиллахад бэлэн байх болно гэдгээ илэрхийлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Микрофон нээлттэй байна.

**М.Төрманлай:** Хуулийн дагуу Монголын үндэсний радио, телевиз нь үндэсний мэдээллийн гол сүлжээ. Тиймээс энэ төсвийн хувьд энэ байгууллага иргэдээс айл өрх бүрээс хураамж авдаг сардаа 1 удаа. Засгийн газраас дэмжлэг үзүүлдэг. Өөрсдийн үйл ажиллагааны орлогын төсвөө бүрдүүлдэг газар байгаа. Энэ байгууллагын төсвийн зарцуулалтыг хяналттай зөв, ил тод байлгахад Үндэсний зөвлөлийн гишүүн анхаарч ажиллах ёстой гэж боддог. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтуяа гишүүн.

**Д.Энхтуяа:** Тэгээд Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдоод тэгээд очоод тэгээд тэр байгууллагыг багахан шиг бас бужигнуулаарай. Тэр байгууллагын тэнд байгаа уран бүтээлчид бүгдээрээ чадварлаг Монголын энэ өв соёл, хэвлэл мэдээллийн салбарын мэдээ мэдээллийг бол яг ингээд хийгээд, зохицуулаад яваад ирчихсэн ийм хамт олон байгаа. Хамгийн гол нь удирдлагын баг Үндэсний зөвлөлтэйгөө нийлээд маш их бужигнуулдаг. Өнгөрсөн хугацаанд нуугаад яах вэ ер нь бол том том хувьсгалууд би кавычкид хэлж байна хувьсгалууд их гардаг. Тийм учраас та бүхэн эв нэгдлийг хангаж ажиллах тал дээр анхаарч ажиллаарай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн.

**Ө.Шижир:**Нэгдүгээрт сая өмнө хэлд хэлэлцсэн Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр миний нэр уг нь жагсаалтад байсан. Та намайг алгасан уншчихлаа. Дахиж битгий ингээрэй. Шууд Түвшин, Мөнхбаясгалан гээд явчихна лээ. Хүлээгээд байсан юм.

Хоёрдугаарт өнгөрсөн, өчигдөр8 өнөөдрөөр Ардчилсан намын бүлэг нийтдээ 4 хуулийн төслөөс санал авах тухай, завсарлага авах тухай санал гаргасан. Эхлээд Улаанбаатар хотын газар олголтыг Монгол Ардын нам Улаанбаатар хотын газар олголтыг хянан шалгалтын түр хороог байгуулах тухай асуудал дээр Монгол Ардын нам завсарлага авахад 3 хоног өгсөн буюу намрын чуулган шийдвэрлэсэн. Ардчилсан намын бүлгээс Орон сууцын банк, Орон сууцын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Монголбанкны томилгоо гээд асуултуудаар завсарлага авахаар 1 цаг өгдөг. Ийм ялгавартай байдлыг ахиж битгий гаргаарай. Та нар мөнх энэ наад суудал дээрээ суугаад, мөнх Улсын Их Хурлын даргыг, Засгийн газрыг удирдахгүй шүү. Энэ байдал өөр дээр чинь ирэх бий. Битгий ингэж ялгавартай хандаж завсарлага өгч бай. Энэ чинь муухай харагдаж байна. Ямар намынхан, өөрийнх нь намын бүлэгт 3 хоног өгөөд Ардчилсан намын бүлэгт 1 цагийн завсарлага өгдөг бол доромжлол шүү. Улаанбаатар хотын газар хэрхэн яаж олгогдсон, яаж хэн хэн хулгай, луйвар хийж авсныг нь ярьа гэхээр 3 хоногийн завсарлага өгөөд хаячихдаг байж болохгүй.

Тэгээд энэ үндэсний телевизээс орж ирж байгаа хэдэн гишүүд хүмүүсээс хэдэн асуулт асуух гэсэн юм. Олон нийтийн радио, телевиз гээд нэртэй. Яг олон нийтийн радио, телевиз байж чаддаг уу гэдэг асуулттай. Айл болгоноос 1200 төгрөг авдаг. Тэгсэн мөртөө яг олон нийтийн радио, телевизийн буюу олон нийтийнхээ эрх ашгийг хангаж чаддаг уу? Чаддаг уу, чаддаггүй юу, тийм, үгүй хариулт. Хэрвээ тийм бол яаж хангасан юм? Үгүй бол яагаад хангахгүй байгаа юм? Хариулт нь.

Дараагийнх нь нэгэнт л олон нийтийн радио, телевиз л юм бол та нар Засгийн газрыг огцруулах тухай, Сүхбаатарын талбай дээр тэтгэвэр нэмэхээр зогсож жагсаж байгаа 2 сарын яг ордны баруун хаалган дээр 2 сар шахуу сууж байгаа ахмадын тухай эд нарын тухай яагаад мэдээ, мэдээлэл бэлтгэдэггүй юм бэ? Энийг юу гэж бодож байгаа юм бэ? Олон нийтийн асуудал чинь бол энэ мөн шүү дээ. Яагаад үнийн өсөлт, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт ийм өндөр байгаад байгаа юм? Яагаад махны үнэ буурахгүй байгаад байгаа юм? Яагаад ахмадууд гадаа тэтгэвэр нэмээч гээд 2 сар суугаад байгаа юм? Яагаад Засгийн

газрын шүүмжилсэн иргэд талбай дээр гарахаар тэрийг мэдээ, мэдээллийг нь гаргахгүй байгаа юм? Үнэхээр энэ дээр та хэд яг өөрсдийнхөө бодлыг хэлээдхээч.

Хоёрдугаарт та нар энэ нэг нь ирээгүй байна. Нөгөө Бат-Эрдэнэ дарга хурал дарга нар чинь нөгөө чуулганы танхимд хүндэтгэн өөрийн биеэр оролцох ёстой гэдэг хуулийн заалт чинь хааччихав? Тэгээд ирээгүй хүн дээр нэгдүгээрт санал хураах юм уу чуулганы танхимд?

Хоёрдугаарт ер нь энэ яг Үндэсний олон нийтийн телевизийг яаж та хэд олон нийтийн болгох юм? Хөрөнгө, санхүүгийн ил тод байдлыг нь яаж бий болгох юм? Үнэхээр яг иргэдийн мэдэх эрхийг олон нийтийн радио, телевизийг нь хангаж чадаж байгаа юм уу гэдэг ийм асуултаар би энэ хариултуудаа авах гэсэн юм. Тэгээд Бат-Эрдэнэ дарга дахиж битгий хүний нэр алгасаж уншаарай. Та Ардчилсан намын бүлгээс ирсэн бичгээ хараарай. Миний микрофон асаад тэр дээр нэр байж байсан шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Уучлаарай таны нэр байсныг ёстой анзааралгүй алдаа гаргаж тэгвэл. Та тэгээд гар өргөөд хэлчихгүй яав даа. Гар өргөөд хэлчихгүй. Би тэгээд тэр болгоныг чинь бас уншихад чинь алдах юм байна шүү дээ. Уучлаарай. Нэг бүрчлэн хариулъя. Бүгдээс нь асуусан уу? Бүгдээрээ хариулъя саяын 2, 3 асуулт байх шиг боллоо.

**Д.Гүн-Үйлс:** Баярлалаа. Тийм ээ, энэ ард түмэн, өрх айл бүхэн яг тухайн Монголын олон нийтийн радио, телевизийг үздэг, үздэггүйгээс үр үл шалтгаалан төлбөр, хураамж төлдөг. Юу их шударга болох вэ гэхээр тэд бид яг юуны төлөө энэ татвар, хураамжийг төлж байгаа юм бэ гэдгээ мэдсэн байх ёстой. Түүнийгээ үзээд тодорхой хэмжээнд бас ард түмний эрх ашгийг хамгаалсан яг тэнцвэртэй тийм мэдээллийг бид харж байна гэдэгтээ бол сэтгэл хангалуун үлдсэн тийм нөхцөлд энийг татвар, хураамжаа төлөх юм бол тэд бол энэ нөхцөл байдалтай эвлэрнэ. Хэрвээ тэгэхгүй бол мэдээж хэрэг эвлэрч чадахгүй л дээ.

Нөгөө талаас гэвэл ер нь Үндэсний олон нийтийн радио, телевиз гэдэг утгаараа бүх мэдээллийг тэнцвэртэй явуулах нь зөв юм гэдэг дээр би энэ гүйцэтгэх удирдлагыг би бас шахаж ажиллана гэж бодож байна. Үндэсний олон нийтийн радио, телевиз гэдэг бол аль ч нам гарсан тухайн намыг, тухайн Засгийн газрыг дэмжиж тэгж нэвтрүүлэг хийж бол болохгүй. Илт давуу байж бол болохгүй гэсэн үг. Тэгэх юм бол ямар нэгэн намын олон нийттэй харилцах алба гэдэг юм уу, хэвлэлийн мэдээллийн алба шиг болж хувирна. Тэгэхээр ард түмний телевиз гэдэг утгаараа энэ бол бүх мэдээлэл бол тэнцвэртэй байх ёстой гэж би өөрөө үздэг хүн.

Миний хувьд ухамсарт амьдралд өөрөө ажил хөдөлмөрийн гараагаа эхлээд их уран бүтээлээ хийж эхэлснээс хойш яг энэ улс төртэй бол огт холбогдож үзээгүй. Миний гол баримталдаг зарчим бол ард түмний маань эв нэгдэл юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр би хамгийн гол нь анхаарч ажиллана. Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз бол эв нэгдлийн дуу хоолой байх ёстой гэж би үздэг юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дараагийн нэр дэвшигч.

**Д.Мягмарсүрэн:** Мягмарсүрэн байна. Тэгэхээр бусад улс орнуудад олон нийтийн радио, телевизийг санхүүжүүлдэг бас хэд хэдэн хувилбар байдаг юм байна. Нэгдүгээрт бол төрийн дэмжлэг, төрөөс санхүүждэг, мөн иргэдийн хураамжаар гэсэн 2 үндсэн үндсэн загвар байдаг. Эндээс Монгол Улс аль алийг нь хослуулсан ийм санхүүжилтийн загвартай нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ 1200 төгрөгийн хураамж бол бас нэлээн эртний нэлээн эрт үйлчилж байсан энэ хураамж бас. Магадгүй тодорхой инфляцтай холбоотой, эдийн засгийн асуудлуудтай холбоотой энэ хураамжийг магадгүй өсгөх шаардлагууд бас гарч байна гэж бодож байна. Тэр тусмаа олон нийтийн хураамж өндөр байгаад төрийн дэмжлэг бага байх тусам Засгийн газраас хараат бус байх боломж нь өндөрсөх, өсөх боломжтой гэж ойлгож байна. Зарим улсад бол тухайлбал, Үндэсний радио, телевизийн хураамж нь тухайн иргэний үүрэг байдлаар хуульдаа тусгагдсан байдаг. Тэгэхээр магадгүй бид нарын хувьд бас Монгол Улсын хувьд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя.

**Д.Мягмарсүрэн:** Тэгэхээр Монгол Улсын хувьд бас 21 жил болсон энэхүү хуульдаа бас тодорхой өөрчлөлтүүдийг хийж байж энэхүү бие даасан байдлуудыг дахин өргөжүүлэх боломжууд гарч ирнэ гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**С.Од-Эрдэнэ:** Товч бас тодорхой хариулъя гэж бодож байна. Өнөөдрийн бас үндэс олон нийтийн радио, телевизийн мэдээллийн тэнцвэртэй байдал бол ийм хангалттай биш түрүүн Шижир гишүүний бас хэлж байгаагаар алдагдсан байдал байгаа. Тэгэхлээр энэ олон нийтийн радио, телевизэд, энэ Үндэсний зөвлөл орсноороо энэ байдалд бас анхаарч ажиллана.

Татвар шимтгэлийн тухайд бол шинэчлэл зайлшгүй шаардлагатай. Энийг хууль тогтоогч нар мэдээж хэрэг түрүүний хэн ярьж байгаагаар энэ 2 хосолмол системийг улам зохицуулалтыг сайжруулах талаар зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай байгаа гэсэн бодолтой байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дараагийн нэр дэвшигч.

**М.Төрманлай:** Үндэсний олон нийтийн радио, телевиз нь ялт ч үгүй ийм хараат бус байх ёстой улс төрөөс. Тэр ч үүднээсээ мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах зүйтэй. Тэгээд үнэхээр Үндэсний зөвлөл бол ялт ч үгүй хяналт тавьж бодлого хийх ёстой. Тэр үүднээсээ журамдаа татвар татвар биш хураамжийн хувьд 1100 төгрөг байгаа. Энийг журамдаа 1 доллар гэж заасан байгаа учраас өнөөгийн энэ ханшийн дагуу бас ер нь хураамжийг бас ер нь нэмж илүү их энэ нэвтрүүлэг хийхэд, энэ телевиз хөтлөхөд үйл ажиллагаа явахад төсөв их шаардлагатай байдаг учраас энийг их зөвөөр шийдвэрлэж ажиллана.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Асуултаа буруу ойлгоод яваад өглөө. 1200 төгрөг олон нийт төлж байгаа учраас олон нийтийн радио телевиз байж чадаж байгаа юу гэж хэлсэн

шүү дээ. Айл өрх болгон автоматаар тогны мөнгөн дээр нэмж аваад байна шүү дээ. Тэгтэл та хэд маань 1200 төгрөгөөр нэмнэ гээд яваад өглөө анхнаасаа.

Мягмарсүрэн бол бүр нэмээд бид нар хараат бус байдлыг бий болгоно гэж байна шүү дээ. Үгүй шүү дээ. Та хэдийн үүрэг бол юу вэ гэхээр олж байгаа орлогоо яаж татвар төлөгчдийн, айл өрхийн тогны мөнгөн дээр нэмж автоматаар авахгүйгээр яаж санхүүгийн болон үйл ажиллагааг нь зөв менежментээр хийх гэж ёстой шүү дээ. Компаниар бол ТУЗ шүү дээ. Тэгээд компаниар ярих юм бол ТУЗ-ийн гишүүд нь ажилчдаасаа авч байгаа нийгмийн даатгалын шимтгэлээ нэмнэ гэж байгаатай яг адилхан үг ярьчихлаа шүү дээ. Тэгээд 1200-г нэмээд тэд болгох гэж байгаа юм? Сая энэ нэмнэ гэсэн Мягмарсүрэн гээд нэр дэвшигч хэл дээ. Та нэмнэ гэж хэлж байна шүү дээ. Нэмээд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хараат бус байдлыг хадгална гэж байна. Улс төрийн томилгоогоор бүгд л томилогдож байгаа шүү дээ та нар бүгдээрээ. Тэгээд яаж хараат бус байх юм?

**Ж.Бат-Эрдэнэ:** Мягмарсүрэн.

**Д.Мягмарсүрэн:** Мягмарсүрэн. Шижир гишүүний асуултад хариулъя. Яах вэ миний санаа бол манайх холимог загвартай төрөөс тодорхой санхүүжилтийг олгодог Засгийн газраас. Тэр тусмаа эрх баригч Засгийн газар, эрх баригчдаас тэрхүү хяналтад орох боломж маань тэр төрийн санхүүжилтээсээ шалтгаалаад байна. Ийм учраас олон нийтийн хураамжийг нь харьцангуй өндөр болгоод төрийн дэмжлэгийг нь санхүүжилтийг нь хязгаарлаж байж энэ бие даасан байдал эрх баригчдаас хараат бус байх боломж илүү өндөрсөнө. Мөн мэдээж олон нийтийн хураамжийг өсгөхтэй холбоотой Үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох болон бусад бүтцийн асуудлуудыг хуулиар бас шийдвэрлэх боломж бол давхар гарч ирэх байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүн нэмэх үү? Отгоны Саранчулуун.

**О.Саранчулуун:** Юуны өмнө нэр дэвшигчдэд амжилт хүсье. Надад тодруулах хэд хэдэн асуудал байна.

Нэгдүгээрт нь олон нийтийн радио, телевизийн хэрэглэгчийн судалгаа гэж байдаг байх тээ? Тэн дээр ер нь хүн амын бүлэг, насны бүлгээр ямар хүмүүс илүү үздэг юм бэ? Тэрний мэдээлэл. Аль нэвтрүүлэг, томоохон нэвтрүүлэг контент нь хамгийн их үзэлттэй ийм нэвтрүүлэг байдаг юм? Тэн дээр ер нь ямар дүн мэдээ байдаг вэ? Сүүлийн 5 жилд ч гэдэг юм уу.

Гуравдугаарт нь болохоор тэр нөгөө айл болгоноос төлж байгаа 1200 төгрөгийг төлж байгаа. Гэхдээ би жишээлбэл миний дохионы хэлээр ярьдаг найзууд маань, харааны бэрхшээлтэй найзууд маань бол тэр 1200 төгрөгийг бусадтай адилхан төлдөг мөртөө ерөөсөө мэдээлэл авч чаддаггүй байхгүй юу. Яагаад гэвэл орчуулга байхгүй байдаг. Ганцхан мэдээ л орчуулгатай байдаг тээ? Тэгэхдээ хүн болгон дохионы хэл мэддэггүй л дээ. Олдмол бэрхшээлтэй болсон хүмүүс бол бүүр хэцүү. Тэгэхээр энэ дээр ер нь ингээд хүртээмж дээр жишээлбэл ямар өөрчлөлт хийе гэж, хийе гэвэл ер нь ямар юм байх вэ? Би нөгөө та хэдийн материалыг үзэхээр тийм ч юм алга л даа. Ер нь ийм байвал аймаар гоё байхгүй юу. Би энэ олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр

ажиллах гэж байгаа ийм хүн байна. Миний мөрийн хөтөлбөр ч юм уу, төлөвлөгөөнд би энэ үзэлт, үзэгчид, хэрэглэгчдийн хувьд ийм бүлэг хүмүүс байна, хүртээмжийг сайжруулна ч гэдэг юм уу, эсвэл нийт контентын тодорхой хувийг ийм хүртээмжийн агуулгатай хийе гэсэн юм орж ирдэг бол мөн ч сайхан даа.

Улсын Их Хурлаас томилогдож байгаа ер нь аливаа албан тушаалтай ер нь хүмүүсийг ингээд танилцуулан харахаар ер нь л тийм юм байхгүй шүү. Ерөөсөө байхгүй. Тэгэхээр байлгахын тулд иймэрхүү зарчмын болон хүний эрхийн гэх юм уу ийм асуудлууд дээр ер нь яаж хандаж байна ямар төлөвлөгөө байна? Эсвэл байж болох юм? Энэ дээр та хэд маань ингээд юу гэж бодож байгаа тухай мэдээлэл өгөөч. Би тэгээд дараа нь бас тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя бүгдээрээ.

**Д.Гүн-Үйлс:** Баярлалаа. Ер нь яг ямар нэвтрүүлгийг үзэгчид хэдэн хувьтай үзэж байгаа вэ гэдгийг бол би яг үнэнээ хэлэхэд энэ талын мэдээлэл надад байхгүй байна. Мэдээж хэрэг Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдсон нөхцөлд энэнтэй эхний ээлжид би танилцана. Ямар ч нөхцөлд Монголын үндэсний радио, телевизээр явж байгаа энэ бүх нэвтрүүлгүүд энэ олон ургалч үзэл зонхилсон энэ нийгэмд аль болох тийм үнэн зөв, баталгаатай талыг нь барих ёстой гэж бодож байгаа.

Жишээлбэл, би өөрөө түүх судлалын талын хүн учраас өнөөдөр чинь сайн дурын түүхчид бол маш их олноор гарч ирсэн тэдэнд бол тодорхой хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн түүхчдийн шалгуурыг бас дамждаг тийм тогтолцоо байх нь зөв юм болов уу гэж үзэж байгаа.

Өмнө Шижир гишүүний асуусан асуултад нөхөөд хариулахад яг 1200 төгрөг тэр тухай бол би тухайлан хэлээгүйгээ би бас энэ ташрамд хэлье. Ер нь энэ 1200 төгрөгийн татвар хураамжийг ихэсгэх, багасгахын тухайд бол бас л тодорхой хэмжээнд ард түмний өөрсдийнх нь саналыг гэдэг юм уу даа саналыг бид авах ёстой. Бид ийм хэмжээний нэвтрүүлгийн контент үзээд ийм мөнгө төлмөөргүй байна гэж болно. Нэг бол та нар нэвтрүүлгээ сүүлийн үед сайжруулж байна, бол арай өөрчлөгдөж байна, шинэчилж байна энэний төлөө бид хэд хэд байдаг юм 100, 1000 ийм мөнгө нэмэхэд бол болж байна гэсэн тийм гэх мэтийн чухам яг процесс нь ямар байдаг юм, концепц нь ямар байдаг юм би мэдэхгүй байна тийм санал асуулгын маягтай ер нь хүмүүсийн нэг ёсондоо гүйцэтгэх удирдлага юм уу, нэг бол Үндэсний зөвлөл энийг бол шийдэх бололцоогүй л дээ. Тийм ер нь ард түмний өөрсдийнх нь хүсэл, сонирхолд л бид чиглүүлж ярих ёстой. Тэгээд хамгийн гол нь бид юу үзсэнийхээ төлөө ямар оюуны хөрөнгө оруулалтыг өөртөө хийж байгаагийнхаа төлөө энэ мөнгийг төлж байгаа юм бэ гэдгээ л ард түмэн маш сайн мэдсэн байх ёстой гэж би бодож байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дараагийнх.

**Д.Мягмарсүрэн:** Мягмарсүрэн Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Яах вэ яг Монгол Улсын хувьд мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн төлөөллөөрөө хэрхэн үздэг талаар судалгаа хараагүй. Тэгээд зүгээр олон улсын түвшинд уламжлалт мэдээллийн хэрэгсэл, тэр дотроо телевиз, радио, сонин

бүгдээрээ ер нь бол үзэлт буурч байгаа. Тэгээд тэр зүй тогтол бас Монгол улсад үйлчилж байгаа болов уу гэж бодож байна.

Гишүүдийн хувьд өмнө нь мэдээллийн тэнцвэрт байдал дээр бас нэлээн чухал асуултуудыг асуусан. Саранчулуун гишүүний хувьд мэдээллийн хүртээмжтэй байдлын талаар бас маш чухал цаг үеийн бас тодорхой хуулийн өөрчлөлтүүд хийх шаардлагуудыг бас асууж байна. Үндэсний зөвлөлийн гишүүд өөрөө салбаруудын төлөөлөл болж орж ирж байгаа. Энийг бас тодорхой хуулийн өөрчлөлт хийгээд хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөгөө нийгмийн төлөөллүүдийг хангах боломжуудыг бас хууль дээр өөрчлөлтүүд хийх тийм шаардлага хэрэгцээ бас байна гэж ойлгож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дараагийн нэр дэвшигч.

**С.Од-Эрдэнэ:** Бусад нэр дэвшигчдэдээ бас давхардуулалгүйгээр Саранчулуун гишүүний асуултыг болохлоор энэ бас хүртээмж, авч чадахгүй байгаа иргэдэд бас ямар арга замаар хүртээмжийг нэмэгдүүлэх вэ гэдэг талаас нь бас хариулъя гэж бодлоо. Олон нийтийн радио, телевиз маань радиогийн 3 суваг, 5 телевизийн сувгаараа мэдээлэл дамжуулж байгаа. Тэгэхлээр энэ сувгуудынхаа бас зориулалт, гадаад суваг, спортын суваг гэдэг шиг бас энэ хүртээмжийг нэмэгдүүлэх талаасаа зохион байгуулалт, мөн бас хуулийн зарим зохицуулалтыг хийлгэх санал дээр бид бүхэн бас ажиллаж хууль тогтоогчид хүрэх замаар энэ асуудлын зохицуулалт хийх нь зүйтэй байх гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саранчулуун гишүүн тодруулъя. Уучлаарай 4 номерын микрофон.

**М.Төрманлай:** Гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд угийн Харилцаа, холбооны зохицуулах хорооноос хувь хэмжээ заачихсан байдаг. Тэр хувь, хэмжээний дагуу дохионы хэлмэрчтэй болон нэвтрүүлгүүдийг илүү их хөтөлбөрт тусгадаг. Бид нар илүү их чиглэл өгч ажиллана гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саранчулуун гишүүн.

**О.Саранчулуун:** Мэдэхгүй асуудлыг хөндөхөөр хүмүүст төвөгтэй л байдаг л даа би ойлгож байна. Манайд бол ер нь ингэдэг шүү дээ тэргэнцэртэй хүмүүсийг бол бид нар эрүүлжүүлэхэд орж болохгүй, бааранд орж болохгүй юм шиг боддог. Сонсдоггүй, сонсгоггүй хүмүүсийг зөвхөн цаг агаарын мэдээ л үздэг гэж боддог байхгүй юу. Тийм болохоор зөвхөн цаг агаарын мэдээн дээрээ л дохионы орчуулгаа тавьдаг. Тэгээд ямар ч байсан минимал та нарт ямар ч байсан нэг юм хийчихлээ шүү дээ. Ингээд боллоо юм биш үү гээд байгаа мөртөө 1200 төгрөг нь бусад айлтай адилхан байсаар л байгаа. Тэгэхээр би та хэдэд өнөөдөр ингээд сонгогдвол бүр даалгавар өгмөөр байгаа юм. Амжилт хүсье. Ямар ч байсан энэ хууль, дүрмээ өөрчлөлт оруулаад энэ төлөөлөл дээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуул. Зөвлөл болгодог юм уу яадаг юм ажиллах хэрэгтэй. Хүртээмжтэй мэдээллийнхээ агуулгыг сайжруулах хэрэгтэй.

Дээрээс нь хэн үзээд байгаа, хаана үзээд байгаа, яаж үзээд байгаагаа ажиглаж судалгаа хийх хэрэгтэй байх. Гамшгийн мэдээлэл жишээлбэл хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүс авдаггүй шүү дээ ерөөсөө. Хамгийн аймаар жишээ бол тэр хэчнээн хүн нас бардаг гээч мэдээлэл авч чадаагүйгээс болж.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж тодруулъя.

**О.Саранчулуун:** Би яагаад ингээд ийм бухимдуу юм шиг ярьдаг гэхлээр үнэхээр л бэрхшээлтэй хүмүүст цаг дуу, хоолой гаргах орчин нөхцөл олддоггүй юм л даа. Тийм болохоор би та хэдийг Монголын Үндэсний телевизийг аврах гэж байгаа юм шиг, аврагчид шинээр эрч хүчтэйгээр ингээд болохгүй байсан зүйлийг засъя, төлөөлөл, больё, дуу хоолой больё гэдэг эрч хүчтэйгээр орж ирж байгаа юм байна л гэж харлаа. Танилцуулгуудыг нь харахад.

Тийм бол тэр сувгаар байж болох тэр онцгой байдлын мэдээлэл, зарим мэдээллүүдийг яг зорилт хүмүүст нь хүрэхэд ажиллаад өгөөч, хүртээмжийг нэмээд өгөөч. Би тэгээд та нарын яваад очиж болно шүү дээ. Эсвэл танай мэдээллийг хэн үзэж байгаа дээр дүн шинжилгээ хийгээд явах ёстой байх. Тэгэхдээ ер нь бол зүгээр энгийнээр би бодоод байх юм. Ийм том байгууллагын Үндэсний зөвлөлийн гишүүн болох гэж байгаа хүмүүс өөрсдөө яг тэр хэн үздэг юм, ямар нэвтрүүлэг нь хандалттай энэ тэр гэдгийг нь судалж мэдээлэл энэ тэр авдаггүй юм уу? Ажиллах гэж байгаа газраа хүн чинь судалдаггүй гэсэн үг юм уу? Ямар учиртай юм? Тэр бол жоохон ойлгомжгүй ийм сонирхолтой л санагдчихлаа. Яаж тэрийгээ одоо судлах.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Баатаржавын Мөнхсоёл.

**Б.Мөнхсоёл:** Үндэсний радио, телевиз гэдэг бол маш чухал ийм байгууллага. 2005 онд би өөрөө Нээлттэй нийгэм форумд ажиллаж байхдаа Хэвлэлийн хүрээлэнтэй хамтраад олон нийтийн хэлэлцүүлгийг хийж байсан юм. Яагаад энэ олон нийтийн үндэсний радио, телевиз болох ёстой вэ? Засаглал нь ямар байх ёстой вэ? Үндэсний зөвлөл гэж байх ёстой юм уу үүрэг нь ямар байх вэ? Сэтгүүлчдийн болон Үндэсний зөвлөлд орж байгаа гишүүдийн ёс зүй гэж юу вэ? Тэгээд Нээлттэй нийгэм форумд байхдаа ёс зүйн код гаргаж жишээ болгоод олон улсын ийм ёс зүйн кодын жишээнүүдийг орчуулж гаргаж өгч байлаа.

Тухайн үед Үндэсний зөвлөлөөс бас адилхан Ерөнхийлөгчөөс, Улсын Их Хурлаас, Засгийн газраас нэр дэвшүүлдэг байсан. Нэр дэвшүүлээд орж байсан 10-аад гишүүдийг бас Гүрж, Эстони, Чех улсад туршлага судлуулах гээд авч явж байлаа. Түүнээс хойш харахад энэ Үндэсний радио, телевиз ерөөсөө өсөж хөгжсөн зүйл алга. Сая гишүүдийн асууж бай асууж байгаа, хариулж байгаа байдлыг харахад үнэхээр чамлалттай байна. Юун энэ Саранчулуун гишүүний хэлж байгаа шиг эрч хүчтэй мотивацтай энэ байгууллагыг сайхан сайжруулах тийм итгэл найдвар бол алга байна шүү. Яаж хариулж байна аа? Ямар ч итгэл үнэмшил алга. Хэн нэгэн ятгаад чи болооч гэчихсэн юм шиг харагдаж байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт цаашдаа юун дээр анхаарах вэ гэхээр яаж бие даасан байх юм, яаж олон нийтийн сонирхолд нийцүүлсэн ийм агуулгатай программ, хөтөлбөр явуулах вэ гэхээр бодлогын түвшинд та бүхэн зөвлөж зангидаж уг нь явах ёстой. Мэдлэг хэр байна вэ? Хоёрдугаарт судалгаа хийх ёстой. Судалгаа яагаад үзэгчид үзэхгүй байна? Үзэхгүй байгаа бол яаж төлбөр нэхэх вэ? Яагаад төлбөр төлөхийг хүсэхгүй байна? Хотод 1100 шүү. Хөдөө 950, сумд 750 төгрөг. Өөр өөр

интервалтай ийм төлбөрүүд байгаа шүү. Бүгд нэг үнэ биш шүү. Наад захын юмаа мэдэхгүй байх шиг санагдлаа сая.

Тэгээд үе үеийн мундаг уран бүтээлчдээ бид нар алдлаа. Үндэсний радио, телевиз бас нэр хүндтэй байсан юм шүү. Хайран суваг, хайран орон даяар цацдаг мэдлэг, мэдээлэл, мэдээ, агуулга. Одоо тэгээд бусад хувийн телевизүүдээсээ хэр ялгарч байгаа юм? Тэгээд сонгуулиар л энэ улс төрчид гишүүн болох гээд байгаа орон нутгийн төлөөлөгч болох гээд байгаа хүмүүс шамбааралдаж хэдэн үнэгүй минутаа авдаг. Тэр үед бүгд анхаарсан болдог. Тэгэхээр энэ бие даасан байдал үзэгчдийн эрх ашиг, тэнцвэртэй, үнэн зөв мэдээлэл авах тэр эрэлт хэрэгцээ, мэдэх эрхийг нь хангахын төлөө та бүхнийг ажиллаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Одоо тэгээд энд хэдхэн сонирхож байгаа гишүүд нь ч хэд байгаа юм. Анхаарна шүү. Маш сайн ажиллаасай гэж хүсэж, хатуу анхаарна. Хатуу хэвлэлийн салбарт ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудаа бас хариуцлагажуулна гэж бодож байна. Тэгээд та бүхэн энэ ажил зүгээр ёс төдий илүүц ажил, хийдэг ажил биш шүү. Маш хариуцлагатай хийнэ шүү. Үндэсний олон нийтийн радио, телевиз шүү. Үүргээ сайн ухамсарлаарай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох эсэх асуудлаар нууц санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагаас бүх санал хураалтуудыг явуулна. Үүнтэй хамт явуулна.

17.09 цаг.

17 цаг болсон байна. Гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалт ингээд явна. Гишүүдийг танхимд урьж байна. Түрүүн.

**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье.**

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 1 цагийн завсарлага энэхүү асуудал дээр авсан. 17 цагт уу? Тийм 17 цагт завсарлага дууссан байна. Ингээд дараагийн асуудалдаа оръё.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Нэрсийг өгнө үү. Нэрсийг өгсөн байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Бөхчулууны Пүрэвдорж.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Ашигт малтмалын тухай хуулиар бас энэ АМНАТ-ын асуудлыг нэлээн хөндөж ярьж байгаа. Мэдээж гишүүдийн өөр байр сууриуд зөндөө бий. Энэ дээр бол хүндэтгэж үзэх шалтгаантай гэж үзэж байгаа. Тэгэхээр Үүрийнтуяа нарын гишүүд яг энэ Эрдэнэтийн АМНАТ-ын асуудлыг шийдвэрлэх зорилгоор бас энэ АМНАТ дээр бас өөр байр суурьтай байгаа. Энгийг нь бас хүмүүс янз бүрээр ойлгоод байх шиг байна. Ер нь бол АМНАТ-аар хамаг орлогыг

нь бүгдийг нь улсын төсөв рүү татаж аваад тэндээ үр ашиггүй зарцуулдаг. Гэтэл тэр Эрдэнэт үйлдвэр өөрөө маш том ордыг илрүүлсэн Оюут ордыг илрүүлсэн. Энэ Оюут орд дээрээ шинээр хөрөнгө оруулалт хийе гэхээр Эрдэнэт үйлдвэр өөрөө хийх боломжгүй бүх төсвийг нь, орлогыг нь аваад явчхаж байгаа.

Тэгэхээр энэ дээр бас тодорхой хэмжээгээр энэ үйлдвэрийнхээ үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ийм санаачилга гаргаад яваад байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр ер нь бол Үүрийнтуяа гишүүнд бас зөвлөхөд яг энэ энэ Ашигт малтмалын тухай хууль дээр энэ АМНАТ-ыг хөндөөд хэрэггүй дээ. Ер нь бол туршлагаа, энэ олон нийтийн санаа бодлоос харахад бол.

Ер нь бол танд зөвлөхөд хуулиар татварын өөрчлөлтийг, татварыг хуулиар тогтооно гэж үндсэндээ заасан байдаг. Гэвч олон олон татварыг тогтоолоор шийддэг. Жишээ нь өнгөрсөн өчигдөр гэхэд тамхины татварын хувь, хэмжээг тогтоолоор шийдлээ шүү дээ. Тэгэхээр АМНАТ бол яг адилхан л татвар. Тэгэхээр энийг бас буцаагаад тогтоолоор шийдэх боломжтой.

Тийм учраас та яг энэ асуудлаа намар чуулган орох дээр заавал 5 хувь гэхгүйгээр бас дундын хувилбар ч байдаг юм уу, 10 хувь ч байдаг юм уу яг зөвхөн Эрдэнэтдээ зориулсан тогтоолын төсөл оруулж ирээд энэ АМНАТ-ынхаа асуудлыг шийдвэрлэж болно.

Тэгэхээр ер нь бол заавал 5 хувь өгөхгүй 10 энэ тэр гэж хэлээд байгаа шалтгаан нь бол Эрдэнэт өөрөө олон жилийн өмнө хөрөнгө оруулалтаа нөхчихсөн, аль хэдийн үйл ажиллагаа нь жигдэрчихсэн. Дээрээс нь Эрдэнэтийн 49 хувийг хувийн хэвшлийнхэн ямар ч байсан олоод ирсэн. 400 сая доллароор Оросуудаас худалдаж аваад олоод ирсэн. Тэр нэгийг нь төр дээрэмдээд авчихсан. Тэр авсан компанийнхаа мөнгийг нэгдүгээрт өгөөгүй.

Хоёрдугаарт нь Эрдэнэт хэрвээ Оросуудын мэдэлд байсан бол бид нар КОВИД-ын үеэр 1 их наяд төгрөг 200 тэрбум төгрөгөөр энэ ард иргэдийн цахилгааны мөнгө, усны мөнгө Монгол орны бүх хүмүүсийн мөнгийг төлөх боломжгүй байсан байхгүй юу даа.

Тэгэхээр энэ олон бүх зардлууд нь хэвийн хэмжээнд оччихсон. Тэгээд бас яг энэ яг л өнөөдөр тэр Оюу толгойдоо хэрэгтэй тэр хөрөнгө оруулалтыг зайлшгүй өөрсдөө гаргах ийм боломжийг бий болгохын тулд та яг тэр АМНАТ-ын асуудал дээр заавал 5 хувь өгөхгүйгээр 10 хувь байдаг юм уу ийм байдлаар зөвхөн Эрдэнэтэд зориулж ийм тогтоолын төслийг бас өргөн барих боломжтой шүү. Тэгээд би энэ дээр зүгээр зөвлөгөө өгч байгаа юм. Бас ингээд Их Хурлын гишүүд бас зарим нэгэн зүйлээс болоод энэ ард түмнийг бас 2 талд хуваагаад янз янзын хэл асуудалд оруулаад байна. Тийм учраас бас энэ арай 3 удаа сонгогдсон гишүүний хувьд бас энэ гишүүдэд зөвлөгөө өгч байна. Тэгээд энэ хуулийг бол дэмжээд явуулах нь зүйтэй гэж бас ташрамд нь хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

**Л.Мөнхбаясгалан:** Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжихгүй байгаа. 7 сар болоод баяр наадам дөхөөд ирэхээр дандаа ийм хуудуутай хуулийн заалтууд оруулж ирдгээ болимоор байна. Ашигт малтмалын

тухай хуульд нийтдээ 300 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан. 2006 оны 07 сарын 06-ны өдөр энэ хууль өөрөө батлагдсан байдаг. 2009 оны 07 сарын 16-ны өдөр энэ хуульд 1 өдөр 36 заалт нэмэлт, өөрчлөлтөөр орж байсан байдаг. Оюу толгойн гэрээ батлагдахын өмнө шүү дээ.

2014 оны 07 сарын 01-ний өдөр 82 заалтаар өөрчлөлт орж байсан. Дубайн гэрээ батлагдахын өмнө өө гэсэн үг. Одоо энэ хуульд яг энэ баяр наадам дөхсөн үед энэ долоо хоногт хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаагүй энэ хуулийг гэнэт оруулж ирсэн. Засгийн газар Оюу толгойтой хэлэлцээр хийж зээлийн хүүг буурууллаа гэхээс цагийн өмнө энэ хууль Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын жагсаалтад орж ирсэн. Өнөөдөр ч энэ жагсаалтад байгаагүй ороод ирсэн.

Тэгэхээр энэ бол 2027 онд хийгдэх Онтрэ-гийн гэрээг угтан хийж байгаа урьдчилж нөхцөл байдал гэж хардаг байна. Тийм учраас энэ хуулийг энэ удаа эрхэм гишүүд дэмжихгүй байж намрын чуулганаар тавтай8 тухтай хэлэлцэх ёстой.

Дараагийн хардаг шалтгаан байна. Өнгөрсөн жил 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Ноён уул, Гутайн давааг ухах Засгийн газраас Алт-III аян оруулж оруулж ирж байсан. Бас л яаралтай горимоор оруулж ирсэн.

07 сарын 09-ний өдөр энэ тусгай хамгаалалттай төрийн тахилгатай уулыг ухах шийдвэрээ гаргаж байсан6 Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх хориг тавьснаар энэ тогтоолын төсөл хэрэгжээгүй.

Сая бас 7 сард дахиад Ноён уулын Эрээн-Баавгайтыг Гацууртын алтны ордыг тогтоолын төсөл муу хулгайн замаар орж ирсэн. Эргүүлээд татсан. Бодвол Монгол Улсын Ерөнхийлөгч загнасан болов уу гэж бодож байна. Тэгэхээр бид нар ийм баяр наадам дөхөхөөр оруулж ирдэг энэ хулгайн хуулиа болимоор байна. Дамдинням сайдын өгсөн ярилцлагыг харсан. АМНАТ-ыг буулгаж энэ хуулийг баталснаар Хармагтай Цагаан суваргын ордыг хөдөлгөнө сайн сайхан юм ярьсан. Том ордуудаа хөдлөлгүй л яах вэ дээ. Тэгэхдээ Цагаан суваргын ордыг стратегийн ордоос гаргах өдөр нь мөн 2014 оны 07 сарын 01-ний өдөр тохиож байсан юм шүү. Та нарын хуудуутай хулгайн замын хуулиуд дандаа баяр наадмаар орж ирдэг.

Ялангуяа энэ Ашигт малтмалын хууль бол дандаа 7 сард орж ирдэг. Наадам дөхөхөө. Өнгөрсөн жил Туул голын онцгой хамгаалалтын бүсэд барилга байшин барих тэр хууль бас 07 сарын 09-ний өдөр Улсын Их Хурлаар батлагдсан. Тийм учраас хэлэлцэх асуудлын дараалалд байгаагүй, одоо яаралтай хэлэлцэх шаардлагагүй Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эрхэм гишүүд дэмжихгүйгээр хойшлуулах шаардлагатай байна.

Бид нар 1 удаа хуудуутай шийдвэр гаргаснаар энэ 10, 20-н жил компаниуд, 10, 20-н жил Монголын ард түмэн хүртэх ёстой ашгаа хүртэж чаддаггүй ийм гашуун туршлагауд зөндөө бий. Энэ хуулиар маш олон заалтууд зүгээр энгийн номхон ард иргэд, дээрээс нь орон нутгийн тусгай хамгаалалтад нөөцөд авсан газруудын эрх ашгийг хөндөнө өө. Тийм учраас энэ хуулиа дэмжихгүй. Одоо нэгэнт та нар батлуулна гээд дайраад байгаа юм чинь дэмжихгүй байх л арга замыг бид нар сонгох хэрэгтэй. Эрхэм гишүүдэд уриалж байна. Энэ хуулийг унагаах хэрэгтэй өнөөдөр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн. Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Пүрэвдорж даргын зөвлөж байгаа асуудлыг би бас судалж үзье. Ард иргэдийгээ хуваагдах, маргаан үүсгэх ийм сэдэв гаргаж байгаа бол ард иргэдээсээ хүлцэл өчье. Миний хувьд Эрдэнэт үйлдвэрт 8 жил ажиллахдаа санхүү, эдийн засгийн салбарыг нь бас хариуцаж ажиллаж байгаа хүний хувьд энэ АМНАТ-тай холбоотой асуудал үүссэн маргаан дээр төрийн өмчит компани төр засагтайгаа шүүхдлээ гэдэг дээрээ тултал бас ажиллаж байсан.

Дээр нь би энэ үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх арга зам гэдэг сэдвээр би бас Эрдэнэт үйлдвэрийнхээ жишээн дээр эрдмийн ажил хийж докторын зэрэг хамгаалсан юм байгаа юм. Тэгээд энэ бол бас үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлдэг нэг хүчин зүйл гэдгийг судалгааныхаа ажлын үр дүнгээр олж харж байсан хүний хувьд.

Нөгөө талдаа би тойргоос сонгогдсон Эрдэнэтийн энэ уурхайчдын, Эрдэнэт хотын ард иргэдийн төлөөлөл болж энэ хүмүүсийн дуу хоолойг хүргэнэ гэж би бас тойргоос ард иргэдийн санал авч гарч ирсэн Улсын Их Хурлын гишүүний хувьд би энд дуугүй байж чадахгүй байгаа юм. Бодлого, шийдвэрийг эсэргүүцсэндээ биш, бодлогын алдаа гаргачихгүй байхын тулд л би үгээ хэлж байгаа.

Эрдэнэт үйлдвэрийн асуудал бол бий. Эрдэнэт үйлдвэр маш том боломжуудыг алдах ийм үндэслэл бий болоод байгаа юм. Ашиглалтын хууль олон жил орж ирээгүй өнөөдөр бас Улсын Их Хурлын босго даваад ороод ирсэн үед бид хэлэлцээд баталчих юм сан гэсэн хүсэл, эрмэлзэл надад бол байна.

Гэхдээ энэ АМНАТ-ын асуудал дээр бид зөв ойлголттой байж мэдсээр байж буруу, зөрүү зүйл ярьдаггүй, байгаа хууль тогтоомжоо ашиглах гаргалгаагаа хардаггүй, хатуу нэг талыг барьсан эрх ашгийн сонирхолтой юм шиг ийм нөхцөл байдлуудыг ялангуяа салбарын дэд сайдаар ажиллаж байсан хүмүүсийн хувьд бол гаргамааргүй байгаа юм. Би бол ялгаатай харж байгаа юм. Би Батнайрамдал даргад бас өнгөрсөн Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр нэлээн хатуу хэлчихсэн. Яах вэ энэ Улсын Их Хурлын гишүүд буруу, зөрүү ойлголттой байгаад энэ асуудлыг ярих нэг хэрэг.

Яг салбар хариуцаж байсан сайд, дэд сайдын хувьд ийм асуудал ярихаар маш их итгэл үнэмшил төрүүлээд байгаа юм л даа. Тэгээд ер нь бол АМНАТ-ыг бууруулснаар эдийн засгийн хувьд маш их үр өгөөжийг авчирдаг юм. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлдэг, эргээд нөөц баялаг нэмэгддэг захын агуулга буурдаг. Энэ олон давуу тал, боломжуудаа бид харж ажиллах нь уул уурхайн салбарын ирээдүй, хэт ирээдүйд хэрэгтэй байгаа юм.

Тэгээд ганц Эрдэнэтийн асуудал биш ирээдүйд ороход бэлэн болчихсон олон зэсийн ордуудаа бид нар ашиглаж, энэ салбарыг зөвхөн нэг гаднын хөрөнгө оруулалттай “Рио Тинто” гэдэг компаниас хамааралтай биш олон хөрөнгө оруулагчтай, хөрөнгө оруулагч нар өрсөлдөж уралдсан үйлдвэрлэлийг хийсэн ийм салбар байгаасай л гэж би энэ салбарын төлөө бас сэтгэл зүрх цохилж явдаг хүний хувьд хэлж байгаа юм.

Тэгээд энэ бол үндсэндээ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын асуудал шүү дээ. Уул уурхайн салбараас бид нар төсвийн орлогынхоо дийлэнх хувийг бүрдүүлж амьдарч байгаа ийм улсын хувьд яг энэ салбараа улс төржүүлээд баймааргүй байгаа юм. Улс төрийн шийдвэрээр аливаа асуудалд хандмааргүй байгаа юм.

Тийм ч учраас миний бие энэ хууль эцсийн хэлэлцүүлэг дээр явж байна. Дахин санал гаргаж өөрчлөх боломжгүй. Улсын Их Хурлын гишүүд шийдээд ингээд явах байх. Миний хувьд намар дахиж хуулийн төсөл өргөн барихаар бас өнөөдөр мэдэгдлээ хийсэн. Энэ хуулийн төсөл дээр Эрдэнэт үйлдвэр бусад шинэ төслүүдэд хамааралтай. Одоо энэ гишүүдийн эргэлзээ төрүүлээд ард иргэдийн дунд буруу ойлголт төрүүлээд байгаа тэр Онтрэ-гийн орд, Онтрэ-гийн асуудал буюу “Онтрэ” компанийн эзэмшиж байгаа 2 лицензтэй холбоотой Оюу толгойн бүлэг ордтой холбоотой асуудлыг энэ хуулийн заалтад хамааруулахгүйгээр орхиод бусад төслүүдэд хэрэглэх боломжтойгоор 47.5 буюу АМНАТ-ын 47.5 буюу АМНАТ-ыг зохицуулсан энэ заалтад нь өөрчлөлт оруулсан хуулийн төслийг өргөн барья гэж ингээд шийдээд явж байгаа гэдгээ бас хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үүрийнтуяа гишүүн санал хэллээ. Болдын Уянга гишүүн.

**Б.Уянга:** Ашигт малтмалын тухай хуульд шинэчилсэн найруулга орж ирнэ гэсэн хүлээлттэй бол байсан. Гэхдээ нэмэлт, өөрчлөлтийн төсөл орж ирсэн. Миний хувьд болохоор яг энэ төслийг бол чамлах аар чанга атгах хэрэгтэй гэж үзэж байгаа. Их олон асуудлууд бол байдаг. Тэгээд маш их ажил хийгддэг газар нь ингээд аягүй их асуудлуудтай юм шиг яригддаг. Зүгээр тэнд ажил буцалж байдаг учраас л олон хүний харах өнцөг нь өөр байдаг байх.

Тэгэхээр энэ хуулийн төслийг маш олон 2006 онд хүчин төгөлдөр байгаа байдлаараа хүчин төгөлдөр их хэрэгжиж байгаа шүү дээ. Тэгээд энэнээс хойш энэ хуулийг сайжруулъя гэж зөндөө явсан. Тэгээд явж явж өнөөдөр ингээд эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Бид нар эцэслэн батлах нь бол намар шүү дээ. Ингээд эцсийн хэлэлцүүлэг явж байна.

Тэгээд ингээд Дамдинням сайдын ард нь маш олон жил салбартаа ажиллаж байгаа энэ ажлын хэсэг сууж байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийг бас дурдаад хэлчихье гэж бодсон юм. Өнөрнасан дарга байна. Санчигдорж дарга, Дашпүрэв, Намчинсүрэн, Ган-Очир, Энхтулга дарга тэр ард нь байх шиг байна. Ингээд их тогтвор суурьшилтай олон жил энэ салбарынхаа төлөө яваад ингээд хууль нь ямар ч гэсэн шинэчилсэн найруулга биш хэдий ч зарим нэгэн зүйл нь засагдаад нэмэлт, өөрчлөлт байдлаар орж ирж байна.

Тэгэхдээ цааш цаашдаа хийх зүйлүүд үлдээд байна. Тэрийг бас энэ хуулийн энэ хувийн хэрэгт нь тэмдэглэл болгон үлдээх зорилгоор дараа хийх ёстой зүйлүүдийг дурдъя гэж бодсон юм. Энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр бол зөвхөн ээстэй холбоотой асуудал ерөөсөө биш. Төмөр байна, жонш байна, бид нар зөндөө шийдэх асуудал энд бол байгаа. Тэгээд хувийн хэвшлээс олоогүй орлогоос нь татвар тавьчихдаг, авчихдаг, авах гээд үздэг. Энийгээ бас яаж шийдэх ёстой юм.

Ингээд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль гэж байгаа. Тэгээд энэ хуулийгаа энэ Ашигт малтмалын үндсэн хуультайгаа нэгтгэе гээд бас чадаагүй бололтой. Тэгэхээр энэ хуулиа бас бүгдээрээ дараа нь яах вэ? Ингээд критикал минерал гээд чухал ашигт малтмал гээд ярьж эхэлсэн. Нэр томьёог нь бол сайхан оруулаад ирж байгаа энэ хуульд. Тэгээд Засгийн газар энэ ашигт малтмалынхаа жагсаалтыг баталъя гэж байгаа юм. Тэгээд яг цаашаагаа юу хийх вэ, яаж энэ салбараа дэмжих юм гэдэг зохицуулалт байхгүй.

Тийм учраас анх Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож ажиллаж эхэлснээсээ хойш чухал Ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төслийг бол боловсруулсан байсан. Засгийн газар луу өгсөн байсан. Тэгэхээр энэ хуулийн төслөөс зөвхөн тодорхойлолт нь орж ирж байгаа тохиолдолд яг энэ бэлэн байгаа хуулийг өргөн барих ёстой юм байна гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ намрын чуулганаар бас яг тэгвэл чухал гэж үзэж байгаа ашигт малтмалуудыг яах ёстой юм бэ гэдгийг бүгдээрээ ярилцацгаах болох нь.

Ингээд орон нутгийн оролцоо, ил тод байдлын асуудал бас нөгөө хэрвээ оруулаад л байсан бол шинэчилсэн найруулга болчих гээд байсан байх л даа. Тэгэхээр Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль гэдэг нэр доор бас өргөн барих хэрэгтэй болж байна. Тэгэхээр яг энэ салбарт бол ажлууд явж байгаа. Сайжрах орон зай бол зөндөө байгаа. Тэгэхээр үнэхээр сонирхож ийм ийм асуудлыг нь шийдэх хэрэгтэй байна гэх юм бол яг энэ салбарын хамт олонд нь мэдээллээ хүргүүлэх хэрэгтэй. Өнөөдөр бол бүгдээрээ эцсийн хэлэлцүүлгийг хийгээд ингээд намрын чуулганаар бол эцэслэн батлах байгаа. Тэгээд тэр хооронд бас өөр бусад асуудлуудаа хэрхэн засах вэ гэдгээ ярилцах нь зүйтэй байх. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Энэ түрүүний парламент дээр хүртэл Ашигт малтмалын тухай хууль орж ирэх гээд орж ирж чадаагүй. Өргөн бариад миний бие ажлын хэсгийг нь ахлаад явъя гэсэн бас л бүтээгүй. Тэгээд одоо ингээд орж ирж байгаадаа энэ хэдүүлээ сайхан хэлэлцээд ямар ч байсан алдаа дутагдал бас магадгүй байж болно. Тэгээд сая Үүрийнтуяа гишүүн хэллээ шүү дээ шаардлагатай бол дахиад бас хууль өргөн бариад ингээд явах нь бол нээлттэй. Тийм болохоор ингээд хэлэлцээд явах нь зүйтэй байх гэж бодож байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Асуулт давхацчихсан тул татлаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Асуулт давхацсан байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 17 цагаас гэсэн. Гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 9 санал байгаа.

17.27 цаг.

Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Өнөөдөр нэлээн хэдэн хуулийн санал хураалтуудыг нэгтгэж явуулна. Санал хураалт явуулна. Гишүүдээ урьж байна. Бүх асуудлаар санал хураалт нэгдсэн санал хураалт явагдана.

Шижир гишүүний өглөөний үгийг нэмээд өгчих юм уу? Би яагаад ч хараагүй байгаа юм, эсвэл энэ дээр гараагүй юм уу айн? Энэ дээр гараагүй юм уу, эсвэл хараагүй юм уу, эсвэл алдаа гаргасан юм болов уу? Хүлцэл өчиж байна. Үгээ хэлчих юм уу? Дахин алдаа гаргахгүй. Бүлгийн дарга нар гишүүдээ цуглуулаарай. Өнөөдрийн асуудлуудаар нэгдсэн санал хураалт явуулна. Монгол Ардын намын бүлгийн дарга Батжаргал, Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл та бүхнийг урьж байна. Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Одоо санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

**С.Бямбацогт:** Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулчихъя. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

“Татгалзсан” гарч байгаа 42 гишүүн чуулганы танхимд хүрэлцэн ирнэ үү. Санал хураалтдаа оролцоно уу. Болормаа гишүүн, Цогтгэрэл дарга, Мөнхсоёл гишүүн орж ирж байна. “Татгалзсан” гарсан гишүүдээс. Жаргалан гишүүн, Тулга гишүүн. Сая нэр дурдсан гишүүдээс бусад гишүүд чуулган танхимд хүрэлцэн ирье. “Татгалзсан” гарч байгаа 42 гишүүн. 37 гишүүн боллоо. Бейсен гишүүн, Очирбат гишүүн орж ирлээ. 35 боллоо.

**Одоо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа илтгэе. Санал хураалт.**

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 69 гишүүн, Энхбаяр гишүүнд 70 гишүүн, Баярбаатар гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Замира гишүүдийг тооцоод 73 гишүүн дэмжлээ. Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Цогтбаатар даргад бас баярлалаа.

17.38 цаг.

**Одоо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.**

Санал хураалт. “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 76 гишүүн буюу 73 хувийн саналаар санал батлагдлаа.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархлаа илэрхийлье.

17.40 цаг.

**Одоо Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.**

Зарчмын зөрүүтэй, саналыг дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 3 санал байна. Гишүүд санал хураалтдаа ил.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын гишүүдийн санаачилсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгасан зарчмын зөрүүтэй санал.

42.2.1.Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийг холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн.

1.Төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт**

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

104 гишүүнээс 76 гишүүн буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан зарчмын зөрүүтэй санал.

42.2.3.Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

1.Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийн **“ХАРИУЦЛАГА”** гэснийг **“ГОМДОЛ ГАРГАХ,”** гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг 7 дугаар зүйлтэй нэгтгэн, 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“5 дугаар зүйл.Гомдол гаргах эрх**

5.1.Бизнес эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх, бизнес эрхлэгчид учирсан хохирлыг хуульд заасны дагуу нөхөн төлөх үүрэгтэй.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 78 гишүүн буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “үндэслэлгүй хяналт шалгалт хийх,” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104 гишүүнээс 78 гишүүн буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

17.45 цаг.

#### **Тамхины хяналтын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Санал хураалт явуулна. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал.

1.Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай 85.43, 96.14 дүгээр зүйл, үндэсний код нэмсүгэй:

**1/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл:**

85. 85.43.

85.43.Энэ бүлгийн бусад газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат 5.

8543.40.00.Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн 20.

8543.9000.Эд анги электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн бусад төхөөрөмжийн 20. Бусад 5.

**2/96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл:**

96. 96.14. 96.14.00.00.Тамхины гаанс (гаансны толгойн орно) болон сигар, янжуур тамхины соруул тэдгээрийн эд анги 20. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 78 гишүүн буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалтад 104 гишүүн орсны 73 гишүүн буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.хамрын тамхи, усан хоолойгоор татах зариулалттай тамхинаас бусад тамхи, татах төхөөрөмж, түүний эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

104-өөс 77 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтаас доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэрийг хасах:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

104-өөс 76 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

17.50 цаг.

**Малчны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар Байнгын хорооноос гаргасан тогтоолын санал хураалт явуулна.**

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

104-өөс Мандхай гишүүн, Хэрлэн гишүүн нэмээд 67, Бейсен гишүүн 68, Очирбат гишүүн 69, Даваагийн Цогтбаатар гишүүн 70 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье.

17.51 цаг.

**Засгийн газарт чиглэл өгөх, орон сууцын худалдан авалт, орон сууцын залилантай холбоотой асуудлаар чиглэл өгөх тогтоол байгаа.**

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 68 саналаар санал дэмжигдлээ.

Орон сууцын залиланг бас таслан зогсоох, тогтоох, зогсоохтой холбоотой бас Улсын Их Хурал тогтоол баталлаа. Гишүүддээ талархал илэрхийлье.

17.52 цаг.

Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй, саналыг дэмжсэн, дэмжээгүйгээс гишүүд үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 9 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.**

1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх хэсгийг үндэслэн хуралдаан даргалагчаас гүйцээн боловсрох чиглэл өгсний дагуу хураасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.38.“маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардлагатай хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэх Монгол Улсын иргэнд олгох эрхийг;”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 104 гишүүн орсноос 59 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29<sup>1</sup> дүгээр зүйл, 29<sup>2</sup> дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“29<sup>1</sup> дүгээр зүйл.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох**

29<sup>1</sup>.1.Ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн олборлож байгаа эсэхэд хяналт тавих, нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг тодорхойлох, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатны төлөвлөлтөд хяналт тавих, уурхайн хажуу болон хаягдал овоолгын чулуулгийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29<sup>1</sup>.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

**29<sup>2</sup> дугаар зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа**

29<sup>2</sup>.1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

29<sup>2</sup>.1.1.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолгын хэмжээ, уулын ажилд хамрагдсан талбай, ил болон далд уурхайн төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

29<sup>2</sup>.1.2.ашигт малтмалын ордын нөөцийг хэрхэн ашиглаж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргах;

29<sup>2</sup>.1.3.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно;

29<sup>2</sup>.1.4.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан хөндлөнгийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцах;

29<sup>2</sup>.1.5.энэ хуулийн 29<sup>2</sup>.1.1-д заасан үйл ажиллагааг хөндлөнгийн хараат бусаар хэрэгжүүлэх.

29<sup>2</sup>.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах заавар, шаардлагыг төрийн захиргааны төв байгууллага батална.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

104 гишүүнээс 65 гишүүн буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

104-өөс 65 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нартай зөвшилцсөнөөр хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

104-өөс 60 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглоно” гэснийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох” гэж өөрчилж, 64<sup>1</sup> дүгээр зүйлийн 64<sup>1</sup>.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104-өөс 62 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх хэсгийг үндэслэн хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104-өөс 66 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104-өөс 65 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104-өөс 65 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрээс “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

104-өөс 64 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

17.59 цаг.

**Одоо Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох эсэх асуудлаар нууц санал хураалт явуулна.**

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг бол дэмжиж байгаа бол ногооноо дарна. Дэмжихгүй бол улаанаа дарна. Ойлгомжтой. Санал хураалт явуулъя.

Дугарсүрэнгийн Гүн-Үйлсийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт.

Хэлсэн шүү дээ Гүн-Үйлс гээд. Анхааралтай байгаарай гишүүд ээ. Санал хураалтад 104 гишүүн орсноос 66 гишүүн буюу 63 хувийн саналаар дэмжигдлээ.

Чулуунбаатарын Батцэнгэлийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 11.5 хувийн саналаар дэмжигдээд энэ хүн дэмжигдсэнгүй.

3.Дашзэвгийн Мягмарсүрэнг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 104 гишүүн орсноос 75 гишүүн буюу 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Сандагийн Эрдэнэ-Одыг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Од-Эрдэнэ. Сандагийн Од-Эрдэнэ. Манай дүү байгаа юм тийм. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Нууц санал хураалт явуулъя.

Санал хураалтад 104 гишүүн орсон. 75 гишүүн буюу 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Маналжавын Төрманлайг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал.

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо Олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нууц санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлдээд хуруугаа уншуулаарай. Санал хураалт явуулна.

Бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Сүхбаатарын Алтанцэцэг, Доржсүрэнгийн Батсүх, Ванжилын Бат-Эрдэнэ, Наваанпэрэнлэйн Жанцан, Дэмбэрэлийн Өлзийбаатар нарыг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя.

104 гишүүнээс 76 гишүүн буюу 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол 2026 оны 07 дугаар сарын 02 Улаанбаатар хот.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Дашзэвгийн Мягмарсүрэн, Сандагийн Од-Эрдэнэ, Маналжавын Төрманлай нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Сүхбаатарын Алтанцэцэг, Доржсүрэнгийн Батсүх, Ванжилын Бат-Эрдэнэ, Наваанпэрэнлэйн Жанцан, Дэмбэрэлийн Өлзийбаатар нарыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийн эцсийн найруулгуудын саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа дууслаа. Санал хураалтад оролцсон 76 гишүүндээ, ирцдээ орсон 104 гишүүндээ бас талархлаа илэрхийлье.

Чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.06 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

